



УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНИЙН ШИЙДВЭРТ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ МЭДЭЛ, НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН
050

Улаанбаатар хот
2025 он

**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНИЙН ШИЙДВЭРТ ОРОЛЦОГЧ
ТАЛУУДЫН ЭРХ МЭДЭЛ, НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

Судалгааны удирдагч:

Батболдын Баясгалан	Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуулийн захирал, доктор, профессор
---------------------	--

Зөвлөх:

Ядмаагийн Бямбасүрэн	Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, профессор
----------------------	---

Судлаачид:

Вандангомбын Данаасүрэн	Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор
Эрдэнэхүүгийн Халиунаа	Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, доктор
Дашнямын Оюунчимэг	Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш, доктор, дэд профессор
Дондогийн Бадамчимэг ахлах	Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт мэргэжилтэн, Удирдлагын академийн докторант
Эрдэнэчулууны Түвшинчулуун	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, Удирдлагын академийн докторант
Рэгзэнгийн Ганцэцэг	Удирдлагын академийн Докторантур, магистрантурын албаны Сургалтын ажилтан, магистр

Мөнхийн Үсэг ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	VI
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	VII
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	IX
ӨМНӨХ ҮГ	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	3
1.1. Судалгааны асуудал	3
1.2. Судалгааны асуулт	5
1.3. Судалгааны зорилго	6
1.4. Судалгааны зорилт	6
1.5. Судалгааны хамрах хүрээ	6
1.6. Судалгааны ач холбогдол	7
1.7. Нэр томъёоны тодорхойлолт	7
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ.....	11
2.1. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлогын оролцогч талууд, онцлог	11
2.1.1. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний салбарын бүтэц, онцлог	11
2.1.2. Эрчим хүчний үнэ тарифын бодлого, бодлогод оролцогч талууд	15
2.2. Эрчим хүчний үнийн бодлого тодорхойлоход оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийг шинжлэх онол, арга зүй, олон улсын туршлага	20
2.2.1. Эрчим хүчний үнийн шийдвэрт харгалзах хүчин зүйлс, орчин үеийн хандлага	20
2.2.2. Эрчим хүчний үнийн бодлогын оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаарх олон улсын туршлага, хандлага	22
2.2.3. Бодлогын оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг шинжлэх онол, арга зүй	31
2.3. Судалгааны үзэл баримтлал	39
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	41
3.1. Судалгааны төрөл	41
3.2. Өгөгдлийн эх сурвалж	41
3.3. Өгөгдөл цуглуулах арга	41
3.4. Өгөгдөл шинжлэх арга	42
3.5. Эх олонлог, түүвэр	43
3.6. Судалгааны найдвартай ба хүчинтэй байдал	46



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ҮР ДҮН 47

4.1. Монгол Улсын эрчим хүчний зах зээлд цахилгаан эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үнийн бодлогын хэрэгжилт	47
4.1.1. Эрчим хүчний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв, үнэ тарифын зохицуулалтын өнөөгийн байдал	47
4.1.2. Цахилгаан эрчим хүчний шийдвэр гаргах үе шат, талуудын оролцооны зохицуулалт	58
4.2. Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн асуулга судалгааны үр дүн, дүгнэлт...63	
4.2.1. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл, эх олонлогоо төлөөлөх чадвар.....	63
4.2.2. Үнийн өсөлтийн талаарх цахилгаан хэрэглэгч өрх болон аж ахуйн нэгж байгууллагын санаа бодол	66
4.2.3. Үнийн өсөлтөд үзүүлэх хэрэглэгчдийн хариу үйлдэл, нөлөө	73
4.2.4. Үнэ тарифын зохицуулалт, нөлөө бүхий этгээдийн талаарх хэрэглэгчийн мэдлэг	85
4.3. Эрчим хүчний салбарын экспертийн асуулга судалгааны үр дүн, дүгнэлт...96	
4.3.1. Судалгаанд хамрагдсан экспертүүдийн ерөнхий мэдээлэл.....	96
4.3.2. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх экспертүүдийн санаа бодол	97
4.3.3. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлого, аргачлалын талаарх экспертүүдийн санаа бодол	100
4.3.4. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, нөлөөлөгч талуудын талаарх экспертүүдийн дүгнэлт.....	102
4.4. Фокус ба ганцаарчилсан ярилцлагын үр дүн, дүгнэлт	104
4.4.1. Цахилгаан эрчим хүчний үнэ өсгөх шийдвэрийн хэрэглэгчид үзүүлэх нөлөө ба хэрэглэгчийн хариу үйлдэл	104
4.4.2. Цахилгаан эрчим хүчний үнэ тогтоох зарчим, аргачлалын талаарх дүгнэлт.....	106
4.4.3. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаар ярилцлагад оролцогчдын дүгнэлт.....	109

ТАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ112

5.1. Судалгааны дүгнэлт	112
5.2. Судалгаанд үндэслэсэн бодлогын зөвлөмж	116

ХАВСРАЛТУУД.....123

Хавсралт 1. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгч-айл өрхөөс авах судалгааны анкет	123
--	-----

Хавсралт 2. Цахилгаан эрчим хүч хэрэглэгч-байгууллагаас авах судалгааны анкет	129
Хавсралт 3. Экспертийн судалгааны хуудас	137
Хавсралт 4. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн судалгааг авах зааварчилгааны хуудас.....	143
Хавсралт 5. Ярилцлагын удирдамж.....	147
Хавсралт 6. ААН хэрэглэгчдийн ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ	151
Хавсралт 7. Эрчим хүчний судалгааны компани, төрийн бус байгууллага, судлаачдын ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ.....	155
Хавсралт 8. Эрчим хүчний судалгааны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ.....	163
Хавсралт 9. Өрхийн хэрэглэгчдийн ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ	169
Хавсралт 10. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын талаарх үнийн шийдвэр гаргагчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын сэдэвчилсэн шинжилгээ	173

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АУНС	Алтай-Улиастайн нэгдсэн сүлжээ
АУЭХС	Алтай-Улиастайн эрчим хүчний систем
ББНС	Баруун бүсийн нэгдсэн сүлжээ
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
БЗӨБЦТС	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
ГХ	Гэр хороолол
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ЗБНС	Зүүн бүсийн нэгдсэн сүлжээ
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ОС	Орон сууц
ОСНААК	Орон сууц, нийтийн аж ахуйн контор
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
ӨБЦТС	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
ӨБЭХС	Өмнөд бүсийн эрчим хүчний систем
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
СЯ	Сангийн яам
ТБНС	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХХ	Үүрэг хүлээсэн хэрэглэгч
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ЭБЦТС	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ
ЭХ	Эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эрчим хүчний зах зээлийн нэг худалдан авагчтай загварын энерги болон мөнгөн урсгал	17
Зураг 2. Тулгамдсан асуудлаар хөтлөгдсөн улс төрийн эдийн засгийн шинжилгээний үндсэн алхам болон гол элементүүд	32
Зураг 3. Ардчиллын шооны загвар.....	37
Зураг 4. Судалгааны үзэл баримтлал	40
Зураг 5. Цахилгаан, дулааны эрчим хүчний борлуулалтын орлого, тэрбум төгрөг	49
Зураг 6. Эрчим хүчний ТЗЭ-дийн үйл ажиллагааны зардлын өөрчлөлт, тэрбум төгрөг	48
Зураг 7. ОХУ-аас худалдаж авсан импортын ЦЭХ-ний төлбөр, тэрбум төгрөг	50
Зураг 8. Эрчим хүчний салбарын ашиг, алдагдал, сая төгрөг.....	50
Зураг 9. Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифын өөрчлөлт (2002-2024).....	52
Зураг 10. Азийн зарим орнуудын хэрэглэгчдийн ЦЭХ-ний үнэ (ам.цент/кВт.ц)-ийн харьцуулалт	57
Зураг 11. Эрчим хүчний үнэ тарифын шийдвэр гаргах буюу үнэ тариф тогтоох үе шат.....	61
Зураг 12. Судалгаанд оролцогч айл өрхүүдийн орон сууцны төрөл, хувиар.....	64
Зураг 13. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдийн санаа бодол, хандлага (санал нийлэх хувиар илэрхийлсэн)	68
Зураг 14. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх мэдээллийн эх сурвалж.....	71
Зураг 15. Өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдийн цахилгааны хэрэглээний төлбөрийн тооцооллын талаарх санаа бодол	72
Зураг 16. Өрх болон ААН байгууллагын хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нөлөөлсөн байдал	73
Зураг 17. Цахилгааны үнийн өсөлтийн өрхийн хэрэглэгчдэд үзүүлж буй нөлөө.....	74
Зураг 18. Өрхийн хэрэглэгчдэд цахилгааны үнийн өсөлтийн үзүүлсэн нөлөө, орон сууцны төрлөөр	75
Зураг 19. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн ААН байгууллагын хэрэглэгчдэд үзүүлсэн нөлөө, орлогын түвшнээр ангилснаар	76

Зураг 20. Өрхийн болон байгууллагын хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт дэх хариу үйлдэл	77
Зураг 21. Өрхийн хэрэглэгчдийн үнийн өсөлтийн дараах цахилгааны хэрэглээнд гарсан өөрчлөлт /орлогын түвшнээр/.....	78
Зураг 22. Өрхийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчийг хэмнэх аргуудын хэрэглээ (санал нийлсэн хувь)	78
Зураг 23. Орлогын ялгаатай бүлгийн айл өрхийн үнийн өөрчлөлтөд үзүүлсэн хариу үйлдэл	79
Зураг 24. Орлогын ялгаатай бүлэгт хамаарах өрхийн хэрэглэгчдийн үнийн өөрчлөлтөд үзүүлсэн хариу үйлдэл.....	80
Зураг 25. Орлогын ялгаатай бүлэгт хамаарах ААН байгууллагын хэрэглэгчдийн үнийн өсөлтийн дараах хариу үйлдэл.....	81
Зураг 26. ААН байгууллагын хэрэглэгчдийн үнийн өсөлтөд үзүүлсэн хариу үйлдэл, орлогын түвшний бүлгээр	82
Зураг 27. Эрчим хүчний үнэ өсвөл цахилгаан хэмнэх аргуудыг ашиглах хандлага	84
Зураг 28. “Цахилгаан эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах хэрэгтэй вэ?” асуултын хариулт (Өрхийн хэрэглэгчдийн хариулт, хувиар)	87
Зураг 29. Эрчим хүчний үнийн бодлогод та, танай ААН байгууллагын санал бодол тусдаг уу?	91
Зураг 30. Эрчим хүчний үнийн мэдээллийг хэр авдаг талаарх хэрэглэгчдийн хариулт.....	94
Зураг 31. Эрчим хүчний үнийн мэдээллийг хэр авдаг талаарх хэрэглэгчдийн хариулт.....	95
Зураг 32. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн үндэслэл, шалтгааны талаарх экспертүүдийн санаа бодол.....	98
Зураг 33. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн үндэслэл, шалтгааны талаарх экспертүүдийн санаа бодол, экспертийн бүлгээр ангилсан байдал	99
Зураг 34. Цахилгаан эрчим хүчний үнэ тогтоож ирсэн аргын талаарх экспертүүдийн мэдлэг	101
Зураг 35. Цахилгаан эрчим хүчний үнийг цаашид хэрхэн тогтоож зохицуулах нь зохистой гэж үзсэн бэ?	102
Зураг 36. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэр гаргалтад холбогдогч талуудын үзүүлэх нөлөө.....	103

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цахилгаан эрчим хүчний нийт үйлдвэрлэл (сая кВт.цаг), 2020-2024 онуудад	11
Хүснэгт 2. Хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, эзлэх хувь, 2020-2024 онуудад	12
Хүснэгт 3. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн тооны өсөлт, 2020-2024 онуудад	13
Хүснэгт 4. Эрчим хүчний үнэ тарифтай холбоотой бодлого, шийдвэрийн оролцогчид, тэдгээрийн чиг үүрэг	18
Хүснэгт 5. Засаглалын хэлбэр ба эрчим хүчний шинэчлэл, шилжилт хийх бодлогын хэрэгжилтийн нөхцөл	28
Хүснэгт 6. Шинжилгээний арга, аргачлал	43
Хүснэгт 7. Эх олонлог ба түүврийн хэмжээ	44
Хүснэгт 8. Экспертийн үнэлгээний оролцогчдын түүврийн хэмжээ	45
Хүснэгт 9. Ганцаарчилсан ярилцлагад урих талуудын төлөөлөл, түүврийн хэмжээ	45
Хүснэгт 10. Фокус бүлгийн ярилцлагад оролцогч бүлэг, түүврийн хэмжээ	45
Хүснэгт 11. Эрчим хүчний үнийн өөрчлөлтийн онцлог, нөхцөл байдал, нөлөөлөл	52
Хүснэгт 12. Эрчим хүчний үнэ тариф тогтоох үе шат, оролцогчдын оролцоог журамласан байдал	62
Хүснэгт 13. Судалгаанд оролцсон байгууллагын хэрэглэгчдийн үйл ажиллагааны чиглэл, салбараар	65
Хүснэгт 14. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх хэрэглэгчдийн санаа бодол (санал нийлэх дүнг хувиар илэрхийлсэн)	67
Хүснэгт 15. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх өрхийн хэрэглэгчдийн санаа бодол, хандлага	69
Хүснэгт 16. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх ААН байгууллагын хэрэглэгчдийн санаа бодол, хандлага	70
Хүснэгт 17. Өрхийн хэрэглэгчдийн цахилгааны үнийн өсөлтийн нөлөө болон өрхийн орлогын түвшний хамаарал	74
Хүснэгт 18. Өрхийн хэрэглэгчдийн цахилгааны үнийн өсөлтийн нөлөө болон өрхийн орон сууцны төрлийн хамаарал	75
Хүснэгт 19. Цахилгааны үнийн өсөлтийн ААН байгууллагын хэрэглэгчдэд үзүүлсэн нөлөө болон байгууллагын орлогын түвшний хамаарал	76

Хүснэгт 20. Цаашдын үнийн өсөлтөд үзүүлэх хариу үйлдэл	83
Хүснэгт 21. Эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах талаарх хэрэглэгчдийн санал бодол	85
Хүснэгт 22. Эрчим хүчний үнийг хэн тогтоодог талаарх хэрэглэгчдийн ойлголт, мэдлэг	88
Хүснэгт 23. Эрчим хүчний үнийг хэн тогтоодог талаарх хэрэглэгчдийн мэдлэгийн өрхийн дундаж орлогын бүлгээр ангилж харуулсан байдал.....	89
Хүснэгт 24. Эрчим хүчний үнийг хэн тогтоодог талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг сууцны төрлөөр ангилж харуулсан байдал.....	90
Хүснэгт 25. Эрчим хүчний үнэ тогтоогч субъектийн талаарх ААН байгууллагын ойлголт мэдлэг, өмчийн хэлбэрээр.....	90
Хүснэгт 26. Та эрчим хүчний үнийг тогтооход нөлөөлж чадах уу?	91
Хүснэгт 27. Эрчим хүчний үнэ тогтооход нөлөөлөх боломжийн талаарх үнэлгээг өрхийн сарын дундаж орлогын бүлгээр ангилсан байдал.....	92
Хүснэгт 28. Эрчим хүчний үнэ тогтооход нөлөөлөх боломжийг үнэлсэн байдлыг ААН байгууллагын өмчийн хэлбэрээр ангилж харуулсан байдал.....	93
Хүснэгт 29. Эрчим хүчний үнийн талаарх хэрэглэгчдийн мэдээлэл авдаг байдал	94
Хүснэгт 30. Эрчим хүчний үнийг өөрчлөхөд хэрэглэгчдийн оролцоог хэрхэн хангах талаар	96
Хүснэгт 31. Судалгаанд оролцсон экспертүүдийн нас, туршлагын байдал...	97
Хүснэгт 32. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт, түүний үр дагаврын талаарх экспертүүдийн санаа бодол	99
Хүснэгт 33. Цахилгаан эрчим хүчний үнэ, тарифын зохицуулалтын талаарх экспертүүдийн үнэлгээ	103
Хүснэгт 34. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрийн нөлөө, хэрэглэгчдийн хариу үйлдлийн талаар өгсөн дүгнэлт	105
Хүснэгт 35. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос ЦЭХ-ний үнэ тогтоох бодлого, аргачлалын талаар өгсөн дүгнэлт.....	107
Хүснэгт 36. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын санал, дүгнэлт	109

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академи нь төрийн захиргаа, төрийн бодлогын судалгаа, эрдэм шинжилгээ, сургалтын төв байгууллага болохынхоо хувьд жил бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, төрийн захиргааны төв байгууллагуудаас захиалга авч суурь болон захиалгат судалгааг хийж ирсэн. Танд тайланг толилуулж буй “Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийн шинжилгээ” хэмээх энэхүү судалгаа нь 2025 оны захиалгат судалгаануудын нэг бөгөөд Удирдлагын академи, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш нар болон Удирдлагын академийн докторантууд баг болон уг судалгааг гүйцэтгэв.

Аливаа улсын эдийн засгийн суурь салбарын нэг тул эрчим хүчний салбарт төрийн оролцоо өндөр, ялангуяа эдийн засгийн өсөлт, бизнесийн тэлэлт, ард иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлдөг тул цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг төрөөс тодорхой хэмжээнд зохицуулах нь элбэг. Хэдийгээр манай улс зах зээлийн эдийн засагт шилжээд багагүй хугацаа өнгөрсөн боловч цахилгаан эрчим хүчний салбарыг либералчилж чадаагүй, хэрэглэгчдийн төлдөг үнэ нь үйлдвэрлэлийн өртгийг нөхөж чаддаггүй нь эрчим хүчний салбарын хөгжлийг боомилох гол хүчин зүйл болсон. Цахилгааны тарифын өсөлт нь хэрэглэгч өрхүүдийн амьжиргаа, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардалд нөлөөлж, улмаар бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг өдөөдөг тул иргэдийн эсэргүүцэлтэй тулгардаг, “улс төржих” сэжим болдог эмзэг асуудал билээ. Энэ ч үүднээс эрчим хүчний салбарт үнэ тарифыг тодорхойлоход оролцогч талуудын сонирхол, оролцоог анхаарч үзэх шаардлагатай. Манай энэ удаагийн судалгаанд эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудыг хамруулан улс төрийн эдийн засгийн хандлагаар судалж, тэдний сонирхол, байр суурь, үнийн бодлого дахь эрх мэдэл, нөлөөллийг тодорхойлсон. Мөн цахилгааны тарифын 2024 оны өөрчлөлтийг кейс болгон авч хэрэглэгчдийн үзүүлж буй хариу үйлдэл, зан үйлд гарч буй өөрчлөлтийг тодруулахыг хичээсэн нь цаашид эрчим хүчний салбарын үнэ тарифын бодлогыг үр дүнтэй тодорхойлж хэрэгжүүлэхэд тус дөхөм болох биз ээ.

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд бүх талын дэмжлэг үзүүлсэн Удирдлагын академийн захиргаа, Эрдмийн зөвлөл, Судалгаа, эрдэм шинжилгээний албаны ажилтнууд, эрдэмтэн багш, судлаачид, судалгааны мэдээллийг цуглуулах, нэгтгэхэд гүн туслалцаа үзүүлсэн, судалгаанд идэвхтэй оролцож

санал бодлоо илэрхийлсэн Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлага, хамт олон, тус байгууллагын үе үеийн дарга, зохицуулагчдын төлөөлөл, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн удирдлага, хамт олон, эрчим хүч хэрэглэгчдийн төлөөлөл, эрчим хүчний салбарын төрийн бус байгууллагууд, тус салбарын мэргэжилтэн, судлаачид, инженер, техникийн ажилтнууддаа судалгааны багийнхныхаа нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн угаас талархал илэрхийлье.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зангилаа асуудлын нэг эрчим хүчний үнэ тарифын бодлогын талаарх судалгааг хийхэд үнэт цаг, мэдлэг, туршлагаа зориулж хамтран ажилласан судалгааны багийн зөвлөх, гишүүд, хамтран зүтгэгчдэдээ гүн талархал илэрхийлж цаашдын эрдмийн ажилд нь амжилт хүсье.

Уншигч Та бүхэн энэхүү судалгаатай холбоотой санал бодлоо Удирдлагын академийн Судалгаа, эрдэм шинжилгээний албаны researchcenter@naog.gov.mn цахим хаягт ирүүлнэ үү.

Судалгааны удирдагч, доктор, профессор
Батболдын Баясгалан

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1. Судалгааны асуудал

Улс орны эдийн засгийн чадавхыг тодорхойлж, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, улс төрийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг гол салбар нь эрчим хүчний салбар байсаар ирсэн. Эрчим хүч нь экспортын орлого оруулах боломжтойгоос гадна хүний амьдралын бүхий л хэрэгцээг хангахад дэмжлэг болж, бусад салбарууд тухайлбал, хөнгөн болон хүнд аж үйлдвэрлэл, тээвэр, харилцаа холбоо, худалдаа, үйлчилгээний салбарын хөгжилд чухал нөлөөтэй. Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA)-ийн тайланд дурдсанаар, 2024 онд дэлхийн эрчим хүчний нийт эрэлт 650 эксажоуль (EJ)¹ болж өссөн нь өмнөх онтой харьцуулахад 2.2 хувиар нэмэгдсэн байна. Ялангуяа цахилгаан эрчим хүч (ЦЭХ)-ний нийт хэрэглээ 4.3 хувиар өссөн нь эрчим хүчний нийт өсөлтөд ихээхэн нөлөөлсөн байна. Тайланд дурдсанаар, 2024 онд дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний 38 хувийг сэргээгдэх эрчим хүч (СЭХ), 28 хувийг байгалийн хий, 15 хувийг нүүрс, 11 хувийг газрын тос болон 8 хувийг цөмийн эрчим хүчний эх үүсвэрээс гарган авчээ. Харин цахилгаан эрчим хүчний 35 хувийг нүүрс, 32 хувийг сэргээгдэх эрчим хүч, 22 хувийг байгалийн хий, 9 хувийг цөмийн эрчим хүчний эх үүсвэрээс тус тус үйлдвэрлэжээ. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд эрчим хүчний эрэлт тогтмол өсөж, цаашид ч эрэлтийн өсөлт хадгалагдахын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн нийт нийлүүлэлтэд эзлэх хувийн жин нь нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна (International Energy Agency, 2024).

Манай улсын хувьд 2024 онд нийт 11.6 тэрбум киловатт-цаг (кВт.ц) цахилгаан эрчим хүчийг хэрэглэсний 75.4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 24.6 хувийг импортоор хангасан (Эрчим Хүчний Зохицуулах Хороо, 2025) ба импортын цахилгаан эрчим хүчинд 197,839.98 ам.доллар төлжээ (Үндэсний статистикийн хороо (ҮСХ), 2025). Нийт 19 дулааны, нарны болон салхин цахилгаан станц ажиллаж байгаа ч Дулааны цахилгаан станц-4 (ДЦС-4) нь дангаараа нийт цахилгаан эрчим хүчний 62.9 хувийг нийлүүлдэг байна (Эрчим Хүчний Зохицуулах Хороо, 2024). Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийн 90.6 хувийг нүүрс, 8.3 хувийг нар, салхи, 0.8 хувийг усан цахилгаан станц, 0.001 хувийг дизель станцаар үйлдвэрлэжээ (Эрчим Хүчний Зохицуулах Хороо, 2025). Нийт 8,754.7 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсний 62.1 хувийг уул уурхай, үйлдвэрлэлийн салбар, 24 хувийг өрх,

¹ 650 EJ нь 180.5 их наяд кВт.ц -тай тэнцэнэ

орон сууц, нийтийн аж ахуй, 4.2 хувийг тээвэр, холбоо, 1.1 хувийг хөдөө аж ахуй, 8.7 хувийг бусад салбар ашиглажээ (ҮСХ, 2025).

Эрчим хүчний эрэлт, хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж буй нь 2015-2024 онд эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 7 хувь өссөнөөс харагдана (ҮСХ, 2025). Энэхүү өсөн нэмэгдэж буй хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж чадахгүй байгаа нь эрчим хүчний салбарын эх үүсвэрийн дутагдал ба алдагдалтай ажилладагтай холбоотой. Тус салбарын нийлүүлэлтийн дутагдал, эдийн засгийн алдагдал өндөр байхад нөлөөлсөн гол хүчин зүйл нь эрчим хүчний үнэ тарифыг өсгөхгүй, тогтвортой барьж ирсэн явдал буюу төрийн өндөр зохицуулалттай эрчим хүчний салбарын хүндрэлийн гол шалтгаан нь үнэ тарифын асуудал. Сүүлийн жилүүдэд цахилгаан эрчим хүчний бодит өртөг дунджаар 1 кВт.ц тутамд 280 төгрөг байхад 2019-2024 онуудад мөрдсөн тарифаар айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны дундаж тариф 216 төгрөг, үүнээс айл өрхөд дунджаар 140 төгрөгөөр буюу эрчим хүчний бодит өртгөөс даруй 2 дахин бага тарифаар тооцон эрчим хүч түгээж ирсэн. Үүний улмаас нүүрсний уурхай, эрчим хүчний нүүрсний төмөр замын тээвэр болон эрчим хүчний салбар нийтдээ жилд 355 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, хуримтлагдсан богино хугацаат өр төлбөр 357 тэрбум төгрөгт хүрч, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрчээ (Эрчим Хүчний Зохицуулах Хороо, 2024).

Иймд Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ)-оос цахилгааны тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг халаалтын улирал дууссаны дараа буюу 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс өртөгт нь хүргэж нэмэх шийдвэр гаргаж, тарифын шинэчлэлийг хэрэгжүүлсэн. Тарифын шинэчлэл хийхдээ айл өрхийн эрчим хүчний төлбөрийн өсөлтийг аль болох бага байлгахаар тооцож, сарын эхний 150 кВт.ц-аас бага хэрэглээг 175 төгрөг, дараагийн 150-300 кВт.ц-ийн хоорондын хэрэглээг 256 төгрөгөөр, 300 кВт.ц-аас илүү гарсан хэрэглээний нэг кВт.ц-ийн төлбөр нь 285 төгрөг байхаар хэрэглэгчийн тарифыг өсгөв.

Хэдийгээр ЭХЗХ нь цахилгаан, дулааны үнэ тарифыг "... бие даан тогтоож, хараат бусаар хэрэгжүүлэх зохицуулалтын байгууллага" (Засгийн газар, 2016) боловч цахилгаан, дулааны үнэ тарифыг нэмэх нь ард иргэд, бизнес эрхлэгчид, улс төрчдийн хүчтэй эсэргүүцэлтэй тулдаг. Монгол Улсын эрчим хүчний зах зээлд мөрдөгдөж байгаа "Нэг худалдан авагчийн загвар"-ын дагуу эрэлт, нийлүүлэлтийг нь зохицуулдаг тул зах зээлийн зарчмаар үнэ тогтоох боломжгүй, үнийн бодлогод төр хүчтэй оролцоотой байна. 2024 оны 11 дүгээр сард цахилгаан, дулааны тарифыг эрчим хүчний үйлдвэрлэлийн өртгийг нөхөх хэмжээнд л өсгөсөн ч, уг нөхцөл байдал иргэдийн бухимдал, эсэргүүцэлтэй тулгарсан нь 2024 оны 11 болон 2025 оны 1 дүгээр сард болсон

иргэдийн жагсаал, энэ хугацаанд ЭХЗХ-нд болон Засгийн газрын 11-11 төвд ирсэн гомдол, түүнд Засгийн газраас хийсэн хариу үйлдлээс харагдана. Түүнчлэн, холбогдох хууль тогтоомжоор салбарын зохицуулагч байгууллагаас эрчим хүчний үнэ тарифыг хараат бусаар тогтоох эрх мэдэлтэй боловч хамгийн сүүлийн тохиолдолд дулааны эрчим хүчний үнэ нэмсэн шийдвэрийн хэрэгжилтийг хойшлуулах шийдвэрийг Засгийн газраас гаргаад байна. Нөгөө талаас эрчим хүчний компаниудын зардлын өсөлт нь үнэ тарифыг тогтоох суурь болдог тул үйлдвэрлэгчдийн зүгээс эрчим хүчний үнэ тарифыг өсгөхийг тууштай шаардаж байна. Энэ мэтчилэн эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт оролцогч талууд нь харилцан адилгүй сонирхол, эрх мэдэлтэй, тэдний зүгээс шийдвэр гаргагч субъектэд үзүүлэх нөлөө ч харилцан адилгүй үр дагавартай байдаг нь энэ салбарын тогтвортой байдлыг хангах, өсөлтийг дэмжих гол хүчин зүйл болох эрчим хүчний “үнэ”, түүнийг тойрсон асуудлыг нухацтайгаар судалж үзэх хэрэгцээг үүсгэж байгаа юм.

Эрчим хүчний салбар нь эдийн засгийн хөгжил, нийгмийн болон улс төрийн тогтвортой байдалд нөлөө үзүүлдэг, улс төржилт ихтэй эмзэг салбар тул уг салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг тооцох, үнэ тарифыг тодорхойлоход оролцогч талуудын сонирхол, оролцоог анхаарч үзэх хэрэгтэй байдаг. Гэхдээ улс төрийн эдийн засаг талаасаа эдгээр оролцогч талуудыг хамарсан судалгаа, дүн шинжилгээ дутмаг байгаа нь цаашид эрчим хүчний салбарын үнэ тарифын бодлогыг үр дүнтэй тодорхойлж хэрэгжүүлэхэд эрсдэл учруулж болзошгүй юм.

1.2. Судалгааны асуулт

Цахилгаан эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлыг судлахдаа дараах асуултын хүрээнд судална. Үүнд:

1. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлогод оролцогч талуудын сонирхлын онцлог юу вэ?
2. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт оролцогч талуудын эрх мэдэл ямар түвшинд байна вэ?
3. Оролцогч талууд цахилгаан эрчим хүчний үнийн бодлого, шийдвэрт нөлөөлж чаддаг уу?
4. 2024 оны цахилгаан эрчим хүчний үнийн өөрчлөлтөд хэрэглэгчдийн ялгаатай бүлгүүд ямар хариу үйлдэл үзүүлж байна вэ?

1.3. Судалгааны зорилго

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлого, шийдвэрт оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг тодорхойлж, үнэ тарифын өөрчлөлтийн хэрэглэгчийн ялгаатай бүлгүүдэд үзүүлж буй нөлөө, тэдний хариу үйлдлийн онцлогийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршино.

1.4. Судалгааны зорилт

Судалгааны зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

1. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлого, шийдвэрт оролцогч талуудын сонирхол, байр суурийн онцлогийг тодорхойлох.
2. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийг тодорхойлох.
3. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт хэрэглэгчдийн үзүүлэх хариу үйлдлийг судлах.
4. Цаашид эрчим хүчний үнэ тарифын бодлого, шийдвэрийн талаар оролцогч талуудтай харилцахад анхаарах асуудлуудыг тодруулан зөвлөмж боловсруулна.

1.5. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэр гаргах тогтолцоо, түүнд оролцогч талуудын эрх мэдэл, сонирхол, нөлөөллийг тодорхойлоход чиглэгдсэн. ЭХЗХ-оос цахилгааны тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өртөгт нь хүргэж нэмэх тарифын шинэчлэлийг хэрэгжүүлсэн нь оролцогч талуудад ямар нөлөө үзүүлсэн, тэд үнэ тарифын шийдвэрт хэрхэн хариу үзүүлсэн, ерөнхийдөө оролцогч талууд цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт хэрхэн нөлөөлдгийг энэхүү судалгаагаар тодорхойлсон. Монгол Улсын Эрчим хүчний тухай хуульд зааснаар “эрчим хүч гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хий”-г ойлгохоор заасан ба энэхүү судалгааны хүрээнд зөвхөн *цахилгаан эрчим хүчний үнэ тарифт хамаарах асуудлыг* судлахаар хязгаарлаж байна. Түүнчлэн газар зүйн хувьд, Улаанбаатар хот болон төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид (айл өрхийн болон аж ахуйн нэгж)-ийг хамрах бөгөөд судалгаанд салбарын голлох мэргэжилтэн, зохицуулагч, үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч компаниуд, судлаач зэрэг гол оролцогч талуудыг хамруулсан.

1.6. Судалгааны ач холбогдол

Энэхүү судалгаагаар цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг тодорхойлсон нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. *Шийдвэр гаргагч нарт дэмжлэг үзүүлэх:* Судалгааны үр дүнд үндэслэн эрчим хүчний үнэ тарифын бодлого, шийдвэрийг илүү үр ашигтай, шударга, ил тод болгоход шаардлагатай мэдээлэл, зөвлөмжийг боловсруулах;
2. *Оролцогч талуудын харилцааг сайжруулах:* Гол оролцогч талуудын хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар салбарын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах;
3. *Эрчим хүчний салбарын тогтвортой, ил тод байдлыг нэмэгдүүлэх:* Үнэ тарифын шийдвэрт оролцогч талуудын сонирхол, байр суурийн ялгаа, эрх мэдэл, нөлөөллийг тодорхойлсноор цаашид тэдний эгэх хариуцлагыг дээшлүүлэх шийдлийг санал болгох, улмаар олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг бүрдүүлэх;
4. *Цаашдын судалгаа, шинжилгээний суурь болох:* Эрчим хүчний салбарын бодлого, түүний дотор үнэ тарифын бодлого, зохицуулалтын талаарх цаашдын судалгаа, шинжилгээний ажлын суурь мэдээлэл, баримт болно.

1.7. Нэр томъёоны тодорхойлолт

- “айл өрх (өрх)” ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг (Үндэсний статистикийн хороо, 2017) хэлнэ. Энэхүү судалгаанд цахилгааны хэрэглэгчийн нэг кодтой айл өрх (өрх)-ийг “өрхийн хэрэглэгч” гэж тодорхойлж хэрэглэсэн.
- “дамжуулагч” гэж Эрчим хүчний тухай хуулийн 14.1-д заасны дагуу цахилгаан, дулаан дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийг хэлнэ (Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, 2007).
- “засаглал” гэдэг нь төрийн удирдлагатай салшгүй холбоотой бөгөөд засаглалын үзэл баримтлал нь олон түмний эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг зөвхөн төрийн байгууллагаар шийдвэрлэх боломжгүй гэж үздэг бөгөөд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог чухалчилдаг (Монгол дахь Конрад Аденауэрын Сан, 2024).
- “ил тод байдал” гэж төрийн байгууллага болон шийдвэр гаргагчид бодлого шийдвэр, төсөв санхүү болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар цаг тухайд нь олон нийтэд хүргэх орчин юм (OECD, 2001).



- “нөлөөлөл” (*influence*) гэж шийдвэрт өөрчлөлт оруулах эсвэл нөлөөлөх зорилготойгоор гаргаж байгаа аливаа зан үйл, үзэл бодлын илэрхийлэл. Монгол хэлний их тайлбар тольд тодорхойлсноор бусдын санаа бодлыг хувиргах чадалтай, нөлөө үзүүлэх үйлийн үр дүн гэж тодорхойлсон. Энэ судалгаанд оролцогч талууд ЭХЗХ-оос гаргаж байгаа үнэ тарифын тооцоолол, шийдвэрийг өөрчлөх, хувиргах чадал, нөлөөг нөлөөлөл гэж тодорхойлж хэрэглэсэн.
- “нэг худалдан авагчийн загвар (*Single buyer model*)” гэж эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн бүх урсгалыг нэг байгууллага төвлөрүүлэн эрчим хүчийг худалдан авч, түгээх компаниудад нийлүүлэх тогтолцоо (Азийн хөгжлийн банк, 2020).
- “оролцогч тал” гэж ямар нэгэн шийдвэр, үйл ажиллагаанд нөлөөлж буй эсвэл нөлөөлөлд өртөж буй этгээдүүд юм (Freeman, 1984). Түүнчлэн оролцогч талууд гэдэг нь бодлогын шийдвэр гаргахад оролцож байгаа болон түүний үр дүн нь тусах хүмүүс эсвэл сонирхлын бүлгүүдийг хэлнэ (Монгол дахь Конрад Аденауэрын Сан, 2024).
- “оролцоо” гэж оролцох үйлийн нэр (Цэвэл, 1966), ямарваа нэгэн зүйлд оролцох буюу холбогдох үйл явдал, төлөв байдал (Cambridge dictionary, n.d.) бөгөөд энэ судалгаанд эрчим хүчний үнэ тарифын шийдвэр гаргахад оролцох оролцоо, төлөв байдлыг судалсан.
- “сонирхол” гэж сонирхох үйлийн нэр (Цэвэл, 1966), тодорхой асуудалд анхаарал хандуулах, оролцох, илүү ихийг судлах хүсэлтэй байх хандлага (Cambridge dictionary, n.d.). Энэ судалгаанд цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг өсгөх эсвэл бууруулах, тогтвортой байлгах талаар анхаарал хандуулах, оролцох, нөлөөлөх хүсэл, хандлагыг сонирхол гэж тодорхойлж хэрэглэсэн.
- “сэргээгдэх эрчим хүч” гэж нар, салхи, ус, геотермаль болон бусад сэргээгдэх эх үүсвэрээс гарган авсан эрчим хүч (Азийн хөгжлийн банк, 2021).
- “тариф” гэж үйлдвэрлэгчийн үнэ, дэмжих тариф, диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ, хэрэглэгчийн эрчим хүчний үнэ, эсхүл эдгээрийн аль нэгийг багтаан Эрчим хүчний зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнийг (Эрчим хүчний тухай хууль, 2011) хэлнэ. Эрчим хүчний тухай хуулийн зарим нэр томъёонд тайлбар хийсэн Улсын дээд шүүхийн 2006 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 26 дугаар тогтоолд “Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэгчийн үнэ, диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах

үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ” зэргийг Эрчим хүчний зохицуулах газраас баталж, нийтлээгүй бол “үнэ” гэсэн ойлголтоор, харин уг газраас тус тусад нь буюу эдгээрийн аль нэгийг багтаан баталж, эрчим хүчний хэрэглэгчдэд мөрдүүлэхээр нийтэлж, нийтийн хүртээл болгосон бол “тариф” гэсэн ойлголтоор тус тус хэрэглэгдэнэ” гэж тайлбар гаргасан байна. Иймд энэ судалгаанд “цахилгаан эрчим хүчний үнэ” гэдэгт Эрчим хүчний тухай хуульд тусгагдсан “тариф” гэдэг тодорхойлолтод хамаарах ойлголтыг буюу Эрчим хүчний зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнийг хамруулж судалсан бөгөөд “үнэ тариф” гэсэн хоршоо үгээр илэрхийлж хэрэглэсэн.

- “тарифын шинэчлэл” гэж эрчим хүчний өртөгт суурилсан үнэ тогтоох, татаасыг бууруулах, хэрэглээний ангиллыг шинэчлэх зорилготой бодлогын өөрчлөлт (Азийн хөгжлийн банк, 2020).
- “улс төрийн эдийн засаг” гэж улс төр ба эдийн засгийн хоорондын харилцан хамаарал, нөлөөллийг судалдаг нийгмийн шинжлэх ухаан юм (Victor, D. G., & Heller, T. C. (Eds.), 2007).
- “үйлдвэрлэгч” гэж Эрчим хүчний тухай хуулийн 13.1-д заасны дагуу цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийг хэлнэ (Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, 2007).
- “хариу үйлдэл” гэж ямарваа нэгэн өдөөлт, бодлогын өөрчлөлт эсвэл үйл явдлын хариуд тодорхой арга хэмжээ авах үйл явцыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тухайн үйл явдлын эсрэг болон түүнээс гарах үр дагаврыг даван туулах, засах зорилготой арга хэмжээ, үйлдэл юм (UNISDR, 2015). Энэ судалгаанд цахилгаан эрчим хүчний үнэ өөрчлөгдөх үйл явдлын хариуд хэрэглэгчийн зүгээс ямар тодорхой арга хэмжээ авч байгааг судлахаар энэ нэр томъёог ашигласан.
- “хэрэглэгч” гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.13-т заасан иргэн, хуулийн этгээдийг (Орон сууцны тухай хууль, 1999) хэлнэ. Энэ судалгаанд хэрэглэгчийг “өрхийн хэрэглэгч” буюу “хэрэглэгч-өрх”, “хэрэглэгч-ААН” гэж хоёр ангилж үзсэн. ЭХЗХ-оос үнэ тарифыг батлахдаа “үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф” ба “айл өрхөд борлуулах цахилгааны тариф”² гэсэн ангиллаар баталдгийг харгалзан энэхүү судалгаанд хэрэглэгчийг өмнө дурдсанаар ангилсан.
- “цахилгаан дамжуулах сүлжээ” гэж нэгдсэн сүлжээ үүсгэж байгаа цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кВ, түүнээс дээш хүчдэлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад

² <https://erc.gov.mn/mn/tariff-center-ийг-үзнэ-үү>.



хүчдэлийн шугам, дэд станц (Эрчим хүчний тухай хууль, 2011) юм.

- “цахилгаан түгээх сүлжээ” гэж эх үүсвэрээс шууд холбогдсон болон цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх цахилгаан түгээх зориулалт бүхий 110 кВ, түүнээс доош хүчдэлийн шугам, дэд станц (Эрчим хүчний тухай хууль, 2011) юм.
- “эрчим хүч” гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг (Эрчим хүчний тухай хууль, 2011). Энэ судалгаанд зөвхөн *цахилгаан* эрчим хүчний үнэ тарифын асуудлыг судалсан.
- “эрх мэдэл” гэдэг нь англи хэлэнд *authority* болон *power* хэмээх хоёр өөр ойлголтоор илэрхийлэгддэг. *Authority* нь төрийн захиргааны байгууллага, хуулиар олгогдсон бүрэн эрхт албан тушаалтнаар дамжин хэрэгжих хууль ёсны эрх мэдэл юм. Харин *power* нь хэн нэгэн хүн бусдын үйлдэлд хяналт тавих, нөлөөлөх чадвар юм (Монгол дахь Конрад Аденауэрын Сан, 2024). Энэхүү судалгаанд хууль ёсны эрхээс гадна хууль, эрх зүйн актад тусгагдаагүй ч эрчим хүчний үнэ тарифыг тогтоох, өөрчлөхөд нөлөөлж байгаа байдал буюу уг асуудлыг гүйцэлдүүлэх нөлөөллийг авч судаллаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

2.1. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлогын оролцогч талууд, онцлог

2.1.1. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний салбарын бүтэц, онцлог

Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдлыг хадгалах, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад шууд нөлөөтэй эдийн засгийн суурь салбар юм. Эрчим хүчний зах зээл нь сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа хэдий ч, эдийн засгийн бусад салбарын эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангахуйц хэмжээнд үйлдвэрлэлээ өсгөж чадахгүй, эх үүсвэрийн дутагдалтай нөхцөлд байна. Цахилгаан эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 4.6 хувиар өссөн байхад сүүлийн хоёр жилд импортоор авсан эрчим хүчний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 13-17 хувиар өссөн үзүүлэлттэй байна (хүснэгтээр харуулав).

Хүснэгт 1. Цахилгаан эрчим хүчний нийт үйлдвэрлэл (сая кВт.цаг), 2020-2024 онуудад

Эх үүсвэр	2020		2021		2022		2023		2024	
	Тоо хэмжээ	Эзлэх хувь	Тоо хэмжээ	Эзлэх хувь	Тоо хэмжээ	Эзлэх хувь	Тоо хэмжээ	Эзлэх хувь	Тоо хэмжээ	Эзлэх хувь
Дулааны цахилгаан станц	6,493.6	91%	7,109.6	90%	7,428.5	91%	7,755.2	91%	7,930.6	91%
Дизель цахилгаан станц	2.7	0.04%	1.1	0.01%	1.2	0.01%	0.5	0.01%	0.1	0.00
Нарны эх үүсгүүр	108.9	2%	156.9	2%	178.7	2%	193.0	2%	232.3	3%
Усан цахилгаан станц	83.3	1%	83.1	1%	61.7	1%	48.1	1%	74.1	1%
Салхин цахилгаан станц	457.2	6%	563.0	7%	508.5	6%	531.5	6%	517.5	6%
Нийт үйлдвэрлэл	7,145.7	2.0%	7,913.6	10.7%	8,178.6	3.3%	8,528.3	4.3%	8,754.7	2.7%
Импорт	1,705.6	-0.6%	1,861.9	9.2%	2,161.5	16.1%	2,447.6	13.2%	2,863.3	17%

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо (2025),
“Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2024”-д үндэслэн боловсруулав.

Түүнчлэн эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтцийг авч үзвэл 90 гаруй хувийг дулааны цахилгаан станцын үйлдвэрлэлээр хангаж байгаа бол сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр 10 хүрэхгүй хувийг эзэлж байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжиж, тусгай зөвшөөрөл олгон нэгдсэн сүлжээнд худалдан авах үнэ тарифыг өндөр тогтоож дэмжиж ирсэн боловч бодит байдалд зах зээлд нийлүүлсэн эрчим хүчний хэмжээнд дорвитой өөрчлөлт ороогүй байна.

Зах зээлийн эрэлт талаас нь авч үзвэл хэрэглээний бүтцэд мөн төдийлөн өөрчлөлт ороогүй байна. 2024 оны жилийн эцсийн мэдээллээр цахилгаан эрчим хүчний хэрэглээний 68.9 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглээ эзэлж байгаа бол, 11.5 хувийг орон сууц (хүснэгт 2-т ОС гэж тэмдэглэв)-ны, 19.6 хувийг гэр хороолол (хүснэгт 2-т ГХ гэж тэмдэглэв)-ын айл өрхийн хэрэглээ эзэлж байна. Харин хэрэглээний 88.8 хувийг Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн хэрэглээ эзэлж байгаа бол баруун бүсийн хэрэглэгчдийнх 2.9 хувийг, зүүн бүсийн нэгдсэн сүлжээний хэрэглэгчдийнх 3.8 хувийг, Алтай-Улиастайн нэгдсэн сүлжээний хэрэглэгчдийн хэрэглээ 1.3 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, эзлэх хувь, 2020-2024 онуудад

Нэр	Ангилал	2020	2021	2022	2023	2024	
ТБНС	ААНБ	3594.1	3951.4	4303.3	4712.5	4939.8	
	ОС	613.7	723.5	746.2	789.3	854.6	
	ГХ	895.1	1179.4	1145.2	1163.7	1300.8	
	Нийт	5102.9	5854.3	6194.7	6665.5	7095.2	88.8%
ББНС	ААНБ	63.5	71.9	83.4	103.4	106.1	
	ОС	14.4	18.2	18.3	19.6	21.9	
	ГХ	59.3	75.6	78.4	81.8	96.2	
	Нийт	137.2	165.7	180.1	204.8	224.2	2.8%
ЗБНС	ААНБ	199.5	211.9	204.2	216.1	230.9	
	ОС	14.5	17.9	18.8	19.5	20.5	
	ГХ	30.7	42.6	40.3	43.2	53.3	
	Нийт	244.7	272.4	263.3	278.8	304.7	3.8%
АУНС	ААНБ	28.3	34.4	40.4	35.7	44.9	
	ОС	6.1	7.7	14.6	12.1	12.1	
	ГХ	25.3	34.3	33.1	48.5	50.5	
	Нийт	59.7	76.4	88.1	96.3	107.5	1.3%
ӨБЦТС	ААНБ	71.8	59	69.4	143.2	178.9	
	ОС	30.6	6.2	5.6	6.6	7.6	
	ГХ	26.1	38.8	35.6	46.5	66.1	
	Нийт	128.5	104	110.6	196.3	252.6	3.2%
Салбарын дүн	ААНБ	3957.2	4328.7	4700.8	5210.9	5510.6	68.9%
	ОС	679.3	773.4	803.5	847.1	916.8	11.5%
	ГХ	1036.5	1370.7	1332.5	1383.8	1566.9	19.6%
	Нийт	5673	6472.8	6836.8	7441.8	7994.3	100%

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо (2025), "Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2024"-д үндэслэн боловсруулав.

Цахилгаан болон дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн тоо жилд 2-7 хувиар өсөж, нийт хэрэглэгчдийн 84 орчим хувийг төвийн бүсийн хэрэглэгч эзэлж байгаа бол 6 хувийг баруун бүсийн, 4 хувийг зүүн бүсийн, 3 хувийг Алтай-Улиастайн, 3 орчим хувийг өмнөд бүсийн хэрэглэгчид тус тус эзэлж байна.

Хүснэгт 3. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн тооны өсөлт, 2020-2024 онуудад

Нэр	2020	2021	2022	2023	2024	
					Тоо	Эзлэх хувь
ТБНС	617,092	635,684	685,055	733,747	743,111	83.7%
ББНС	47,705	45,743	47,844	52,592	56,313	6.3%
ДБЭХС	31,597	28,235	33,272	34,419	35,182	4%
ӨБЭХС	17,867	18,904	21,024	22,952	24,854	2.8%
АУЭХС	23,136	23,639	24,915	27,379	28,720	3.2%
Нийт	737,397	752,205	812,110	871,089	888,180	100%
Хэрэглэгчийн тооны өсөлт		2%	8%	7%	2%	

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо (2025), “Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2024”-д үндэслэн боловсруулав.

Ийнхүү эрчим хүчний зах зээл нь эрэлт, нийлүүлэлтийн аль ч талаас өсөлттэй байгаа хэдий ч, хэрэглээний өсөлтийг хангахуйц, бусад салбарын өсөлтийг дэмжихүйц хэмжээнд үйлдвэрлэлийг өсгөх техник, эдийн засгийн боломжгүй, хүндрэлтэй нөхцөл үүссэн.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдийн дунджаар 7-8 хувиар өсөж байхад дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ дунджаар 6-7 хувийн өсөлттэй байна. Эрчим хүчний салбарын хэмжээнд сүүлийн жилүүдэд өвлийн их ачааллын үед суурилагдсан бүрэн хүчин чадлаараа, нөөц тоноглолгүй аваарын горимд, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Том чадлын шинэ эх үүсвэр барьж ашиглалтад оруулахгүй бол эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангаж чадахгүй, эрчим хүчний хангамжийн хязгаарлалтаас өөр сонголтгүй, хүндрэлтэй нөхцөл байдал үүсжээ (Эрчим хүчний зохицуулах хороо, 2024).

Дээр дурдсан хүндрэлтэй нөхцөлийн үндсэн шалтгаан нь “эрчим хүчний үнэ тарифын бодлогын доголдол” болохыг тухайн салбарын бодлого тодорхойлогч гол субъектүүд тодорхой тоо баримтаар нотолж мэдээлсээр ирсэн байна. Цахилгаан эрчим хүчний бодит өртөг 1 киловатт.цаг тутамд 280 төгрөг бөгөөд 2024 оны сүүлээр хийсэн тарифын өөрчлөлтөөс өмнө айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгаан эрчим хүчний дундаж тариф 216 төгрөг, үүнээс айл өрхөд мөрдөх тариф дунджаар 140 төгрөг буюу бодит өртгөөс 2 дахин доогуур байсан. Дулааны эрчим хүчний өртөг нь 1 гигакалори тутамд

63 мянган төгрөг ба Улаанбаатар хотын хэрэглэгчдэд дунджаар 33.8 мянган төгрөгөөр борлуулж байна. Тухайлбал, орон сууцны айл өрхийн халаалтын тариф 1 метр квадрат тутамд 506 төгрөг байна. Гэтэл энэ нь орон нутаг дахь аймгийн төвүүдэд 800-1024 төгрөг байна. Ийнхүү эрчим хүчний үнэ тариф бодит өртгөөс хэт доогуур байгаагаас үүдэн нүүрсний уурхай, нүүрсний төмөр замын тээвэр болон эрчим хүчний салбар 2024 оны байдлаар жилд 355 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, хуримтлагдсан богино хугацаат өр төлбөр 357 тэрбум төгрөгт хүрсний улмаас үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж эхэлсэн (Эрчим хүчний зохицуулах хороо, 2024).

Эрчим хүчний үнэ тарифыг бага байлгах нь улс төрийн ба нийгмийн бодлогын ач холбогдолтой гэж үзвэл нөгөө талд нь салбарыг дэмжих улсын төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ёстой. Гэтэл эрчим хүчний салбарын хүндрэлтэй байдлыг шийдвэрлэхэд улсын төсвөөс зарцуулах зардлын хэмжээ ч бага байна. Эрчим хүчний сайдын багцын төсвийн зарлагын улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь 2023 онд 0.8 хувь, ДНБ-д эзлэх хувь 0.3 хувь байгаа нь бусад COFOG³ ангиллаар зардлаа тооцдог улс орнуудтай харьцуулахад бага үзүүлэлттэй байна. Олон улсын дунджийг харвал салбарын ДНБ-д эзлэх хувь 1.2 хувь, нийт улсын төсвийн зардалд эзлэх хувь 2.6 байна. Энэ нь Монгол Улсын эрчим хүчний сайдын төсөв хангалтгүй байгааг илтгэж байна (НҮБХХ: Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл, 2024). Ийнхүү нэг талаас эрчим хүчний салбар нь орлогоороо зарлагаа нөхөх боломжгүй, нөгөө талаас төрөөс уг салбарт үзүүлэх дэмжлэг, улсын төсвийн санхүүжилтийн хэмжээ хязгаарлагдмал байгаа нөхцөл нь салбарын эдийн засгийн хүндрэлийг нөхцөлдүүлж байна. Монгол Улс нь эрчим хүчний түүхий эд баялаг, арвинтай ч хөрөнгө санхүү, технологи, дэд бүтэц, хүний нөөцийн хувьд сул талтай салбар болохыг судлаачид дүгнэж, (Мягмарсүрэн.Д, 2017, хууд. 138) энэ сул талаа нөхөх зорилгоор өнгөрсөн хугацаанд салбарт гадаадын хөрөнгө оруулалт татах, технологийн шинэчлэл хийх бодлогыг төрөөс хэрэгжүүлж ирсэн ч хангалттай хэмжээнд биш байгааг салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд харуулж байна.

Салбарын тулгамдсан асуудлын үндсэн шалтгаан болсон үнэ тарифын бодлого, түүний онцлог, оролцогч талуудын чиг үүргийн хуваарилалтыг авч үзье.

³ COFOG (Classification of the Functions of Government) буюу Төрийн чиг үүргийн ангилал нь засгийн газрын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх чиг үүргийг ангилах олон улсын стандарт юм. Энэхүү ангиллыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн Хорооноос анх боловсруулан 1999 оны 3 сард баталсан бөгөөд гол зорилго нь Засгийн газрын төсвийн зардлыг үйл ажиллагааны төрлөөр нь тодорхойлон ангилахад чиглэдэг. COFOG ангиллыг Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ), Олон Улсын Валютын Сан (ОУВС), Дэлхийн банк, Европын Холбооны болон ЭЗХАХБ-ийн гишүүн орнууд ашигладаг. (<https://unstats.un.org/unsd/classifications/cofog/revision>)

2.1.2. Эрчим хүчний үнэ тарифын бодлого, бодлогод оролцогч талууд

Эрчим хүчний бодлого гэдэг нь тодорхой субъектээс (гол төлөв төр) эрчим хүчийг үйлдвэрлэх, хуваарилах, хэрэглэх зэргийг багтаасан эрчим хүчний салбарын хөгжлийг хангахад чиглэсэн бодлого үйл явц буюу салбарын хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох бодлого юм (Мягмарсүрэн.Д, 2017, хууд. 3). Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар мөн болохыг төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогод хүлээн зөвшөөрч тодорхойлж ирсэн. Эрчим хүчний бодлого нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа, эрчим хүчний тоног төхөөрөмжийн ашиглалт, стандартын бодлого, эрчим хүчний аюулгүй байдал, нөөц ашиглалт, эрчим хүчний бүтээгдэхүүн үйлчилгээний татвар, хөнгөлөлт, татаасын бодлого зэрэг олон асуудлыг хөндөх бөгөөд нэг томоохон хэсэг нь үнэ тарифын бодлого байдаг. Эрчим хүчний үнэ тарифын бодлогын онцлог, бодлого тодорхойлоход оролцогч талуудын талаар хөндөхийн тулд зах зээлийн ерөнхий бүтэц, түүхэн уламжлалыг авч үзэх шаардлагатай. 1990 оноос өмнө Монгол Улс эрчим хүчний салбарын эрэлт, нийлүүлэлт, технологи, түүнчлэн хүний нөөцийн бодлогын хувьд тухайн үеийн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ЗСБНХУ)-аас өндөр хамааралтай байснаас үүдэн зах зээлийн шилжилтийн эхний жилүүдэд салбар хүндрэлд орж томоохон өөрчлөлт хийх нөхцөлтэй тулгарсан. Ийнхүү 1995 онд Эрчим хүчний тухай хуулийг баталж, улмаар олон улсын байгууллагуудын бодлого, дэмжлэгээр салбарт бүтцийн өөрчлөлт хийснээр тус салбарын засаглалын бүтэц, оролцогч талуудын харилцаа зэрэг нь өнөөгийн өнгө төрх, зарчмаар ажиллах эхлэл тавигдсан.

Шилжилтийн эхний жилүүдэд эдийн засгийн хямралаас гадна засаглалын хямралд өртсөн эрчим хүчний салбар нь суурь салбар болохынхоо хувьд улс орны эдийн засаг, бусад салбарын хөгжилд шууд нөлөөлж байснаас үүдэн төрөөс хэрэгжүүлэх бодлогод зарчмын өөрчлөлт хийж, 2001 онд Эрчим хүчний тухай хуулийг шинэчлэн баталжээ. Хуулийн хүрээнд 2002 онд эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн газруудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж бие даасан компаниуд үүсэж, Эрчим хүчний зохицуулах газар, Диспетчерийн үндэсний төв байгуулагдан зах зээлийн шинэ загвар болох “Нэг худалдан авагчтай загвар”-т шилжин ажилласан. Мөн эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилттэй төслүүдийн үр дүнд цахилгаан станцуудын найдвартай ажиллагаа дээшилж, хэрэглэгчдээс авах орлого төвлөрүүлэлт эрс сайжирч салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд дээшилсэн байна (Н.Түвшинтөгс & Б.Ариунжаргал, 2010).

Энэхүү бүтцийн өөрчлөлтийн гол цөм нь эрчим хүчний зохицуулалтыг хэрэгжүүлэх хараат бус, бие даасан институцийг байгуулж, салбарын үйлдвэр, аж ахуйн байгууллагуудыг арилжааны хэлбэрт оруулах, алдагдалтай жижиг системийг хувьчлах, хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд чиглэж байсан бөгөөд нэн түрүүнд дараах асуудлуудад анхаарч, тодорхой ажил хийж эхэлсэн (АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газар, 2002). Үүнд:

- Түлш, эрчим хүчний үйлдвэрлэлийн циклд оролцогч байгууллага хоорондын өр, авлагыг шийдвэрлэх,
- Хэрэглэгчдээс авлага цуглуулах ажлыг эрчимжүүлж, системийг өөрчлөх,
- Эрчим хүч түгээх, хангах техникийн болон арилжааны алдагдлыг бууруулах,
- Үнэ тарифын бүтцийг өөрчилж, өртөг зардлаа бүрэн нөхөхүйц үнэ тарифыг тодорхойлох,
- Эрчим хүчний импортын хэмжээг бууруулж, гадаад өрийн удирдлагыг сайжруулах зэрэг болно.


Ийнхүү олон улсын тухайлбал, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Дэлхийн банк зэрэг байгууллагын тусламж, дэмжлэгээр эрчим хүчний салбарт хийсэн өөрчлөлтийн үр дүнд салбарын өнөөгийн тогтолцоо бүрдэж, эдийн засгийн суурь, тэргүүлэх салбарын үүргээ хэрэгжүүлсээр ирсэн.

Монгол Улсын эрчим хүчний зах зээлд “нэг худалдан авагчтай загвар”-ыг 2002 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс, үйлдвэрлэгч хоорондын арилжааны спот зах зээлийн зарчмыг 2005 оны 01 дүгээр сараас, өрсөлдөөнт зах зээлийн зарим үзэл баримтлалыг 2007 оны 01 дүгээр сараас нэвтрүүлж эхэлсэн ба зах зээлийн үндсэн загвар болох “нэг худалдан авагчтай загвар”-ын үндсэн зарчмыг Зураг1-т харуулав.

Энэ загварын дагуу хэрэглэгчдээс эрчим хүчний төлбөрт төлсөн мөнгө “Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данс”-нд төвлөрч, тухайн өдөртөө Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ)-оос баталсан коэффициентын дагуу эрчим хүч үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч компаниудын дансанд хуваарилагддаг. Энэхүү механизм нь цахилгаан эрчим хүчний төлбөрөөс бүрдэх орлогоос энерги үйлдвэрлэх болон дамжуулж түгээх хангах өртөгтэй уялдуулж, шударгаар хувь хүртэх боломжийг эрчим хүч үйлдвэрлэгч, дамжуулах, хангах, түгээх компаниудад олгож байгаа бөгөөд мөнгөний урсгалыг хуваарилах хувь хэмжээг эрчим хүчний үйлдвэрлэл болон хэрэглээний прогноз, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлын шинжилгээнд үндэслэн зохицуулагч байгууллага тогтоодог.

Эрчим хүчний салбарт 2002 оноос хойш хийгдсэн бүтцийн өөрчлөлт нь тодорхой үр дүнд хүрсэн болохыг салбарын статистик үзүүлэлтүүд нотолдог хэдий ч, олон жилийн туршид салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифыг хатуу зохицуулалттай, өртгөөс нь хэт багаар тогтоож ирсэн, салбарын хөрөнгө оруулалтын зохистой бодлого алдагдсан, эрчим хүчний үйлдвэрлэл, хангах, түгээх технологийн дорвитой шинэчлэл хийгээгүй зэрэг нь салбарт олон сөрөг үр дагаврууд үүсгэснийг салбарын мэргэжилтнүүд, судлаачид түүнчлэн бодлого тодорхойлогчид ч дүгнэдэг.

Зураг 1. Эрчим хүчний зах зээлийн нэг худалдан авагчтай загварын энерги болон мөнгөн урсгал



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо



2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний зах зээлийн оролцогчдын эрх үүрэг, харилцааг хуульчлан тогтоож өгснөөс үнэ тарифтай холбогдох бодлогыг тодорхойлох, зохицуулах, хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэй талууд, тэдгээрийн чиг үүргийг дараах байдлаар хуульчилсан байна (УИХ, Эрчим хүчний тухай хууль, 2001).

Хүснэгт 4. Эрчим хүчний үнэ тарифтай холбоотой бодлого, шийдвэрийн оролцогчид, тэдгээрийн чиг үүрэг

№	Оролцогч талууд	Хуулийн заалт	Агуулга/тайлбар
1.	Улсын Их Хурал	4 дүгээр зүйл	Эрчим хүчний талаарх төрийн бодлогыг тодорхойлж цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.
2.	Засгийн газар	5 дугаар зүйл	Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах - Эрчим хүчний зохицуулах хороог байгуулах, дүрмийг батлах - Эрчим хүч хэрэглэх болон шугам сүлжээг хамгаалах дүрэм, дамжуулах сүлжээний хамрах хүрээг тогтоох - Эрчим хүчний аюулгүй нөөц болон хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх нөөцийн жагсаалтыг батлах зэрэгтэй холбоотой нийт 6 эрх
3.	Төрийн захиргааны төв байгууллага	6 дугаар зүйл	Эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон - Эрчим хүчний талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулах, онцгой нөхцөлд мөрдөх эрчим хүчний хангамжийн талаарх журам батлах, сүлжээний ашиглалт, аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм журмыг баталж мөрдүүлэх зэрэг нийт 19 бүрэн эрх - Эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдлагыг томилж чөлөөлөхөд зөвшилцөх
4.	Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга	7 дугаар зүйл	Эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаар бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга, байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, мод, бут, сөөгийг зайлуулах, дээрх зөрчлийг гаргуулахгүй байх

5.	Эрчим хүчний зохицуулах хороо	8 дугаар зүйл 9 дүгээр зүйл	Зохицуулах хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна. - Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах зэрэг нийт 20 гаруй бүрэн эрхтэй байхаар хуульчлагдсан байна. Зохицуулах хорооны бүрэн эрхэд цахилгаан, эрчим хүчний үнэ, тарифын шийдвэр гаргахтай холбогдох хэд хэдэн бүрэн эрх байна. Үүнд: - Тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх - Эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхыг бүрдүүлсэн зохих ашгийн түвшин бүхий үнэ тарифын тогтолцоог бий болгох - Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах - Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам батлах - Хэрэглэгчдэд ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах
----	-------------------------------	--------------------------------	---

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хуульд зааснаар эрчим хүчний үнэ тариф тогтоох эрх мэдэл нь хараат бус зохицуулагч байгууллагад буюу Эрчим хүчний зохицуулах хороонд хадгалагдаж байгаа боловч бодит байдалд үнийн шийдвэр нь улс төрчдийн нөлөө, сонгуулийн амлалт зэрэг олон хүчин зүйлсийн уулзвар, нөлөөнд байсаар байна. Эрчим хүчний үнэ тарифын бодлого, шинэчлэлд оролцогч “төрийг” төлөөлөх талууд нь Засгийн газар, Ерөнхий сайд, УИХ, ХЗХ байгаа бөгөөд эдгээр талууд өнгөрсөн хугацаанд голлох, идэвхтэй байр суурийг эзэлж ирсэн. Харин “төрийн бус” талд улс төрийн намууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, хэрэглэгч ба олон нийтийн сонирхлын бүлэг, банк, санхүүгийн байгууллага, хандивлагч ба олон улсын байгууллага зэрэг талыг хамруулах ба тэдний идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх нь Монгол Улсын эрчим хүчний үнэ тарифын бодлогын шинэчлэлд чухал ач холбогдолтойг зарим судлаачид онцолсон байна (N.Dorjdari & Ts.Tumentsogt, 2023). Эрчим хүчний үнэ тарифын бодлого, шийдвэрийн талаарх ойлголт, мэдээлэл, энэ

талаар хийсэн судалгаа хангалтгүй байдгаас үүдэн эдгээр оролцогч талуудын бодитой оролцоо, нөлөөлөл ч хангалтгүй байна гэж судлаач Н.Дорждарь, Ц.Түмэнцогт нар дүгнэжээ.

Иймд Монгол Улсын хувьд хөгжлийг дэмжих, хурдасгахад гол нөлөөтэй энэ салбарын “тулгамдсан асуудал-эрчим хүчний үнэ тариф”-ын асуудлыг хэрхэн шийдэж байгаа олон улсын туршлагыг судалж харьцуулан дүгнэх боломжтой юм.

2.2. Эрчим хүчний үнийн бодлого тодорхойлоход оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийг шинжлэх онол, арга зүй, олон улсын туршлага

2.2.1. Эрчим хүчний үнийн шийдвэрт харгалзах хүчин зүйлс, орчин үеийн хандлага

Эрчим хүч хэмээх бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогоос нь хамаарч олон хүчин зүйлийг харгалзан үнийн бодлогыг тодорхойлж үнэ тогтоох шийдвэр гаргах шаардлага үүсдэг байна. Тухайлбал (Munasnighe & Warford, 1982),

- **Эрчим хүчний зах зээлийн эдийн засгийн үр ашиг:** Үнэ нь нөөцийг оновчтой хуваарилах үндсэн хэрэгсэл болох тул богино хугацаанаас гадна урт хугацааны ахиуц зардлыг үнийн тооцоололд тусгах шаардлагатай.
- **Шударга ёс, тэгш байдал:** Эрчим хүч нь айл өрхийн суурь хэрэгцээ учир тодорхой бүлгийн хэрэглэгчдэд зориулсан хөнгөлөлт, нийгмийн халамжийн асуудлыг харгалзан үзэх хэрэгтэй болдог.
- **Санхүүгийн тогтвортой байдал:** Үнэ нь салбарын үйлдвэр, аж ахуйн газрын өртөг зардлыг нөхөх, ирээдүйд үүсэх санхүүгийн эх үүсвэрийн хэрэгцээг хангах хэмжээнд байх ёстой.
- **Хялбар байдал:** Тарифын бүтэц нь хэрэглэгчдэд хялбар ойлгомжтой, зардлаа хянаж тооцоолоход хялбар байх ёстой.
- **Хөгжлийн зорилтуудыг дэмжих:** Бүс нутгийн хөгжлийг дэмжих, экспортыг дэмжих зэрэг эдийн засаг, улс төрийн зорилтуудыг харгалзан үзэх шаардлагатай.

Эрчим хүчний үнэ тогтооход харгалзах дээрх хүчин зүйлсээс гадна зайлшгүй харгалзах эдийн засаг, нийгмийн бусад хүчин зүйлс, зохицуулалтын арга зүйг ч судлаачид дурдсан байна (Kaye & Outhred, 1989). Үүнд:

- **Оролцогч талуудыг идэвхжүүлэх:** Хэрэглэгчид болон нийлүүлэгчид аль аль нь оновчтой шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх. Тухайлбал, үнээр дамжуулан үйлдвэрлэгчид өртөг зардлаа бууруулах, шинэ техник технологи нэвтрүүлэхийг дэмжихээс гадна хэрэглэгчдийг эрчим хүчээ

хэмнэх сэдлийг урамшуулах гэх мэтээр үнэ нь зохицуулалтын арга хэрэгсэл болохыг илүүтэй тооцоолж шийдвэр гаргах.

- **Цаг хугацааны хүчин зүйлийг тооцоолж үнэ тогтоох:** Цаг хугацааны явцад зайлшгүй гарах өөрчлөлтүүд тухайлбал, өртөг, эрэлт хэрэгцээний өөрчлөлт, хандлагыг харгалзан үнийг тогтмол шинэчлэхэд чиглэх.
- **Тодорхойгүй байдал, эрсдэлийн нөхцөлийг тооцоолох:** Ирээдүйн тодорхойгүй байдлыг үнэлж, эрсдэлийг зөв удирдахад чиглэсэн үнэ тогтоох загварыг хөгжүүлэх.

Уламжлалт хандлагаар эрчим хүчний үнийг тогтоох, үнийн шийдвэр гаргахад харгалздаг дээрх хүчин зүйлсээс гадна дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал буюу түүхий эдийн үнийн хэлбэлзэл, глобал улс төр-эдийн засгийн тогтворгүй байдал, бүс нутгийн эдийн засгийн дайн, байгаль орчныг хамгаалах бодлогын нөлөөлөл зэрэг хүчин зүйлсийг мөн эрчим хүчний үнийн шийдвэрт зайлшгүй харгалзах шаардлага үүсч байна (Anatolii, Tetyana, & Yulia, 2024). Түүнчлэн эрчим хүчний зах зээлийн бүтцэд гарч байгаа хурдацтай өөрчлөлт, тухайлбал, тархмал эх үүсвэр, шинэ технологийн эрчим хүч үйлдвэрлэл, эрчим хүчийг нөөцлөх технологийн шийдэл, мэдээллийн технологийн нөлөөгөөр бий болсон ухаалаг систем зэргээс үүдэлтэйгээр зах зээлийн харилцаанд оролцогчдыг урамшуулах, үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах бодлогыг ч мөн үнэ тарифт харгалзах нөхцөл үүссэн (Liu, Hu, Yu, & Trinh, 2023). Дэлхий нийтээр байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжиж, цаашид эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь тасралтгүй өсөн нэмэгдэх, давамгайлах хандлагатай болсон үед эрэлт, нийлүүлэлтийн зохицуулалт, үнийн бодлого, шийдвэрт ч зарчмын өөрчлөлт гарах нь тодорхой. Дээр дурдсан олон хүчин зүйлийг харгалзан эрчим хүчний үнийг тогтоох аргачлал, арга зүйг зах зээлийнхээ онцлогт тохируулан сонгох зарчмыг улс орнууд баримталж байна.

Олон улсад эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох дараах үндсэн хандлага байна. Үүнд:

- Зах зээлийн хандлага (market pricing) – Чөлөөт зах зээлтэй улс орнуудын хувьд тухайн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр дээр үнэ тогтож байна. Тархмал эх үүсвэртэй зах зээлд эрчим хүчний бөөний болон жижиглэнгийн зах зээл дээрх үнэ нь эрэлт, нийлүүлэлтийн зарчмаар тогтдог.
- “Зардал дээр нэмэх нь” хандлага (cost-plus pricing) – Энэхүү аргачлалыг төрийн зохицуулалттай зах зээл бүхий улс орнууд нийтлэг байдлаар ашигладаг. Үндсэн зарчим нь бодит өртөг зардал болон ашгийн зохих түвшнийг тарифт тусгадаг аргачлал юм. Эрчим хүч нь эдийн засгийн



бусад салбарын үйлдвэрлэл, үйл ажиллагаанд шууд нөлөөлөх суурь зардалд тооцогддог тул улс орнууд стратегийн түвшинд анхаарч, ихэвчлэн хараат бус зохицуулах байгууллагуудаас үнэ тарифын зохицуулалтыг хийж, салбарын эдийн засгийн үр ашгийг тооцоолж зохицуулдаг түгээмэл хандлага юм.

- Сүүлийн үед улс орнуудын зохицуулах байгууллагууд “Зардал дээр нэмэх” аргачлалыг “Урамшуулалд суурилсан” (Incentive based) хандлагатай хослуулан ашиглах нь нийтлэг болж байна. Урамшуулалд суурилсан хандлага гэж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэмнэлттэй, үр ашигтай ажиллагааг идэвхжүүлэх, тарифын зохицуулалтын хугацаанд гарсан зардлын хэмнэлт, үр ашгийг хэрэглэгч-тусгай зөвшөөрөл эзэмшигч нар хувааж хүртэх тогтолцоог дэмжсэн аргачлал юм.

Өмнө дурдсан олон хүчин зүйлсийг харгалзан, үнэ тогтоох аль ч аргачлалыг сонгосон тэр нь үнийн бодлого, шийдвэрт оролцогч талуудын ашиг сонирхолд ялгаатай нөлөө үзүүлнэ. Жишээлбэл, “зардал дээр нэмэх” аргачлалыг үнэ тогтооход ашиглах тохиолдолд эдийн засгийн макро үзүүлэлтүүд, үйлдвэрлэлийн зардлын өсөлт, түүний хяналт зэрэг хүчин зүйлсийг чухалчлан харгалзах нөхцөл үүсдэг бол, урамшуулалд суурилсан аргачлал нь зах зээлийн үр ашигт илүүтэй төвлөрдөг. “Зардал дээр нэмэх” аргыг баримтлах тохиолдолд үйлдвэрлэгчид зардлын хяналтад төдийлөн анхаарахгүй, зардлаа өсгөж саналаа хүргүүлэх зэрэг араншин гаргадаг бол урамшуулалд суурилсан аргачлал нь үйлдвэрлэгчдийн техникийн алдагдлаа бууруулах арга замыг эрэлхийлэх санал, санаачилгыг дэмждэг. Энэ мэтчилэн үнийн шийдвэр, түүнд ашиглах аргачлал зэргээс хамаарч оролцогч талуудад үзүүлэх нөлөө, эргээд тэднээс ирэх хариу үйлдэл, нөлөөлөл ч харилцан адилгүй байх юм.

2.2.2. Эрчим хүчний үнийн бодлогын оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаарх олон улсын туршлага, хандлага

Хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам, боломжууд нь улс орон бүрт ялгаатай байдаг. Монгол Улсын хувьд эдийн засгийн хөгжлийн нэг суурь нөхцөл нь эрчим хүчний салбарын тогтвортой байдал, үнэ тарифын бодлогын асуудал болохыг өмнө дурдсан. Иймд эрчим хүчний үнийн бодлого, шийдвэрийг гаргахад нөлөөлөх хүчин зүйлсийг ямар өнцгөөр судлах шаардлагатай вэ гэсэн асуулт тавигдана. Хөгжлийн бодлого, шинэчлэлт амжилттай хэрэгжих эсэх нь улс төр, эдийн засаг, нийгэм, институцийн олон хүчин зүйлсээс хамаардаг (Acemoglu, D., & Robinson, J. A., 2013, хууд. 88). Тухайлбал:

- *Улс төрийн хүчин зүйлс* - Хөгжлийн бодлого нь улс төрийн тогтвортой байдал, эрх мэдэл бүхий бүлгүүдийн ашиг сонирхолтой салшгүй холбоотой байдаг (North, D. C., Wallis, J. J., & Weingast, B. R. , 2009,

хуудсд. 30-50) бөгөөд засгийн газрын тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлтийг хурдасгах гол хүчин зүйлсийн нэг болдог (Keefe, 2007, p. 806). Байгалийн баялаг ихтэй улс орнуудад улс төрийн элитүүд баялгийн хяналтаа хадгалах сонирхолтой байдаг нь хөгжлийг сааруулах нэг шалтгаан болдог (Ross, 2012, p. 199). Зарим улс орны улс төрч, удирдагчид шинэчлэлтийг улс төрийн нэр хүндээ өсгөх, олон нийтийн дэмжлэг авах, олон улсын байгууллагуудын шаардлагыг хангах зорилготой дэмждэг бол, зарим улсад улс төрийн элитүүд өөрсдийн эрх мэдэл, эдийн засгийн ашиг сонирхолд нийцэхгүй өөрчлөлтийг эсэргүүцдэг (Grindle, 2001).

- *Эдийн засгийн хүчин зүйлс* - Улс орны хөгжлийг тодорхойлогч чухал хүчин зүйл бол эдийн засгийн бүтэц, зах зээлийн механизм, санхүүгийн зохистой бодлого бөгөөд тогтвортой өсөлтийг хангахын тулд улс орон бүрийн өвөрмөц нөхцөл байдалд нийцсэн институциудыг бий болгож эдийн засгийн уян хатан стратеги боловсруулах нь чухал (Rodrik, 2008, pp. 153-184).
- *Институцийн хүчин зүйлс* – Улс орны хөгжил дэвшил, эдийн засгийн тогтвортой байдал нь тухайн улсын институцийн тогтолцоо, чадавхаас ихээхэн хамаардаг (North D. C., 1990, pp. 107-117).
- *Нийгмийн хүчин зүйлс* - Хөгжлийн үйл явцад тухайн улсын боловсрол, эрүүл мэндийн тогтолцоо, нийгмийн бүтэц (Sen, 1999 p. 56), нийгмийн соёл, түүний үнэт зүйл, итгэл үнэмшил, уламжлал (Weber, 1905) болон нийгмийн итгэлцэл (Inglehart, 1997) зэрэг чухал нөлөөтэй.

Дээрх хүчин зүйлс нь эрчим хүчний үнийн бодлого боловсруулалт, хэрэгжилтэд шууд болон шууд бус нөлөөлөл үзүүлдэг бөгөөд бидний судалж буй эрчим хүчний салбарын тулгамдсан асуудал, үнэ тарифын бодлогод дээр дурдсан хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгааг болон тухайн бодлогын оролцогч, нөлөөлөгч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн хүчийг улс төрийн эдийн засгийн хандлагаар болон институцийн эдийн засгийн хандлагаар судлах боломжтой.

Улс төрийн эдийн засгийн хандлага

Улс төрийн эдийн засгийн хандлага нь хөгжлийн бодлогыг зөвхөн санхүүжилт, эдийн засгийн механизм, техникийн шийдэл талаас авч үзэх, судлах нь хангалтгүй гэж үздэг. Учир нь улс орны хөгжлийг тодорхойлох гол хүчин зүйл нь эдийн засгийн хүчин зүйлүүд төдийгүй улс төрийн бүтэц, институц, эрх мэдлийн харилцаа зэрэг өргөн хүрээний хүчин зүйлүүд юм. Тодруулбал улс орны эрх баригч, шийдвэр гаргагчдын үйл ажиллагаанд улс төрийн сэдэл (*political incentives*) болон улс төрийн хязгаарлалтууд

(*constraints*) ихээхэн нөлөөлдөг (Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.), 2014). Жишээлбэл, хөгжлийн бодлого боловсруулахдаа улс төрчид иргэдийн дэмжлэгийг авах, өөрийн засаглалыг хадгалах, эрх мэдлээ хамгаалах зэрэг улс төрийн сонирхлоо тэргүүнд тавих нь элбэг. Зарим тохиолдолд улс төрчид шинэчлэлт, өөрчлөлтийг дэмжих нь өөрсдийн ашиг сонирхолд нийцэхгүй бол түүнийг сааруулах, удаашруулах үйл ажиллагаа явуулдаг. Хамгийн үр дүнтэй, мэргэжлийн түвшинд боловсруулсан бодлого ч улс төрийн орчин, эрх баригчдын ашиг сонирхол, олон нийтийн шахалт зэргээс шалтгаалан хэрэгжихгүй байх, эсвэл өөрчлөгдөх тохиолдол түгээмэл билээ. Тухайлбал, тодорхой шинэчлэлтийг хийх нь богино хугацаанд улс төрийн эрсдэл дагуулж болзошгүй учраас эрх баригчид урт хугацааны хөгжлийн бодлогыг орхигдуулж, олон нийтийн сэтгэл ханамжийг шууд нэмэгдүүлэх богино хугацааны арга хэмжээг сонгох нь элбэг (Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.), 2014, p. 1). Нэн ялангуяа улс төрийн элитүүдийн ашиг сонирхол, эрх мэдлийн харилцаанд клиентелизм⁴ (*clientelism*), патронажийн сүлжээ⁵ (*patronage networks*), популизм⁶ (*populism*) зэрэг улс төрийн механизм, стратегиуд илэрч, энэ нь бодлого боловсруулалтад хүчтэй нөлөөлдөг бөгөөд ихэвчлэн хөгжлийн үйл явцыг сааруулж, шинэчлэлт хийх боломжийг хязгаарлах сөрөг үр дагаварт хүргэдэг (Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.), 2014).

Эрчим хүчний үнийн бодлого нь улс орны эдийн засаг, инфляц, иргэдийн амьжиргаа, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны зардал, өрсөлдөх чадварт нөлөөлдөг бөгөөд эрчим хүчний үнэ нэмбэл иргэдийн эсэргүүцэлтэй тулдаг тул эрчим хүчний шинэчлэл нь улс төрийн хувьд эмзэг асуудал юм. Тухайлбал, эрчим хүчний үнийг нэмэгдүүлэх нь сонгогчдын хүчтэй эсэргүүцэл дагуулдаг тул шийдвэр гаргагчид богино хугацааны улс төрийн ашигт нийцсэн шийдлийг сонгох нь элбэг байдаг. Иймд улс төрийн эдийн засгийн хандлагаар хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд тулгардаг гол асуудлуудыг илрүүлж судлахдаа тэдгээрийг улс төр, эдийн засаг, институцийн хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээр нарийвчлан судлах шаардлагатай.

Хөгжлийн тулгамдсан асуудлыг судлах өөр нэг хандлага нь институцийн хандлага юм.

Институцийн хандлага

Институц нь улс орны хөгжил, нийгэм-эдийн засгийн тогтвортой байдал, засаглалын чанарыг тодорхойлох үндсэн хүчин зүйл юм. Иймд бодлогын

⁴ Клиентелизм (Танил талаа дэмжих тогтолцоо) гэдэг нь улс төрийн эрх мэдэл бүхий хүмүүс өөрсдийн байр суурийг хадгалах, нөлөөгөө тогтоохын тулд тодорхой бүлгүүдэд давуу байдал олгох явдал юм.

⁵ Патронажийн сүлжээ (Ивээн тэтгэлгийн сүлжээ) гэдэг нь эрх мэдэл, нийгмийн байр суурь харилцан адилгүй хүмүүсийн хооронд үүсдэг ашиг сонирхлын харилцааг илэрхийлдэг.

⁶ Популизм (Олон нийтийн сэтгэл хөдлөлийг ашиглах стратеги) нь олон нийтийн дэмжлэгийг авахын тулд улс төрчид богино хугацааны амлалт, уриа, сэтгэл хөдлөлийн хүчтэй нөлөөлөл бүхий бодлого хэрэгжүүлэх явдал юм.

асуудлыг институцийн хандлагаар судлах нь чухал. Институцийн хандлага буюу институционализмын ач холбогдлыг орчин үеийн эдийн засгийн хэлэлцүүлэгт оруулж, хөгжүүлэхэд дараах нэрт судлаачид онцгой хувь нэмэр оруулсан. Үүнд: К. Арроу, Ж. Бюкенан, Р. Коуз, Х. Демсетз, А. Даунс, В. Нисканен, Д. С. Норт, Э. Остром, Г. Туллок, О. Уильямсон нар юм. Орчин үеийн институционализмд давамгайлж буй гол хандлага шинэ институцийн эдийн засаг (*New Institutional Economics*) бөгөөд энэхүү хандлага нь нео-классик эдийн засгийн суурь зарчмуудыг баримталж, институц нь хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагааг чиглүүлэх хязгаарлалтууд болон урамшууллын системээс бүрддэг хэмээн үздэг (North D. C., 1990).

Тухайлбал, О.Уильямсон институцийг нийгмийн болон хувь хүний үйл ажиллагааг чиглүүлэх хүрээ (Williamson, 1993) буюу энэ нь шийдвэр гаргах, бодлого боловсруулахад оролцогч талуудын үйл ажиллагааг тодорхойлж чиглүүлдэг гэж үзсэн. Харин Д.С. Норт институцийг нийгмийн 'тоглоомын дүрэм (*rules of the game*)' буюу хүмүүсийн хоорондын харилцааг чиглүүлэх, хязгаарлах, зохицуулах үүрэгтэй дүрэм журам, хэм хэмжээ гэж тодорхойлсон. Тэдгээр нь хүмүүсийн шийдвэр гаргалт, харилцан үйлчлэлд нөлөөлөх гол механизм болдог (North D. , 1990). Мөн тэрээр институцийг албан болон албан бус гэж ангилсан бөгөөд эдгээрээр дамжуулан хүмүүсийн зан үйлийг зохицуулдаг байна. Албан институц нь хууль, дүрэм журам, гэрээ, өмчийн эрх гэх мэт дүрмээр, харин албан бус институц нь ёс заншил, уламжлал, итгэл үнэмшил, үнэт зүйлс, нийгмийн зан төлөвийн нормууд (жишээ нь: ахмад настныг хүндлэх), ёс суртахууны хэм хэмжээгээр илэрхийлэгддэг (North D. C., 1990). Албан бус институц нь тухайн нийгэмд гүн гүнзгий тогтсон, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг тул тогтвортой, бат бөх, аливаа гадаад нөлөөнд тэсвэртэй байдаг. Тэдгээрийг хянах тусгай механизм байдаггүй, эсвэл бий болгох шаардлагагүй байдаг бөгөөд зөрчсөн тохиолдолд ихэвчлэн нийгмээс гадуурхагддаг. Харин албан институц нь хууль эрх зүй, нормын бичигдсэн, кодлогдсон системээр илэрхийлэгддэг, гаднын хүчин зүйлийн нөлөөгөөр хурдан өөрчлөгддөг. Тэдгээрийн хэрэгжилтийг хангахад тусгай хэрэгжүүлэх, хяналтын аппарат шаардлагатай бөгөөд дагаж мөрдөхгүй байх тохиолдолд энэ зорилгоор томилогдсон байгууллагууд мөн зохицуулалт хийдэг (North D. C., 1990).

Аливаа тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлт нь институцийн өөрчлөлттэй нягт уялдаатай байдаг. Т.Веблений үзэж байгаагаар институц нь түүхэн нөхцөл байдлын үр дүн бөгөөд шинэ орчинд дасан зохицохдоо цаг хугацаа шаарддаг (Wilkin, 2016). Д.С. Норт улс орнуудын хөгжил нь институцийн бүтэц, зохион байгуулалт, институцийн гүн суурь норм, хэм хэмжээнээс хамаарч ялгаатай байдаг (North D. C., 1994) гэж үзсэн. Шинэ институцийн эдийн засгийн хүрээнд энэхүү тогтолцооны өөрчлөлтийг хөгжлийн замналын (*path dependence*) үзэл

баримтлалаар мөн судалдаг.

Path dependence (хөгжлийн замнал) хэмээх ойлголтыг Б. Артур (1989), П. Дэвид (1985) нар хөгжүүлж, *'history matters'* буюу “түүх нь өнөөгийн болон ирээдүйн төлөв байдалд асар их нөлөөтэй” болохыг онолын болон практик судалгаагаар баталсан (David, 1985), (Arthur, 1989). Тэд чөлөөт зах зээл өөрөө үр ашигтай сонголт хийх баталгаа болдоггүйг нотолж, улс орнуудын хөгжлийн замналыг урьдчилан тогтсон институцийн тогтолцоо тодорхойлдог гэж үзсэн. Энэхүү үзэл баримтлалын дагуу нийгмийн институц нь түүхэн хөгжлийн явцад бий болсон/тогтсон хэм хэмжээ, үнэт зүйлс дээр суурилж, шинэчлэлт хийх боломжийг хязгаарлах буюу тодорхой нэг чиглэлд хязгаарлах нөхцөл үүсгэдэг (David, 1985) (Arthur, 1989). Д.С.Норт энэхүү үзэл баримтлалыг өргөтгөн судалж, түүхэн хүчин зүйлсийн улмаас улс орнууд хөгжих эсвэл хөгжлийн замд түгжигдэх (*lock-in effect*) боломжтойг харуулсан. Улмаар улс орон бүр ‘институцийн матриц’ буюу нийгмийн үндсэн дүрэм, журам, хэм хэмжээтэй байдаг бөгөөд урт хугацааны хөгжил нь институцийн өөрчлөлтөөс шууд хамаардаг ажээ. Хөгжил зогсонги (*stagnation*) болох нь институцийн шинэчлэлт хийх чадвараас шалтгаалах буюу гүн гүнзгий тогтсон (суурьшсан) институц шинэ асуудлыг шийдвэрлэхэд тохирохгүй байх нь хөгжлийг гацаанд хүргэх эрсдэлтэй ба итгэл үнэмшил, үнэт зүйлс шинэ сорилтод дасан зохицож чадахгүй бол хөгжил удааширдаг байна (North D. C., 1994).

Дээрх онол, хандлагыг авч үзвэл Монгол Улсын эдийн засгийн гол салбар боловч бусад салбарын хөгжлийг хязгаарлах нэг хүчин зүйл болоод байгаа эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлыг бид судлахдаа институцийн болон улс төрийн эдийн засгийн онолд суурилан судлах боломжтой юм.

Эрчим хүчний үнэ буюу суурь үнийг өсгөвөл сонгогчдын бухимдлыг нэмэгдүүлнэ гэх зэргээр богино хугацааны улс төрийн ашиг хонжоонд тулгуурласан шийдвэрүүд нь зөвхөн салбарын тогтвортой байдалд нөлөөлөөд зогсохгүй, өргөн хүрээнд бусад голлох салбаруудын хөгжлийг боомилж байна. Эрчим хүчний салбарын үнийн зохицуулалт нь улс төрийн ашиг сонирхлын томоохон талбар болж, институцийн сул дорой байдлаас үүдэн тогтвортой бодлого хэрэгжүүлэхэд хүндрэл учирсаар ирсэн. Улс төрийн эдийн засгийн хандлагын үүднээс авч үзвэл “эрчим хүч” хэмээх бүтээгдэхүүн, түүний үнэ нь айл өрх, аж ахуйн нэгж-хэрэглэгч, үйлдвэрлэгч, төр, зохицуулах байгууллага болон олон улсын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын төвд байдаг. Улс төрийн шийдвэр гаргагчид эрчим хүчний үнийн бодлогыг олон нийтийн дэмжлэг авах хэрэгсэл болгон ашиглаж (Victor, D. G., & Heller, T. C. (Eds.), 2007) (Silva, 2019), улмаар улс төр, оролцогч талуудын энэхүү ашиг сонирхлын нөлөөгөөр эрчим хүчний салбарын хөгжил удааширдаг (Stokes, 2020) гэдгийг олон улсад хийгдсэн судалгаануудын үр дүн харуулдаг. Түүнчлэн, эрчим хүчний

салбарын үнэ тогтоох бодлого нь төрийн хүчтэй зохицуулалтын дор байдаг. Нэн ялангуяа шилжилтийн эдийн засагтай улс орнуудад (Жишээ нь: Монгол, Казакстан) эрчим хүчний тарифыг төрөөс зохиомлоор бага түвшинд барьснаар салбарын санхүүгийн тогтвортой байдал алдагджээ (World Bank, 2022). Мөн эрчим хүчний үнийн өсөлт нь нийгэм, улс төрийн тогтворгүй байдал үүсгэх эрсдэлтэй. Тухайлбал, Латин Америкийн зарим орнуудад (Чили, Аргентин) эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэний дараа олон нийтийн эсэргүүцэл, улс төрийн тогтворгүй байдал үүсэж, засгийн газар буулт хийн зарим татаасыг сэргээх, үнийг буцаан тогтоох шийдвэр гаргасан байдаг (Silva, 2019).

Түүнчлэн Йорг Радтке, Ортвин Ренн (2024) нар эрчим хүчний салбарын шилжилтийг улс төр, бодлогын оролцооны үүднээс судалсан. Тодруулбал, эрчим хүчний салбарын өргөн хүрээний шилжилтэд оролцооны механизмыг улс төрийн янз бүрийн засаглалын хэлбэртэй холбон судалсан бөгөөд энэ хүрээнд: (i) автократ, (ii) өрсөлдөөнт, (iii) хамтарсан, (iv) тусгалт болон (v) оролцооны гэсэн таван төрлийн засаглалын хэлбэрийг авч үзсэн байна (Хүснэгт 5-ыг харна уу). Засаглалын хэлбэр тус бүрийн оролцооны гол шинж чанаруудыг авч үзсэнээр эрчим хүчний шилжилтийг илүү үр дүнтэй, ардчилсан хууль ёсыг дэмжсэн хэлбэрээр хэрэгжүүлэх боломж, давуу болон сул талуудыг тодорхойлсон. Ингэснээр улс орон бүр өөрийн бодлогын онцлог, нөхцөл байдалд нийцсэн эрчим хүчний шилжилтийг шинжилж, олон нийтийн дэмжлэгийг хэрхэн татах талаар бодлогын хувилбар дэвшүүлэх боломжтой. Аль нэг засаглалын хэлбэр дангаар эрчим хүчний шилжилтийг амжилттай хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд хамтарсан, тусгалт, оролцооны засаглалын элементүүдийг хослуулсан 'зуучлалын засаглал (*mediated governance*)' хэмээх шинэ хандлагыг судлаачид санал болгожээ. Зуучлалын засаглал нь эрчим хүчний шилжилтийг ардчилсан засаглалын хүрээнд илүү тогтвортой хэрэгжүүлэх, олон талын ашиг сонирхлыг уялдуулж, эрсдэлийг бууруулах давуу талтай бөгөөд дараах гол шинжүүдийг агуулдаг. Үүнд:

- Олон нийтийн оролцоог гол байр сууринд авч үзэх – Эрчим хүчний шилжилтийг зөвхөн төрийн эсвэл зах зээлийн механизм бус, иргэдийн идэвхтэй оролцоотойгоор авч хэрэгжүүлэх.
- Төвлөрсөн бус шийдвэр гаргалт – Шийдвэр гаргалтад талуудыг (үйлдвэрлэгч, хэрэглэгчээс гадна орон нутаг, хувийн хэвшил, иргэний нийгэм) оролцуулах.
- Орон нутгийн санаачилгыг дэмжих – Эрчим хүчний шилжилт нь зөвхөн макро бодлогоор бус, бүс нутгийн санал санаачилга, бодлого, инновац дээр суурилсан шийдлүүдийг агуулах зэрэг болно.



Хүснэгт 5. Засаглалын хэлбэр ба эрчим хүчний шинэчлэл, шилжилт хийх бодлогын хэрэгжилтийн нөхцөл

Засаглалын хэлбэр	Удирдлага ба шийдвэр гаргалт	Бодлого боловсруулах орчин нөхцөл	Оролцооны хэлбэр	Бодлогын тогтвортой байдал	Олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх хэлбэр	Үр дүнгийн түвшин
Автократ	Улс төрийн хувьд давамгай эрх бүхий удирдагч ба эрх баригч намтай	Сонгууль тогтмол явагддаг ч удирдагч нь сөрөг хүчнийг хязгаарлах, бодлого боловсруулах үйл явцад хяналт тавихыг эрмэлздэг	Улс төрийн оролцоо хязгаарлагдмал, удирдагчид бэлгэдлийн хэлбэрийн оролцоог хангадаг	Тогтвортой эрчим хүчний шилжилтийн бодлогыг тэргүүлэх чиглэл болгох эсвэл үр дүнтэй хэрэгжүүлэх магадлал багатай	Итгэл	Улс төрийн удирдагчдад ашиггүй байх нөхцөлөөс шалтгаалан Үр дүн нь хязгаарлагдмал
Өрсөлдөөнт	Олон нийтийн дэмжлэгийг эрэлхийлдэг хоёр өрсөлдөгч намтай	Аль нам засгийн эрхэнд байгаагаас хамаарч бодлого өөрчлөгддөг	Эрх баригч намын хөтөлбөрийг дэмжих хүрээнд оролцоог хангадаг	Уур амьсгалын бодлогыг урт хугацааны тогтвортой байдлын үүднээс илүүтэй стратегийн үзэл баримтлал талаас нь авч үздэг	Ятгалт	Сөрөг хүчний эсэргүүцэл, олон нийтийн дэмжлэгийг алдах айдсаас шалтгаалан Үр дүн нь хязгаарлагдмал
Хамтарсан	Нөлөө бүхий оролцогч талуудын хүрээнд зөвшилцөлд хүрэхэд эрмэлздэг, ихэвчлэн хаалттай хаалганы ард	Эдийн засгийн оролцогч талууд болон ТББ-уудыг шийдвэр гаргах үйл явцын эхэн үеэс оролцуулж зөрчилдөөнийг шийдвэрлэх замаар тэдэнтэй зөвлөлддөг	Гол оролцогч талуудыг хамардаг хэдий ч шинэ санаачилга, зохион байгуулалтад ороогүй иргэдийг оролцуулаагүй	Богино хугацаанд нэн яаралтай асуудлуудыг урт хугацааны тогтвортой байдлын бодлогоос илүүтэй тэргүүлэх чиглэл болгодог	Хариу үйлдэл	Үр дүн өндөр байж болох ч тодорхой чиглэлүүдэд хязгаарлагдмал

Засаглалын хэлбэр	Удирдлага ба шийдвэр гаргалт	Бодлого боловсруулах орчин нөхцөл	Оролцооны хэлбэр	Бодлогын тогтвортой байдал	Олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх хэлбэр	Үр дүнгийн түвшин
Тусгалт	Эргэцүүлэн шинжлэх замаар чанартай шийдвэр гаргалтад анхаардаг	Нээлттэй, шударга хэлэлцүүлэг өрнүүлж, чанартай аргументууд гаргахад анхаардаг	Тогтвортой байдлын бодлогод аман амлалт өгөх нь элбэг	Бодлогын хэрэгжилт удаан, бүрэн бус байж болох бөгөөд аман амлалт нь бодитоор биеллээ олохгүй байж болно	Зөвшилцөл	Үр дүн бага хэдий ч үйл явцын чанар өндөр
Оролцоот	Нийгмийн бүх хэсгийн шууд оролцоог дэмждэг	Янз бүрийн оролцооны аргыг ашиглах боломжоор хангадаг, үүнд бүх нийтийн санал асуулга орно	Иргэдийн төлөөллийг хамтын шийдвэр гаргалтад оролцуулахыг зорьдог	Үр дүнтэй эсэх нь бүх оролцогч талуудад тухайн арга хэмжээг шуурхай авах шаардлагатай гэдгийг итгүүлж чадах эсэхээс хамаарна. Бодлого боловсруулалт нь сонгогчдын хувьсан өөрчлөгдөх сонголтоос хамааран хугацааны туршид нийцтэй бус байх хандлагатай	Төлөөлөл	Үр дүн сайн байж болох ч зохицуулалт, цогц стратеги дутагдалтай байх нь элбэг
Зуучлалын засаглал (шинэ хандлага)	Асуудлыг шатлан шийдвэрлэх: Орон нутгийн төлөөлөгчдийг засаглалын дараагийн түвшинд шилжүүлэн оролцуулах		Оролцогч талууд болон олон нийтийн оролцооны уян хатан, хүртээмжтэй хэлбэрүүдийг ашиглах		Оролцоог хэвтээ болон босоо чиглэлийн засаглалын бүтцэд хангах	Эрчим хүчний шилжилтийн зорилтуудыг хангахыг эрмэлзсэн олон нийтийг бий болгосон үр дүн өндөр түвшинд гардаг.

Эх сурвалж: Radtke, J., & Renn, O. (2024). Participation in energy transitions: a comparison of policy styles

Судалгааны үр дүнгээс харахад улс төрийн тогтолцоо, эрчим хүчний салбар дахь засаглалын хэлбэр нь салбарын өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд улс орнуудад харилцан адилгүй нөлөөлж, эерэг сөрөг үр дагавар авчирдаг болох нь харагдаж байна.

Эрчим хүчний үнийн бодлого нь зөвхөн эдийн засгийн үр ашигтай байдалд тулгуурлах бус, улс төр, институцийн хүчин зүйлсээс хамаардаг. Тухайлбал, хөгжиж буй томоохон таван орны (Бразил, Хятад, Энэтхэг, Мексик, Өмнөд Африк) эрчим хүчний салбарын шинэчлэлтийн амжилт, бүтэлгүйтлийг судлахдаа улс төр, институцийн хүчин зүйлсийн нөлөөллийг онцолж үзжээ (David G. Victor & Thomas C. Heller, 2007). Эдгээр улс орнууд нь стандарт зах зээлийн загварчлал (*standart textbook model*)⁷-ын дагуу эрчим хүчний салбарыг чөлөөлөх, зах зээлийн механизмыг хэрэгжүүлэх бодлого баримталсан боловч, шинэчлэлтийн үр дүн харилцан адилгүй гарчээ. Шалтгаан нь улс төрийн тогтвортой байдал, институцийн чадавх, нийгмийн ойлголт зэргээс ихээхэн хамаарч байв. Тухайлбал, эдгээр улс бүгд өөрсдийн эрчим хүчний хараат бус зохицуулагч агентлаг, байгууллагууд байгуулсан боловч тэдний эрх мэдэл, хараат бус байдал харилцан адилгүй байсан (Victor, D. G., & Heller, T. C. (Eds.), 2007, p. 16). Жишээ нь, Бразил улс хараат бус зохицуулалтын байгууллага байгуулсан ч, улс төрийн оролцоо өндөр байснаас эрх мэдэл нь хязгаарлагдсан. Энэтхэг улсад муж бүрийн түвшинд зохицуулагч байгууллага байгуулсан ч, хяналт, хэрэгжилт нь мужийн онцлогоос хамаарч ялгаатай байв. Харин Мексик улсад бие даасан зохицуулагч байгууллагатай байсан ч, эрчим хүчний үнийг бие даан тогтоох эрхгүй байв. Тариф тогтоох үйл явц улс төрийн нөлөөнд орсон тул бодит өртгөөс доогуур цахилгаан борлуулах бодлого нь салбарын алдагдал нэмэгдэх гол шалтгаан болжээ. Түүнчлэн Хятад Улсад засгийн газрын мэдэлд байсан зохицуулагч агентлаг бодитой эрх мэдэлгүй байв. Өмнөд Африкт тусгай зохицуулалтын бие даасан байгууллагатай ч, улс төрийн оролцоо, авлигын улмаас үр дүн муутай байсан байна. Эдгээр туршлагаас харахад улс орнууд хараат бус албан ёсны (*de jure*) зохицуулагч байгууллагуудыг байгуулсан ч, бодит байдалд (*de facto*) эрх мэдэлгүй байсан бөгөөд хэрэв зохицуулагч байгууллага улс төрөөс хараат байвал шинэчлэлт үр дүнгүй болох магадлалтайг судалгааны үр дүн харуулсан (Victor, D. G., & Heller, T. C. (Eds.), 2007). Түүнчлэн, шинэчлэлт хийх үйл явц нь улс төрийн ашиг сонирхлын зөрчилтэй тулгарсан. Улс төрчид, үйлдвэрчний эвлэл, бизнесийн бүлэглэл өөрсдийн байр сууриа хадгалах сонирхолтой байсан тул

⁷ Стандарт зах зээлийн загварчлал нь цэвэр өрсөлдөөнд зах зээл, хувийн өмч давамгайлсан өрсөлдөх чадвартай эрчим хүчний зах зээлийг хөгжүүлэхэд л гол анхаарлаа хандуулдаг бөгөөд энэ загвараар өөрчлөлт хийхийг зорьсон засгийн газрууд энэхүү загварын тодорхойлсон эцсийн зорилгод хүрэхийн тулд ямар алхам хийх (эсвэл хийх ёстой) талаар төдийлөн анхаарал хандуулаагүй. Цахилгаан эрчим хүчний салбарын шинэчлэлийг хийсэн ихэнх засгийн газрууд стандарт зах зээлийн загварын бүх гол элементүүдийг тусгасан урт хугацааны зорилгыг тодорхойлсон боловч тэр нь “тодорхойгүй” байсан.

шинэчлэлийг эсэргүүцэх хандлагатай байжээ. Жишээ нь: Бразил, Мексик улсуудад, улс төрчид болон үйлдвэрчний эвлэл хувьчлалыг эрс эсэргүүцэж байсан бол Энэтхэг улсад хөдөө аж ахуйн салбарт маш хямд цахилгаан түгээх бодлоготой байсан тул тариаланчид эрчим хүчний шинэчлэлийг эсэргүүцсэн. Өмнөд Африкт Эском (Eskom⁸) болон үйлдвэрчний эвлэл хувьчлалыг эсэргүүцэж, ажлын байрны тогтвортой байдлыг шалтгаан болгон дурдсан. Харин Хятад Улсад засгийн газар томоохон эрчим хүчний компаниудыг задалбал төрийн хяналт алдагдана гэж үзэж, шинэчлэлтийг хязгаарласан байна. Үүнээс харахад, эрчим хүчний салбарын шинэчлэлт улс төрийн өндөр эрсдэлтэй бөгөөд олон нийтийн дэмжлэгийг татах бодлого боловсруулах шаардлагатайг харуулж байна (Victor, D. G., & Heller, T. C. (Eds.), 2007, хуудсд. 14, 263-266). Иймд бодлогод оролцогч, нөлөөлөгч талуудын ашиг, сонирхол болон зөрчил, аливаа шийдвэрт тэдний үзүүлэх хариу үйлдлийг судлах нь ихээхэн ач холбогдолтой.

2.2.3. Бодлогын оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг шинжлэх онол, арга зүй

Бодлогын оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг шинжлэх нь бодлогын хэрэгжилт, тогтвортой байдал, шинэчлэлтийн амжилтыг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдог. Тодруулбал, Брайсон Ж.М. (2003) аливаа төсөл хөтөлбөр, бодлого амжилттай хэрэгжих эсэх нь зөвхөн техникийн хүчин зүйлээс бус, тэдгээрт нөлөөлж буй, эсвэл нөлөөлөлд өртдөг хүмүүс, бүлэг, институцийн оролцооноос хамаардаг хэмээн тэмдэглэсэн. Иймд оролцогч талуудыг зөв тодорхойлж, ангилан шинжлэх нь стратегийн удирдлага, шийдвэр гаргалтыг дэмжих, итгэлцэл, хууль ёсны байдлыг хангах болон зөрчлийг бууруулах чухал хэрэгсэл хэмээн онцолсон (Bryson, 2003). Ийнхүү оролцогч талуудын ашиг сонирхол болон эрх мэдлийг системтэйгээр шинжлэх нь бодлого боловсруулах үйл явцыг зөв чиглүүлэх, хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэхээс гадна боломжит эрсдэлийг урьдчилан тодорхойлох ач холбогдолтой болохыг судлаачид онцолжээ (Reed et al, 2009).

Оролцогч талуудын шинжилгээний практикт судлаачид судалгааны зорилгоосоо хамааран олон төрлийн аргачлал ашигладаг. Тухайлбал, Рийд М.С. нар (2009) оролцогч талуудын шинжилгээний аргачлалыг үндсэн гурван ангилалд хуваан үзүүлжээ. Үүнд:


- *Оролцогч талуудыг тодорхойлох арга:* Тухайн нөхцөл байдалд ямар оролцогч талууд байгааг тодорхойлох арга юм.
- *Оролцогч талуудыг ялган ангилах арга:* Оролцогч талуудын нөлөөлөл, сонирхол, хууль ёсны байдал, эрх мэдлийг ангилах арга юм.

⁸ Eskom - Өмнөд Африкийн эрчим хүчний салбарын төрийн өмчит томоохон монопол байгууллага

- *Оролцогч талуудын харилцааг шинжлэх арга*: Оролцогч талуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, боломжит зөрчилдөөнийг ялган тодорхойлоход ашигладаг (Reed, 2009).

Судлаачид оролцогч талуудын шинжилгээний үе шат, аргачлалыг өөр өөр байдлаар санал болгодог хэдий ч, ихэвчлэн улс төрийн эдийн засгийн болон засаглалын онолуудад тулгуурласан арга зүйг ашигладаг. Энэ төрлийн судалгаанд түгээмэл хэрэглэгддэг арга нь тулгамдсан асуудлаар хөтлөгдсөн улс төрийн эдийн засгийн шинжилгээний аргачлал (*Problem driven political economy analysis*) юм. Уг аргачлал нь хөгжлийн бодлого, шинэчлэлтийг амжилттай хэрэгжүүлэхэд улс төр, эдийн засгийн бодит нөхцөл байдлыг ойлгох, улс төрийн саад тотгорыг даван туулах арга замыг тодорхойлоход тусалдаг бөгөөд бодит нөхцөл байдалд нийцсэн шийдэл боловсруулахад чиглэдэг. Хөгжлийн асуудлын тухайд зөвхөн техникийн шийдэлд найдах бус, улс төрийн орчин, институцийн чадамж, оролцогч талуудын ашиг сонирхол, бодлогын хэрэгжилтийн саад бэрхшээлийг нарийн тооцоолох шаардлагатай гэсэн үзэл баримтлал нь энэхүү аргачлалын гол цөм юм (Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.), 2014).

Зураг 2. Тулгамдсан асуудлаар хөтлөгдсөн улс төрийн эдийн засгийн шинжилгээний үндсэн алхам болон гол элементүүд



Эх сурвалж: Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.) (2014). *Problem -Driven Political Economy Analysis: The World Bank's Experience. Directions in Development*

Аргачлал нь үндсэн гурван үе шаттайгаар хэрэгждэг:

Алхам 1. Шийдвэрлэх асуудлыг тодорхойлох – Эхний шатанд улс орон эсвэл салбарын хүрээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлно.

Алхам 2. Асуудлын үндсэн шалтгааныг судлах – Энэ шатанд тухайн асуудал ямар учир шалтгааны улмаас үүссэн, хэрхэн үргэлжилж байгаа талаар улс төрийн эдийн засгийн хүчин зүйлсийг нарийвчлан шинжилнэ. Үүний тулд гурван үндсэн хэмжүүрээр дүгнэлт хийнэ. Үүнд:

- *Бүтцийн хүчин зүйлс (Structural factors)* буюу байгалийн нөөц ба газарзүйн байршил, хүн ам зүйн өөрчлөлт, нийгмийн бүтэц хамаарахаас гадна гадаад хүчин зүйлс хамаарна.
- *Институц (албан, албан бус)-ийн хүчин зүйлс (Institutions - formal and informal)* - Институцийн хүчин зүйлсэд албан болон албан бус институцийн нөлөөлөх хүчин зүйлс хамаарна. Албан институцид хууль дүрэм журам, засаглалын механизм зэрэг албан ёсны бүтэц хамаарна. Харин албан бус институцид улс төрийн соёл, уламжлал, зан заншил, итгэл үнэмшил зэрэг албан бус хүчин зүйлс хамаарна. Институц нь оролцогч талуудын харилцаа, үйл ажиллагаанд сөрөг болон эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Албан бус институциуд нь албан институцитэй нийцэж байвал бодлогын хэрэгжилтийг дэмждэг. Харин нийцэхгүй бол авлига, хээл хахуул, клиентелизм, төрийн албаны завхрал зэрэг сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй.
- *Оролцогч талуудын ашиг сонирхол, эрх мэдэл (Stakeholder interests, constellations, and power)* - Оролцогч талууд нь төрийн байгууллага, улс төрийн нам, бизнесийн бүлэг, олон нийтийн хөдөлгөөн, иргэн гэх мэт янз бүрийн эрх ашиг бүхий бүлгүүд байж болно. Эдгээр бүлгийн хоорондын харилцаа нь бодлого хэрэгжих эсэх, ямар хэлбэрээр хэрэгжихэд голлох нөлөөтэй.

Алхам 3. Шийдлийг тодорхойлох, хэрэгжүүлэх арга зам - Эцсийн шатанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжит арга замуудыг тодорхойлж, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд тохирсон бодлогын стратегийг боловсруулахад анхаарна (Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.), 2014, хуудсд. 4-6).

Дээрх аргачлалын дагуу Верена Фритц (Verena Fritz, 2014) Монгол Улсын улс төр, эдийн засгийн нөхцөл байдлыг шинжилж, институцийн тогтолцоо сул, улс төрийн тогтворгүй байдал, төсвийн удирдлагын доголдол зэрэг хүчин зүйлс нь эдийн засгийн хөгжлийн явцад хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг онцолсон. Тэрээр 2000-аад оны уул уурхайн өсөлтийн үед санхүүгийн сахилга бат сул, төсвийн удирдлага хангалтгүй, урт хугацааны хуримтлал үүсгээгүй

зэрэг институцийн асуудлууд тулгарсан болохыг тодорхойлжээ (Fritz, 2014, pp. 31-66). Улмаар эдийн засгийн өсөлтийн үед төсвийн орлого нэмэгдэхэд, засгийн газар зарцуулалтыг огцом нэмэгдүүлэх хандлагатай болж, харин эдийн засгийн уналтын үед төсвийн алдагдалд орох эрсдэл өндөрсөж, тогтвортой байдлыг алдагдуулах нөхцөл бүрдсэн. Түүнчлэн баялгийн орлогоос хуримтлал үүсгээгүй нь (өөрөөр хэлбэл, төсвийн зохистой удирдлагагүйгээр баялгийн орлогоо шууд зарцуулсан) эдийн засгийн тогтворгүй байдлыг гүнзгийрүүлсэн байна (Fritz, 2014, pp. 41-44). Эдгээр асуудлууд нь улс төрийн тогтолцооны сул, хуваагдмал байдалтай нягт уялдаатай байв. Сонгуулийн мөчлөгөөс хамаарсан төсвийн популист бодлого давамгайлж, улс төрийн намууд сонгууль бүрийн өмнө төрийн зарцуулалтыг нэмэгдүүлэх хандлагатай байна. Энэ нь төсвийн хяналтгүй тэлэлт, санхүүгийн сахилга бат сулрах, урт хугацааны хөгжилд хүндрэл зэргийг үүсгэх гол хүчин зүйлсийн нэг болсон юм (Fritz, 2014, pp. 42-46).

Бусад салбарын нэгэн адил эрчим хүчний салбарын үнийн бодлогод нөлөөлдөг олон оролцогч тал бий. Тэдгээр нь эрчим хүчний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнэ тариф, бодлого, зохицуулалтад өөрсдийн ашиг сонирхол, эрх ашгийг хамгаалахын тулд оролцож, тодорхой нөлөөллийг үзүүлдэг. Гэхдээ эрчим хүч нь улс орны эдийн засаг, иргэдийн амьдралын чанарт чухал ач холбогдолтой стратегийн бүтээгдэхүүн тул уг салбарын үнийн бодлого нь ихэнх улс оронд цэвэр зах зээлийн зарчмаар тодорхойлогддоггүй, харин төрийн зохицуулалттайгаар тогтдог онцлогтой.

Оролцогч талуудыг төр, хувийн хэвшил, хэрэглэгч-айл өрх болон хэрэглэгч байгууллага, иргэний нийгмийн, санхүүгийн болон олон улсын байгууллагууд хэмээн ангилж болно. Эдгээр нь харилцан адилгүй эрх ашиг, сонирхлын үүднээс эрчим хүчний салбарт оролцож, бодлого шийдвэрт нөлөөлөх чадвар нь ч адилгүй байдаг (N.Dorjdari & Ts.Tumentsogt, 2023). Тухайлбал:

- *Төр* нь эрчим хүчний салбарын бодлогыг тодорхойлж, салбарын зохицуулалтын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, зохицуулалтын байгууллагыг байгуулан, зохицуулагчдыг томилж, хараат бусаар зах зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Харин төсөв, санхүү, байгаль орчны асуудал эрхэлдэг яам, агентлагууд нь уг салбарт хөрөнгө оруулалтын болон байгаль орчны чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон төрийн дэмжлэгийг үзүүлэх зохицуулалт хийдэг.
- *Эрчим хүчний зохицуулагч байгууллага* зах зээлд оролцогч талуудын эрх ашиг, үүрэг хариуцлагын тэнцвэрийг хангаж, зохицуулагчийн үүргийг хэрэгжүүлдэг. Ингэхдээ эрчим хүчний зохицуулагч агентлаг (Эрчим хүчний зохицуулах хороо зэрэг байгууллага) нь эрчим хүчний

үнэ, тариф тогтоох, компаниудын үйл ажиллагааг хянах, хөрөнгө оруулалтын зөвшөөрөл өгөх үүрэгтэй.

- *Эрчим хүчний үйлдвэрлэгч-нийлүүлэгчид* - Цахилгаан, дулаан, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч компаниуд нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг гол оролцогч тал юм. Тэд ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг тул эрчим хүчний үнэ, тарифын бодлогод идэвхтэй оролцох сонирхолтой. Эрчим хүчний үнэ нэмэгдэх нь тэдний орлого, ашгийг нэмэгдүүлэх тул үнийн бодлогод ихээхэн анхаарал хандуулдаг. Мөн эдгээр компани хэр ашигтай ажиллахаас эрчим хүчний салбарт хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ хамаардаг.
- *Эрчим хүч дамжуулах, түгээх, хангах байгууллагууд* нь эрчим хүчний эх үүсвэрийг хэрэглэгчдэд хүргэх, үнийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй.
- *Хэрэглэгчид* нь аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхүүд юм. Эрчим хүчний үнэ нь тэдний үйлдвэрлэл, үйлчилгээний өртөг, өрхийн зардалд нөлөөлөх гол хүчин зүйл тул тэдний хувьд аль болох үнийг өсгөхгүй байх сонирхолтой. Иймд эрчим хүчний үнийн бодлогод хэрэглэгчид шууд нөлөөлдөг. Иргэд нэг талаас уг салбарын хэрэглэгч, нөгөө талаас улс төрийн сонгуульд оролцогч-сонгогчид тул эрчим хүчний үнийг нэмэгдүүлэх нь улс төрчдийн хувьд эмзэг асуудал бөгөөд иргэдийн дургүйцэл, эсэргүүцлийг өдөөх шийдвэр юм. Иймд эрчим хүчний үнийг нэмэгдүүлэх сонирхол улс төрчдөд төдийлөн их байдаггүй. Хэрэв эрчим хүчний үнэ өсвөл хэрэглэгчдийн амьдралын чанар, амьжиргааны түвшинд шууд нөлөөлнө. Аж ахуйн нэгжүүдийн хувьд ч гэсэн үнийн өөрчлөлт тэдний үйлдвэрлэлийн өртөг, өрсөлдөх чадварт шууд нөлөөлдөг.
- *Хөрөнгө оруулагчид болон санхүүгийн байгууллагууд* нь салбарт хэрэгжүүлэх төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахад оролцдог. Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгчид нь эрчим хүчний үнийн өсөлтөд чухал нөлөө үзүүлж, улмаар эх үүсвэр нэмэгдүүлэх, технологийг сайжруулахад чиглэсэн томоохон төслүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлэх зорилготой тул үнийн өсөлтийг ихэвчлэн дэмждэг.
- *Иргэний нийгэм болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод* нь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчны асуудалд анхаарлаа хандуулдаг ба эрчим хүчний салбарын мэргэжлийн холбоод нь уг салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын эрх ашгийг нэн тэргүүнд анхаардаг. Тэд эрчим хүчний үнийн бодлогыг

хэрэгжүүлэх, уг салбарт хийх хөрөнгө оруулалтын төслүүдийн явцад ил тод байдлыг хэрхэн хангаж, нөөцийг шударга хуваарилж байгаа эсэхийг хянах, иргэдийн эрх ашгийн төлөө дуу хоолойгоо илэрхийлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

- *Олон улсын байгууллагууд*, ялангуяа Дэлхийн банк, Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Олон улсын эрчим хүчний агентлаг (IEA) зэрэг нь эрчим хүчний бодлого, хөгжлийн асуудлаар зөвлөмж гаргах, хөрөнгө оруулалт хийх, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжих чиглэлд оролцдог.
- *Хэвлэл мэдээллийн байгууллагууд* нь эрчим хүчний зах зээлд хэрэгжих өөрчлөлтийг мэдээлэх, таниулах, аливаа шинэчлэлийн бодлого ялангуяа үнэ тарифын өөрчлөлтийн талаар мэдээллийг түгээж, эргээд хэрэглэгчдийн хариу үйлдэл, санал гомдлыг сонсож түгээх гол суваг болдог.


Олон улсын туршлагаас үзэхэд эрчим хүчний зах зээлд оролцогч талууд нь шууд болон шууд бусаар үнийн болон бусад бодлогод нөлөөлж, эерэг, сөрөг олон үр дагаврыг бий болгодог байна. Иймд эрчим хүчний бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын оролцооны төрөл, хэлбэр, нөлөөллийн хүчийг тооцож, оролцогч талуудын хариу үйлдлийг залах, бодлогоо зөв таниулж хэрэгжүүлбэл салбарын өөрчлөлт, шинэчлэлийг зөв хийх боломжтой.

Арчон Фунг (2006) ардчилсан засаглал дахь талуудын оролцооны төрөл хэлбэрийг судалж оролцооны механизм нь хууль ёсны байдал, шударга ёс, үр дүнтэй бодлого боловсруулахад нөлөөтэй, гэвч тэдгээрийн хэрэгжилт бодит улс төрийн орчин, эрх мэдлийн тогтолцооны нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг гэдгийг онцолсон. Судалгаандаа тэрээр оролцооны механизмуудыг гурван үндсэн хэмжүүрээр тайлбарласан. Үүнд:

1. Хэн оролцож байна вэ?
2. Оролцогч талууд хэрхэн харилцаж, шийдвэр гаргаж байна вэ?
3. Шийдвэр нь бодлогод хэрхэн нөлөөлж байна вэ?

Арчон Фунг (2006) эдгээр гурван хэмжүүр дээр суурилан 'Ардчиллын шоо (*Democracy Cube*)' гэх онолын загварыг боловсруулж, оролцооны арга хэлбэрүүдийг ангилан тодорхойлсон (Fung, Varieties of participation in complex governance, 2006).

Зураг 3. Ардчиллын шооны загвар



Эх сурвалж: Fung, A. (2006). *Varieties of participation in complex governance*, *Public administration review*, хуудсд, 66-75.

Түүнчлэн Арчон Фунг (2020) эрх мэдлийг 'давамгайлал, ноёрхол (*domination*)' -ын өнцгөөс бус, харин эрх мэдлийг ашиглан хүмүүсийг чөлөөлөх (*liberation*) талаас оролцоог авч үзсэн. Ингэхдээ эрх мэдлийг дөрвөн түвшинд ангилан эрх мэдлийг хэрхэн үр дүнтэй ашиглаж, засаглал дахь шийдвэр гаргалтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийг судалсан (Fung, 2020).

Эрх мэдлийн дөрвөн түвшин:

1. *Өдөр тутмын эрх мэдэл (Everyday Power)* – нь хувь хүн, байгууллага хоорондын харилцаа, өдөр тутмын шийдвэрт үзүүлэх нөлөөг буюу хүн бүр өөрийн эрх ашгаа өдөр тутмын амьдралдаа хамгаалах, эрх мэдлээ мэдрэх боломжоор хангагдах нөхцөлийг энэ ангилалд хамруулна. Жишээ нь: хийсэн хөдөлмөртөө нийцсэн шударга цалин хөлс, хими цэвэрлэгээний бизнест тавигдах байгаль орчны шаардлагууд гэх мэт.
2. *Бодлого, хууль тогтоомжийн эрх мэдэл (Policy and Regulatory Power)* – нь хуулиар дамжуулан хүмүүсийн амьдралд үзүүлэх нөлөө буюу хувь хүний эрх ашгийг хамгаалах, ахиулах боломжийг хангах хууль эрх зүй, бодлогын асуудлыг энэ ангилалд хамруулна. Жишээ нь: хөдөлмөрийн хөлсний доод түвшин эсвэл байгаль орчны хууль, дүрэм, журмууд зэрэг багтана.
3. *Бүтцийн эрх мэдэл (Structural Power)* - нь улс төрийн болон нийгмийн хүрээнд үйлчилдэг дүрэм, нөөц, үйл явцуудыг судалж, нийгмийн бүлгүүд болон байгууллагууд хэрхэн шийдвэр гаргалтад нөлөөлдөг



болохыг авч үздэг (Тухайлбал, сонгох эрх, сонгуулийн санхүүжилтийн хууль, үйлдвэрчний эвлэлийн дүрэм зэрэгт).

4. *Ёс суртахууны эрх мэдэл (Ethical Power)* - нь нийгмийн үнэт зүйлс, ёс суртахууны ойлголт, итгэл үнэмшлийн нөлөөг судалж, нийгмийн итгэл үнэмшил болон үнэт зүйл хэрхэн олон нийтийн үзэл бодол, бодлого шийдвэрт нөлөөлж буйг илтгэнэ (Fung, 2020).

Дээр дурдсан эрчим хүчний салбарын засаглал, институцийн судалгааны үр дүнгээс харвал эрчим хүчний үнийг тогтооход хэрэглэгчдийн хариу үйлдэл, нөлөөг хамгийн анхаарахуйц, улс төрийн шийдвэр гаргахад харгалзах хүчин зүйл болгодог зүй тогтол олон улсад байна. Эрчим хүчний салбар, зах зээлийн хямрал гэж нэрлэгддэг нөхцөл байдал нь ихэвчлэн эрчим хүчний салбарт баримтлах “бодлогын хямрал” байдаг (M.Griffin, 1974) бусад улс орнуудын жишээ Монгол Улсын хувьд ч давтагдаж байгаа юм. Эрчим хүчний үнэ тарифыг хэт удаан хугацаанд тогтвортой барьж өртгөөс бага үнээр хэрэглэгчдэд борлуулж байгаа нь нэг талаас эдийн засгийн суурь бүтээгдэхүүн болох эрчим хүчний үнээр дамжуулан өрхийн хэрэглэгчид болон бусад салбарын үйлдвэрлэгчдийг дэмжиж байгаа мэт боловч хэрэглэгчдийг хэт бага үнэд дасгаж хэрэглээгээ хянах соёлд сургахгүй байх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнийн мэдрэмж, хариу үйлдэлд чиглэсэн ялгаатай бодлого хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахаас гадна эрчим хүчний салбарыг эдийн засгийн хүндрэлд оруулдаг сөрөг талтай. Цахилгаан эрчим хүч хэрэглэгчид үнийн өөрчлөлтийг хэрхэн мэдэрч байгааг тогтмол шинжилснээр цаашид үнийн өөрчлөлт нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлт хэрхэн өөрчлөгдөхийг прогноздохоос гадна үнийн талаарх мэдээллийг хүргэх нь тэднийг хэрэглээгээ хянах соёлд сургадаг болохыг судлаачид тогтоосон байна (Frondel & Kussel, 2019). Хэдийгээр үйлдвэрлэлийг буюу нийлүүлэлтийн талыг хянах замаар эрчим хүчний зах зээлийн төлөв байдалд хурдан нөлөөлж, хүндрэлийг даван туулах боломжтой боловч үнийн өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх хэрэглэгчийн ухаалаг шийдэл нь эрчим хүчний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт нөлөөлөх нэг хүчин зүйл байх боломжтой юм.

Ихэнх зах зээлд эрчим хүчний үнийн өөрчлөлтийг мэдрэх хэрэглэгчийн мэдрэмж бага хэдий ч, хэт бага үнэд дассан хэрэглэгчид үнийн өсөлтийг хүлээн авч хэрэглээгээ хянах, бууруулах боломжтой. Түүнчлэн үнийн талаар мэдээлэлтэй хэрэглэгчид нь илүү мэдрэмжтэйгээр хэрэглээгээ хянаж бууруулдаг буюу тарифын мэдээлэл өгснөөр тэдний үнийн өөрчлөлтөд үзүүлэх хариу үйлдэл (мэдрэмж) эрс өсдөгийг харуулсан байдаг (Frondel & Kussel, 2019). Хэрэглэгчдэд цаг агаарын болон зах зээлийн оргил ачааллын үед эсвэл хэрэглээний түвшнээс хамаарч ялгаатай үнэ тогтоох замаар тэднийг хэрэглээгээ ухаалгаар, оновчтой хянах боломжтойг зөвхөн тоон

шинжилгээний аргаар бус туршилтын аргаар ч тогтоосон байна. Тухайлбал, Норвегийн өрхийн хэрэглэгчдийн дунд хийсэн туршилт судалгаанаас үзвэл өрхүүд цаг тутмын өндөр үнэ бүхий дохионы үед цахилгаан хэрэглээгээ бууруулж, уян хатан зохицуулалт хийж чаддаг нь тогтоогдсон. Тэд голчлон цахилгаан халаалт зэрэг хэрэглээг багасгах, зарим ажлуудыг хойшлуулах замаар дасан зохицсон ба үүний үр дүнд оргил цагийн хэрэглээ дунджаар нэг цагт 0.085 кВт.ц буюу 2.92%-иар буурсан байна (Hofmann & Lindberg, 2024).

Түүнчлэн хэрэглэгчид үнийн өсөлтөд үзүүлэх хариу үйлдэл богино хугацаанд бага буюу эхний ээлжид хэрэглээний зуршлаа бага өөрчилдөг ч, цаг хугацаа өнгөрөхөд буюу урт хугацаанд илүү эрчимтэй хэмнэлт хийх, технологио солих, хэрэглээгээ зохицуулах зэргээр хариу үйлдэл үзүүлдэг байна. Иймд цахилгаан эрчим хүчний үнийн өөрчлөлтийн талаарх хэрэглэгчийн хариу үйлдлийг судалж үр дүнг богино хугацааны шийдвэрт ашиглахаас илүүтэйгээр урт хугацааны үнийн бодлогыг тодорхойлох, эрчим хүчний хэмнэлттэй технологи, төхөөрөмж нэвтрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах зэрэг бодлогын шийдлийг боловсруулахад ашиглах хэрэгтэй (Schledorn, et al., 2024). Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн үнийн өсөлтөд үзүүлэх хариу үйлдэл нь дээр дурдсанаар цаг хугацааны хувьд өөрчлөгдөхөөс гадна бүс нутгийн ялгаатай байдал ч нөлөөлдөг байна (Schledorn, et al., 2024). Иймд улс орнуудын эрчим хүчний хэрэглэгчийн зах зээлд ажиглагддаг үнийн өсөлтөд үзүүлэх хэрэглэгчийн хариу үйлдлийн нийтлэг хандлага Монголын эрчим хүчний зах зээлд хэрхэн илэрч байгааг судалгааны асуултуудын хүрээнд судалж, үр дүнг бодлогын шийдэлд ашиглах нь чухал юм.

Эрчим хүчний үнийн шийдвэрийн нөлөөнд шууд өртдөг эцсийн хэрэглэгчээс гадна бодлогын шийдвэрт оролцогч, нөлөөлөгч талууд нь эрх мэдлийн ялгаатай хэлбэрүүдээр харилцан адилгүй хүч, нөлөөтэйгөөр бодлогын үе шатуудад нөлөөлж өөрсдийн эрх ашигт нийцсэн бодлогын хувилбарыг дэмждэг, хэрэгжүүлдэг байна.

2.3. Судалгааны үзэл баримтлал

Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох эрчим хүчний салбарын хамгийн тулгамдсан асуудал болох “цахилгаан эрчим хүчний үнэ”-ийн бодлого, шийдвэрт нөлөөлөгч талуудын оролцоо, тэр дундаа тэдгээрийн эрх мэдэл, сонирхол, нөлөөллийг тодорхойлж эдгээр талуудтай харилцах харилцааны зохистой стратегийн талаар зөвлөмж боловсруулах зорилго бүхий энэхүү судалгааг гүйцэтгэхдээ дараах үзэл баримтлалын хүрээнд судална.

Зураг 4. Судалгааны үзэл баримтлал



Үнийн шийдвэрт оролцогч талуудын оролцоог

- Сонирхол: эдийн засаг, улс төрийн, нийгмийн
- Эрх мэдэл: өдөр тутмын, бодлого, хууль тогтоомжийн, бүтцийн, ёс суртахууны эрх мэдлийн аль хэлбэр
- Нөлөөлөл: хүчтэй нөлөөтэй, сул нөлөөтэй, нөлөөгүй

гэсэн хүрээгээр судална.

Эрчим хүчний үнэ тариф нь зах зээлийн тэнцвэрийг хангах үүрэгтэй бөгөөд нэг талаас үйлдвэрлэгч, нийлүүлэгч (Монгол Улсын эрчим хүчний зах зээлийн хувьд эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчид) нөгөө талаас хэрэглэгч (айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага)-ийн ашиг, сонирхлын тэнцвэрийг хангах зорилготой зохицуулалтын гол хэрэгсэл болдог.

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Ийнхүү эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт оролцогч талуудын оролцоо, оролцооны механизмуудыг Арчон Фунгийн боловсруулсан гурван үндсэн хэмжүүрээр тайлбарлана. Өөрөөр хэлбэл:

1. Хэн, хэрхэн оролцож байна вэ?
2. Оролцогч талууд хэрхэн харилцаж, шийдвэр гаргаж байна вэ?
3. Оролцогч талуудын оролцоо, шийдвэр, хариу үйлдэл нь үнийн бодлого, шийдвэрт хэрхэн нөлөөлж байна вэ?

гэсэн асуултаар судалж оролцооны арга хэлбэрүүдийг ангилна. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг тогтоох шийдвэрийг хараат бус эрчим хүчний зохицуулах байгууллага гаргахаар хуульчилсан боловч бодит байдалд оролцогч талууд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох, энэхүү нөлөөлөлдөө хэрэглэгчдийн хариу үйлдлийг хэрхэн ашиглаж байгааг 2024 онд хийгдсэн үнийн өөрчлөлтийн кейсийг ашиглан судална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1. Судалгааны төрөл

Энэхүү судалгаа нь тодорхойлох судалгаа бөгөөд эрчим хүчний үнийн бодлого тодорхойлоход оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн хүчийг задлан шинжлэх, үнийн өөрчлөлтийн хэрэглэгчдэд үзүүлэх хариу үйлдлийг тодорхойлох зорилготой.

3.2. Өгөгдлийн эх сурвалж

Судалгааны өгөгдлийг анхдагч болон хоёрдогч эх сурвалжаас бүрдүүлсэн.

1. Анхдагч өгөгдөл:

- Асуумжийн судалгаа (өрх болон аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчид)
- Экспертийн үнэлгээ (улс төрч, салбарын бодлогын оролцогч, мэргэжилтэн, судлаачдын төлөөлөл)
- Ганцаарчилсан ба фокус бүлгийн ярилцлага (эрчим хүчний бодлогын оролцогчид, хэрэглэгчид)
- Кейс судалгаа (2024 онд хийгдсэн эрчим хүчний үнийн өөрчлөлтийн бодит жишээнүүд)

2. Хоёрдогч өгөгдөл:

- Эрчим хүчний үнийн бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн актууд
- Эрчим хүчний талаарх статистикийн мэдээлэл, эмхэтгэсэн өгөгдөл
- Олон улсын ижил төстэй судалгааны өгөгдөл, статистик мэдээлэл
- Өргөдөл, гомдол хүлээн авах сувгуудаар ирсэн хэрэглэгчийн гомдол гэх мэт.

3.3. Өгөгдөл цуглуулах арга

Судалгааны өгөгдлийг цуглуулахдаа дараах аргуудыг ашигласан бөгөөд анхдагч болон хоёрдогч эх сурвалжид тулгуурласан. Үүнд дараах үндсэн аргууд багтана:

- Асуулгын арга: Эрчим хүчний гол хэрэглэгчид болох айл өрх болон аж ахуйн нэгж байгууллагуудаас асуумжаар анхдагч өгөгдөл цуглуулж, хэрэглэгчдийн сегмент бүрээр судалсан. Асуумжийн үр дүн нь



хэрэглэгчдийн үнийн өөрчлөлтийн талаарх санал бодлыг тодорхойлж, үнийн шийдвэр тэдэнд ямар нөлөөлөл үзүүлсэн, эргээд хариу үйлдэл нь үнийн шийдвэрт нөлөөлж байгаа эсэхийг дүгнэх боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн асуулгын аргаар эрчим хүчний салбарын экспертүүдээс судалгаа авч, цахилгааны үнэ тарифын зохицуулалт, оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийн байдлыг үнэлж дүгнэсэн.

- Ганцаарчилсан ярилцлагын арга: Судалгааны зорилго, зорилттой уялдуулан эрчим хүчний үнийн шийдвэр гаргагчдын төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Энэхүү аргаар эрчим хүчний үнийн бодлогын талаарх тэдний санал бодол, шийдвэр гаргах процесс, эрх мэдлийн хэрэгжилт, үнийн шийдвэр гаргахад бусад оролцогч талуудаас хэрхэн нөлөөлдөг, эрчим хүчний үнэ тарифын бодлогын ирээдүйн хүлээлт зэргийг тодорхойлсон.
- Фокус бүлгийн ярилцлага: Эрчим хүчний үнийн бодлогын нөлөөлөл, үнийн шийдвэр гаргахад оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг илүү нарийвчлан судлахын тулд фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. Энэхүү арга нь тодорхой бүлгийн оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, санал бодлыг харьцуулах, хандлагыг тодорхойлоход чиглэсэн. Бүлгүүдийн сонголт:

Хэрэглэгч-айл өрх

- Хэрэглэгч- аж ахуйн нэгж
- Эрчим хүчний компаниуд, тусгай зөвшөөрөл эзэмшигчид
- Мэргэжилтнүүд, судлаачдын гэсэн үндсэн бүлгүүдийн төлөөллийг ярилцлагад хамруулсан.

3.4. Өгөгдөл шинжлэх арга

Судалгааны үр дүнг боловсруулж, дүгнэлт хийхдээ тоон болон чанарын шинжилгээний аргуудыг хослуулсан. Энэ нь эрчим хүчний үнийн бодлогын оролцогч талуудын оролцооны механизм, тэдний нөлөөллийн хүчийг нарийвчлан судлах, үнийн өөрчлөлтийн нөлөөллийг бодитоор тодорхойлоход туслах юм.

Хүснэгт 6. Шинжилгээний арга, аргачлал

Шинжилгээний арга	Хэрэглэх аргачлал
Тоон шинжилгээ	SPSS болон статистик шинжилгээний аргаар өгөгдлийг боловсруулж шинжилсэн.
Чанарын өгөгдлийн шинжилгээ	Ярилцлага, фокус бүлгийн ярилцлагын өгөгдлийг нэгтгэн кодолж, сэдэвчилсэн шинжилгээ хийсэн.
Контент шинжилгээ	Контент шинжилгээний хүрээнд цахилгаан эрчим хүчний үнийн өөрчлөлттэй холбоотой холбогдох байгууллагуудад иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар түүвэрлэн авч тематик шинжилгээний аргачлал ашигласан буюу текстэн өгөгдөл доторх давтагдах сэдэв, хандлагыг тодорхойлж, бүлэглэн шинжилгээ хийсэн. Түүнчлэн бодлого, шийдвэрийн баримт бичгүүдийг мөн тематик шинжилгээний аргачлалаар шинжилсэн.
Кейс шинжилгээ	Цахилгаан эрчим хүчний үнийн бодлогын жишээ тохиолдлыг ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын өгөгдөл, мэдээлэлд суурилан нэг эсвэл хэд хэдэн бодит жишээн дээр тулгуурлан тодорхой сэдвийг гүнзгийрүүлэн судалсан. Ингэхдээ бодит кейсийн ажиглалтын арга ашигласан бөгөөд энэхүү аргаар онцгой нөхцөл байдалд орсон хэрэглэгчдийн жишээг судалж, бодлогын өөрчлөлт ямар нөлөөлөл үзүүлж буйг тодорхойлох боломжтой. Тухайлбал, эрчим хүчний үнийн өсөлтийн дараа гарсан хэрэглэгчдийн хариу үйлдэл, улс төрийн шийдвэр гаргалт ба хэрэглэгчдийн эсэргүүцэл гэх мэтийг үялдуулж судалсан.

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

3.5. Эх олонлог, түүвэр

Эх олонлог: Эрчим хүчний зохицуулах хорооны статистик мэдээллээр 2024 оны байдлаар төвийн бүс, түүний дотор Улаанбаатар болон Төв аймгийн хэмжээнд нийт 743.1 мянган эрчим хүчний хэрэглэгч бүртгэгдсэн бөгөөд үүнээс 91.7 хувь буюу 681.4 мянга нь айл өрх, 8.3 хувь буюу 61.7 мянга нь аж ахуйн нэгж, байгууллага байна (Эрчим хүчний зохицуулах хороо, 2024).

Түүврийн аргачлал: Түүврийн сонголтыг санамсаргүй болон зорилтот түүврийн аргуудыг хослуулан гүйцэтгэсэн. Санамсаргүй түүвэр (Random Sampling)-ийн аргаар өрх, аж ахуйн нэгжүүдээс түүврийн хэмжээнд тохирсон байдлаар санамсаргүй түүвэрлэн асуумж авсан бол, зорилтот түүвэр (Purposive Sampling)-ийн аргаар эрчим хүчний үнийн бодлогын оролцогч талууд, салбарын мэргэжилтнүүд, шийдвэр гаргагчидтай ярилцлага, фокус бүлгийн ярилцлага хийсэн.

Асуулга - Түүврийн хэмжээний тооцоо: Түүврийн хэмжээг дараах томьёогоор тооцоолсон:

$$n = \frac{Z^2 p(1-p)}{C^2}$$

Энд: n-түүврийн хэмжээ, Z-итгэх түвшин (95% -ийн итгэх түвшний хувьд $Z=1.96$), p-сонирхож буй хувьсагчийн илрэх магадлал, C-алдааны хязгаар (итгэх завсар). Түүврийн итгэх түвшнийг 95%, харин алдааны хязгаарыг өрхийн хэрэглэгчдэд $\pm 3.5\%$, харин аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд $\pm 4\%$ байхаар сонгосон. Түүврийн хэмжээ: Нийт 1379 хэрэглэгч түүвэрт тооцоологдсон. Судалгааны өгөгдлийн чанарыг нэмэгдүүлэх үүднээс судалгааны төлөвлөлтийн шатанд түүврийг 10 хувиар нэмэгдүүлж, судалгаанд нийт 1516 хэрэглэгч түүвэрт хамрагдахаар тооцоолсон. Үүнээс 862 өрхийн хэрэглэгч, 654 аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэгчдийг хамруулахаар тооцоолсон. Туршилтын судалгааны үр дүнд өгөгдлийн найдвартай байдлыг үнэлж үзэхэд асуулгад оролцогчдын хариулсан байдал, хүчингүй асуумжийн тоог харгалзан судалгааны найдвартай байдлыг нэмэгдүүлэх, төлөөлөх чадвар болон өгөгдлийн чанарын баталгааг сайжруулах, айл өрх болон аж ахуйн нэгжийг дэд бүлгүүд (жишээ нь: орлогын түвшин, өмчийн хэлбэр, байршил)-ээр нарийвчилсан шинжилгээ хийх боломжийг хангах зорилгоор түүврийг 10 хувиар нэмэгдүүлсэн болно.

Хүснэгт 7. Эх олонлог ба түүврийн хэмжээ

Хэрэглэгчийн ангилал	Эх олонлог	Эхний түүврийн тоо	Түүврийг 10%-р нэмэгдүүлсэн түүврийн тоо
Өрх	681,384	784	862
Аж ахуйн нэгж, байгууллага	61,727	595	654
Нийт	743,111	1379	1516

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ) нь ТБНС-ний хэрэглэгчдийн 8.3 хувийг бүрдүүлж байгаа боловч, 2024 онд төвийн бүсийн хэрэглэгчид нийт 7,994.3 сая кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэсний 68.9 хувийг нь ААНБ, 31.1 хувийг өрхийн хэрэглэгчийн хэрэглээ эзэлж байгаа учир түүврийн тоо хэмжээний хувьд ойролцоо байх нь судалгааны үр дүнгийн найдвартай байдлыг мөн нэмэгдүүлсэн.

Экспертийн үнэлгээний оролцогчдын түүврийн хэмжээг зорилтот түүврийн аргаар тодорхойлсон. Энэхүү арга нь цахилгаан эрчим хүчний чиглэлээр мэдлэг туршлагатай гол оролцогч талуудыг сонгон авах боломжийг бүрдүүлсэн. Түүвэр бүрдүүлэхдээ бүлэг бүрийн төлөөлөх чадварыг хангах, салбарын гол оролцогч талуудыг бүрэн хамруулах зарчим баримталсан.

Хүснэгт 8. Экспертийн үнэлгээний оролцогчдын түүврийн хэмжээ

Бүлэг	Оролцогчдын төлөөлөл	Түүврийн тоо
Төр, улс төр	Эрчим хүчний асуудалд анхаарал хандуулдаг улс төрчид, салбарын сайд нарын төлөөлөл	8
	Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагчид	15
Мэргэжилтнүүд	Эрчим хүчний салбарын мэргэжилтнүүд, инженерүүдийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл	15
Судлаачид	Эрчим хүчний чиглэлд ажилладаг судлаачид	7
Нийт		45

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Гүнзгийрүүлсэн ярилцлага, фокус бүлгийн ярилцлагад зорилтот түүврийн аргаар түүврийн хэмжээг тодорхойлсон. Ингэхдээ судалгааны зорилго, хүрээтэй уялдуулан ганцаарчилсан ярилцлагад цахилгаан эрчим хүчний шийдвэрийн гол оролцогч талуудыг хамруулсан бол, фокус бүлгийн ярилцлагад цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид, мэргэжилтэн судлаачдыг хамруулсан.

Хүснэгт 9. Ганцаарчилсан ярилцлагад урих талуудын төлөөлөл, түүврийн хэмжээ

Бүлэг	Тайлбар	Түүврийн тоо
Төрийн төлөөлөл, зохицуулагч, ЭХЗХ-ны мэргэжилтнүүд	Эрчим хүчний үнийн шийдвэрийг эцэслэн гаргадаг ЭХЗХ-ны удирдлага, мэргэжилтэн, зохицуулагчдын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн.	10
Нийт		10 хүн

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хүснэгт 10. Фокус бүлгийн ярилцлагад оролцогч бүлэг, түүврийн хэмжээ

Бүлэг	Оролцогчдын төлөөлөл	Түүврийн тоо	Фокус бүлгийн тоо
Өрхийн хэрэглэгчид	Бага, дунд, их хэрэглээтэй өрхийн төлөөлөл	6–8 хүн	1 бүлэг
Аж ахуйн нэгж-хэрэглэгчид	Үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг бизнесийн төлөөлөл	6–8 хүн	1 бүлэг
Эрчим хүчний компаниуд	Эрчим хүч үйлдвэрлэгч, түгээх, хангах компаниудын төлөөлөл	5–7 хүн	1 бүлэг
Мэргэжилтнүүд, судлаачид	Эдийн засаг, эрчим хүчний салбарын мэргэжилтэн, судлаач, шинжээчид	5–7 хүн	1 бүлэг
Нийт		30 хүн	4 бүлэг

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Гүнзгийрүүлсэн ба фокус бүлгийн ярилцлагыг тусгайлан боловсруулсан удирдамжийн дагуу зохион байгууллаа.

3.6. Судалгааны найдвартай ба хүчинтэй байдал

Өгөгдөл цуглуулах үйл явцад судалгааны найдвартай ба хүчинтэй байдлыг дараах байдлаар хангаж ажиллалаа. Үүнд:

- Бид судалгааны асуумжийг боловсруулж, хоёр үе шаттайгаар туршсан. Эхний шатанд айл өрхийн 70, аж ахуйн нэгж байгууллагын 10 хэрэглэгчээр асуумжийг бөглүүлж, өгөгдлийн боловсруулалтыг хийж, асуулгад хариулах хугацаа, асуултыг ойлгож хариулсан байдал, асуултын зөрчил, нийцэл, уялдаа холбоог шалгаж, эхний хувилбарт өөрчлөлт оруулсан.
- Хэрэглэгчийн туршилт судалгааны дараа асуулгын анкетыг эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдээр бөглүүлж, нэр томьёо, ойлголтыг жигдлэх ажлыг хийж, асуулгын хуудсыг эцэслэн боловсруулсан.
- Асуулгын хуудсыг кодлон, талбарын судалгаанд ажиллах судлаачдад нэгдсэн зааварчилгаа өгсөн. Урьдчилан тооцоолсон түүвэрт сонгогдох хэрэглэгчдийг санамсаргүй байдлаар сонгож судалгаанд хамруулах ба хэрэглэгчдийг асуулгад үнэн зөв хариулах боломж, нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг зааварчилсан.
- Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн холбогдох мэдээллийг авч, судалгааг үнэн зөв бөглөсөн эсэхийг утсаар шалгаж тодруулах зарчмаар ажилласан.
- Ганцаарчилсан ба фокус бүлгийн ярилцлагын удирдамжийг боловсруулж мөрдсөн. Ярилцлагад оролцогчдод мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийг судалгааны зорилгоор ашиглах, ярилцлагын бичлэгийг хийж боловсруулан дүн шинжилгээ хийж ашиглах талаар мэдээлж, зөвшөөрөл авсан. Мэдээллийн боловсруулалтыг хийхдээ ярилцлагад оролцогчдын хувийн мэдээллийг нууцалж, зөвхөн агуулгын шинжилгээ хийсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ҮР ДҮН

4.1. Монгол Улсын эрчим хүчний зах зээлд цахилгаан эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үнийн бодлогын хэрэгжилт


4.1.1. Эрчим хүчний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв, үнэ тарифын зохицуулалтын өнөөгийн байдал

Монгол Улсын цахилгаан эрчим хүч (ЦЭХ)-ний хэрэглээ 2024 онд өмнөх оны гүйцэтгэлээс 643.1 сая кВт.ц буюу 5.9 хувиар нэмэгдэж 11.6 тэрбум кВт.ц болсон ба үүний 75.3 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 24.7 хувийг ОХУ болон БНХАУ-аас импортоор худалдан авсан. Импортоор худалдаж авсан ЦЭХ-ний 50.7 хувийг Оюутолгой ХХК-ийн хэрэглээг хангах зорилгоор, үлдсэн 49.3 хувийг бусад бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн хэрэглээг хангах зорилгоор худалдан авсан байна. Харин дулааны хэрэглээ 1.3 хувиар нэмэгдэж 17.1 сая Гкал болсон байна (Эрчим хүчний зохицуулах хороо, 2024).

Эрчим хүчний салбар 2001 оны эцэст бүтцийн өөрчлөлтөд хамрагдаж одоогийн “нэг худалдан авагчийн загвар” гэж нэрлэгдэж хэвшсэн зах зээлийн зохицуулалттай хэлбэрт шилжих үед салбарт 9 компани цахилгаан түгээх, цахилгаанаар хангах тусгай зөвшөөрөл, 3 компани дулаан түгээх, дулаанаар хангах тусгай зөвшөөрлийг тус тус авч, үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд салбарын хэмжээнд 89.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байв. Тэгвэл 2024 оны байдлаар цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах 33 тусгай зөвшөөрөл эзэмшигч (ТЗЭ) компани, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах 87 ТЗЭ компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд борлуулалтын орлогын хэмжээ 2.2 их наяд төгрөг болж, орлогоор тооцвол зах зээл 25.1 дахин тэлсэн байна. Цахилгаан, дулааны эрчим хүчний борлуулалтын орлогын өсөлтийг Зураг 5-д харуулав.

Эрчим хүчний хэрэглээ, үйлчлэх хүрээ, тоног төхөөрөмжийн хүчин чадал нэмэгдэж байгаатай холбоотойгоор ТЗЭ компаниудын зардал, түүний дотор түлш, ажиллагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг үйл ажиллагааны зардал 2001 онд 96.1 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 1.96 их наяд төгрөг болж 20.4 дахин өссөн байна.


Зураг 5. Цахилгаан, дулааны эрчим хүчний борлуулалтын орлого, тэрбум төгрөг⁹



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Үйл ажиллагааны зардал, салбарын мөнгөн урсгалд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь зээлийн хүү, эргэн төлөлт бөгөөд ДЦС болон цахилгаан дамжуулах ТЗЭ компаниудад зайлшгүй хийгдэх өргөтгөл, шинэчлэлийн ажлыг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн тарифт тусгах замаар эргэн төлдөг. Эрчим хүчний салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны зардлын өсөлтийг дараах зургаар харуулав.

Зураг 6. Эрчим хүчний ТЗЭ-дийн үйл ажиллагааны зардлын өөрчлөлт, тэрбум төгрөг¹⁰



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

⁹ Аймаг, нийслэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн борлуулалтыг оруулж тооцоогүй. 2019 оноос хойш нийт үйл ажиллагааны орлогын дотор нь орон сууц, нийтийн аж ахуйн газар, конторуудаас төвлөрүүлсэн дулааны орлого, аймгийн дулааны станцуудын орлого зэргийг задлан харуулсан. Улаанаар тэмдэглэсэн дүн нь өмнөх жилтэй харьцуулсан өсөлтийн хувь болно.


¹⁰ Зардлын өмнөх жилтэй харьцуулсан өсөлтийн хувийг цэнхэр өнгөөр тэмдэглэв. Тухайлбал, 2024 онд үйл ажиллагааны зардал нь өмнөх онтой харьцуулахад 19 хувиар өссөн байна.

ТЗЭ компаниудын үйл ажиллагааны зардал өссөнөөс гадна салбарын нийт зардалд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдэд төлөх төлбөр юм. Монгол Улсын Их Хурлаас Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг анх 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр баталсан бөгөөд тус хуульд салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВт.ц ЦЭХ-ний үнийг 0.08-0.095 ам.доллар (213-253 төгрөг), нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВт.ц ЦЭХ-ний үнийг 0.15-0.18 ам.доллар (399-478 төгрөг) байхаар тусгасан¹¹. Валютаар тооцож хуульчилсан сэргээгдэх эрчим хүч худалдан авах үнийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний ам.долларын төгрөгтэй харьцах ханшаар тооцвол салхины эрчим хүчийг худалдаж авах үнэ 273.6-324.9 төгрөг, нарны эрчим хүчийг худалдан авах үнэ нь 513-615.6 төгрөг байна. Мөн 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 63 дугаар тогтоолоор “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого” батлагдсан бөгөөд тус баримт бичигт эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүч (СЭХ)-ний эзлэх хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлж СЭХ-ийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж байсан. Улмаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.37 дахь заалтад “Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх” гэж тусгасан. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 2025 оны байдлаар 155 МВт чадалтай 3 салхин цахилгаан станц, 130 МВт чадалтай 7 нарны цахилгаан станц, нийт 285 МВт чадалтай 9 СЭХ-ний станц 2013-2024 онуудад ашиглалтад орсон. Мөн Ухаа-худгийн 18 МВт чадалтай ДЦС болон Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 53 МВт чадалтай ДЦС ашиглалтад орсонтой холбоотойгоор сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдэд төлөх төлбөрийн хэмжээ нэмэгдсэн байна. Энэ нь салбарын нийт зардал, мөнгөн урсгал, улмаар ашиг алдагдалд бодитой нөлөө үзүүлсэн ба валютын ханшийн өсөлттэй холбоотойгоор цаашид ч өсөх хандлагатай байх нь.

Эрчим хүчний салбарын ашигт ажиллагаанд нөлөө үзүүлдэг дараагийн нэг хүчин зүйл нь импортын цахилгаан эрчим хүчний төлбөр юм. ОХУ-аас 2002 онд нийт 37.2 сая кВт.ц ЦЭХ худалдан авч байсан бол 2024 онд 1,320.1 сая кВт.ц ЦЭХ худалдаж авсан бөгөөд үнэ нь 2002 онд дунджаар 35.28 төг/кВт.ц байсан бол 2020 онд 190.50 төг/кВт.ц болж даруй 5.4 дахин нэмэгдсэн байна.

¹¹ 2019.07.01-ний өдрийн валютын ханш 1 ам.доллар 2657.92 төгрөгтэй тэнцэж байв.


Зураг 7. ОХУ-аас худалдаж авсан импортын ЦЭХ-ний төлбөр, тэрбум төгрөг¹²



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүчний хэрэглээний үйлдвэрлэлийн шууд ба шууд зардлын эрчимтэй өсөлт нөгөө талаас энэхүү, өртөг зардлыг нөхөхүйц түвшинд үнэ тарифыг өсгөлгүйгээр хатуу зохицуулалттайгаар тогтоож ирсэн нь тус салбарыг алдагдалтай ажиллах үндсэн нөхцөл болжээ. Салбарын алдагдлын хэмжээг доорх зурагт харуулав.

Зураг 8. Эрчим хүчний салбарын ашиг, алдагдал, сая төгрөг



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүчний салбарын алдагдал сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөн нэмэгдэж 2024 онд 231.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, балансын дүнгээр 3.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Салбарын хуримтлагдсан алдагдалд нөлөөлсөн гол хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэвэл:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үйл ажиллагааны зардлын тасралтгүй өсөлт, үйлдвэрлэлийн түүхий эд болох нүүрсний үнийн өсөлтөөс гадна техник, технологийн хоцрогдол, хуучралаас шалтгаалсан нэмэгдэл зардлын өсөлтийг борлуулалтын орлогоор нөхөх боломжгүй нь хуримтлагдсан алдагдал үүсгэсэн.
- Цар тахлын үед айл өрх, бизнесийн салбарыг дэмжих зорилгоор төрөөс үзүүлсэн үнэ тарифын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нөлөө сүүлийн жилүүдэд салбарын алдагдлыг улам нэмэгдүүлсэн.


¹² Цэнхэрээр тэмдэглэсэн нь импортын ЦЭХ-ний төлбөрийн өмнөх жилтэй харьцуулсан өсөлтийн хувь болно. Тухайлбал, 2024 онд импортын ЦЭХ-ний төлбөр өмнөх онтой харьцуулахад 15.3 хувиар өссөн байна.

- Шинээр ашиглалтад орсон сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэгчдээс нэгдсэн сүлжээнд худалдаж авах ЦЭХ-ний төлбөрийг өндөр тогтоосон нь хэрэглэгчдэд борлуулах тарифыг нэмэгдүүлээгүй нөхцөлд салбарын санхүүд тодорхой хэмжээний дарамт үүсгэсэн.
- Эх үүсвэрийн хомсдолоос үүдэлтэйгээр богино хугацааны эрэлт, эрчим хүчний найдвартай түгээлтийг хангахын тулд техник, технологийн шинэчлэл, их засварыг зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлж, эргэн төлөлтийг тарифт тусгаж байгаа нь мөнгөний урсгалд болон алдагдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна.
- Дээр дурдсан эдийн засаг, санхүүгийн шууд хүчин зүйлсийн зэрэгцээ тус салбарын төрийн өмчийн компаниудад бүтээмж муу, бүтэц, зохион байгуулалт оновчтой биш, хүний нөөцийн удирдлага сул, худалдан авалтын ил тод байдал хангалтгүй зэрэг нь (Удирдлагын академи, 2020) салбарын санхүүгийн алдагдалд нөлөөлөх бас нэг хүчин зүйл билээ.

Эрчим хүчний салбарт хийсэн бүтцийн өөрчлөлтөөр зах зээлийн өнөөгийн хэв маягт шилжсэн 2001 оноос хойш салбар их, бага хэмжээгээр байнгын алдагдалтай байсныг дээр дурсан статистик үзүүлэлтээс харж болох бөгөөд үнийг ямагт үйлдвэрлэлийн өртгөөс доогуур тогтоож ирсэн нь үүний үндсэн шалтгаан юм. Иймд эрчим хүчний үнэ тарифын талаар гаргаж ирсэн шийдвэрүүд, тухайн үеийн нөхцөл байдлыг баримт бичгийн шинжилгээний аргаар шинжилж дүгнэе.

Монгол Улсын хувьд Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д заасан үнэ, тариф тогтоох зарчмын хүрээнд мөрдөж байгаа “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тариф тогтоох аргачлал” нь “Зардал дээр нэмэх” хандлага дээр суурилсан аргачлал юм. Өнгөрсөн хугацаанд ЭХЗХ-оос үнэ тариф тогтоох аргачлалд хэд хэдэн удаагийн өөрчлөлт оруулж, 2014 онд “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам”-ыг баталснаар үнэ тарифыг зөвхөн үйлдвэрлэлийн зардлаас гадна эдийн засгийн бусад хүчин зүйлийг харгалзан индексжүүлэх зарчмыг нэвтрүүлж эхэлсэн. Одоогийн мөрдөж байгаа “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”-ыг ЭХЗХ-ны 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 504 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, 2014-2017 онуудад баталсан холбогдох журмуудыг хүчингүй болгожээ. 2002-2024 оны хооронд үнэ тариф тогтоох аргачлалд орсон өөрчлөлтүүдийн дагуу тооцож энэ хугацаанд цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифт нийт 12 удаагийн өөрчлөлтийг оруулсан байна.

Зураг 9. Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифын өөрчлөлт (2002-2024)



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Цахилгаан, дулааны эрчим хүчний үнийг өөрчлөх өнгөрсөн хугацааны шийдвэр, түүний тухайн үеийн нөхцөл байдал, онцлог, шийдвэрийг хэрэгжүүлэх үеийн нөлөөлөл, үр дагаврыг баримт бичгийн агуулгад шинжилгээ хийж дүгнэн нэгтгэв.

Хүснэгт 11. Эрчим хүчний үнийн өөрчлөлтийн онцлог, нөхцөл байдал, нөлөөлөл

№	Он	Онцлог, нөхцөл байдал	Нөлөөлөл, үр дагавар
1.	2002 он	Цахилгаан, дулааны тарифыг 21.2 хувиар өсгөсөн. Салбарын алдагдлыг бууруулах, зардал нөхөх зорилготой өөрчлөлт.	УИХ-аас ажлын хэсэг томилж улс төрийн нөлөөгөөр тарифын өсгөх шийдвэрийг өөрчилж өсөлтийн хувийг бууруулсан.
2.	2005 он	Цахилгаан, дулааны тарифыг 19.3 хувиар өсгөсөн. Мөн салбарын алдагдлыг нөхөх зорилготой өөрчлөлт хийсэн.	Зах зээлийн оролцогч талуудаас хүчтэй хариу үйлдэл, нөлөө үзүүлээгүй.
3.	2008 он	Цахилгаан, дулааны тарифыг 27.8 хувиар өсгөсөн. Тарифын бүтцийн өөрчлөлтийг хийсэн ба айл өрхийн цахилгааны суурь тарифыг шинээр баталсан.	Зах зээлийн оролцогч талуудаас хүчтэй хариу үйлдэл, нөлөө үзүүлээгүй.
4.	2011 он	Цахилгааны тарифыг 9.5-12.5 хувь, дулааны тарифыг 12.2 хувиар өсгөсөн. Уул уурхай, олборлох боловсруулах аж үйлдвэрийн ангиллын хэрэглэгчийн тарифыг шинээр баталж, тарифын бүтцийн өөрчлөлт хийсэн. Салбарын зардлын өсөлтийг санхүүжүүлэх гол зорилготой. Нүүрсний үнэ, тээврийн тарифын өсөлтийг нөхөх, салбарын ажилтнуудын цалин нэмэх, элэгдлийн зардлыг тарифт тусгах зохицуулалтыг хийсэн.	Зах зээлийн оролцогч талуудаас хүчтэй хариу үйлдэл, нөлөө үзүүлээгүй.

5.	2013 он	Цахилгааны тарифыг 19.3-30.4 хувь, дулааны тарифыг 30 хувь нэмэгдүүлсэн. Уул уурхайн хэрэглэгчдийн цахилгааны тарифыг 30 хувиар, бусад үйлдвэр, ААНБ-ын цахилгааны тарифыг 20%-аар, шөнийн цахилгааны тарифыг 30-50 хувиар нэмэгдүүлж, тарифын бүтцийг хэрэглэгчдэд ойлгомжтой, энгийн байлгах зорилгоор ахуйн хэрэглэгчийн тарифын ангиллыг 150 кВт.ц хүртэлх хэрэглээг тооцох, 151 кВт.ц-аас дээших хэрэглээг тооцох байдлаар тогтоосон. Дулааны үйлчилгээний тариф шинээр баталсан тарифын бүтцийн өөрчлөлтийг хийсэн. УИХ-аас 2010 онд баталсан 72 дугаар тогтоолын үйлчлэх хугацаа дуусаж эрчим хүчний салбарт олгогдсон урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт эхэлсэн нь салбарын алдагдлыг нэмэгдүүлж, улмаар тарифыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болсон.	Орон сууцны айл өрхөд халаалт, хэрэглээний халуун усны төлбөрөөс гадна дулааны үйлчилгээний тарифыг гаргаж сар бүр тогтмол төлбөр төлж эхэлсэнтэй холбоотой хэрэглэгчээс уг тарифыг эсэргүүцэх, тайлбар авах тохиолдол олноор гарч байсан.
6.	2014 он	Цахилгааны тарифыг 16.1-21.3 хувь, дулааны тарифыг 15.2-17.2 хувь, баруун бүсийн цахилгааны тарифыг 38-68.4 хувь тус тус нэмэгдүүлсэн. Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхыг сайжруулах, алдагдлыг бууруулах зорилгоор хэрэглэгчийн тарифт 3 удаагийн тарифын зохицуулалт хийсэн бөгөөд эрчим хүчний тарифыг анх удаа индексжүүлж эхэлсэн.	УИХ-ын 2014 оны «Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай» 34-р тогтоол гарч Монголбанкны Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Үүний үр дүнд салбарын компаниуд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр техник, технологийн шинэчлэл хийсэн. Гэхдээ богино хугацааны зээлийг эргэн төлөх нь салбарын мөнгөн урсгалд нөлөөлж ТЗЭ-чид үүнийг тарифт тусгах шаардлагатайг илэрхийлсэн.

7.	2015 он	Цахилгааны тарифыг 11-18.1 хувь, дулааны тарифыг 15-25 хувиар нэмэгдүүлсэн. Эрчим хүчний системийн оргил ачааллыг бууруулах, хэрэглэгчдийн зохистой хэрэглээг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагуудад цахилгааны чадлын тарифыг нэвтрүүлсэн. Системийн оргил ачааллын хугацаанд буюу 17:00-22:00 цагийн хооронд хэрэглэсэн хэрэглэгчийн бодит чадлыг 9,000 төг/кВт/сар-аар тооцохоор тогтоосон ба оройн оргил ачааллын үед цахилгаан хэрэглэдэггүй, хоногийн бусад цагуудад ажилладаг хэрэглэгчдэд чадлын төлбөрөөс хамаарсан санхүүгийн ачаалал үүсэхгүй байхаар уяан хатан зохицуулалтыг хэрэгжүүлсэн. Аж ахуйн нэгжийн чадлын тариф, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг тус тус шинээр баталсан.	Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг эсэргүүцэж, ЭХЗХ-г шүүхэд өгсөн бөгөөд шүүхээс ЭХЗХ-ны шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн.
8.	2016 он	СЭХ-ийг дэмжих тарифт өөрчлөлт оруулж 0.05 төгрөгөөр бууруулав.	
9.	2017 он	Цахилгааны тарифыг 5.5 хувиар өсгөсөн. СЭХ-ийг дэмжих тарифт өөрчлөлт оруулсан ба Салхин ба нарны цахилгаан станц ашиглалтад орж нэгдсэн сүлжээнд нийлүүлэлт хийж СЭХ-ний нийт 4 эх үүсвэр ашиглалтад орж, нийлүүлэх хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор тарифыг нэмэгдүүлсэн.	Сэргээгдэх эрчим хүчний тариф нь системийн алдагдалд нөлөөлсөн.
10.	2019 он	Цахилгааны тарифыг 16 хувь, дулааны тарифыг 10 хувиар нэмэгдүүлсэн. ЦЭХ-ний тарифыг ОХУ-аас худалдаж авах чадлын тарифтай уялдуулах, хэрэглэгчид ЦЭХ-ний хэрэглээгээ зохицуулж эрчим хүчний төлбөрөө бууруулах боломжийг бүрдүүлэх, мөн тарифын өөрчлөлтийн нөлөөллийг хэрэглэгчдэд бага байлгах зорилгоор тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр зохицуулсан.	СЭХ-ийг дэмжих тарифтай холбоотой санал гомдлууд ирж байсан.

11.	2022 он	Цахилгааны тариф (аж ахуйн нэгж байгууллага) 14-38 хувь, дулааны тариф (аж ахуйн нэгж байгууллага) 28 хувиар нэмэгдсэн. Инфляцад огцом нөлөө үзүүлэхгүй, хэрэглэгчийн төлбөрийн өсөлтийг бага байлгах зорилгоор айл өрхийн цахилгаан, дулааны тарифыг нэмэгдүүлэхгүй, харин аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны үнэ тарифт өөрчлөлт оруулсан.	Уул уурхайн ангиллын хэрэглэгчийн тариф 28-38 хувиар нэмэгдсэнтэй холбоотой Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас тарифын өсөлтийг эсэргүүцэж байсан. Уул уурхайн ангилалд үүрэн холбоо, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, банк, согтууруулах ундаа үйлдвэрлэгчийг оруулсантай холбоотой эдгээр хэрэглэгчийн тариф 50-60 хувиар нэмэгдсэн бөгөөд үүрэн холбоо, интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зүгээс удаа дараа гомдол, санал гаргаж байсан. ААНБ-ын тарифыг хэрэглээнээс хамааруулан шатлалтайгаар ялгаатай нэмснээс шалтгаалан ЦЭХ-ээр хангах гэрээгээ тоолуур тус бүрээр салгуулах, түрээсээр ажилладаг аж ахуйн нэгжид төлбөр тооцоход хүндрэлүүд бий болсон.
12.	2024 он	Цахилгааны тарифыг 29.6 хувиар өсгөсөн. Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр ангиллын дундаж тариф 294 төгрөг байсныг 342 төгрөг болгож 16.3 хувиар, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тариф 222 төгрөг байсныг 291 төгрөг болгож 30.7 хувиар өсгөж, айл өрхийн цахилгааны сарын 0-150, 151-300, 301 кВт.ц-аас дээш хэрэглээний шаталсан тариф тогтоосон. Айл өрхийн дундаж тариф 140 төгрөг байсныг 212 төгрөг болгож 50.8 хувиар өөрчилсөн. Энгийн тоолууртай айл өрхийн тарифыг 0-150 кВт.ц-ийн хэрэглээнд 175 төгрөг болгож 30 хувиар, 151-300 кВт.ц-ийн хэрэглээнд 256 төгрөг болгож 66 хувиар, 301 кВт.ц-аас дээш хэрэглээнд 285 төгрөг болгож 85 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Айл өрхийн хэрэглээнээс хамаарч шаталсан тариф, оргил цагийн цахилгааны тарифын тогтолцоог нэвтрүүлсэн. Дулааны тарифт 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс аж ахуйн нэгж, байгууллагын тарифыг 72.8 хувиар, айл өрхийн тарифыг 100 хувиар өөрчлөлт оруулахаар төлөвлөж байсан.	Дулааны эрчим хүчний үнийг өсгөх шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаар тогтоолын дагуу хойшлуулсан. Тус зохицуулалтаар тарифын өөрчлөлтөөс гадна айл өрхийн дулааны хэмжүүрт суурилсан тарифт шилжүүлэхээр төлөвлөж байсан. Цахилгааны хэрэглээ өндөр айл өрхүүдийн зүгээс бухимдал гарсан. Эрчим хүчний зохицуулах хороо, Засгийн газрын 11-11 төв, цахилгаан түгээх компаниудад ирүүлсэн гомдлыг агуулгаас үзэхэд цахилгааны үнэ тарифыг 30 хувиар нэмэгдүүлнэ гэсэн ойлголт авсан ч, бодит байдалд илүү өсгөсөн, цахилгаан эрчим хүчээр халаалт, дулаанаа шийдвэрлэсэн айл өрхийн цахилгааны төлбөр 70 хүртэл хувиар нэмэгдсэн нь бухимдал үүсгэсэн. Хэрэглэгчид цахилгааныг өдөр, шөнийн цагт тохируулах аргыг хэрэгжүүлж хэвшээгүйгээс хэрэглээ өндөр гарч төлбөр өссөн, орон сууцны дулаан алдагдал өндөр байгаагаас цахилгааны хэрэглээний дийлэнх нь халаалт, дулааныг шийдэхэд зарцуулагдаж байгааг мэргэжлийн байгууллагуудаас хийсэн туршилт, судалгаа нотолсон байна.

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Монгол Улсын эрчим хүчний зах зээлд үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлсэн 20 гаруй жилийн туршлагын талаарх баримт бичгийн агуулгын шинжилгээнээс дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

- ЭХЗХ-оос цахилгаан, дулааны эрчим хүчний үнийг өөрчлөх шийдвэрийг 2002-2024 онуудад 12 удаа гаргаснаас 1 удаа л үнийг бууруулах, бусад нь үнэ, тарифыг өсгөх шийдвэр байсан ба зарим тохиолдолд гэр хорооллын хэрэглэгчдэд тарифын хөнгөлөлт үзүүлэх, шөнийн тарифыг бууруулах зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн бодлогыг ч хэрэгжүүлж ирсэн байна.
- Үнийн өөрчлөлт хийсэн цаг хугацааг харвал УИХ-ын сонгуулийн дараагийн жилд үнийн өөрчлөлтийг хийсэн нь дийлэнх, харин сонгуулийн өмнөх жилд гэр хорооллын хэрэглэгчдэд үнийн хөнгөлөлт үзүүлэх гэх мэт зохицуулалтын шийдвэр гаргаж байснаас үзэхэд суурь үнийг өсгөх нь сонгогчдод нөлөөлөх нэг хэлбэр гэдэг утгаар цахилгаан эрчим хүчний үнийн зохицуулалтад улс төрийн нөлөөлөл тодорхой хэмжээгээр байж ирснийг илтгэж байна.
- 2012-2016 онд үнэ тарифын өөрчлөлтийг хэд хэдэн удаа хийхдээ өсгөхөөс гадна тарифын бүтцийн өөрчлөлтийг хийсэн нь бодит үр дүнгээ өгч 2016 онд салбарын алдагдал хамгийн бага түвшинд хүрч байв.
- Эдийн засгийн эрчимжилттэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөн ба хэрэглээг дагаж үйлдвэрлэл, зардлын өсөлт бий болсон ч зардлын өсөлтийн хурдыг нөхөх хэмжээнд үнийг өсгөх боломжгүй салбар тул байнгын алдагдалтай ажилласаар иржээ.
- Хэрэглэгчдийн гомдлоос үүдэлтэйгээр УИХ, Засгийн газраас үнэ тарифын өөрчлөлтийн үйлчлэх хугацааг хойшлуулах, өсөлтийг бууруулах, зохицуулагчдын гаргасан шийдвэрийг цуцлах тохиолдол 2 удаа гарсан байна.
- 12 удаагийн үнэ тариф өсгөх шийдвэр нь үнийг өсгөхөөс гадна тарифт бүтцийн өөрчлөлт хийж зохистой бодлого хэрэгжүүлэхэд чиглэж байсан ба нэг удаад дунджаар 15-25 хувиар өсгөж иржээ. Үнэ тарифын өөрчлөлт хийсний дараа хэрэглэгчдээс ирүүлсэн гомдол, саналыг авч үзвэл хамгийн сүүлийн буюу 2024 онд хийсэн өөрчлөлтийн дараа илүү олон сувгаар Эрчим хүчний зохицуулах хороо, Засгийн газарт гомдол гаргасан байна.

ЭХЗХ нь үнэ тарифын шийдвэр гаргахдаа баталсан аргачлалын дагуу ажиллахаас гадна, нэг талаас үйлдвэрлэгч, нийлүүлэгч, нөгөө талаас хэрэглэгчдийн ашиг, сонирхлын тэнцлийг хангах түвшинд зохистой тогтоох

бодлого баримталж, урьдчилсан судалгаа, тооцоог хийж, үнэ, тарифын эцсийн шийдвэрийг гаргадаг байна.


Шигтгээ 1. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

...Би Зохицуулах хорооны дарга байхдаа үнийг өөрчлөх шийдвэрийг яг сонгуулийн дараа хийсэн, ямар Засгийн газар томилогдох, сонгуулийн дүн ямар болохыг мэдээгүй байхдаа л шууд хэлэлцээд шийдсэн. Үнэ нэмэх шийдвэрээ гаргасны дараа салбарын сайд дуудаад “яагаад надад мэдэгдэхгүй үнэ нэмсэн бэ?” гэхэд нь “хэрэв танд хэлбэл, Ерөнхий сайд руу ороод ЦЭХ-ний үнэ нэмэх шийдвэр зогсоно, хуулиараа бид хараат бусаар, тооцоо судалгаанд үндэслэж үнэ нэмэх шийдвэр гаргана шүү дээ” гэж хэлсэн. ... ЭХЗХ-ны гаргасан шийдвэр нь Зохицуулах газрын даргаас чөлөөлөх “албан бус” үндэслэл болсон тохиолдол ч байгаа. Ер нь олон хүчин зүйл нөлөөлдөг ч, цахилгаан эрчим хүчний үнийг хөдөлгөх шийдвэр нь ЭХЗХ-ны дарга нарын тухайд “эр зориг” шаарддаг шийдвэр байдаг.

Дээр дурдсан тэмдэглэлээс харахад эрчим хүчний үнэ тарифын шийдвэр гаргахдаа тооцоо судалгаанд үндэслэж үйлдвэрлэгч, хэрэглэгчийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангахаас гадна тухайн үеийн улс төр, эдийн засаг, нийгмийн бусад хүчин зүйл, Засгийн газрын бодлого, шийдвэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзсаар иржээ.

Хэдийгээр сүүлийн 20 гаруй жил эрчим хүчний үнэ тарифыг өсгөх шийдвэрийг гаргаж байсан ч, бусад улс орны хэрэглэгчидтэй харьцуулахад үнэ тарифын хувьд харьцангуй хямд цахилгаан эрчим хүчийг бид хэрэглэж байна.

Зураг 10. Азийн зарим орнуудын хэрэглэгчдийн ЦЭХ-ний үнэ (ам.цент/кВт.ц)-ийн харьцуулалт



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо (2024).
Эрчим хүчний үнийн өөрчлөлтийн талаарх танилцуулга.

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэр гаргах нь ЭХЗХ-ны хэрэгжүүлэх чиг үүрэг боловч энэхүү шийдвэрт оролцогч талууд нөлөөлдөг, мөн хэрэглэгчдийн ялгаатай бүлгүүдэд үнийн өөрчлөлт харилцан адилгүй

нөлөө үзүүлж, улмаар хараат бусаар гаргасан шийдвэрт нөлөөлж, өөрчлүүлэх тохиолдол гардаг. Нөгөө талаас олон жилийн хуримтлагдсан санхүүгийн алдагдал нь энэ салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлс болсон зэрэг нь харагдаж байна. Энэхүү нөхцөл байдлыг тодруулах, дүн шинжилгээг гүнзгийрүүлэх үүднээс үнийн шийдвэр гаргах процесс, туршлагыг дэлгэрүүлэн шинжиллээ.

4.1.2. Цахилгаан эрчим хүчний шийдвэр гаргах үе шат, талуудын оролцооны зохицуулалт

Монгол Улсад 2002 онд “Эрчим хүчний тухай хууль”-ийг шинэчлэн баталж, цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох чиг үүргийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлан, зах зээлийн зарчимд суурилсан, хараат бус, бие даасан зохицуулалтын байгууллага ажиллах эрх зүйн орчин бүрдсэн. Энэхүү тогтолцоо нь үнэ тарифыг мэргэжлийн чиг баримжаа, судалгаа үндэслэлтэйгээр боловсруулж, олон нийтэд мэдээлэх, хуульд заасны дагуу санал авах, тарифын шийдвэрийг батлах шат дараалсан механизмыг агуулсан байдаг.

Эрчим хүчний тухай хуулийн 9.1.4 дэх заалтад зааснаар Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүчний тариф (үнэ) тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй (УИХ, 2001). Мөнхүү хуулийн “Үнэ, тариф” хэмээх дөрөвдүгээр бүлэгт зааснаар тариф тогтооход дараах зарчим баримтлахыг хуульчлан заасан байна. Үүнд:

- үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;
- цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;
- эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх;
- үнийг инфляцтай уялдуулан тооцох;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавх хэвийн байлгахуйц хэмжээнд байх;
- эрчим хүчний тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;
- эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;
- тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал болон оруулсан хөрөнгийн өгөөжийг тооцсон ашгийн зохих түвшнийг хангасан байх.

Дээрх зарчмуудаас харахад Монгол Улсын эрчим хүчний зах зээлд үнэ тариф тогтоохдоо “зардал дээр нэмэх нь” зарчмыг голлон баримтлахын зэрэгцээ сүүлийн жилүүдэд зах зээлд гарч байгаа өөрчлөлтүүдийг харгалзан хэрэглэгч, үйлдвэрлэгчийг урамшуулах, макро эдийн засгийн хүчин зүйл, хэрэглэгчийн бүтэц, хэрэглээний өсөлтийн хандлага, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл зэргийг харгалзан индексжүүлэх зэрэг хосолсон арга хандлагын тодорхой элементүүдийг хэрэглэж байна.

Шигтгээ 2. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

...Манай эрчим хүчний зах зээлд одоо “зардал дээр нэмэх” зарчмыг хэрэглээд явж байгаа. Энэ бол олон улсад хэрэглэдэг л аргачлал. Эх үүсвэрийн дийлэнхийг хуучин станцууд үйлдвэрлэж байгаа буюу нэгэнт элэгдлийн зардлаараа өртгөө нөхсөн үйлдвэрүүд ажиллаж байгаа учир өртөг, зардал бага л гарна. Гэтэл цаашид шинээр өндөр өртөгтэй, зээлийн эх үүсвэрээр баригдах үйлдвэрүүд ашиглалтад орж тэдний үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг сүлжээнд нийлүүлэх тохиолдолд өртөг, зардал өсөх нь гарцаагүй. Үүнийг ч бид тарифын аргачлалд хэрхэн тусгааа бодох л хэрэгтэй. Нэг худалдан авагчийн загвар нэвтрүүлэх эхэн үед гадаадын зөвлөхүүд өөр, өөр аргачлалыг зөвлөж л байсан. Түүнд бас шинэ үйлдвэрүүд ашиглалтад оруулбал яах вэ гэдгийг харгалздаг хувилбар байсан. ...Ер нь ЭХЗХ эдгээр хүчин зүйлсийг урьдчилж тооцоолоод үнийн прогнозоо зарладаг байж болох л байх.

ЭХЗХ-ны зохицуулагчаар ажиллаж байсан төлөөллийг оролцуулсан ганцаарчилсан ярилцлагад оролцогчид үнэ тарифын одоогийн аргачлалыг мөрдөхдөө эрчим хүч үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн зардлаас гадна эдийн засаг, нийгмийн бусад хүчин зүйлсийг харгалзан өөрчилж, сайжруулах хэрэгцээ байгааг ч дурдаж байв.

ЭХЗХ-оос үнэ, тарифын талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”¹³ болон “Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах, шалгах журам”¹⁴-ыг боловсруулан мөрдөж байгаа нь үнэ, тарифын шийдвэр гаргахад ашиглах гол эрх зүйн акт юм. Эдгээр журамд заасан эрчим хүчний үнэ тариф тогтооход баримтлах зарчим, харгалзах хүчин зүйл, шийдвэр гаргах үе шатыг Зураг 11-т харуулав.

Зураг 11-т харуулсан 1-8 ба 13-18 дугаар үе шатууд нь үнэ тарифын зохицуулалтын журам, мөн захиргааны шийдвэр гаргахад холбогдох хууль, тогтоомжид тусгагдсан алхмууд бөгөөд 9-12 дугаар үе шат нь цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах үед ажил хэргийн шугамаар мөрдөгдөж ирсэн “албан бус” зохицуулалт байна. Үнэ тарифын зохицуулалтын энэ үе шатанд хийгддэг нь үнэ тарифт өөрчлөлт оруулах

¹³ ЭХЗХ-ны 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 504 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

¹⁴ ЭХЗХ-ны 2017 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан.

үед ЭХЗХ-оос талуудад илгээсэн албан бичиг, тайлбар, танилцуулга, мөн судалгааны хүрээнд хийсэн ганцаарчилсан ба фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын өгсөн мэдээллээр батлагдаж байгаа юм.

Шигтгээ 3. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

... Миний хувьд 6-7 удаагийн үнэ тариф нэмэх үйл явцад оролцсон, тариф нэмэхэд яг юу болдог вэ гэхээр, “хэрэглэгчийн тариф нэмэх ёстой”, “салбар алдагдалтай байна” гэдгийг бүгд л мэддэг. ЭХЗХ-оос бүх тооцоо, судалгаагаа хийгээд 20-30 хувиар нэмэгдүүлэх ёстой юм байна гээд гаргадаг, энэ судалгаагаа Хорооны дарга нар салбарын сайдтайгаа хоорондоо албан, албан бусаар ярилцана, тооцоогоо бөөндөө очиж танилцуулна. Тэгээд сайд бол Ерөнхий сайдтай ярилцана л гэдэг юм. Тэгээд мөн л уулзана, ажлын албаны хүмүүсээ дагуулж орж танилцуулга хийнэ. Тэр үед тариф нэм ч гэхгүй, нэмэхгүй ч гэхгүй, энэ үед бид мэдээж хичээнэ, бүх нөхцөл байдлаа тайлбарлана, танилцуулна, тооцоо судалгаагаа үзүүлнэ. Харин салбарынхан бол ЭХЗХ нь тариф нэмэх оролдлого хийсэнгүй гээд л шүүмжилдэг, бид үүнтэй холбоотой баахан бичиг, тайлбар холбогдох газруудад явуулдаг, тухайлбал, ЗГХЭГ, УИХ-ын дарга, Ерөнхий сайд гээд хаяглаад илгээнэ. Ажиглаад байхад явж явж эцсийн шийдвэрийг Ерөнхий сайд л гаргаж байна. Гэтэл яг ийм процесс аль ч баримт бичиг, дүрэм журамд байхгүй шүү дээ. Тэр дүрэм журамд нь Зохицуулах хороо хараат бусаар тарифыг тогтооно, индексжүүлнэ, хэрэгжүүлнэ гээд тусгасан хуулийн сайхан заалттай. Гэтэл яг эцсийн шийдвэр бол тэнд очиж гарна. Яагаад Ерөнхий сайд, Засгийн газар тариф нэмж чадахгүй юм гэхээр аргагүй л юм байна лээ л дээ, цахилгаан, дулааны үнэ улсын бүх хүнд л хамааралтай учраас...

Ийнхүү эрчим хүчний үнэ тарифын шийдвэр гаргах үйл явцыг журамлан тогтоосон албан ёсны болон журамлан тогтоогоогүй ч практикт хэрэгждэг “албан бус” үе шатуудыг оролцуулан зураглавал дараах үе шатуудтай байна.

Зураг 11. Эрчим хүчний үнэ тарифын шийдвэр гаргах буюу үнэ тариф тогтоох үе шат



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо

Эрчим хүчний үнэ тариф тогтоохтой холбогдох журам, түүний хэрэгжилтийн практикт үндэслэсэн дээрх зураглалаас үе шатуудыг 4 үндсэн циклд ангилан тухайн циклд оролцогчдын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийг дүгнэж харуулав.

Хүснэгт 12. Эрчим хүчний үнэ тариф тогтоох үе шат, оролцогчдын оролцоог журамласан байдал

Үе шат	Гол оролцогч тал	Сонирхол	Эрх мэдэл	Нөлөөлөл
1-2-р үе шат	Тусгай зөвшөөрөл эзэмшигч (ТЗЭ)	Тарифыг нэмэгдүүлэх	Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны зардлаа үндэслэлтэйгээр боловсруулж санал хүргүүлэх	ЭХЗХ-ны ажлын алба, зохицуулагчдад тайлбарлах шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах
3-7-р үе шат	ЭХЗХ-ны мэргэжлийн баг	Салбарын зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх хамгийн зохистой хувилбарыг гаргах	- ТЗЭ-ийн саналыг хянах, шалгах - Салбарын оролцогч талуудын эрх ашгийн тэнцвэрийг хангахуйц хувилбар боловсруулах - Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тооцоолж гаргах - Түлшний болон тээврийн үнийг хянах	ТЗЭ болон үнийн шийдвэрт нөлөөлдөг Эрчим хүчний бодлого тодорхойлогч талуудад тайлбарлаж нөлөөлөх замаар оновчтой хувилбарыг тооцоолж гаргах
8 ба 13-р үе шат	Нэг талаас хэрэглэгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд, мэргэжлийн холбоод, ЭХЗХ-ны мэргэжлийн баг	- Үнэ тарифыг тогтвортой хадгалах, эрх ашгаа хамгаалах - Салбарын хүндрэлтэй байдлыг ойлгуулах, эсэргүүцлийг бууруулах	- Үнэ өсөх хандлагыг эсэргүүцэх, санал гомдлоо илэрхийлэх - Салбарын нөхцөл байдлын талаар мэдээллээр хангах	ЭХЗХ-ны зүгээс хэрэглэгчдийг мэдээллээр хангах, мэдээлэх замаар үнийн шийдвэрийг зөвшөөрүүлэх, эсэргүүцлийг бууруулах
9-12-р үе шат	ЭХ-ний асуудал эрхэлсэн сайд, Ерөнхий сайд, Засгийн газар	Эрчим хүчний салбарыг тогтвортой байлгах Хэрэглэгч-иргэд (сонгогч)-ийн эрх ашгийг хамгаалах	Эрчим хүчний үнэ, тарифын шийдвэрийг дэмжих эсвэл няцаах	Хуулиар ЭХЗХ-ны шийдвэрт нөлөөлөхгүй боловч зөвшилцөх замаар шийдвэрийг дэмжих, няцаах үүрэг чиглэл өгдөг
14-р үе шат	ЭХЗХ-ны дарга, зохицуулагчид	Салбарын зохицуулалтыг хийж оновчтой шийдвэр гаргах, оролцогч талуудын эрх ашгийг тэнцвэртэй хангах	Үнэ, тарифын шийдвэрийг гаргах	Хараат бусаар, хамтын шийдвэр гаргах

15-17-р үе шат	ЭХЗХ	Эрчим хүчний үнэ тарифын талаарх шийдвэрээ хамгаалах	Оролцогч талуудад мэдээлэл, тайлбар өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Үнийн шийдвэрээ хамгаалах салбарын оролцогч талууд болон Засгийн газар, улс төрчдөд ойлгуулах
18-р үе шат	Хэрэглэгчтэй шууд харьцдаг ТЗЭ (цахилгаан, дулаан түгээх, хангах байгууллагууд) ба хэрэглэгч	ТЗЭ нь хэрэглэгчдэд үнэ тарифын өсөлтийг ойлгуулж мөрдөх Хэрэглэгчид эрх ашгаа хамгаалж үнэ нэмсэн шийдвэрийн талаар саналаа илэрхийлэх	Үнийн шийдвэрт нөлөөлөх эрх мэдэл хязгаарлагдмал	Хэрэглэгчид цахилгаан, дулаанаар хангах, түгээх байгууллагуудад гомдол гаргадаг.

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

ТЗЭ-дийн саналд үндэслэн тарифын хэмжээг мэргэжлийн үндэслэлтэйгээр боловсруулж, олон нийтэд мэдээлэх, хуульд заасны дагуу санал авах, эцэст нь тарифын шийдвэрийг батлах шат дараалсан механизмыг агуулсан, гол оролцогч талуудын сонирхлын тэнцвэрийг ханган, ЭХЗХ буюу зохицуулагчид “хараат бусаар” шийдвэр гаргахаар зохицуулагдсан боловч бодит байдалд эрчим хүчний салбарын бодлого тодорхойлогч буюу Эрчим хүчний сайд, Засгийн газар, зарим тохиолдолд улс төрийн намуудтай зөвшилцөх замаар шийдвэрт хүрдэг байна. Баримт бичгийн шинжилгээний энэхүү үр дүн, дүгнэлтийг дараагийн хэсэгт асуулга судалгаа, ярилцлагын үр дүнтэй харьцуулан, үнийн шийдвэр дэх тэдний эрх мэдэл, нөлөөллийг нарийвчлан шинжлэв.

4.2. Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн асуулга судалгааны үр дүн, дүгнэлт


4.2.1. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл, эх олонлогоо төлөөлөх чадвар

Цахилгаан эрчим хүчний үнийн талаарх хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлон, үнэ тарифын өөрчлөлт хэрэглэгчийн ялгаатай бүлгүүдэд хэрхэн нөлөөлснийг судалж, үнийн талаар баримтлах зохистой бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад чиглэсэн зөвлөмж боловсруулах зорилгоор асуумж боловсруулж, хэрэглэгч айл өрхийг төлөөлсөн 866 иргэн, 698 хэрэглэгч байгууллагыг хамруулан асуулгын аргаар судалгаа хийсэн. Туршилтын судалгааны явцад асуулгад оролцогчдын асуулгад хариулсан байдал, хүчингүй асуумжийн тоог харгалзан судалгааны найдвартай байдлыг нэмэгдүүлэх үүднээс төлөвлөсөн түүврийн хэмжээг өсгөж судалгааг авсан болно. Энэ

нь судалгааны найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлсөн. Судалгаанд хамрагдах түүврийн хэмжээг тогтоохдоо судалгааны баг Төвийн эрчим хүчний системийн хэрэглэгчдийн байршил, айл өрхийн хэрэглэгчдийн орон сууцны төрөл (орон сууц, гэр хороолол, амины орон сууц/хаус), харин байгууллагын хэрэглэгчдийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ангиллыг нь тус бүр харгалзан үзэж мужилсан санамсаргүй түүврийн аргаар тодорхойлсон тул дээрх судалгааны түүвэр нь эх олонлогоо төлөөлөх чадварыг бүрэн хангасан гэж үзэж байна.

Хэрэглэгч айл өрхийн судалгаанд хамрагдсан хүмүүсийн хувьд 35-49 насны бүлэг хамгийн олон буюу 41.7 хувийг эзэлсэн бол, 50-64 насны хэрэглэгч судалгаанд оролцогчдын 26.9 хувь, 20-34 настны ангилал 21.8 хувийг тус тус эзэлсэн нь энэхүү судалгаа нийгмийн хамгийн идэвхтэй насны бүлгүүдийг хамарсан болохыг илтгэнэ. Судалгаанд эмэгтэйчүүдийн оролцоо (59.5 хувь) нь эрэгтэйчүүдээс (40.5 хувь) бага зэрэг илүү байв. Ам бүлийн тооны хувьд 1-4 тооны гишүүнтэй өрхүүд 68.1 хувь буюу дийлэнх хувийг эзэлжээ. Өрхийн орлогын хувьд 1.1-2 сая болон 2.1-3 сая төгрөгийн сарын орлоготой бүлгүүд хамгийн их буюу тус бүр 31.2 хувь ба 29.7 хувийг эзэлсэн бол, 5.1-7 сая болон 7.1 саяас дээш орлоготой өрхүүд хамгийн бага буюу 4.3 хувь, 3.8 хувийг тус тус эзлэв. Орон сууцны төрлийн хувьд судалгаанд хамрагдагсдын 55.6 хувь нь орон сууцанд, 23.8 хувь нь гэр хороололд байшинд, 12.4 хувь нь гэр хороололд гэрт, 7 хувь нь амины орон сууц/хаусанд, үлдсэн 1 хувь нь нийтийн байр болон бусад хэлбэрийн сууцанд амьдардаг байна. Үүнийг зургаар харуулав.

Зураг 12. Судалгаанд оролцогч айл өрхүүдийн орон сууцны төрөл, хувиар



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Судалгаанд хамрагдсан байгууллагын хэрэглэгчдийн хувьд үйл ажиллагааны 20 салбарын төлөөллийг багтаасан ба дийлэнх нь буюу 33.1 хувь нь үйлчилгээ ба бусад үйл ажиллагаа, 14.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 8 хувь нь байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх салбарын төлөөлөл байлаа.

Хүснэгт 13. Судалгаанд оролцсон байгууллагын хэрэглэгчдийн үйл ажиллагааны чиглэл, салбараар

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9	1.3
Уул уурхай, олборлолт	32	4.6
Боловсруулах үйлдвэрлэл	46	6.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	4	0.6
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	13	1.9
Барилга	44	6.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	103	14.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	16	2.3
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	56	8.0
Мэдээлэл, холбоо	19	2.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	10	1.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	12	1.7
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5	0.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	9	1.3
Боловсрол	23	3.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	52	7.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	12	1.7
Үйлчилгээний бусад салбар	231	33.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2	0.3
Нийт	698	100.0

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Үйл ажиллагаа явуулсан жилийн хувьд судалгаанд хамрагдсан байгууллагын 38.6 хувь нь 16-аас дээш жил, 31.5 хувь нь 1-5 жил, 21.4 хувь нь 11-15 жил тус бүр үйл ажиллагаа явуулсан байна. Ажилтны тооны хувьд 9 хүртэлх ажилтантай байгууллага дийлэнх нь буюу 47.6 хувь, мөн 10-19 ажилтантай байгууллага 14.2 хувийг эзэлж байсан бол байгууллагын жилийн

орлого нь 300 хүртэлх сая төгрөг байгууллага 53.6 хувь, 300 сая-1 тэрбум төгрөг байгууллага 21.1 хувийг эзэлсэн нь манай улсын эдийн засагт голлох үүрэг бүхий бичил болон жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарын төлөөллийг сайн хангасан гэж үзэхээр байна. Мөн 200-аас дээш тооны ажилтантай байгууллага 14 хувь, 2.5 тэрбумаас дээш орлоготой байгууллага 17.6 хувийг тус тус эзэлсэн нь судалгааны түүвэр нь мөн том аж ахуйн нэгжийн төлөөллийг ч хангасан болно.

Байгууллагын хэрэглэгчийн асуумжийг голчлон тухайн байгууллагын удирдах албан тушаалтан (30.5 хувь), менежер (28.6 хувь) болон бусад (26.0 хувь) албан тушаалтан бөглөж судалгаанд хамрагдсан. Тэдгээрээс 49.9 хувь нь эрэгтэй, үлдсэн 50.1 хувь нь эмэгтэй байв.

Судалгаанд оролцогч байгууллагын дийлэнх нь буюу 69.3 хувь нь цахилгааны 3 фазын тоолууртай байсан бол, үлдсэн 30.7 хувь нь 1 фазын тоолууртай. Харин цахилгааны төлбөрийн тарифын хувьд дийлэнх нь буюу 63.1 хувь нь энгийн буюу нэг тарифаар, үлдсэн 36.9 хувь нь өдөр, шөнө, оройн 3 тарифаар төлбөрөө төлдөг болохоо илэрхийлжээ.

4.2.2. Үнийн өсөлтийн талаарх цахилгаан хэрэглэгч өрх болон аж ахуйн нэгж байгууллагын санаа бодол

Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаар хэрэглэгчдийн санаа бодлыг асуулгын аргаар тодруулахад, нийт судалгаанд хамрагдсан өрх болон аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-ын хэрэглэгчид үнийн өсөлтийг төдийлөн дэмжихгүй байна. Тухайлбал,

- 'Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж инфляц өснө' хэмээн өрхийн хэрэглэгчдийн 72.6 хувь, ААНБ-ын хэрэглэгчдийн 78.2 хувь нь үзсэн байна.
- 'Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр агаарын бохирдолд сөрөг нөлөө үзүүлнэ' гэж өрхийн хэрэглэгчдийн 68.2 хувь, ААНБ-ын хэрэглэгчдийн 79.4 хувь нь хариулсан.
- 'Өрхийн санхүүд хүндрэл учруулна, ядуурал нэмэгдэнэ' гэж нийт өрхийн хэрэглэгчдийн 65.4 хувь нь үзсэн бол, ААНБ-ын 72.4 хувь нь 'байгууллагын санхүүд хүндрэл учирч алдагдал нэмэгдэнэ' гэжээ.
- 'Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр бизнесийн ашиг буурна' гэж өрхийн хэрэглэгчдийн 65.2 хувь, ААНБ-ын хэрэглэгчдийн 75.2 хувь нь тус тус үзсэн байна.

Гэхдээ судалгааны үр дүнгээс харахад, цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтөөс үүдэлтэй зарим эерэг хандлага илэрч байна. Тухайлбал,

- Өрх болон ААНБ-ын хэрэглэгчдийн аль аль нь цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нь сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх хөшүүрэг болно гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, өрхийн хэрэглэгчдийн хувьд 63.6 хувь, ААНБ хэрэглэгчдийн хувьд 65.4 хувь нь уг хариултыг сонгосон нь цэвэр, тогтвортой эрчим хүчний шийдэл рүү шилжих нийгмийн хандлага, ойлголт төлөвшиж эхэлснийг харуулна.
- 'Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хэрэглэгчдийн хэрэглээнд өөрчлөлт гарч, хэмнэлттэйгээр хэрэглэдэг болно' гэж нийт өрхийн хэрэглэгчдийн хувьд 59.8 хувь, ААН хэрэглэгчдийн хувьд 61.4 хувь нь үзжээ.
- Харин цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр 'эдийн засагт ач холбогдолтой', 'салбар алдагдалгүй болж хөрөнгө оруулалт нэмэгдэнэ', 'үнийг өсгөх нь зайлшгүй' хэмээх эерэг утгатай хариултыг дэмжсэн хэрэглэгчдийн хувь ч бага биш буюу 50-аас дээш хувьтай байна. Эдгээр хариултын дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 14. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх хэрэглэгчдийн санаа бодол (санал нийлэх дүнг хувиар илэрхийлсэн)¹⁵

№	Үнийн өсөлтийн талаарх санаа бодол	Хэрэглэгч-айл өрх	Хэрэглэгч-ААН
1.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь зайлшгүй зүйл байсан	53.8	56.2
2.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь улс орны эдийн засагт ач холбогдолтой	56.4	58
3.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангах ач холбогдолтой	55.6	57.2
4.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хэрэглэгчдийн хэрэглээнд өөрчлөлт гарч, хэмнэлттэйгээр хэрэглэдэг болно	59.8	61.4
5.	Цахилгаан эрчим хүчний үнэ өсөж эрчим хүчний салбар алдагдалгүй болсноор хөрөнгө оруулагчид нэмэгдэх боломжтой	54.6	57.6
6.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах сонирхол нэмэгдэнэ	63.6	65.4
7.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр айл өрхийн санхүүд хүндрэл учирч ядуурал нэмэгдэнэ	65.4	72.4
	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр ААН байгууллагын санхүүд хүндрэл учирч алдагдал нэмэгдэнэ		


¹⁵ Тайлбар: Асуумж тус бүртэй хамгийн өндөр хувиар санал нэгдсэнийг гүн улаан өнгөөр, хамгийн бага хувиар санал нэгдсэнийг гүн хөх өнгөөр тэмдэглэв.

8.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж инфляц өснө	72.6	78.2
9.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хаягдал дугуй, хог түлэх гэх мэтээр агаарын бохирдолд сөрөг нөлөө үзүүлэх зохисгүй үйлдэл нэмэгдэнэ.	68.2	79.4
	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр түүхий эд материал, барааны үнэ өсөж, зардал нэмэгдэнэ		
10.	Бизнесийн байгууллагуудын ашиг орлого буурна.	65.2	75.2

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх айл өрх, болон ААН байгууллагын хэрэглэгчдийн санаа бодлыг тодруулахад, нийт судалгаанд хамрагдсан өрхийн хэрэглэгчдийн 53.2 хувь, ААН байгууллагын хэрэглэгчдийн 59.8 хувь нь цахилгаан эрчим хүч өндөр үнэтэй ч тасралтгүй, найдвартай хангамжтай байх нь чухал гэж хариулсан бол, өрхийн хэрэглэгчдийн 43.7 хувь, ААН байгууллагын хэрэглэгчдийн 34.7 хувь нь цахилгаан эрчим хүчний үнэ бага, тодорхой хэмжээний хязгаарлалттай байх нь чухал гэжээ.

Зураг 13. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдийн санаа бодол, хандлага (санал нийлэх хувиар илэрхийлсэн)



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Эрчим хүчний үнэ тарифын өсөлтийг хэрэглэгчид эсэргүүцдэг боловч хангамжийн найдвартай байдлыг чухалчлах, нөгөө талаас огцом нэмэх биш, салбарын эдийн засгийн нөхцөлтэй уялдуулж нэмэх ёстой гэсэн байр суурийг ч фокус бүлгийн ярилцлагын үед илэрхийлж байлаа.

Шигтгээ 4. Хэрэглэгч айл өрхийн төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс

... Би буруу мэдээлэлтэй байж магадгүй. Тэгэхдээ миний ойлголтоор үнийг хүчээр ингэж барьж байснаас шалтгаалж дулааны цахилгаан станцууд хүндрэлтэй байдалд орсон, эрэлт нийлүүлэлтийнхээ зарчмаар явахаар угаасаа эрчим хүчний үнэ өсөж таарна гэсэн ойлголттой байдаг. Тэгэхээр үнийг нэмэхгүй удаан барьж байгаад нэмсэн, энэ нь угаасаа бодлогогүй явж ирсний жишээ юм болов уу гэж бодож байна.

Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх өрхийн хэрэглэгчдийг орлогын түвшнээр ангилан харвал:

- Орлого багатай өрхүүд (2 сая төгрөг хүртэл)-ийн 50.6-52.2 хувь нь хямд үнэтэй хувилбарыг илүүд үзэх нь давамгайлж байна.
- Дунд түвшний орлоготой (2.1-3 сая төгрөг хүртэл) өрхүүдэд энэхүү хандлага нь тэнцвэржиж, өндөр үнэтэй ч найдвартай хангамжийг илүүд үзэх байдал бага зэрэг давамгайлж байна.
- Харин 3.1 саяас дээш орлоготой өрхүүд өндөр үнэтэй ч найдвартай хангамжийг илүүд үзэж (66.7-68.6 хувь) байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх өрхийн хэрэглэгчдийн санаа бодол, хандлага

Өрхийн орлого	Цахилгаан эрчим хүч өндөр үнэтэй ч тасралтгүй, найдвартай хангамжтай байх	Цахилгаан эрчим хүчний үнэ бага, тодорхой хэмжээний хязгаарлалттай байх	Цахилгаан эрчим хүчний үнэ болон хангамж ямар байх нь надад хамааралгүй	Нийт
1 сая төгрөг хүртэл	46.1%	52.2%	1.7%	115 (14.1%)
1.1 сая -2 сая	47.4%	50.6%	2.0%	251 (30.7%)
2.1 сая -3 сая	50.6%	44.9%	4.5%	245 (30.0%)
3.1 сая -5 сая	68.6%	27.9%	3.6%	140 (17.1%)
5.1 сая -7 сая	66.7%	30.6%	2.8%	36 (4.4%)
7.1 саяас дээш	66.7%	30.0%	3.3%	30 (3.7%)
Нийт	436 (53.4%)	356 (43.6%)	25 (3.1%)	817¹⁶ (100%)

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Харин судалгаанд хамрагдсан 698 ААН байгууллагаас энэ асуултад бүрэн хариулт өгсөн 565 ААН байгууллагын 60.9 хувь нь цахилгаан эрчим хүч өндөр үнэтэй ч тасралтгүй, найдвартай хангамжтай байхыг илүүд үзэж, 34 хувь нь бага үнэтэй, тодорхой хэмжээний хязгаарлалттай хангамжийг, үлдсэн 5.1 хувь нь үнэ болон хангамж ямар байх нь хамааралгүй гэж үзжээ. Үүнийг ААН

¹⁶ Судалгаанд оролцсон 866 өрхийн хэрэглэгчээс 49 нь энэ асуултад хариулаагүй байсан.

байгууллагын орлогын түвшинтэй хамааруулж үзвэл, тогтвортой хангамжийг илүүд үзэх хандлага орлогын түвшин ихсэх тусам нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал:

- 300 саяас доош төгрөгийн орлоготой байгууллагуудын 54.7 хувь нь өндөр үнэтэй ч тасралтгүй, найдвартай хангамжийг чухалчилсан бол, 41 хувь нь хямд үнэ, хязгаарлалттай хангамжийг илүүд үзэж байна;
- 300 сая-1 тэрбум төгрөгийн орлоготой байгууллагуудын 63 хувь нь найдвартай хангамжтай өндөр үнийг, 27.7 хувь хямд үнэ, хязгаарлалттай хангамжийг илүүд үзсэн;
- 1 тэрбум-2.5 тэрбум төгрөгийн орлоготой байгууллагуудын 78.6 хувь нь өндөр үнэтэй, тасралтгүй, найдвартай хангамжийг, 19 хувь нь хямд үнэ, хязгаарлалттай хангамжийг илүүд үзсэн;
- Харин 2.5 тэрбумаас дээш төгрөгийн орлоготой байгууллагуудын 69.2 хувь нь найдвартай хангамжийг, 26.9 хувь нь хямд үнийг тус тус илүүд үзсэн байна.

Эдгээр үр дүн нь үйл ажиллагааны тасралтгүй байдал орлогын хэмжээнд шууд нөлөөлдөг бизнесийн салбарын онцлогийг илтгэж, цахилгааны найдвартай байдлыг үнийн өсөлтөөс илүүд үзэх хандлага байгууллагуудад түлхүү байгааг илтгэнэ. Гэхдээ орлого бага буюу 300 сая хүртэлх төгрөгийн орлоготой байгууллагын 41 хувь нь хямд үнэ, хязгаарлалттай зохицуулалтыг сонгожээ.


Хүснэгт 16. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт болон хангамжийн талаарх ААН байгууллагын хэрэглэгчдийн санаа бодол, хандлага

Байгууллагын орлого	Цахилгаан эрчим хүч өндөр үнэтэй ч тасралтгүй, найдвартай байх нь чухал	Цахилгаан эрчим хүчний үнэ бага, тодорхой хязгаарлалттай байх.	Цахилгаан эрчим хүчний үнэ, хангамж надад болон манай байгууллагад хамааралгүй.	Нийт
300 сая төгрөг хүртэл	54.7%	41.0%	4.3%	300 (53.1%)
300 сая-1 тэрбум	63.0%	27.7%	9.2%	119 (21.1%)
1 тэрбум-2.5 тэрбум	78.6%	19.0%	2.4%	42 (7.4%)
2.5 тэрбумаас дээш	69.2%	26.9%	3.8%	104 (18.4%)
Нийт	344 (60.9%)	192 (34%)	29 (5.1%)	565 (100%)

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Шийдвэр гаргагчид үнийн талаарх мэдээллийг цаашид ямар сувгаар хүргэх нь илүү үр дүнтэйг мэдэх зорилгоор цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх мэдээллийг хэрэглэгчид ямар эх сурвалжаас авч байгааг тодрууллаа. Судалгааны үр дүнгээс харвал өрхийн хэрэглэгчид нийгмийн цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээс үнийн өсөлтийн талаарх мэдээллийг түлхүү авдаг бол, ААН байгууллагын хэрэглэгчид нийгмийн цахим сүлжээ болон илүү албан ёсны баримтажсан эх сурвалжуудаас (төлбөрийн нэхэмжлэх, цахим сайт гэх мэт) мэдээллийг авдаг байна. Гэвч ЭХЗХ-ны цахим сайтаас мэдээлэл авч буй хувь харьцангуй бага байгаа нь төрийн байгууллагын цахим мэдээллийн хүртээмж сул байгааг харуулж байна (Зураг 14).

Зураг 14. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх мэдээллийн эх сурвалж



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг хэрэглэгчдэд танилцуулах, хэлэлцүүлэх байдал сул байдгийг анхаарч, цаашид өөрчлөх шаардлагатай байгааг ч ярилцлагад оролцогчид илэрхийлсэн.

Шигтгээ 5. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

Үнэ тарифын өөрчлөлтийг мэдээлэх олон нийтийн хэлэлцүүлгийг бид өнгөрсөн хугацаанд тун маруухан хийж ирсэн. Олон нийтийн хэлэлцүүлэг хийх нь битгий хэл, ер нь салбартаа ч бараг зарлаж болохгүй гэдэг ийм “командтай” шүү дээ. Хэрэв урьдчилж зарлавал наадах чинь улс төржих мэдээлэл болж “үнэ нэмэх гэж байна” гээд сөрөг хүчин, бусад талуудаас улс төржүүлэх магадлалтай гэсэн болгоомжлол байдаг. Яг сонгодог утгаараа зохицуулалт хэрэгжихгүй байгаа учраас олон нийтийн хэлэлцүүлэг хийх юм бол нээрээ л нэмэхээр төлөвлөсөн юмаа зогсоох эрсдэлтэй, тэгээд тэнд яг хэрэглэгчид нь оролцохгүй, асуудал үүснэ. Өнгөрсөн туршлагаас харахад дэмжиж байсан улсууд хүртэл буруу зохицуулалт хийчхэж гээд яриад байхаар ЭХЗХ-нд ч бас хэцүү байдаг. Яваандаа хэлэлцүүлгийг хийх ёстой юм байна, нөхцөл байдлаа ойлгуулж байх хэрэгтэй юм байна гэдэг бодолтой болоод байна. Судалгааны үр дүнгээс ч, мөн үнэ нэмсний дараа тал талаас ирдэг шалгалтуудаар ч та нар ерөөсөө олон нийтэд хэлээгүй байна, танилцуулаагүй байна гэдэг шүүмжлэл, дүгнэлтүүд ч гарсан. Тэгээд ямар ч байсан бодит үнэнээ ярих ёстой юм байна гэдэг ойлголттой болчихсон.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан аль аль бүлгийн нийт хэрэглэгчдийн 70-аас дээш хувь нь цахилгааны төлбөр нь тоолуурын заалтын дагуу үнэн зөв тооцогддог гэж үздэг. Гэхдээ нийт судалгаанд хамрагдсан өрхийн хэрэглэгчдийн 18 хувь нь ‘байцаагч таамгаар бичдэг’, ‘нэхэмжлэх ойлгомжгүй’ байдаг хэмээн төлбөрийн үнэн зөв, ил тод байдалд шүүмжлэлтэй хандсан. Харин ААНБ-ын 1/5 нь ‘төлбөрийн нэхэмжлэхээ шалгадаггүй’ хэмээн хариулжээ.

Зураг 15. Өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдийн цахилгааны хэрэглээний төлбөрийн тооцооллын талаарх санаа бодол



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт


Энэ хэсгээс харахад хэдийгээр цахилгааны үнэ өсөх нь хэрэглэгчдийн өрхийн болон бизнесийн зардлыг нэмэгдүүлдэг ч, цахилгаан эрчим хүчний тасралтгүй найдвартай байдал нь тэдэнд илүү чухал хэрэгцээтэй гэдгийг

илэрхийлсэн. Мөн эрчим хүчний үнийн мэдээллийг хүртээмжтэй сувгаар хүргэх, тарифын өөрчлөлтийг оролцогч талуудад танилцуулах, хэлэлцүүлэх шаардлага байгааг дурдсан байна.

4.2.3. Үнийн өсөлтөд үзүүлэх хэрэглэгчдийн хариу үйлдэл, нөлөө

Цахилгааны үнийн өсөлт өрх болон ААН байгууллагын хэрэглэгчдэд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад, судалгаанд хамрагдсан нийт өрхийн хэрэглэгчдийн 92.5 хувь нь 'их, бага хэмжээгээр нөлөөлж байгаа', 7.5 хувь нь 'нөлөө үзүүлээгүй' хэмээн хариулсан. Харин ААН байгууллагын хэрэглэгчдийн 96.2 хувь нь 'их, бага хэмжээгээр нөлөөлж байгаа', дөнгөж 3.8 хувь нь л 'нөлөө үзүүлээгүй' гэсэн.


Зураг 16. Өрх болон ААН байгууллагын хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нөлөөлсөн байдал



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Өрхийн хэрэглэгчдийг орлогын түвшнээр нь ангилан цахилгааны үнийн өсөлтийн нөлөөг авч үзэхэд, өрхийн орлогын түвшин нэмэгдэх тусам цахилгааны үнийн өсөлтийн дарамтыг мэдрэх нь буурч байна. Тодруулбал:

- бага орлоготой буюу 1 сая төгрөгөөс доош орлоготой өрхийн 55.6 хувь нь 'ихээхэн дарамт болж байна' хэмээн хариулсан бол,
- харьцангуй өндөр орлоготой буюу 5.1-7 сая төгрөгийн орлоготой өрхийн 31.4 хувь,
- өндөр орлоготой буюу 7.1 саяас дээш төгрөгийн орлоготой өрхийн 20 хувь нь ийм дарамт мэдэрч байгаагаа илэрхийлжээ.

Зураг 17. Цахилгааны үнийн өсөлтийн өрхийн хэрэглэгчдэд үзүүлж буй нөлөө


Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Уг хандлагын статистик хамаарлыг *Kendall's tau-b*¹⁷ корреляцийн шинжилгээгээр шалгахад -0.171 гэсэн сул урвуу хамаарал илэрсэн нь статистикийн хувьд ач холбогдолтой ($p\text{-value} = 0.000$) болохыг нь харуулж байна. Өөрөөр хэлбэл, өрхийн орлого нэмэгдэх тусам цахилгааны үнийн өсөлт нь тухайн өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөө буурах хандлагатай байна.

Хүснэгт 17. Өрхийн хэрэглэгчдийн цахилгааны үнийн өсөлтийн нөлөө болон өрхийн орлогын түвшний хамаарал

Symmetric Measures		Value	Asymptotic Standard Error ^a	Approximate T ^b	Approximate Significance
Ordinal by Ordinal	Kendall's tau-b	-0.171	0.030	-5.689	0.000
N of Valid Cases		817	-	-	-

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт


Цахилгааны үнийн өсөлтийн нөлөөг өрхийн хэрэглэгчдийн орон сууцны төрлөөр нь ангилан авч үзвэл сууцны төрлөөс хамаарч хэрэглэгчдэд үзүүлэх үнийн өсөлтийн нөлөө ялгаатай байна (Зураг 18-г харна уу). Гэр хорооллын гэрт амьдардаг өрхүүдийн 49.1 хувь нь үнийн өсөлтийн ихээхэн дарамтыг мэдэрсэн бол 43.4 хувь нь бага хэмжээгээр нөлөө үзүүлсэн гэж хариулсан. Харин гэр хорооллын байшинд амьдардаг өрхүүдийн 50.2 хувь нь ихээхэн дарамттай гэж үзсэн бол, 46.3 хувь нь бага хэмжээгээр нөлөө үзүүлсэн гэж хариулсан

¹⁷ Kendall's tau-b буюу Кендалын ранкийн корреляцийн коэффициент нь ординал чанарын хувьсагчдын хоорондын хамаарлын хүч, чиглэлийг харуулдаг статистик шинжилгээний аргуудын нэг юм.

Ординал хувьсагчдын хоорондын хамаарлын хүч, чиглэлийг хэмжих Kendall's tau-b, Kendall's tau-c, Gamma гэх мэт параметрийн бус олон аргууд байдаг бөгөөд эдгээрийн утгууд -1-ээс +1-ийн хооронд утга авдаг. (+) утга нь шууд хамаарлыг, (-) утга нь урвуу хамааралтай байгааг харуулдаг бөгөөд ± 1 рүү дөхөх тусам хүчтэй хамаарлыг, 0 рүү дөхсөн байвал сул хамаарлыг харуулдаг.

байна. Орон сууцанд амьдардаг өрхүүдийн 56.5 хувьд нь бага хэмжээгээр, 34.4 хувьд нь ихээхэн дарамт үзүүлсэн, 9.1 хувьд нь үнийн өсөлтөөс нөлөөлөл мэдрэгдээгүй байна. Харин амины орон сууцанд амьдардаг иргэдийн 50 хувьд нь бага хэмжээгээр, 39.7 хувьд нь ихээхэн дарамт үзүүлсэн, харин 10.3 хувьд нь огт нөлөөлөөгүй гэжээ.

Зураг 18. Өрхийн хэрэглэгчдэд цахилгааны үнийн өсөлтийн үзүүлсэн нөлөө, орон сууцны төрлөөр



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Уг хандлагын статистик хамаарлыг *Kendall's tau-b* корреляцийн шинжилгээгээр шалгахад -0.117 буюу сууцны төрөл болон цахилгааны үнийн өсөлтөөс үүдэх дарамтын түвшин хоёрын хооронд сул урвуу хамаарал байгааг илэрхийлж байна. Хэдий хамаарал сул ч гэсэн $p\text{-value} = 0.000$ буюу статистикийн хувьд ач холбогдолтой үр дүн гарсан.

Хүснэгт 18. Өрхийн хэрэглэгчдийн цахилгааны үнийн өсөлтийн нөлөө болон өрхийн орон сууцны төрлийн хамаарал


Symmetric Measures		Value	Asymptotic Standard Error ^a	Approximate T ^b	Approximate Significance
Ordinal by Ordinal	Kendall's tau-b	-0.117	0.032	-3.682	0.000
N of Valid Cases		817	-	-	-

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Харин цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт ААН байгууллагын зардал болон ашигт хэр нөлөө үзүүлж байгааг шинжлэхэд, судалгаанд хамрагдсан нийт ААН байгууллагын 4 хувьд л нөлөө үзүүлээгүй гэжээ. Тодруулбал, бага орлоготой буюу 300 сая төгрөгийн орлоготой байгууллагуудын 47 хувь нь бага хэмжээгээр, 50 хувь нь ихээхэн хэмжээгээр дарамт мэдрэсэн гэсэн нь тэдний санхүүгийн нөөц, зардлын бүтэц цахилгааны төлбөрийн өсөлтөд

мэдрэг байгааг илтгэнэ. ААН байгууллагын орлогын түвшин нэмэгдэх тусам эрчим хүчний үнийн өсөлтийн нөлөө буурах хандлагатай байна. Тухайлбал, 2.5 тэрбумаас дээш төгрөгийн орлоготой байгууллагуудын 66 хувь нь бага хэмжээгээр, 26 хувь нь ихээхэн хэмжээгээр, 8 хувь нь нөлөө үзүүлээгүй хэмээн хариулсан байна (Зураг 19). Уг хамаарлыг *Kendall's tau-b* корреляцийн шинжилгээгээр нягтлахад, үнийн өсөлт болон байгууллагын зардал ашигт нөлөөлөх байдал сул, урвуу хамааралтай буюу -0.145 байгаа нь орлогын түвшин нэмэгдэх тусам цахилгааны үнийн өсөлтөөс үүдэх дарамт тодорхой хэмжээгээр буурч байгааг харуулж байна. Хэдий хамаарал сул хэдий ч *p-value* = 0.000 тул уг хамаарал статистикийн хувьд нэлээд ач холбогдолтой болохыг илтгэнэ (Хүснэгт 19-ыг харна уу).

Зураг 19. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн ААН байгууллагын хэрэглэгчдэд үзүүлсэн нөлөө, орлогын түвшнээр ангилснаар



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хүснэгт 19. Цахилгааны үнийн өсөлтийн ААН байгууллагын хэрэглэгчдэд үзүүлсэн нөлөө болон байгууллагын орлогын түвшний хамаарал

Symmetric Measures		Value	Asymptotic Standard Error ^a	Approximate T ^b	Approximate Significance
Ordinal by Ordinal	Kendall's tau-b	-0.145	0.038	-3.839	0.000
N of Valid Cases		565	-	-	-

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгааны үнийн өөрчлөлтийн хариуд өрх, ААН байгууллагын хэрэглэгчдийн хамгийн түгээмэл үзүүлсэн хариу үйлдэл нь эрчим хүчний хэрэглээгээ хэмнэхийг хичээсэн (64.1-64.6 хувь) бөгөөд нийгмийн сүлжээнд санаа бодлоо хуваалцах (21.7-26.4 хувь), цахилгаан түгээх компанид санал гомдол гаргах (16.5-20.1 хувь), холбогдох яам, байгууллагад санал гомдол гаргасан (10.9-11.4 хувь) бол үнийн өсөлтийг 16.5-19 хувь нь хүлээн зөвшөөрч дасан зохицсон хэмээн хариулжээ (Зураг 20-ыг харна уу).

Зураг 20. Өрхийн болон байгууллагын хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт дэх хариу үйлдэл




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт хэрэглээний хэв маягт томоохон өөрчлөлт үзүүлээгүй байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн хэрэглэгчдийн 44.1 хувь нь хэрэглээгээ хянаж эхэлсэн, 47.8 хувь нь хэрэглээндээ өөрчлөлт гаргаагүй, хэвээр байгаа бол 8.1 хувь нь хэрэглээгээ нэмсэн хэмээн хариулжээ. Харин судалгаанд хамрагдсан нийт ААН байгууллагын хэрэглэгчдийн 32.8 хувь нь хэрэглээгээ хянаж эхэлсэн, 58.4 хувь нь ямар нэг өөрчлөлт хийгээгүй, хэрэглээ хэвээр байгаа, харин 8.8 хувийнх нь хэрэглээ нэмэгдсэн байна.

Цахилгааны үнийн өсөлт хэрэглээнд хэрхэн нөлөөлж буйг өрхийн сарын орлогын түвшнээр ангилан авч үзэхэд, бага орлоготой (1 сая төгрөгөөс доош) өрхийн 41.1 хувь нь хэрэглээгээ хянаж багасгасан, 46.7 хувь нь хэрэглээгээ өөрчлөөгүй, хэрэглээ хэвээр гэж хариулсан. Дундаж орлоготой өрхүүд (2.1-5 сая төгрөгийн орлоготой)-ийн цахилгааны хэрэглээгээ хянах, багасгах нь арай өндөр (43.4-46.3 хувь) байгаа хэдий ч, хэрэглээ хэвээр гэсэн хариулт давамгайлж (47.5-49.3 хувь) байна. Харин өндөр орлоготой буюу 7.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн хувьд хэрэглээгээ хянаж эхэлсэн гэх хариулт хамгийн өндөр хувьтай буюу 50 хувийг эзэлж, 43.3 хувь нь хэрэглээ хэвээр гэж хариулжээ. Эндээс харахад цахилгааны үнийн өсөлт амьжиргаанд нь нөлөөлж эхэлсэн ч хэрэглээгээ танаж, цахилгааны зардлаа бууруулах хариу үйлдэл төдийлөн сайн хийгдээгүй байна. Үр дүнг дараах зургаар харуулав.


Зураг 21. Өрхийн хэрэглэгчдийн үнийн өсөлтийн дараах цахилгааны хэрэглээнд гарсан өөрчлөлт /орлогын түвшнээр/



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хэрэглээгээ тодорхой хэмжээгээр хянахдаа хэрэглэгчид ямар аргыг ихэвчлэн хэрэглэж буйг тандахад судалгаанд хамрагдсан өрхүүд цахилгаан хэрэгслээ хэрэглээгүй үедээ унтраах, орон байрны дулаанаа хадгалах, гэр, байшингаа дулаалах зэрэг аргыг нэвтрүүлж байна.

Зураг 22. Өрхийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчийг хэмнэх аргуудын хэрэглээ (санал нийлсэн хувь)




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгааны үнийн өсөлттэй холбоотойгоор хэрэглээндээ өөрчлөлт оруулсан байдлыг өрхийн орлогын түвшин болон сууцны төрөлтэй харьцуулан үзэхэд дараах хандлагууд ажиглагдаж байна. Өрхийн орлогын түвшнээр харьцуулбал:

- ‘Хэрэглээгээ хянаж, хэмнэх’ нь бүхий л өрхийн орлогын түвшинд хамгийн түгээмэл хариу үйлдэл байв. Тухайлбал, бага орлоготой өрхүүд (1 сая төгрөгөөс доош)-ийн 35 хувь, дундаж орлоготой өрхүүд (2.1–5 сая төгрөг)-ийн 37–40 хувь болон өндөр орлоготой өрхүүд (7.1 саяас дээш)-ийн 46 хувь нь ‘хэрэглээгээ хянаж, хэмнэсэн’ байна.
- ‘Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах’ хувилбарыг бага орлоготой өрхүүдийн 11–12 хувь, дундаж орлоготой өрхүүдийн 9–17 хувь, харин өндөр орлоготой өрхүүдийн 21 хувь нь ашигласан байна.
- ‘Дулаан алдагдлыг бууруулах’ оролдлого орлогын бүх түвшинд харьцангуй жигд буюу дунджаар 12–17 хувийн хооронд хэлбэлзэж байна.
- ‘Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хайх’ оролдлогыг бага орлоготой өрхүүдийн 8 хувь, дундаж орлоготой өрхүүд (3.1–5 сая)-ийн 10 хувь, өндөр орлоготой өрх (7.1 саяас дээш)-үүдийн 18 хувь нь хийснээ илэрхийлжээ.

Эдгээр үр дүнгээс харахад орлого өндөрсөх тусам хэрэглээгээ хянах, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй техник хэрэгслийн сонголт хийх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах идэвх санаачилга нэмэгдэж буйг харж болно.

Зураг 23. Орлогын ялгаатай бүлгийн айл өрхийн үнийн өөрчлөлтөд үзүүлсэн хариу үйлдэл




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Харин өрхийн сууцны төрлөөр хариу үйлдлийг нь харьцуулан авч үзвэл:

- ‘Хэрэглээгээ хянаж, хэмнэх’ нь хамгийн нийтлэг хэрэглэдэг арга гэж нийтийн байранд амьдардаг өрхүүдийн 43 хувь, гэр хороололд гэрт амьдардаг өрхүүдийн 39 хувь, орон сууцанд амьдардаг өрхүүдийн 39 хувь, амины сууцтай өрхүүдийн 34 хувь нь хариулжээ.
- Эрчим хүчний үнэ нэмэгдсэнээс үүдэлтэйгээр хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах аргыг амины орон сууц (хаус)-д амьдардаг өрхүүдийн 15 хувь, гэр хорооллын байшинд амьдардаг өрхүүд болон нийтийн байранд амьдардаг өрхүүдийн 14 хувь нь ашиглахыг зорьж байна.
- Орон сууцныхаа дулаан алдагдлыг бууруулах замаар цахилгааны төлбөрөө хянах оролдлогыг гэр хорооллын гэр болон байшинд амьдардаг өрхүүдийн 21 хувь, амины сууцанд амьдардаг өрхүүдийн 16 хувь, орон сууцанд амьдардаг өрхүүдийн 10 хувь нь туршжээ.
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хамгийн идэвхтэй хайж туршсан нь амины сууцны хэрэглэгчид (18 хувь), гэр хорооллын байшинд амьдардаг өрхүүд (14 хувь), гэрт амьдардаг болон орон сууцны хэрэглэгчид (7 хувь) байна.

Зураг 24. Орлогын ялгаатай бүлэгт хамаарах өрхийн хэрэглэгчдийн үнийн өөрчлөлтөд үзүүлсэн хариу үйлдэл




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгааны үнийн өсөлт ААН байгууллагын хэрэглээнд хэрхэн нөлөөлж буйг байгууллагын орлогын түвшнээр ангилан авч үзэхэд, орлогын ялгаатай ангилал бүхий ААН байгууллагуудын дийлэнх нь цахилгааны үнэ өссөн ч хэрэглээгээ өөрчлөөгүй, хэвээр хадгалсан байна. Тухайлбал, жилийн орлого

нь 300 сая төгрөг хүртэлх орлоготой байгууллагын 58 хувь, 300 сая-1 тэрбум төгрөгийн орлоготой байгууллагын 62 хувь, 2.5 тэрбумаас дээш орлоготой байгууллагын 59 хувь нь 'хэрэглээ хэвээр' гэж хариулжээ.

Зураг 25. Орлогын ялгаатай бүлэгт хамаарах ААН байгууллагын хэрэглэгчдийн үнийн өсөлтийн дараах хариу үйлдэл



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Судалгаанд хамрагдсан ААН байгууллагын цахилгаан хэмнэх хамгийн түгээмэл аргууд нь гэрлээ унтраах, цахилгаан хэрэгслээ хэрэглээгүй үедээ унтраах, барилга байгууламжийн дулааныг хадгалах, дулаалах, мэдрэгчтэй гэрэл ашиглах зэрэг аргуудыг нэрлэсэн байна.

Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтөд ААН-үүд хэрхэн хариу арга хэмжээ авч буй нь байгууллагын жилийн орлогын түвшнээс хамаарч ялгаатай байна. Тухайлбал:

- Ажилтнуудад цахилгаан хэмнэх талаар санамж өгөх нь хамгийн өргөн хэрэглэгдсэн арга хэмжээ байсан бөгөөд ялангуяа 300 сая төгрөг хүртэлх орлоготой байгууллагуудын дунд хамгийн түгээмэл (49 хувь) хэрэглэгджээ. Харин бусад орлогын бүлгүүдийн хувьд энэ хариу үйлдэл дунджаар 28-37 хувьтай байна. Энэ нь хүний нөөцөд чиглэсэн зардал багатай, хурдан хэрэгжих боломжтой хариу арга хэмжээ ба бага орлоготой байгууллагууд үүнд онцгой ач холбогдол өгчээ.
- Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашигласан байдал бүх байгууллагад ажиглагдаж байгаа ч орлогын хэмжээ өсөхийн хэрээр хэрэгжүүлэлтийн идэвх нэмэгдэх хандлагатай. Тухайлбал, 300 сая хүртэл орлоготой байгууллагуудын 12 хувь, 1-2.5 тэрбумын орлоготой байгууллагуудын 20 хувь, 2.5 тэрбумаас дээш орлоготой байгууллагуудын 28 хувь нь ийм төрлийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлжээ. Энэ нь хөрөнгө оруулалт шаарддаг техник, технологийн

хариу арга хэмжээ тул санхүүгийн боломжтой байгууллагуудад богино хугацаанд бодитой хэрэгжсэн байна.

- Барилгын дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ нь орлогын түвшнээс үл хамааран харьцангуй жигд хийгдсэн арга хэмжээ байв. Орлогын бүлгүүдийн дунд 13-17 хувь байна.
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хайх арга хамгийн идэвхтэй хэрэгжсэн бүлэг нь 1-2.5 тэрбум төгрөгийн орлоготой байгууллагууд (35%) байлаа. Бусад орлогын түвшний бүлэгт хамаарах байгууллагуудын хувьд энэ хариу үйлдэл 7-13 хувьтай байв. Энэ нь дунд түвшний орлоготой байгууллагууд шинэ, тогтвортой эх үүсвэр хайх хэрэгцээ болон боломжийг хамгийн оновчтой хослуулж байгааг харуулж байна (Зураг 26-г харна уу).

Зураг 26. ААН байгууллагын хэрэглэгчдийн үнийн өсөлтөд үзүүлсэн хариу үйлдэл, орлогын түвшний бүлгээр



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Эрчим хүчний үнэ нэмэгдэхэд хэрэглэгчдийн одоо гаргаж буй хариу үйлдлээс гадна цаашид үнэ дахин нэмэгдвэл хэрхэх талаар асууж, тэдний зан төлөвт өөрчлөлт гарах эсэхийг тандсан хоёр асуулт асуусан.

Өмнө дурдсанчлан, эрчим хүчний үнэ нэмэгдсэн хагас жилийн хугацаанд өрх болон ААН байгууллагын хэрэглэгчид тодорхой өөрчлөлтийг хийж эхэлсэн ч хэрэглэгчид хариу үйлдэл үзүүлэхэд тодорхой хугацаа хэрэгтэй. Түүнчлэн, тэдний зан төлөвт өөрчлөлт гарахад бүр ч урт хугацаа хэрэгтэй билээ. Энэ үүднээс ирээдүйд хийх үйлдлийг нь тандаж “Цаашид эрчим

хүчний үнэ дахин өсвөл та ямар хариу үйлдэл үзүүлэх вэ?” хэмээн асуухад давхардсан тоогоор өрхийн хэрэглэгчийн 1025 хариулт, ААН байгууллагын хэрэглэгчдийн 841 хариултын 40 гаруй хувь (өрх 48 хувь, ААН байгууллага 40.5 хувь) нь ‘Шударга бус хэмээн эсэргүүцэх’-ээ илэрхийлсэн бол 27 орчим хувь (өрх 27.9 хувь, ААН байгууллага 26 хувь) нь ‘хэрэглээгээ хязгаарлана’, 15-22 хувь нь ‘шинэ технологи ашиглаж хэрэглээгээ хэмнэнэ’, 10 орчим хувь нь ‘нөхцөл байдалтайгаа эвлэрэн одоогийн хэрэглээгээ үргэлжлүүлнэ’ гэв. Эндээс өөрсдийн хэрэглээгээ технологийн болон бусад шийдлээр хязгаарлах хэрэглэгчид 43-48 хувь байгаа нь сайшаалтай. Гэхдээ ЭХЗХ цаашид үнэ нэмэхдээ хэрэглэгчдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарах магадлал өндөр байгааг анхаарах шаардлагатай нь энэхүү асуултын хариултаас харагдаж байна.

Хүснэгт 20. Цаашдын үнийн өсөлтөд үзүүлэх хариу үйлдэл


Хариулт	Хэрэглэгч-айл өрх	Хэрэглэгч-байгууллага
Хэрэглээгээ хязгаарлана	27.9%	26.2%
Шинэ технологи (сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр зэрэг) ашиглана	15.2%	21.8%
Шударга бус гэж үзэж эсэргүүцнэ	48.0%	40.5%
Нөхцөл байдалтай эвлэрч, хүлээн зөвшөөрнө	8.9%	11.5%
Нийт хариултын тоо¹⁸	1025	841

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хэрэглэгчийн хийх хариу үйлдлийг илүү тодруулах зорилгоор “Цаашдаа эрчим хүчний үнэ өсвөл цахилгаан хэмнэх дараах аргуудыг ашиглах бодолтой байна уу?” хэмээн асуухад дараах хариултаа өгсөн.

¹⁸ Олон сонголттой хариулт бүхий асуулт байсан учир хариултын тоо нь асуулгад оролцогчийн тооноос өндөр байна.

Зураг 27. Эрчим хүчний үнэ өсвөл цахилгаан хэмнэх аргуудыг ашиглах хандлага



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Эдгээр хариултаас харахад өрхийн хэрэглэгчид эхний ээлжид гэр, орон байраа дулаалах (62.2 хувь), эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах (50.5 хувь), мэдрэгчтэй гэрэл ашиглах (48.6 хувь) сонголтуудыг хийхээ илэрхийлсэн. Мөн сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж ашиглах (44 хувь), хана таазаа гэгээтэй өнгөөр будах (тийм-48 хувь, магадгүй -38 хувь) зэрэг аргыг ч цаашид хэрэглэх боломжтойгоо “магадгүй” гэсэн хариултын хүрээнд өгчээ. ААН байгууллагын хэрэглэгчид нь байгалийн агааржуулалтыг хэрэглэж цахилгаанаа хэмнэх (65.2 хувь), мэдрэгчтэй гэрэл ашиглах (64.2 хувь), барилгаа дулаалах (61.7 хувь), эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах (59.3 хувь) аргуудад илүү их санал өгчээ. Өрхийн хэрэглэгчтэй нэгэн адил сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж ашиглах (тийм -31.1 хувь, магадгүй -48.3) сонирхол ч өндөр байна.

2024 оны төгсгөлд цахилгаан эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэний дараа хэрэглэгчдийн гаргасан гомдлыг судалж шийдвэрлэсэн мэдээллийг авч үзэхэд цахилгаанаар халаалтаа шийдвэрлэсэн айл, өрхүүд нэлээд хувийг эзэлж, түүний дотор дулааны алдагдал өндөртэй айл, өрх олон байжээ. Ийм тохиолдолд цахилгааны төлбөр нэмэгдсэн нь тэднийг орон байрны дулааны алдагдлаа бууруулах зэрэг энгийн алхам хийж эхлэхэд ч нөлөөлжээ.

Шигтгээ 6. Хэрэглэгчийн гомдолд хийсэн дүн шинжилгээний тайлангаас

2025 оны 01 дүгээр сарын 23 ний өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 4 ний өдрийг хүртэл хугацаанд Улаанбаатар хотын нийт 123 хэрэглэгчийн гомдлыг ЭХЗХ, УБЦТС ТӨХК-ийн хамтарсан ажлын хэсгээс судалсан байна. Гомдол гаргасан хэрэглэгчийн халаагуурын төрлийн хувьд ангилбал нийт гомдлын 13 хэрэглэгч буюу 11 хувийг хосолмол халаалттай, 105 хэрэглэгч буюу 86 хувийг цахилгаанаар халаалттай, 4 хэрэглэгч буюу 3 хувийг бусад төрлийн халаалттай хэрэглэгч эзэлж байна. Гомдол гаргасан айл өрхүүдийн барилгын дулаан алдагдлыг хэмжихэд 51 хэрэглэгчийн байр, орон сууцанд хананы дулаан алдагдалтай, 69 хэрэглэгч байр орон сууц шалны дулаан алдагдалтай, 67 хэрэглэгчийн хувьд тааз, дээврийн дулааны алдагдалтай, 93 хэрэглэгчийн хана, дээврийн уулзвар хэсэгт дулаан алдагдалтай байсан ба цахилгаан эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэн цаг хугацаанд нь гадна хүйтний эрч нэмэгдсэн нь хэрэглээний өсөлтөд шууд нөлөө үзүүлжээ.

Үнийн өсөлтөд үзүүлэх хэрэглэгчийн хариу үйлдлийг тандах асуултуудын хариултаас үзэхэд эрчим хүчний үнийн өсөлт нь хэрэглэгчдийн зан төлөв, хэрэглээний хандлагад эерэг нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.

4.2.4. Үнэ тарифын зохицуулалт, нөлөө бүхий этгээдийн талаарх хэрэглэгчийн мэдлэг

“Цахилгаан эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах хэрэгтэй гэж бодож байна вэ?” гэсэн асуултад өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдийн санал нийлсэн хариулт (тухайн өгүүлэмж тус бүртэй огт санал нийлэхгүйгээс бүрэн санал нийлэх гэсэн 5 хариултын хувилбартай байсан) ойролцоо үр дүнтэй гарсныг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 21. Эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах талаарх хэрэглэгчдийн санал бодол

№	Асуултууд	Хэрэглэгч-айл өрх	Хэрэглэгч-байгууллага
1.	Эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн зарчмаар, эрэлт нийлүүлэлттэй уялдуулж тогтоох	66%	71%
2.	Инфляцтай уялдуулан тогтмол өөрчилж байх	58%	61%
3.	Алдагдлаа нөхөх хэмжээнд байх	65%	69%
4.	Алдагдалтай ч төрөөс зохицуулан үнийг бага байлгах	64%	64%
5.	Шөнийн цагийн хөнгөлөлтийг байнга хэрэгжүүлэх	77%	80%
6.	Оргил ачааллын үед хэрэглэсэн цахилгааны үнийг илүү өндөр тогтоох	52%	54%
7.	Хэрэглээний хэмжээгээр ялгаатай үнэ тариф тогтоох	63%	65%
8.	Сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн, эрчим хүчээ хэмнэсэн хэрэглэгчдийг урамшуулах	75%	78%
9.	Хэрэглэгч цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж бусад хэрэглэгчдэд борлуулахыг дэмжих, худалдаж авах үнэ тарифыг нэмэх	62%	70%
10.	Зуны цагт ажил, сургууль, цэцэрлэгийн эхлэх цагийг эрт болгож байгалийн гэрэлтүүлгийг илүү ашиглан цахилгааны хэрэглээг бууруулах	71%	75%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт




Өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдийн хувьд шөнийн цагийн хөнгөлөлтийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь маш чухал (өрх -77 хувь, ААН байгууллага -80 хувь); мөн сэргээгдэх хүчийг дэмжих, эрчим хүчний хэмнэлт хийсэн хэрэглэгчдийг урамшуулах (өрх -75 хувь, ААН байгууллага -78 хувь); зун цагт ажил, сургуулийг эрт эхлүүлэх (өрх -71 хувь, ААН байгууллага -75 хувь) зэрэг нь эрчим хүчний зардлаа хэмнэхэд ихээхэн ач холбогдолтой болохыг илэрхийлсэн. Хэдийгээр эрчим хүчний үнэ нэмэгдсэн нь хэрэглэгчдэд сөргөөр нөлөөлж байгаа ч, эрчим хүчний үнэ тарифыг эрэлт, нийлүүлэлттэй нь уялдуулж, зах зээлийн зарчмаар тогтоох (өрх -66 хувь, ААН байгууллага -71 хувь); инфляцтай уялдуулан тогтмол өөрчлөх (өрх -58 хувь, ААН байгууллага -61 хувь) нь зүйтэй гэдэгтэй хэрэглэгчид санал нэгдэж байна. Харин оргил ачааллын үед хэрэглэсэн цахилгааны үнийг өндөр тогтоох аргатай хэрэглэгчид төдийлөн санал нийлэхгүй (өрх -52 хувь, ААН байгууллага -54 хувь) байгаа нь тэдний хариултаас харагдана (Хүснэгт 21).

Өрхийн сарын дундаж орлогоос хамаарч тэдний санаа бодол ялгаатай байгаа эсэхийг нягтлахад ялгаатай байдал бараг ажиглагдсангүй. Сарын дундаж орлого 5 сая төгрөгөөс дээш өрхүүд “Сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн, эрчим хүчээ хэмнэсэн хэрэглэгчдийг урамшуулах” (82-85 хувь), “Шөнийн цагийн хөнгөлөлтийг байнга хэрэгжүүлэх” (81-83 хувь) нь чухал болохыг онцолсон нь эдгээр хариултын дундаж хувь болох 75-77 хувиас ч харагдана. Эндээс орлогын түвшин өндөрсөх тусам цахилгааны үнийн өсөлтөд илүү их өртөж байгаа тул эдгээр бүлгийн ахуйн хэрэглэгчид цахилгааны зардлаа хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний технологийг өөрсдийн байр сууцдаа ашиглах сэдэл илүү их болж байгаа эерэг үр дүнг илтгэнэ. Уг хандлага нь өрхийн сууцны төрлөөр ангилахад ч ажиглагдсан бөгөөд амины орон сууц (хаус)-д амьдардаг иргэд шөнийн цагийн хөнгөлөлтийг байнга хэрэгжүүлэх (85 хувь), сэргээгдэх эрчим хүч хэрэглэн эрчим хүчээ хэмнэх (84 хувь) сонирхолтой байгаагаа илэрхийлсэн нь бусад төрлийн сууцанд амьдардаг өрхүүдийнхээс хамаагүй өндөр байна.

Эрчим хүчний үнийг зохицуулах талаарх энэхүү асуултын хариулт бүрээр өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчид хэрхэн хариулсныг дараах зурагт дэлгэрэнгүй харуулав.

Зураг 28. “Цахилгаан эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах хэрэгтэй вэ?” асуултын хариулт (Өрхийн хэрэглэгчдийн хариулт, хувиар)



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хэдийгээр өрх болон ААН байгууллагын хэрэглэгчдийн хувьд аль аль нь эрчим хүчний үнийг зах зээлийн зарчмаар тогтоох, сэргээгдэх эрчим хүч хэрэглэх, эрчим хүч хэмнэвэл урамшуулах, шөнийн цагийн тарифыг үргэлжлүүлэх зэргийг адилхан дэмжиж байгаа ч, ААН байгууллагын хэрэглэгчдийн хувьд байгууллагын орлого, зардал, цахилгааны тоолуураас хамааралтайгаар ялгаатай санаа бодол бий эсэхийг мөн шинжилж үзсэн. Жилийн орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш том ААН байгууллагын хувьд ‘Сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн, эрчим хүчээ хэмнэсэн хэрэглэгчдийг урамшуулах’ (86 хувь), ‘Шөнийн цагийн хөнгөлөлтийг байнга хэрэгжүүлэх’ (85 хувь) гэсэн хариултуудыг хамгийн их сонгосон бол, 1-2.5 тэрбум төгрөгийн жилийн орлоготой дунд аж ахуйн нэгжүүд ‘Зуны цагт ажил, сургууль, цэцэрлэгийн эхлэх цагийг эрт болгож байгалийн гэрэлтүүлгийг илүү ашиглан цахилгааны хэрэглээг бууруулах’ (84 хувь), ‘Сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн, эрчим хүчээ хэмнэсэн хэрэглэгчдийг урамшуулах’ (81 хувь) хийх нь илүү чухал гэж үзсэн. Асуултад хариулсан байдал нь байгууллагуудын сарын дундаж зардал болон хэдэн фазын тоолууртайгаас хамаарахгүйгээр ижил байгаагаас харахад ААН байгууллагын хэрэглэгчид бүхэлдээ адил чиг хандлагатай байна. Түүнчлэн, өрх болон ААН байгууллагын хэрэглэгчдийн аль аль нь орлого, зардал, сууцны төрөл, тоолуурын ялгаатай байдлаас үл хамааран ‘Оргил ачааллын үед цахилгааны үнийг өндөр тогтоох’, ‘Инфляцтай уялдуулан тогтмол өөрчлөх’ замаар эрчим хүчний үнийг тогтоох нь оновчгүй зохицуулалт хэмээн үзэж байна.

Эрчим хүчний үнийн зохицуулалтын хувьд хэрэглэгчид үнийг зах зээлийн зарчмаар уян хатан тогтоож, хэрэглээгээ хэмнэх, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, шөнийн цагаар хөнгөлөлттэй тарифаар ашиглах зэрэгт урамшуулал үзүүлэхийг дэмжихийн зэрэгцээ зуны цагт байгалийн гэрлийг

ашиглан ажил, сургуулийн цагийн хуваарийг зохицуулах байдлаар эрчим хүчээ аль болох хэмнэх сэдэлтэй байгааг дээрх хариултуудаас харж болно. Энэ нь хэрэглэгчид болох өрх, аж ахуйн нэгж байгууллагууд “өдөр тутмын эрх мэдэл”-ийнхээ хувьд өөрсдийн эрх ашгаа хамгаалан аль болох эрчим хүчээ хэмнэх сэдэлтэй байгаагийн зэрэгцээ эрчим хүчний үнийг зохицуулахдаа хэрэглэгчдийн хэрэглээнд шууд хязгаарлалт хийн тэдний эрх мэдэлд халдахад дурамжхан байх нь харагдана.

Эрчим хүчний үнийн бодлогод оролцохын тулд үнийн шийдвэрийн оролцогч талууд, шийдвэр гаргагчдын талаар хэрэглэгчид мэддэг байх учиртай. Мэдлэг, мэдээлэлтэй оролцогчид эрх мэдлээ эдэлж, илүү нөлөөлөлтэй оролцон, бусадтайгаа үр дүнтэй харилцаж чадах билээ. Иймд судалгааны хүрээнд үнийн шийдвэр гаргагч нь хэн болох, үнийн бодлогод хэрэглэгчид нөлөөлж чаддаг эсэх, тэд үнийн мэдээллийг хэр сайн авдаг талаар асуусан билээ.

Эрчим хүчний тухай хуулийн 8.1-д “Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, **үнэ тарифыг тогтоох**, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй” хэмээн заасан (УИХ, 2001). Харин эрчим хүчний хэрэглэгчид үнийг мэддэг эсэхийг тодруулж асуухад нийт хэрэглэгчдийн 1/3 нь л (өрхийн хэрэглэгчдийн 30.7 хувь, ААН байгууллагын хэрэглэгчдийн 33.7 хувь) ЭХЗХ үнэ тогтоодог хэмээн хариулжээ.

Хүснэгт 22. Эрчим хүчний үнийг хэн тогтоодог талаарх хэрэглэгчдийн ойлголт, мэдлэг

Хариулт	Хэрэглэгч-өрх	Хэрэглэгч- байгууллага
УИХ	8.6%	8.1%
Засгийн газар	18.3%	16.4%
Эрчим хүчний яам	22.2%	23.4%
Эрчим хүчний зохицуулах хороо	30.7%	33.7%
Цахилгаан түгээх компаниуд	5.4%	7.3%
Иргэдийн оролцоо, санал асуулгаар	8.1%	7.3%
Мэдэхгүй	6.7%	3.8%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Энэхүү олон хариулттай асуултад хариулсан 1,260 хариултын 110 (8.6 хувь) нь эрчим хүчний үнийг УИХ тогтоодог гэсэн бол, Засгийн газар болон Эрчим хүчний яамыг үнэ тогтоодог хэмээн 517 хариулт (40.5 хувь) гарсан. Сонирхолтой нь иргэдийн оролцоо, санал асуулгаар эрчим хүчний үнийг тогтоодог хэмээн 8.1 хувь нь хариулсан байна. ААН байгууллагын оролцогчдын хувьд ч энэ талаарх мэдлэг хангалтгүй байна. Учир нь ААН байгууллагын хэрэглэгчдээс өгсөн 1,084 давхардсан хариултын 39.8 хувь нь Засгийн газар болон яам

үнэ тогтоодог, 8.1 хувь нь УИХ, 7.3 хувь нь цахилгаан түгээх компаниуд, мөн 7.3 хувь нь иргэдийн оролцоо, саналаар үнэ тогтоодог гэжээ. Эндээс эрчим хүчний үнийг тодорхойлогч субъектийн талаарх хэрэглэгчдийн мэдлэг тун хангалтгүй байна.

Өрхийн дундаж орлого болон “Таны бодлоор эрчим хүчний үнийг хэн тогтоодог вэ?” асуултын хооронд харьцуулан үзэхэд орлого багатай иргэд эрчим хүчний үнийг ЭХЗХ тогтоодгийг хамгийн бага (27.3 хувь) мэдэж байгаа бол, 7.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн хэрэглэгчийн энэ талаарх мэдлэг хамгийн сайн (44.2 хувь) байв. ‘Иргэдийн оролцоотойгоор үнэ тогтдог’ гэдэгт бага орлоготой иргэд хамгийн өөдрөг (9.3 хувь) итгэдэг бол, 7.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн 2.3 хувь нь л үүнд итгэдэг байна (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Эрчим хүчний үнийг хэн тогтоодог талаарх хэрэглэгчдийн мэдлэгийн өрхийн дундаж орлогын бүлгээр ангилж харуулсан байдал

Өрхийн дундаж орлого	УИХ	Засгийн газар	Эрчим хүчний яам	Эрчим хүчний зохицуулах хороо	Цахилгаан түгээх компаниуд	Иргэдийн оролцоо, саналаар	Мэдэхгүй	Нийт хариултын тоо
1 сая төгрөгөөс доош	7.5%	15.5%	23.6%	27.3%	7.5%	9.3%	9.3%	161
1.1-2 сая	9.5%	20.1%	22.6%	25.6%	4.8%	9.5%	7.8%	398
2.1-3 сая	7.7%	18.8%	19.6%	33.9%	4.8%	8.5%	6.9%	378
3.1-5 сая	9.5%	15.4%	22.6%	35.3%	6.8%	5.9%	4.5%	221
5.1-7 сая	10.9%	17.2%	31.3%	28.1%	4.7%	6.3%	1.6%	64
7.1 саяас дээш	7.0%	18.6%	20.9%	44.2%	2.3%	2.3%	4.7%	43

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Өрхийн сууцны төрөл болон “8.1 Таны бодлоор эрчим хүчний үнийг хэн тогтоодог вэ?” хэмээх олон хариулттай асуултыг шинжлэхэд өмнөх хариултуудтай ойролцоо байгаа ч гэр хороололд гэрт амьдардаг өрхийн 6.9 хувь нь ‘цахилгаан түгээх компаниуд үнэ тогтоодог’, 9.2 хувь ‘иргэдийн оролцоотойгоор үнэ тогтоодог’ гэсэн бол амины орон сууцанд амьдардаг өрхөөс ‘цахилгаан түгээх компаниуд үнэ тогтоодог’ гэж хэн нь ч хариулаагүй (0 хувь), ‘иргэдийн оролцоотойгоор үнэ тогтоодог’ гэж 5.6 хувь нь л хариулжээ (Хүснэгт 24). Ерөнхийдөө орлого нэмэгдэх, сууцны төрөл сайжрахын хэрээр иргэдийн оролцоотойгоор үнэ тогтдог гэдэгт иргэд итгэх нь багасаж байна.

Хүснэгт 24. Эрчим хүчний үнийг хэн тогтоодог талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг сууцны төрлөөр ангилж харуулсан байдал

Өрхийн дундаж орлого	УИХ	Засгийн газар	Эрчим хүчний яам	Эрчим хүчний зохицуулах хороо	Цахилгаан түгээх компаниуд	Иргэдийн оролцоо, саналаар	Мэдэхгүй	Нийт хариултын тоо
Гэр хороололд гэрт	4.6%	17.7%	26.2%	20.8%	6.9%	9.2%	14.6%	130
Гэр хороололд байшинд	590.0%	19.4%	23.0%	30.6%	4.6%	11.5%	4.9%	304
Нийтийн байранд	16.7%	0.0%	16.7%	33.3%	0.0%	16.7%	16.7%	6
Орон сууцанд	9.4%	17.6%	21.2%	32.8%	6.3%	6.8%	5.7%	731
Амины орон сууц (хаус)-д амьдардаг	16.9%	21.3%	21.3%	27.0%	0.0%	5.6%	7.9%	89

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

ААН байгууллагын өмчийн хэлбэрээс хамаарч дээрх хариултад ялгаатай байдал ажиглагдаж буй эсэхийг нягтлахад хувьцаат компаниудын өгсөн хариултад 'ЭХЗХ-оос үнэ тогтоодог' гэсэн хариулт хамгийн өндөр (43.4 хувь) байгаа ч, цахилгаан түгээх компани (5.3 хувь), иргэдийн саналаар тогтоодог (6.2 хувь) гэсэн хариултауд ч байна. Харин төрийн болон орон нутгийн өмчит, төсвийн байгууллагууд 'иргэдийн саналаар үнэ тогтоодог', мөн 'Засгийн газар болон Эрчим хүчний яамнаас үнэ тогтоодог' гэсэн хариултыг илүү өгсөн нь ААН байгууллагын хэрэглэгчдийн дунд үнэ тогтоогч субъектийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байгааг илтгэнэ (Хүснэгт 25).

Хүснэгт 25. Эрчим хүчний үнэ тогтоогч субъектийн талаарх ААН байгууллагын ойлголт мэдлэг, өмчийн хэлбэрээр


Байгууллагын өмчийн хэлбэр	УИХ	Засгийн газар	Эрчим хүчний яам	Эрчим хүчний зохицуулах хороо	Цахилгаан түгээх компаниуд	Иргэдийн оролцоо, саналаар	Мэдэхгүй	Нийт хариултын тоо
Хувьцаат компани (ХК)	8.8%	15.0%	17.7%	43.4%	5.3%	6.2%	3.5%	113
Төрийн өмчит аж ахуйн нэгж	8.2%	16.6%	24.1%	32.1%	7.8%	6.9%	4.2%	841
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	7.3%	12.2%	19.5%	39.0%	12.2%	9.8%	0.0%	41
Төсвийн байгууллага	2.9%	17.1%	25.7%	34.3%	5.7%	11.4%	2.9%	35
Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)	11.1%	18.5%	25.9%	31.5%	1.9%	11.1%	0.0%	54

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Уг асуултад хариулсан ААН байгууллагын албан тушаалтнуудын хувьд хариултауд нь ойролцоо байв. Бусадтайгаа харьцуулахад нягтлан бодогч нар 'цахилгаан түгээх компаниуд' (4.4 хувь) болон 'иргэдийн оролцоотойгоор (4.4 хувь) үнэ тогтдог' гэж хамгийн бага хариулжээ. Сүүлийн хариултын хувьд удирдах албан тушаалтнууд (8.4 хувь) болон бусад албан тушаалтнууд (10.6 хувь) 'иргэдийн оролцоотойгоор үнэ тогтдог' хэмээн өөдрөг төсөөлөлтэй байдаг ажээ.

Судалгааны үзэл баримтлалын хүрээнд дэвшүүлсэн оролцогч талуудын эрчим хүчний үнэ тогтооход оролцдог эсэх, нөлөөлж чадаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор Асуулт 8.2 “Эрчим хүчний үнийн бодлогод танай ААН байгууллагын санал бодол тусдаг уу?” болон Асуулт 8.3 “Та эрчим хүчний үнийг тогтооход нөлөөлж чадах уу?” гэдгийг асуусан.

Зураг 29. Эрчим хүчний үнийн бодлогод та, танай ААН байгууллагын санал бодол тусдаг уу?



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хэрэглэгчдийн хариултаас харахад цахилгаан эрчим хүчний үнийн бодлогод тэдний санал тусдаггүй (өрх -71 хувь, байгууллага -74.3 хувь) гэж үздэг бөгөөд дөнгөж 8 хувь нь л саналаа тусгадаг гэжээ. Мөн хэрэглэгчдийн 20 орчим хувь нь энэ талаар мэддэггүй байна.

Үүнтэй уялдаатай “Та эрчим хүчний үнийг тогтооход нөлөөлж чадах уу?” гэсэн олон сонголттой асуулт асуухад өрхийн хэрэглэгчдийн хариултын 58 хувь, ААН байгууллагын хэрэглэгчдийн хариултын 64 хувь нь “эрчим хүчний үнэ тогтооход ямар ч нөлөө үзүүлж чадахгүй” гэсэн сонголт байв.

Хүснэгт 26. Та эрчим хүчний үнийг тогтооход нөлөөлж чадах уу?

Хариулт	Хэрэглэгч-өрх	Хэрэглэгч-байгууллага
Эрчим хүчний үнэ тогтооход би ямар ч нөлөө үзүүлж чадахгүй	58%	64%
Би өөрийн хүрээллээрээ (эрчим хүчний салбарын танил тал, эрх баригч, улс төрчдөд ойр байдал) дамжуулан үнийн өсөлтөд нөлөөлж чадна	6%	4%
Өөрийн сонгосон УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчөөрөө дамжуулан нөлөөлж чадна	9%	6%
Нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлж нөлөөлнө	25%	23%
Би цахилгаан эрчим хүчний үнэ тогтооход бүрэн нөлөөлж чадна	3%	3%
Нийт хариултын тоо¹⁹	949	754

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

¹⁹ Олон сонголттой асуулт байсан тул хариултын тоо нь оролцогчийн тооноос олон байна.

Гэхдээ оролцогчдын нийт хариултын ¼ орчим хувь нь нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлэх замаар нөлөөлж чадна гэсэн бол, 10 хүрэхгүй хувь нь төлөөллийн ардчиллын зарчмаар сонгосон шийдвэр гаргагчид болох УИХ-ын гишүүн, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөө уламжлах байдлаар нөлөөлж чадна гэжээ. Мөн нөлөө бүхий этгээдэд лобби багаар дамжуулан үнийн өсөлтөд нөлөөлж чадна гэж өрхийн хэрэглэгчдийн 6 хувь, ААН байгууллагын 4 хувь нь үзсэн байна. Өрх болон ААН байгууллагын хэрэглэгчдийн дөнгөж 3 хувь нь л эрчим хүчний үнэ тогтооход бүрэн нөлөөлж чадна гэсэн итгэлтэй байна.

Хэдийгээр талаас илүү хувь нь үнэ тогтооход нөлөөлж чадахгүй гэсэн боловч өрхийн хэрэглэгчдийн өгсөн хариулт нь өрхийн сарын дундаж орлогоос хамаарч ялгаатай байгаа эсэхийг шинжлэхэд орлого багатай өрх (1 саяас доош төгрөг) сонгосон УИХ болон ИТХ-ын төлөөлөгчдөөрөө дамжуулан нөлөөлж чадна (15.4 хувь) гэдэгтээ тодорхой хэмжээгээр итгэлтэй байгаа бол нийгмийн сүлжээгээ дамжуулан нөлөөлөх (20.3 хувь), өөрийн хүрээллээрээ нөлөөлөх (6.5 хувь), өөрөө нөлөөлж чадна (4.9 хувь) гэдэгтээ итгэл муутай байна. Эсрэгээр өндөр орлоготой (7.1 саяас дээш төгрөг) өрхүүд сонгосон УИХ болон ИТХ-ын төлөөлөгчдөөрөө дамжуулан нөлөөлнө гэдэгтээ огт итгэхгүй, харин нийгмийн сүлжээгээр дамжуулан нөлөөлөх (27.8 хувь), өөрийн хүрээллээрээ нөлөөлөх (16.7 хувь), өөрөө нөлөөлж чадна (8.3 хувь) гэдэгтээ итгэлтэй байна. Дундаж орлоготой өрхүүд (2.1-5 сая төгрөг) эрчим хүчний үнэ тогтооход өөрсдөө нөлөөлж чадна гэдэгт хамгийн бага (0.6-1.1 хувь) итгэж байгаа нь сонирхолтой дүр зураг юм. Хүснэгт 27-оос харахад бага орлоготой иргэд төлөөллийн ардчилалд итгэх итгэлээ бүрэн алдаагүй байгаа бол, орлого нэмэгдэхийн хэрээр өөрөө болон өөрийн хүрээллээрээ дамжуулан лоббидож үнэ тогтооход нөлөөлөх, нийгмийн сүлжээг ашиглан нөлөөлөхөд илүү ач холбогдол өгч байна.

Хүснэгт 27. Эрчим хүчний үнэ тогтооход нөлөөлөх боломжийн талаарх үнэлгээг өрхийн сарын дундаж орлогын бүлгээр ангилсан байдал

Өрхийн дундаж орлого	Эрчим хүчний үнэ тогтооход би ямар ч нөлөө үзүүлж чадахгүй	Би хүрээллээрээ дамжуулан үнийн өсөлтөд нөлөөлж чадна	Сонгосон УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчдөөрөө дамжуулан нөлөөлж чадна	Нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлж нөлөөлнө	Би цахилгаан эрчим хүчний үнэ тогтооход бүрэн нөлөөлж чадна	Хариултын тоо
1 сая төгрөгөөс доош	52.8%	6.5%	15.4%	20.3%	4.9%	123
1.1-2 сая	59.3%	4.2%	7.2%	24.4%	4.9%	307
2.1-3 сая	60.6%	4.6%	9.2%	24.6%	1.1%	284
3.1-5 сая	54.1%	7.6%	9.6%	28.0%	0.6%	157
5.1-7 сая	57.1%	2.4%	9.5%	23.8%	7.1%	42
7.1 саяас дээш	47.2%	16.7	0.0%	27.8%	8.3%	36
Хариултын тоо	545	53	86	234	31	949

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

ААН байгууллагын өмчийн хэлбэрээс харахад хувийн хэвшлийн байгууллагын 78 хувь нь эрчим хүчний үнэ тогтооход ямар ч нөлөө үзүүлж чадахгүй гэсэн бол орон нутгийн өмчит компаниудын 48.4 хувь нь уг хариултыг сонгожээ. Нийгмийн сүлжээгээр нөлөөлж болно хэмээн орон нутгийн өмчит компани (32.3 хувь), төсвийн байгууллагууд (29.2 хувь) үзсэн бол хувийн хэвшлийн компаниуд үүнд итгэл муутай (12.5 хувь) байна. ХК болон төрийн байгууллагууд сонгосон төлөөллөөрөө дамжуулан эрчим хүчний үнэ тогтооход нөлөөлж чадна (6.1-6.7 хувь) гэсэн бол хувийн хэвшлийн ХХК үүнд огт итгэхгүй (0 хувь) байна. ХК болон ХХК-иуд эрчим хүчний үнэ тогтооход бүрэн нөлөөлж чадна гэдэгт хамгийн бага (2.2-3.1 хувь) оноо өгчээ (Хүснэгт 32).

Уг асуултад хэрхэн хариулсныг ААН байгууллагын хэмжээгээр нь харьцуулан үзэхэд жижиг буюу 10-19 ажилтантай байгууллага (70 хувь) болон том буюу 200-аас дээш ажилтантай байгууллага (70 хувь) нь эрчим хүчний үнэд ямар ч нөлөө үзүүлж чадахгүй гэж үзсэн байна. Том аж ахуйн нэгж нь өөрийн хүрээлээр дамжуулан үнэд нөлөөлж чадна (6.4 хувь) хэмээн хариулсан бол бичил, жижиг, дундууд (2-3.4 хувь) итгэлгүй байна. 1-9 ажилтантай бичил аж ахуйн нэгжүүд сонгосон төлөөллөөрөө (8.9 хувь) эсвэл нийгмийн сүлжээгээр дамжуулан (25.4 хувь) эрчим хүчний үнэд нөлөөлнө гэдэгт бусдаасаа арай илүү итгэлтэй байна. Эсрэгээрээ том аж ахуйн нэгж, байгууллагууд эдгээр сонголтыг хамгийн бага (4.5 хувь болон 15.5 хувь) дугуйлжээ.

Хүснэгт 28. Эрчим хүчний үнэ тогтооход нөлөөлөх боломжийг үнэлсэн байдлыг ААН байгууллагын өмчийн хэлбэрээр ангилж харуулсан байдал

Байгууллагын өмчийн хэлбэр	Эрчим хүчний үнэ тогтооход би ямар ч нөлөө үзүүлж чадахгүй	Би хүрээллээрээ дамжуулан үнийн өсөлтөд нөлөөлж чадна	Сонгосон УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчөөрөө дамжуулан нөлөөлж чадна	Нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлж нөлөөлнө	Би цахилгаан эрчим хүчний үнэ тогтооход бүрэн нөлөөлж чадна	Хариултын тоо
Хувьцаат компани (ХК)	65.6%	5.6%	6.7%	20.0%	2.2%	90
Төрийн өмчит аж ахуйн нэгж	65.2%	3.1%	6.1%	22.2%	3.5%	577
Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	48.4%	6.5%	6.5%	32.3%	6.5%	31
Төсвийн байгууллага	58.3%	4.2%	4.2%	29.2%	4.2%	24
Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)	78.1%	6.3%	0.0%	12.5%	3.1%	32
Нийт хариултын тоо	489	28	44	167	26	754

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Хэрэглэгчдийн нөлөөллийн хүчийг тандсан асуултын хариултаас харахад тэдний нөлөөллийн хүч тааруу, нөлөөлж чадна гэдэгтээ итгэлгүй байна. Харин нийгмийн сүлжээ зэргийг ашиглан үзэл бодлоо илэрхийлэх замаар эрчим

хүчний үнийн бодлогод нөлөөлөх боломж бий хэмээн ¼ хувь нь үзэж байгаа нь энэ төрлийн мэдээллийн сувгийг цаашид ашиглан тодорхой үр дүнд хүрэх боломж байж болохыг илтгэнэ.

Эрчим хүчний үнийн бодлогод нөлөөлөхийн тулд хэрэглэгчид мэдээллээр хангагддаг, энэ чиглэлийн мэдээллийг сонирхон анхаардаг байх нь үнийн шийдвэрт санаа бодлоо тусгах, эрх ашгаа хамгаалахад чухал ач холбогдолтой. Тэгвэл энэ талаар тандсан асуултыг мөн асуусан. Та эрчим хүчний үнэ тарифын талаарх мэдээллийг хэр их авдаг вэ? хэмээн асуухад хэрэглэгчдийн тал хүрэхгүй хувь (өрхийн 45 хувь; ААН байгууллагын 41 хувь) нь энэ талаар байнга сонирхдог бол, үлдсэн 50 гаруй хувь (өрхийн 50 хувь; ААН байгууллагын 57 хувь) нь хааяа сонирхдог гэж хариулсан.


Хүснэгт 29. Эрчим хүчний үнийн талаарх хэрэглэгчдийн мэдээлэл авдаг байдал

Хариулт	Хэрэглэгч-өрх	Хэрэглэгч-байгууллага
Огт сонирхдоггүй	5.5%	2.6%
Хааяа	49.8%	56.5%
Байнга сонирхдог	44.7%	40.9%
Нийт хариултын тоо	817	565


Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Мэдээлэлтэй оролцогч нь бодлого шийдвэрт идэвхтэй оролцож, хяналт тавих боломж бүрдэнэ. Гэтэл өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчид мэдээлэл хангалттай авдаггүй, мөн тэр бүр сонирхоод байдаггүй нь үр дүнтэй оролцоонд сөргөөр нөлөөлөх талтай. Энэхүү байдал нь өрхийн орлого, ААН байгууллагын хэмжээнээс хамаарч ялгаатай байгаа эсэхийг дараах зурагт харуулав.

Зураг 30. Эрчим хүчний үнийн мэдээллийг хэр авдаг талаарх хэрэглэгчдийн хариулт



Зураг 31. Эрчим хүчний үнийн мэдээллийг хэр авдаг талаарх хэрэглэгчдийн хариулт



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Эндээс харахад, сарын дундаж орлого багатай өрхүүдэд эрчим хүчний үнийн өөрчлөлт илүү дарамт учруулдаг тул тэд үнийн талаарх мэдээллийг илүү их (55 хувь) сонирхдог байна. Харин ААН байгууллагын хэрэглэгчдийн хувьд хэмжээ нь томрох тусам эрчим хүчний үнийн талаарх мэдээллийг илүү авдаг (60.4 хувь), жижиг байх тусам мэдээллийг хааяа (64.8 хувь) л авдаг байна.

Оролцогч талуудын оролцоог хангахын тулд тэдэнтэй харилцах арга зам нь оновчтой буюу тэдэнд нийцтэй байх учиртай. Иймд хэрэглэгчидтэй харилцах ямар арга зам нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцэж буйг тодруулах зорилгоор “Эрчим хүчний үнэ тарифыг өөрчлөх үед ААН байгууллагын хэрэглэгчдийн оролцоог хэрхэн хангавал зохистой вэ?” гэсэн олон сонголттой асуулт оруулсан. Уг асуултад цахимаар санал авах (өрх -48.7 хувь, байгууллага -41.6 хувь) нь хамгийн оновчтой гэсэн бол, мэргэжлийн холбоодоор дамжуулан санал өгөх болон бусад гэсэн хариулт хамгийн бага (өрх 2 хувь, байгууллага 9.7 хувь) дэмжлэг авсан. Мөн ААН байгууллагын хэрэглэгчдийн хувьд өдөр тутмын хэвлэлээр дамжуулан үнэ өөрчлөх шийдвэрт санал өгөхийг төдийлөн ойшоохгүй (10 хувь) байна.

Хүснэгт 30. Эрчим хүчний үнийг өөрчлөхөд хэрэглэгчдийн оролцоог хэрхэн хангах талаар

Хариулт	Хэрэглэгч-өрх	Хэрэглэгч-байгууллага
Цахимаар санал өгөх	48.7%	41.6%
Биечлэн уулзаж ярилцах	11.4%	12.0%
Сонсголд оролцож санал бодлоо илэрхийлэх	11.3%	13.3%
Хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо илэрхийлэх	12.4%	13.3%
Өдөр тутмын хэвлэлд нийтлэгдсэн үнэ өөрчлөх шийдвэрийн төсөлд санал өгөх	14.1%	10.0%
Мэргэжлийн холбоодоор дамжуулан санал хэлэх, лоббидох, нөлөөлөх, бусад	2.0%	9.7%
Нийт хариултын тоо²⁰	1141	1137

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Уг хариултын хувьд өрхийн орлого, сууцны төрлөөс хамаарч ялгаатай хариулсан утга байхгүй байна. Харин ААН байгууллагын өмчийн хэлбэрээр хариултуудыг шинжлэхэд төрийн өмчит ААН нь 'цахимаар санал өгөх'-ийг хамгийн их (44 хувь) дэмжсэн бол, ХХК-ийн оролцогчдын өгсөн хариултаас 'Биечлэн уулзаж ярилцах' (16.4 хувь) болон 'Сонсголд оролцож саналаа хэлэх' (18 хувь) гэсэн хариултууд бусад оролцогчдынхтой харьцуулахад арай өндөр байна.

Эдгээр хариултаас харахад эрчим хүчний бодлогыг зохицуулахад хэрэглэгчдийн оролцоо хангагдаагүй, тэдний мэдлэг ойлголт тааруу, бодлогод нөлөөлж чаддаггүй байна. 2024 онд хийгдсэн эрчим хүчний үнийн өсөлт нь өрхийн болон ААН байгууллагын хэрэглэгчдэд нөлөөлж эхэлсэн тул тэдний зүгээс хэрэглээгээ хязгаарлах, эрчим хүч хэмнэх шийдлүүдийг бодолцож эхэлсэн ба цаашид гэр, барилгаа дулаалах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгслийг ашиглах, сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэн ашиглах бодолтой байгаагаа илэрхийлсэн. Энэхүү хэрэглэгчдийн зан төлөвийн өөрчлөлт нь эрчим хүчний салбарын хувьд хүсүүштэй хандлага бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих үндэсний бодлогуудтай ч нийцэж байна.

4.3. Эрчим хүчний салбарын экспертийн асуулга судалгааны үр дүн, дүгнэлт

4.3.1. Судалгаанд хамрагдсан экспертүүдийн ерөнхий мэдээлэл

Цахилгаан эрчим хүчний үнийн бодлогод оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөлөл, өнгөрсөн онд гаргасан үнэ тарифын талаарх шийдвэрийн үр дагавар, үнэ тарифын бодлого хэр зохистой хэрэгжиж байгаа, цаашид

²⁰ Олон сонголттой асуулт учир хариултын тоо нь асуулгад оролцогчийн тооноос олон байна.

анхаарах асуудлын талаар салбарын экспертүүдийн санаа бодлыг тодруулах асуулга судалгааг мөн хийж үр дүнг энд нэгтгэв. Салбарын экспертүүдийг эрчим хүчний асуудлаар бодлого тодорхойлогч/улс төрч, сайд²¹ (1), Эрчим хүчний зохицуулах хорооны дарга/зохицуулагч (2), эрчим хүчний асуудлаар судалдаг судлаач/эрдэмтэн (3), салбарын мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл (4) гэсэн дөрвөн бүлэгт ангилсан.

Судалгаанд нийт 45 эксперт оролцсоноос 40 буюу 88.9 хувь нь эрэгтэй, 5 буюу 11.1 хувь нь эмэгтэй байна. Эрчим хүчний салбарын бодлого тодорхойлох түвшинд дийлэнх нь эрэгтэйчүүд ажилладаг, бусад салбартай харьцуулахад эрчим хүчний салбарт эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байдаг хандлага үүнд нөлөөлсөн.

Судалгаанд оролцогч экспертүүдийн нас болон ажилласан жилийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 31. Судалгаанд оролцсон экспертүүдийн нас, туршлагын байдал

Экспертүүдийн насны ангилал	Тоо	Эзлэх хувь	Ажилласан жилийн ангилал	Тоо	Эзлэх хувь
35-49	12	27%	20 хүртэл жил	14	31%
50-64	22	49%	20-30 жил	12	27%
65 ба түүнээс дээш	11	24%	30-40 жил	14	31%
Нийт	45	1	40-өөс дээш жил	5	11%
			Нийт	45	1

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Судалгаанд оролцсон экспертүүдийн хувьд 50-64 насныхан 49 хувийг эзэлж, туршлагын хувьд уг салбарт 20 хүртэлх жилийн туршлагатай 14, 20-30 жилийн ажлын туршлагатай 12, 30-40 жилийн ажлын туршлагатай 14 эксперт судалгаанд оролцсон нь бидний асуултад бодитой хариулт өгч эрчим хүчний салбарын талаарх судалгааны үр дүнг баталгаажуулахад дэмжлэг болохоор төлөөлөл юм.

4.3.2. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх экспертүүдийн санаа бодол

Цахилгаан эрчим хүчний үнийн талаар сүүлийн 20 гаруй жил гаргасан шийдвэр, түүний үр дүнгийн талаарх баримт бичгийн судалгаанд үндэслэн үнийг өсгөх шийдвэрийн үндэслэл шалтгааныг илэрхийлэх 5 өгүүлэмжийг боловсруулж, салбарын экспертүүдээс цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн шалтгааныг 1-5 хүртэлх оноогоор дүгнэхийг хүсэхэд 'олон жил

²¹ Экспертийн судалгааг авсан хугацаа нь Засгийн газрын үйл ажиллагааг эсэргүүцсэн "Огцрох амархан" жагсаал эхлэх үетэй давхацсан нь уг судалгаанд эрчим хүчний асуудлаар анхаарч ажилладаг улс төрч, Улсын Их хурлын гишүүдийг хамруулахад хүндрэл учирч байсан.

өртгөөс хэт доогуур хатуу үнэ баримталж ирсэн алдааг засах' зорилгоор үнийг нэмсэн шийдвэр гаргасан гэдэгтэй хамгийн их санал нэгдэж байна. Нэгдсэн үр дүнг дараах зургаар харуулав.

Зураг 32. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн үндэслэл, шалтгааны талаарх экспертүүдийн санаа бодол




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

'Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, ашиглалтыг дэмжих тарифыг хэрэглэгчдийн тарифт тусгасан шийдвэрийг эсэргүүцэх', түүнчлэн 'эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын орон тоо, бүтээмж, бүтэц зохион байгуулалт, худалдан авалтын ил тод байдлын талаар иргэд, хэрэглэгчид шүүмжлэлтэй хандаж цахилгаан эрчим хүчний үнийг нэмэхээс өмнө эдгээр асуудлыг шийдвэрлэх ёстой' гэх хандлага байдаг бол, салбарын экспертүүд үүнтэй төдийлөн санал нийлэхгүй байна. Харин үнийг өсгөх үндсэн шалтгаан нь 'тарифын зохицуулалт хангалтгүй байснаас үүдэлтэй салбарын хуримтлагдсан алдагдлыг бууруулах', 'өртгөөс доогуур хатуу үнэ баримталж ирсэн алдааг засах' явдал байсан гэж үзсэн байна.

Энэ асуултад экспертийн бүлэг тус бүр хэр ялгаатай хариулт өгснийг доорх зурагт харуулав. Экспертүүд цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн үндэслэл, шалтгаантай үндсэндээ санал нэгдэж байна.

Зураг 33. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн үндэслэл, шалтгааны талаарх экспертүүдийн санаа бодол, экспертийн бүлгээр ангилсан байдал



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

2024 онд хийсэн цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх шийдвэрийн үр дагаврыг экспертүүд хэрхэн үнэлж байгааг дараагийн бүлэг асуултаар тодорхойлсон. Эрчим хүчний салбарын алдагдлыг бууруулах, салбарт тулгамдаад байгаа санхүүгийн хүндрэлийг шийдэх нэг гарц нь үнэ нэмэх алхам байсантай санал нэгдэж байгаа бол, үнийн өсөлтийн дараа зах зээлд оролцогч талуудаас ямар хариу үйлдэл үзүүлэхийг экспертүүд хэрхэн дүгнэснийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 32. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт, түүний үр дагаврын талаарх экспертүүдийн санаа бодол

Үнэлгээ	Нийт дундаж үнэлгээ	Эрчим хүчний асуудлаар бодлого тодорхойлогч /улс төрч	Эрчим хүчний зохицуулах хорооны дарга/ зохицуулагч	Эрчим хүчний асуудлаар судалдаг судлаач/ эрдэмтэн	Эрчим хүчний салбарын мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл
ЦЭХ-ний үнийг өсгөснөөр салбарын санхүү эдийн засгийн нөхцөл сайжирч, хэвийн үйл ажиллагаа хангагдана.	4.41	5.00	4.60	4.19	4.42
ЦЭХ-ний үнийг өсгөх нь эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангах цор ганц арга зам мөн.	3.84	4.00	4.00	3.88	3.58
ЦЭХ-ний үнэ өссөнөөр хэрэглэгчид хэрэглээгээ хянах, хэмнэх дадал, үйлдэл нэмэгдэнэ.	4.44	5.00	4.75	4.25	4.25

ЦЭХ-ний үнэ өсөж эрчим хүчний салбар алдагдалгүй болсноор хөрөнгө оруулагчид нэмэгдэнэ.	4.47	5.00	4.44	4.38	4.58
Эрчим хүчний салбар техник технологийн шинэчлэл, засвар үйлчилгээгээ төлөвлөсөн хэмжээнд хийж хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.	4.44	5.00	4.63	4.19	4.50
ЦЭХ-ний үнэ өссөнөөр аж ахуйн нэгж, байгууллагын зардлыг өсгөж, ашигт ажиллагаанд сергөөр нөлөөлнө.	2.93	3.00	2.81	3.19	2.75
ЦЭХ-ний үнэ өссөнөөр инфляц өснө.	2.80	4.00	2.44	3.06	2.83
ЦЭХ-ний үнийн өсөлт нь айл өрхийн амьжиргааг доройтуулна.	2.36	2.00	2.13	2.94	1.92

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт²²


Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөснөөр салбарын санхүү эдийн засгийн нөхцөл байдал сайжирч хөрөнгө оруулагчдын сонирхлыг татан эрчим хүчний найдвартай, тасралтгүй байдал дээшилнэ, техник, технологийн шинэчлэл хийх нөхцөл бүрдэх эерэг үр дагавар авчирна гэж экспертүүд дүгнэж байна. Харин үнийн энэ удаагийн өсөлт нь айл өрхийн амьжиргаа, бизнес эрхлэгчдийн ашигт ажиллагаанд төдийлөн хүчтэй нөлөө үзүүлэхгүй, инфляцыг дангаараа өсгөх суурь хүчин зүйл болохгүй гэж дүгнэсэн байна.

4.3.3. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын бодлого, аргачлалын талаарх экспертүүдийн санаа бодол

Монгол Улсын эрчим хүчний зах зээл нь өндөр зохицуулалттай зах зээл бөгөөд зардалд суурилсан аргачлалаар буюу ЭХЗХ-оос тусгай зөвшөөрөл авсан эзэмшигчдийн зардал, эрчим хүчний эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдал, таамаглал зэрэгт үндэслэн эрчим хүчний үнийг тогтоож ирсэн. Хэдийгээр тодорхой арга зүйгээр үнийг тооцоолдог боловч иргэдийн амьжиргаа, эдийн засгийн бусад салбарын аж ахуйн нэгж байгууллагын зардалд шууд нөлөөлдөг онцлогийг харгалзан, үнэ тариф тогтоох үйл явц нь оролцогч талуудын нөлөөлөл дор хэрэгждэгийг баримт бичгийн судалгааны үр дүн харуулсан. Тэгвэл ЭХЗХ-ны хэрэгжүүлж ирсэн үнэ тарифын зохицуулалт, мөрдөж ирсэн аргачлалын талаар болон цаашид үүнийг хэрхэн өөрчилбөл зохистой талаар салбарын экспертүүд ямар саналтай байгааг судалж дүгнэлээ.

²² Тайлбар: Асуумж тус бүртэй хамгийн өндөр хувиар санал нэгдсэнийг шар өнгөөр, хамгийн бага хувиар санал нэгдсэнийг ногоон өнгөөр тэмдэглэв.

Зураг 34. Цахилгаан эрчим хүчний үнэ тогтоож ирсэн аргын талаар экспертүүдийн мэдлэг



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Салбарын экспертүүд цахилгаан эрчим хүчний үнийг бодит, өртөг зардалд тулгуурлан салбарын мэргэжилтнүүдийн буюу ЭХЗХ-оос гаргасан бодит тооцоололд үндэслэн тогтоодог гэдэгт өгсөн үнэлгээний дундаж 3.13 буюу 63 хувьтай санал нэгдэж байгаа бөгөөд улс төрчдийн саналыг тусган, тэдний өндөр оролцоо, нөлөөтэйгөөр үнийн шийдвэр гаргадаг гэдэг өгүүлэмжтэй санал нийлсэн үнэлгээний дундаж 3.69 гэсэн хамгийн өндөр хувиар санал нийлж байгаа дүгнэлт байна. Харин үнэ тогтоох шийдвэрүүд нь “хэрэглэгчийн санаа бодлыг тэр бүр тусгадаггүй, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилттэй шууд уялддаггүй, үнийг тогтооход эдийн засгийн хүчин зүйлс, зах зээлийн зарчмыг тэр бүр баримталдаггүй” гэж дүгнэжээ.

Харин цаашид цахилгаан эрчим хүчний үнийг хэрхэн тодорхойлж, тогтоох нь зохистой, үнэ тарифын зохицуулалтын бодлогод юуг харгалзвал зүйтэйг салбарын экспертүүд дараах байдлаар дүгнэсэн байна.

Зураг 35. Цахилгаан эрчим хүчний үнийг цаашид хэрхэн тогтоож зохицуулах нь зохистой гэж үзсэн бэ?



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгаан эрчим хүчний үнэ, тарифыг өртгөөс доогуур тогтоох нь зохисгүй, харин үнэ тариф нь үйлдвэрлэл, түгээлтийн өртгийг бүрэн нөхөхүйц байх ёстой гэдэгтэй экспертүүд санал нэг байна. Харин үнийг тогтоохдоо эрчим хүчний үйлдвэрлэлийн өртөг, инфляц, эдийн засгийн бусад хүчин зүйлийг харгалзан хувьсдаг үнийн аргачлал нэвтрүүлэх, мөн эрчим хүчний системийн өөрчлөлтийг хийж иргэд, байгууллагыг эрчим хүч үйлдвэрлэгч байх бодлогыг дэмжсэн үнэ тарифын бодлого, зохицуулалт хэрэгтэй гэдэгтэй хамгийн өндөр хувиар санал нэгдсэнийг дээрх зургаас харж болно.

4.3.4. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, нөлөөлөгч талуудын талаарх экспертүүдийн дүгнэлт

Эрчим хүчний тухай хуулийн 8.1-д заасан Эрчим хүчний зохицуулах хорооны хараат бусаар хэрэгжүүлэх эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, **үнэ тарифыг тогтоох**, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг (УИХ, 2001) бодит байдалд хэр хэрэгжиж байгааг салбарын экспертүүдээр дүгнүүлсэн. Судалгаанд хамрагдсан экспертүүдийн нийт саналын дунджаар үнэ тарифын зохицуулалтад Засгийн газрын тэргүүн болон гишүүдийн нөлөөлөл өндөр байдаг гэдэгтэй хамгийн өндөр хувиар санал нэгдсэн бол, эрчим хүчний зах зээлд зохицуулалт бага, зах зээлийн зарчим үйлчилдэг гэдэгтэй хамгийн бага хувиар санал нэгджээ. Энэ талаар экспертийн бүлгүүдийн санал бодол төдийлөн зөрүүтэй биш байна.

Хүснэгт 33. Цахилгаан эрчим хүчний үнэ, тарифын зохицуулалтын талаарх экспертүүдийн үнэлгээ

Экспертийн бүлэг	УИХ-ын нөлөө бүхий гишүүдийн санал, нөлөөлгөөр зохицуулдаг.	Үнэ тарифын зохицуулалтанд ЗГ-ын тэргүүн болон гишүүдийн нөлөөлөл их байдаг.	Эрх барьж буй намын удирдлагын шийдвэрээр зохицуулдаг.	Эрчим хүчний зохицуулах хороо хуулиар хүлээсэн эрх, үүргийн хүрээнд хараат бусаар үнэ тарифыг зохицуулдаг.	Нийгмийн сүлжээн дэх иргэдийн санаа борлыг харгалзан зохицуулдаг.	Хэрэглэгч, үйлдвэрлэгчийн харилцан зөвшилцөөр зохицуулдаг.	Эрчим хүчний үйлдвэрлэгч, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хэрэглэгч зэрэг оролцогч талуудын саналыг тусган зохицуулдаг.	Зохицуулалт бага, зах зээлийн зарчим үйлчилдэг.
Нийт экспертүүдийн санал нийлэх үнэлгээний дундаж	55.0%	81.3%	75.6%	56.4%	53.3%	39.6%	46.4%	38.1%
Эрчим хүчний асуудлаар бодлого тодорхойлогч/улс төрч	20.0%	80.0%	80.0%	40.0%	80.0%	80.0%	40.0%	20.0%
Эрчим хүчний зохицуулах хорооны дарга/зохицуулагч	49.3%	80.0%	63.8%	60.0%	45.0%	38.8%	55.0%	40.0%
Эрчим хүчний асуудлаар судалдаг судлаач/эрдэмтэн	62.5%	83.8%	87.5%	57.5%	66.3%	40.0%	38.8%	41.3%
Эрчим хүчний салбарын мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл	50.0%	80.0%	75.0%	51.7%	45.0%	36.7%	45.5%	32.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Зах зээлд цахилгаан эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажиллаж ирсэн ЭХЗХ-ны дарга, зохицуулагчид хүртэл хараат бусаар үнэ тарифыг зохицуулдаг гэдэгтэй 60 хувиар санал нэгдсэн байгаа нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд бусад оролцогч талуудын нөлөө тодорхой хэмжээгээр байдгийг илтгэж байна. Эндээс ЭХЗХ нь үнэ, тарифын шийдвэр гаргах чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг нь экспертүүдийн хариултаас харагдав.

Эрчим хүчний үнийн шийдвэр гаргалтад холбогдогч талуудын нөлөө хэр их байдгийг экспертүүдээр үнэлүүлэхэд дараах байдалтай байна.

Зураг 36. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэр гаргалтад холбогдогч талуудын үзүүлэх нөлөө



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт хамгийн өндөр нөлөөтэй нь Засгийн газар, Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний яам гэж экспертүүд дүгнэсэн бол салбарын мэргэжлийн холбоод, хэрэглэгчид, цахилгаан үйлдвэрлэгч, дамжуулах, түгээх компаниудын нөлөө хамгийн бага гэж дүгнэсэн байна. Харин хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээ, улс төрчдийн нөлөө дундаж түвшинд байна гэж үзжээ. Хэрэглэгчдийн санал асуулгын судалгаагаар мөн ойролцоо үр дүн гарсан бөгөөд хэрэглэгч айл өрх, албан байгууллагууд үнэ тарифын бодлого, шийдвэрт тэр бүр нөлөөлж чадахгүй боловч нийгмийн сүлжээгээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх, нөлөөлөх боломжтой гэж үзсэнтэй нийцэж байна.

4.4. Фокус ба ганцаарчилсан ярилцлагын үр дүн, дүгнэлт

Эрчим хүчний үнэ, тарифын бодлого, шийдвэрт оролцогч талуудын ялгаатай байр суурийг нарийвчлан тодорхойлох, асуулга судалгаа, баримт бичгийн судалгааны үр дүнгээ баталгаажуулах зорилгоор ярилцлагыг зохион байгуулж, дараах дөрвөн бүлгийн төлөөллийг фокус бүлгийн ярилцлагад урьж оролцуулсан. Үүнд:

- Хэрэглэгч-айл өрхийн төлөөлөл
- Хэрэглэгч-аж, ахуйн нэгжийн төлөөлөл
- Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын төлөөлөл
- Эрчим хүчний салбарын мэргэжилтэн, судлаачдын төлөөлөл

Харин эрчим хүчний үнэ, тарифын шийдвэр гаргадаг гол субъект буюу ЭХЗХ-ны дарга, зохицуулагч, үнэ тарифын бодлогын газрын даргаар 2001 оноос хойш ажиллаж байсан 10 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийлээ.

Боловсруулсан удирдамжийн дагуу ярилцлагыг зохион байгуулж тематик шинжилгээний арга зүйгээр өгөгдөлд шинжилгээ хийж үр дүнг гаргав.

4.4.1. Цахилгаан эрчим хүчний үнэ өсгөх шийдвэрийн хэрэглэгчид үзүүлэх нөлөө ба хэрэглэгчийн хариу үйлдэл

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтөд хэрэглэгчид богино хугацаанд соргог хандаж, аажимдаа дасан зохицох байдал ажиглагдсан ба үнийн өсөлтөд шүүмжлэлтэй хандаж байгаа ч, уг шийдвэр нь гарцаагүй байсныг хүлээн зөвшөөрөх хандлага хэрэглэгчдэд давамгайл байна. Цахилгаан эрчим хүчний үнэ нэмсэн шийдвэрийн талаарх хэрэглэгчдийн санаа бодол, тэдний хариу үйлдлийг судлах асуулга судалгааны үр дүн, хандлага ярилцлагаар батлагдаж байгааг дараах дүгнэлтүүд харууллаа.

Хүснэгт 34. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрийн нөлөө, хэрэглэгчдийн хариу үйлдлийн талаар өгсөн дүгнэлт

Сэдэв	Хэрэглэгч-Өрхийн төлөөлөл	Хэрэглэгч-ААН-ын төлөөлөл
Үнийн шийдвэрийн нөлөө	- Өрхийн эдийн засагт шууд нөлөө үзүүлсэн боловч ам бүл цөөтэй, хэрэглээ багатай айлын өрхийн төсөвт хүчтэй нөлөө үзүүлээгүй. - Халаалтаа цахилгаанаар шийддэг айлуудад хүндээр туссан. - Цахилгааны үнийн өсөлтөөс шалтгаалан халаалтын шийдлээ өөрчлөх шийдвэрт хүрсэн.	- Үйлдвэрлэлийн шууд зардал өссөн. - Шууд зардлын өсөлтөөс гадна зардлыг харгалзан өөрийн бүтээгдэхүүний үнээ өсгөсөн нь өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болсон. - Төлөвлөгдөөгүй зардлын өсөлт нь бусад зардлаа тухайлбал, компанийн нийгмийн халамжийн төсвөө бууруулах нэг хүчин зүйл болсон.
Эерэг үр дагавар ба хариу үйлдэл	- Цахилгаан эрчим хүчээ хэмнэх талаар бодож эхэлсэн, энгийн үйлдлүүд тухайлбал, ашиглаагүй гэрлээ унтраах, ус буцалгагчаа салгах гэх мэтийг байнга хэрэгжүүлдэг болсон. - Цахилгаан хямд байсан учир зарцуулалтыг төдийлөн хянадаггүй байснаа ойлгосон. - Нарны эрчим хүчээр халаах шийдлийг судалж үзсэн. Эхний хөрөнгө оруулалт өндөр бол шилжихэд хүндрэлтэй.	- Удирдлагын зүгээс технологийн шийдэл, тоног төхөөрөмжийн сонголтод анхаарал хандуулж эхэлсэн буюу эрчим хүчээ хэмнэх сэдэл өгсөн. - Сэргээгдэх эрчим хүчээр эх үүсвэрээ шийдэх шийдлийг хайж байна. - Оргил ачааллын үед хэрэглээг бууруулах зорилгоор үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг өөрчилж туршсан. - Шинээр хэрэгжих төслүүдийн хөрөнгө оруулалтын тооцооллоо өөрчлөх, цаашид зардал өсөх хандлагатайгаар прогноз хийж эхэлсэн.
Үнийн бодлого, үнэ тогтоох аргачлалын талаарх шүүмжлэл ба цаашдын хандлагад өгөх санал	- Цаг үеэ олоогүй буюу өвлийн улиралд нэмсэн нь буруу. - Орон сууц, байшин, ААН-ийн хэрэглээний ялгааг харгалзаагүй, нэг ижил байдлаар нэмсэн нь хэрэглэгчдийн дунд бухимдал үүсгэсэн. - Цахилгааны үнэ харьцангуй хямд байсан нь хүмүүсийг (жишээлбэл, цэнэглэгчээ залгаатай орхих) хэт хамаагүй хэрэглээнд хүргэж байсныг зарим оролцогч хүлээн зөвшөөрсөн.	- Өнгөрсөн үнийн өсөлт нь зөвхөн шархаа нөхөх (алдагдлаа нөхөх) төдий түвшинд хүрч, чанар сайжруулах эсэх нь эргэлзээтэй. - Үйлдвэрлэгч, оператор, уул уурхай зэрэг тус тусад нь ялгавартай тариф гаргасан нь зөв. Хэмнэлт/үр өгөөж гаргасан хэрэглээний 20 хувийг урамшуулал маягаар буцааж олгох нь хөшүүрэг болно. - Гэнэтийн тасалдал, хязгаарлалт нь үйлдвэрлэл, үйлчилгээний процесст хүндрэл учруулж, нэмэлт зардал (генератор, батареи авах) бий болгодог, тиймээс найдвартай байдал чухал. - СЭХ-ний төслүүдийг хэрхэн дэмжих, ялангуяа өөрсдийн хэрэглээнээс бий болсон илүүдлийг улсад нийлүүлэх үйл явц ойлгомжгүй, асуудал тавихад удаан (1-2 сар) шийдэгддэг бөгөөд олон шаардлага тавьдаг. - Инфляцтай уялдуулан бага багаар, урьдчилан төлөвлөж нэмэх. Үнийн өсөлт нь шинэчлэлд чиглэсэн байх ёстой.

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Үнийн өсөлтийн нөлөөг үнэлсэн хэрэглэгчдийн санал, дүгнэлтийг цахилгаан эрчим хүчний чиглэлийн судлаач, мэргэжилтнүүд болон ТЗЭ байгууллагын төлөөлөл мөн ижил дүгнэсэн байна. Үнийн өсөлтийн хамгийн эерэг нөлөө нь хэрэглээг ухаалаг болгож хэмнэх дадалд сургаж, хэрэглэгч шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг өдөөсөн, энэхүү шууд үр дагавар нь оргил ачааллын хэрэглээ бодитой буурснаас харагдаж байгаа бөгөөд хэрэглэгч илүү ухаалаг болж байна. Хэдийгээр цахилгаан эрчим хүчний үнийг нэмсэн нь алдагдалтай ажиллаж буй салбарт “амьсгалах зай” олгосон хэдий ч, үнийг бодит өртөгт дөхүүлэх нь эдийн засгийн хувьд зайлшгүй шаардлага байсан. Харин хямд үнэд дассан хэрэглэгчдэд урт хугацааны дараагийн огцом нэмэлт нь дахиад ойрын 2-3 жилдээ нэмэхгүй байх гэсэн хуурамч хүлээлт үүсгэж, энэ нь дахиад л салбарт сөрөг үр дагавар дагуулах хандлагатай байна.

Шигтгээ 7. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:

Цахилгаан эрчим хүчний үнэ нэмэх шийдвэр нь хүн бүрт хамааралтай учир нийгэмд тодорхой давлагаа бий болгодог. Гэхдээ жирийн ард түмэн бол ойлгодог. ... намайг зохицуулагчаар ажиллаж байх үед гаргасан шийдвэрээс үүдээд нэг аймагт хүчтэй эсэргүүцэл гарч, бид очиж уулзалт хийсэн, тухайн үед жоохон болгоомжтой л очсон. Тэгээд уулзалтын явцад сайхан яриад, харьцуулалт хийгээд, та нарын карманаас ийм юм гарч байгаа, гар утастай харьцуулах юм бол ийм гээд л хэлсэн бүгд л ойлгосон. Үнэ нэмэх шийдвэр гаргах нь хүнд боловч эрчим хүчний салбараа хүндрэлээс гаргахаас гадна хэрэглэгчдээ зөв хэрэглээнд сургах эерэг үр дагаврыг дандаа авчирдаг.

Цахилгаан эрчим хүчний үнэ нэмэх шийдвэрийг хэрэглэгчид шууд эсэргүүцэхгүй, харин тодорхой нөхцөл байдалд шүүмжлэлттэй хандаж, аажмаар үнийн өөрчлөлтөд дасан зохицох, нөхцөл байдалдаа тохирсон шийдвэр гаргахад чиглүүлдэг болохыг оролцогч талууд нотолж байна. Үүнийг ганцаарчилсан ярилцлагад оролцогчийн дүгнэлт ч мөн давхар нотолж байна.

Хэрэглэгчид цахилгаан эрчим хүчний үнийг өсгөхийг шууд, бүрэн дэмждэггүй ч үнийн өсөлтөд дасан зохицож цаашид хэмнэлттэйгээр хэрэглэх, эрчим хүчний хямд эх үүсвэр, дэвшилтэт технологийг судлах сэдлийг төрүүлдэг эерэг үр дагавартай байна. Хэрэглэгчдийн гол сонирхол нь үнээс илүүтэйгээр тасралтгүй, тогтвортой, найдвартай эрчим хүчний хангамж бөгөөд үнийн огцом өсөлтийг бус, урьдчилан төлөвлөсөн, инфляцтай уялдсан өөрчлөлтийг дэмжих хандлага давамгайлж байна.

4.4.2. Цахилгаан эрчим хүчний үнэ тогтоох зарчим, аргачлалын талаарх дүгнэлт

Цахилгаан эрчим хүчний үнэ тогтоож буй өнөөгийн зарчим, аргачлалын талаар ярилцлагын явцад тодруулахад хэрэглээнээс хамаарсан шатлалтай тариф, хэмнэлтийг урамшуулах бодлого, огцом нэмэхгүйгээр инфляцтай

уялдуулж аажмаар өсгөх зарчим баримтлах нь зүйтэй гэсэн саналыг хэрэглэгчид гаргаж байсан бол, эрчим хүчний салбарын судлаач, мэргэжилтнүүд болон ТЗЭ-ийн төлөөлөл үнэ тогтоох аргачлал, ирээдүйн чиг хандлагын талаар илүү гүнзгий, тодорхой саналуудыг өгсөн.

Хүснэгт 35. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдоос ЦЭХ-ний үнэ тогтоох бодлого, аргачлалын талаар өгсөн дүгнэлт

Сэдэв	ТЗЭ компанийн төлөөлөл	Эрчим хүчний судлаач, мэргэжилтнүүдийн төлөөлөл
Үнэ тогтоох аргачлалын өнөөгийн байдал, давуу сул тал	• Үнэ тогтоосон шийдвэр нь нэмэх биш алдагдал нөхөх шийдвэр • Сүлжээнд ДЦС-ууд хямд өртгөөр нийлүүлж байхад шинэ станцууд өртгөөс хоёр дахин өндөр үнээр ЦЭХ нийлүүлж байгаа нь өнөөгийн тарифын тогтолцоо буруу байгааг харуулж байна. • Үнийн өсөлтөөс шалтгаалж системийн хэмжээнд нэмэгдсэн орлогын хуваарилалт буруу буюу төрийн өмчийн компаниудад бага, гадаадын болон хувийн хөрөнгө оруулалттай шинэ станцуудад илүү хуваарилагдаж байна. • Зардал дээр суурилж үнэ тогтоож байгаа нь оновчтой биш, үр ашигтай эсвэл үр ашиггүй зардлыг сайн хянахгүй тохиолдолд үнэ тогтоох үндэслэл буруу болно.	• Цахилгаан, дулааны өртгийг нарийвчлан салгаж тооцоолох, түүнд үндэслэн үнийг тогтоох. • Хэт төвлөрсөн сүлжээний эрсдэлийг тооцож үнийг тогтоох, цаашид энэ нь хүндрэл үүсгэхийг урьдчилж тооцоолох.
Үнийн бодлого, үнэ тогтоох аргачлалд цаашид анхаарах асуудал	• Үнийг инфляцтай уялдуулж индексжүүлж жилд тогтмол 7-12 хувь өсгөдөг зарчим, аргачлалыг нэвтрүүлэх. • Харилцаа холбооны салбар шиг хэрэгцээнд тулгуурласан, цагийн нөлөөлөлтэй үнийн аргачлалыг нэвтрүүлэх. • Үнэ тарифыг тогтмол болон хувьсах гэж хоёр ангилж, тогтмол үнийг Засгийн газрын оролцоотой тогтоодог, харин хувьсах хэсгийг салбарын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор олон хүчин зүйлээс хамаарч хараат бусаар тогтоодог аргачлал нэвтрүүлэх. • Дулааны алдагдал ихтэй барилгын сөрөг үр дагавар, халамжийн буруу бодлого зэрэг нь эрчим хүчээр дамжиж иргэдэд дарамт болж байгааг зогсоох. Хэрэглэгчдэд ижил зарчим баримтлан харин халамж, татаас эсвэл торгууль, урамшуулал зэргийг тухайн салбарын бодлогоор нь хүргэдэг болгох. • Оргил ачаалалд өндөр нөлөөтэй уул уурхайн салбарын үнийг тусгайлсан аргачлалаар тооцож нэмэх.	• Хөрөнгө оруулалтыг татах хэмжээнд үнийг тогтоох. • Инфляц, валютын ханшийн хэлбэлзэл ЦЭХ-ний үнэд шууд хамааралтайгаар хэлбэлздэг зарчмаар үнийг тогтоох аргачлал боловсруулж мөрдөх. • Тархмал эх үүсвэрийг дэмжих бодлогыг үнэ тарифын бодлоготой нягт уялдуулах.

Үнэ тогтоох аргачлал түүнийг цаашид хэрхэн өөрчлөх талаар мэргэжилтэн, судлаачид, ТЗЭ-чид нэгдмэл бөгөөд илүү гүнзгий санал өгсөн бол хэрэглэгчдийн хувьд үнэ тариф ойлгомжтой байхаас гадна огцом нэмэх бус эдийн засгийн хүчин зүйлсээс хамаарч багаар нэмэгдүүлэхийг дэмжих хандлагатай байна. Түүнчлэн ганцаарчилсан ярилцлагад оролцогчид ч эрчим хүчний үнэ тариф тодорхой хүчин зүйлсээс хамаарч хувьсаж өөрчлөгддөг байх зарчмыг илүүтэй дэмжиж байна.

Эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд үнийг оновчтой тогтоохын чухлыг ярилцлагад оролцогч бүх талууд онцолж, үнийг индексжүүлэхээс гадна эрчим хүчний салбарын бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг хянах, хөрөнгө оруулалтыг татах, шинэ бөгөөд үр ашигтай технологи нэвтрүүлэхийг үнийн бодлогоор дэмжихийг ч санал болгож байна.

Шигтгээ 8. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:

Тариф тогтоох аргачлалууд яваандаа улам нарийсна. Жишээлбэл: Улсын төсвийн төсөл дээр 2 дахь жилдээ тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлнэ гээд ороод ирж байгаа биз, үүнийг бүх талууд хүлээн зөвшөөрч байна. Яг энэ шиг зарчим эрчим хүчинд нэвтэрч индексжүүлнэ гэдэг ойлголтыг хэрэглэгч, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгч аль аль тал нь анзаарч, төсөв төлөвлөгөөндөө тусгадаг болбол сайн. Хүмүүс анзаардаг болсон байна лээ. Одоо энэ чинь индексжүүлж байгаа хэлбэр. Эрчим хүчний салбарт дандаа урт хугацаатай төслүүд хэрэгждэг, минимум 5 жилээс дээш урт хугацааны төслүүд явдаг. Тэгэхээр мөнгөний урт хугацааны үнэ цэн, ирээдүйн орлогын өнөөгийн үнэ цэнийг ч харгалзаж тариф тогтоох хэрэгцээ гарна. Цаашид эх үүсвэрийн үйлдвэрлэгчдийн дунд хувийн хэвшлийн оролцоо улам нэмэгдэнэ, ойрын 10 жилд магадгүй 50:50 болох хандлагатай байна. Энэ урт хугацааны прогнозыг бид урьдчилж харж тарифын бодлогоо тогтоох ёстой. Диспетчерийн зохицуулалтыг ухаалаг оюунаар хийж, үйлчилгээн дэх хүний оролцоо буурна. Энэ нь зардлыг бууруулах үед тарифын бүтэц үндсэндээ өөрчлөгдөнө.

Үнэ нь эрчим хүчний салбарын зохицуулалтын гол хэрэгсэл учир зөвхөн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзахаас илүүтэй салбарын хөгжил, урт хугацааны тогтвортой төлөв байдлыг харгалзсан аргачлал нэвтрүүлэхийг талууд онцолсон.

Шигтгээ 9. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:

Зарчмын хувьд одоогийн барьж байгаа зарчим бол зөв. Өөрөөр хэлбэл, тарифыг яаж тогтоодог вэ гэхээр бодит өртөг зардалд үндэслэдэг байхгүй юу. Ирээдүйд энэ аргачлал сул тал болж технологи хурдтай хөгжөөд ирэнгүүт түүний хурдыг гүйцэхгүй, нөлөөллийг тооцож чадахгүй байж магадгүй. Яагаад гэхээр үнэ тарифыг тооцох суурь мэдээлэл нь өнгөрсөн жилийн гүйцэтгэл байдаг учраас ирээдүйд гарах нөлөөллийг харж чадахгүй байх магадлалтай ба цаашид үүнийг урьдчилж харж, бас тусгах гэж оролдох хэрэгтэй.

4.4.3. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаар ярилцлагад оролцогчдын дүгнэлт

Эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаар фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын санал, дүгнэлтийг нэгтгэж дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 36. Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын санал, дүгнэлт

Сэдэв	Хэрэглэгч-айл өрхийн төлөөлөл	Хэрэглэгч-ААН- ийн төлөөлөл	ТЗЭ компанийн төлөөлөл	Эрчим хүчний мэргэжилтэн, судлаачдын төлөөлөл
Сонирхол	Үнэ хямд боловч бас найдвартай байх. Ойлгомжтой, хямд тарифтай байхаас гадна зохистой хэрэглээг урамшуулах.	Цахилгаан эрчим хүч найдвартай, хязгаарлалтгүй байх нь ААН байгууллагад хамгийн чухал. Үнийг огцом нэмэхгүй харин урьдчилан төсөв, тооцоололдоо тусгах боломжтойгоор үнийн өөрчлөлтийн талаар урьдчилж мэддэг байх. Эрчим хүч хэрэглэгчээс үйлдвэрлэгч болох сонирхол томоохон аж ахуйн нэгжүүдэд байгааг бодлогоор дэмжих.	Үнийг зөвхөн алдагдал нөхөх хэмжээнд нэмсэн нь учир дутагдалтай. Цаашид системийн тогтвортой, найдвартай ажиллах нөхцөлийг урьдчилан тооцоолж үнэ тогтоох.	Үнийн шийдвэрийн талаарх оролцогч талуудын сонирхлыг ашиг алдагдлаа нөхөх, хөрөнгө оруулалтын сонирхол буюу ашиг олох, системийн тогтвортой байдлыг хангах хэрэгсэл болгох сонирхол байдаг бол, эрчим хүчний хямд үнийг улс төрчид сонгогчдод таалагдах хэрэгсэл болгох сонирхолтой.
Эрх мэдэл	Хэрэглэгч үнэд нөлөөлөх боломжгүй. Идэвхтэй биш учир үнийн шийдвэрт оролцдоггүй.	ААН байгууллагууд ЦЭХ-ний үнэд нөлөөлөх боломжгүй. ЭХЗХ-оос гадна улс төр, Засгийн газрын эрх мэдэл хамгийн өндөр.	ТЗЭ-чид үнэ өсгөх үндэслэл, саналаа ЭХЗХ-нд хүргүүлдэг. Энэ нь үнийн суурь болдог учир тодорхой хэмжээнд оролцож байна. Үнэ тарифын шийдвэрт ЗГ, Ерөнхий сайд, УИХ хамгийн ихээр нөлөөлж ЭХЗХ-ны хараат бус байдлыг үгүй хийж байна.	Үнэ тарифын шийдвэрт Засгийн газар, Ерөнхий сайд хамгийн өндөр эрх мэдэлтэйгээр оролцдог.



Нөлөөлөл	Хэрэглэгчид ихэвчлэн цахилгаан түгээх компанид хандаж гомдол, саналаа гаргадаг боловч шийдвэрт харгалздаггүй. Хэрэглэгч зөвхөн төлбөрөө хугацаанд төлөх үүрэгтэй гэдэг байдлаар ханддаг. Цахилгаан хэмнэсэн хэрэглэгчдэд бодит урамшуулал олгох нь тэдний оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлнэ.	ЦЭХ-ний доголдлоос үүдэлтэйгээр ААН-үүдийн үйлчилгээний доголдол, үнийн өсөлт нь ЦЭХ-ний үнийн шийдвэрийг эсэргүүцэхэд дам нөлөөлдөг.	ТЗЭ-д зардлын тооцооллоо өгч үнэ бүрдэлтэд нөлөөлдөг. Шинэ технологийн, СЭХ-ний үйлдвэрүүд үнийн шийдвэрт нөлөө үзүүлдэг байх талтай. Улс төрчид зохицуулагчдын томилгоогоор дамжуулж нөлөөлж байна.	Улс төрчид үнэ нэмэх шийдвэрийг сонгогчдод таалагдах шийдвэр болгож ашигладаг. Зохицуулагчдын томилгоогоор дамжуулж нөлөөлдөг. Салбарын шинжээчид үнийн бодлого, шийдвэрт хангалтай оролцож нөлөөлж чаддаггүй, зарим үед хэлэлцүүлэг хийж тэднийг сонссон дүр эсгэдэг.
----------	--	---	--	--

Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцох сонирхол нь оролцогч талууд өөрсдийн байр суурь, эрх ашгийг хамгаалахад чиглэдэг гэдгийг бүх талууд өөр, өөрийн өнцөг, онцлогоостайлбарлаж байсан. Харин үнийн шийдвэр гаргах эрх мэдэл нь хууль, эрх зүйн хувьд ЭХЗХ-нд хадгалагдаж байгаа боловч эцсийн шийдвэрт хамгийн хүчтэй нөлөөтэй, эрх мэдэлтэй субъект нь Засгийн газар, түүний дотор Ерөнхий сайд байна гэдэгтэй бүгд санал нэгдэж байна. Үүнийг ганцаарчилсан ярилцлагад оролцогчид ч онцолсон.

Шигтгээ 10. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:

ЭХЗХ хуулийн хувьд хараат бусаар шийдвэр гаргах зохицуулалттай боловч ялангуяа даргыг голчлон Эрчим хүчний сайд санал болгож, Ерөнхий сайд томилдог учир томилгооны хараат байх нөхцөл үүсдэг. Би ажиллаж байхдаа тооцоолол хийж бэлдэж байгаад яг сонгуулийн дараа үнэ нэмж байсан, энэ тохиолдолд хүртэл Ерөнхий сайд дуудаад яагаад үнэ нэмсэн билээ гэдэг асуудал тавьж л байсан.

Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрийг өөрчлөхөд нөлөөлөх, тодорхой сегментэд чиглэсэн үнийн хөнгөлөлт урамшууллын шийдвэрийг Засгийн газраас гаргах зэрэг нь сонгууль дөхсөн хугацаанд олширдог талаар зохицуулагчид дурдаж байсан. Түүнчлэн үнэ нэмсний дараах богино хугацаанд илэрдэг хэрэглэгчдийн эсэргүүцлийг улс төрчдөөс нийгэмд нөлөөлөх хэрэгсэл болгож ашиглах тохиолдол ч их байдаг байна.

Шигтгээ 11. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс:

Зохицуулагч нар хараат бус байх гэж ихэд чармайдаг, үе үеийн сайд нартай үнэ, тарифын бодлого дээр зөрж явлаа. Би чиний цэрэг биш асуудлаа бичгээр ханд гээд хэлж л байсан. Улс төрийн нөлөө өндөр байж ирсэн нь үнэн. цаашид энэ байдал өөрчлөгдөнө. Зохицуулагч нарт нөлөөлөх хувийн хэвшлийн компаниуд, хөрөнгө оруулагчдын нөлөө асар өндөр болно.

Зөвхөн Засгийн газар, улс төрчдийн нөлөөнөөс гадна эрчим хүчний системд оролцогч үйлдвэрлэгч, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид үнийн шийдвэрт нөлөөлөх оролдлого гаргах, тэдний нөлөөлөл нэмэгдэх хандлагатайг зохицуулагчид мөн онцолж байсан. Үүнээс сэргийлэх нэг хэлбэр нь зохицуулагчдын тоог нэмэх, тэднийг томилж сонгодог тогтолцоог өөрчилж, олон талын оролцоог хангах, цалин хангамжийг нь өсгөж, эдийн засгийн хараат бус байдлыг дээшлүүлэх нь чухал болохыг ч онцолсон.

ТАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

5.1. Судалгааны дүгнэлт

Монгол Улсын эдийн засгийн хамгийн чухал салбар-эрчим хүчний салбарын тулгамдсан асуудал болох үнэ тарифын бодлогын асуудлыг хөндөж цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн судалгааг хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна.

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэр, аргачлал, хэрэгжилтийн талаар:

- Монгол Улсын эрчим хүчний зах зээлийн үнэ тарифын бодлого нь салбарын зохицуулалтын гол бодлогын нэг бөгөөд сүүлийн жилүүдэд үнийг тогтвортой, хямд байх зарчмыг баримталж ирсэн нь салбарын эдийн засгийн хүндрэлийн үндсэн нөхцөл болсон байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд Эрчим хүчний зохицуулах хорооноос үнэ тарифын талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн ба зах зээлийн бусад хүчин зүйлийг харгалзан индексжүүлэн тогтоох, эрчим хүчний хэмнэлтийн сэдлийг урамшуулах, хэрэглээнээс хамаарсан шатлалтай тариф тогтоох, үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, ялгаатай үнийн бодлого баримтлах зэрэг шинэлэг хандлагыг нэвтрүүлж эхэлсэн ч, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн өртгөөс бага үнээр эрчим хүчийг хэрэглэгчдэд нийлүүлж ирсэн нь салбарт санхүүгийн хүндрэл үүсгэж, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсээс хамаарч индексжүүлэх зарчим бүрэн хэрэгжээгүй байна.
- Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлтийг нэвтрүүлж хэрэгжүүлсэн 20 гаруй жилийн хугацаанд 12 удаагийн үнэ нэмэх шийдвэрийг ЭХЗХ-оос гаргасан нь хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эсэргүүцэлтэй тулгарч байснаас гадна хараат бусаар гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, хэрэгжих хугацааг хойшлуулах байдлаар “улс төрийн” нөлөөнд автаж байжээ. Хамгийн сүүлд буюу 2024 онд үнэ нэмсэн шийдвэр нь салбарт хуримтлагдсан санхүүгийн алдагдлыг нөхөхөд чиглэсэн боловч дулааны үнийн өсөлтийн шийдвэр хэрэгжих хугацааг хойшлуулсан нь мэргэжилтнүүдийн гаргасан тооцоо, судалгааны бодит үр дүнг бууруулж салбарын алдагдлыг бүрэн нөхөж чадахааргүй болжээ.

- Эрчим хүчний үнэ хямд байгаа нь салбарт шинээр хөрөнгө оруулалт татах боломж, нөхцөлийг хязгаарлаж, үйлдвэрлэлийн өсөлт нь хэрэглээний өсөлтийг хангаж чадахгүйгээс үүдэн өндөр үнэтэй импортын худалдан авалт нэмэгдэж, улмаар энэ нь салбарын эдийн засгийн чадавхад сөргөөр нөлөөлж байна.
- Эрчим хүчний үнэ тарифыг зардалд суурилсан аргачлалаар тогтоож байгаа нөхцөлд эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санал бүрэн дүүрэн биш ч үнийн шийдвэрт тусдаг, харин хэрэглэгчдийн саналыг “хэлбэрийн” төдий тусгадаг буюу тэдний санал бодол үнэ тарифын шийдвэрт тусдаггүй болохыг судалгааны үр дүн нотолсон.
- Эрчим хүчний үнэ тарифыг тогтоохдоо үйлдвэрлэлийн өртөг, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны зардал, зохицуулалтын төлбөрөөс гадна инфляц, валютын ханшийн хэлбэлзэл зэрэг эдийн засгийн бусад хүчин зүйлийг харгалзан хувьсдаг үнийн аргачлал нэвтрүүлэх, мөн эрчим хүчний системийн өөрчлөлтийг хийж иргэд, байгууллагыг эрчим хүч үйлдвэрлэгч байх, эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэх зан үйлийг дэмжсэн үнэ тарифын бодлого, зохицуулалтыг хийх шаардлагатайг судалгаанд оролцогч талууд онцолж байна.
- Шинээр өндөр өртөгтэй эх үүсвэрүүд нэмэгдэж, эдгээр нь урт удаан хугацааны гэрээтэй, зайлшгүй биелүүлэх нөхцөлийг тулгасан заалтуудтай байгаа нь эрчим хүчний хэрэглэгчдийн үнэ тариф цаашид ч тасралтгүй өсөх хандлагыг харуулж байна, гэхдээ хэрэглэгчдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарах магадлал өндөр байгааг судалгааны үр дүн нотолсон. Иймд үнэ тарифын өөрчлөлт, түүний хандлага, өөрчлөгдөх нөхцөл, салбарын эдийн засгийн төлөв байдлын талаар хэрэглэгчдэд мэдээлэл сайн өгч, цаг хугацааны хувьд өвөл биш, хэрэглээ буурах циклийн үед өөрчлөлтийг хийх нь зохистой юм.
- Цаашид эх үүсвэрийн бүтцэд гарч байгаа өөрчлөлт буюу эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр үнэ тариф өсөх, салбарын эрэлт, нийлүүлэлт хэрхэн өөрчлөгдөх, түүнд технологийн дэвшлийн үзүүлэх нөлөөг тооцоолж урт хугацааны таамаглал хийх, түүнийгээ эдийн засгийн бусад салбарынханд мэдээлж хэвшвэл үнийн өсөлт, өөрчлөлтийг эсэргүүцэх байдал буурах, үнэ тариф нь эдийн засгийн олон хүчин зүйлээс хамаарч хэлбэлздэг гэсэн ойлголт, хүлээлт бий болно.

Эрчим хүчний үнэ тарифын бодлогод оролцогч талуудын сонирхол, байр суурийн онцлогийн талаар

- Эрчим хүчний зохицуулалттай зах зээлийн онцлогийн дагуу нэг талаас



тусгай зөвшөөрөл эзэмшигч-салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжийн ашиг, сонирхол, нөгөө талаас эрчим хүч хэрэглэгчийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, үнэ тарифын шийдвэрийг хараат бусаар гаргах хуулиар оноосон эрх, үүрэг нь ЭХЗХ-нд хадгалагдаж байгаа боловч, үнэ тариф тогтооход бодлогын яам, Засгийн газар, Ерөнхий сайд, улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн байгууллага, мэргэжлийн холбоод, салбарын хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч байгууллага гэсэн олон талууд тодорхой сонирхол, эрх мэдэлтэйгээр оролцож нөлөөлж байдгийг судалгааны үр дүн нотолж байна.

- Эрчим хүчний үнийн шийдвэр гаргах эрх зүйн орчин олон улсын хандлагатай нийцэж байгаа боловч ЭХЗХ-ны хараат бусаар шийдвэр гаргах эрх мэдэл бодит байдалд бүрэн хэрэгждэггүй, Засгийн газар, Ерөнхий сайдын нөлөө өндөр байна. Суурь үнийн өсөлт нь иргэдийн буюу айл өрхийн төсөвт шууд нөлөөлөхөөс гадна бусад салбарын үйлдвэрлэлийн зардалд нөлөөлдөг учир эрчим хүчний үнийг бага байлгах нь сонгогчдын эрх ашигт эергээр нөлөөлөх улс төрийн шийдвэр болдог ажээ.
- Эрчим хүчний салбарт гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах гол хүчин зүйл нь “үнэ” бөгөөд сүүлийн жилүүдэд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төслүүдэд урт хугацааны тогтвортой үнийн гэрээг баталж мөрдүүлж байгаа нь цаашид салбарын мөнгөн урсгалд хүчтэй нөлөө үзүүлж, улмаар улс төрөөс гадна зохицуулагчдын шийдвэрт хувийн хэвшлийнхний нөлөө өндөр болох хандлагатай байна.
- Хэрэглэгчид хямд үнийг чухалчилдаг боловч үнийн өсөлтөд аажимдаа дасан зохицож, өндөр үнэтэй боловч найдвартай хангамжийг чухалчилж байна. Энэ хандлага өндөр орлоготой, томоохон аж ахуйн нэгжийн хувьд илүү чухал болохыг судалгааны үр дүн харуулсан. Эрчим хүч тасалдах нь эрчим хүчний өртөг зардлаас илүүтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний доголдол үүсгэж, улмаар алдагдалд хүргэдэг учир найдвартай, тасралтгүй байх нь чухал гэдгийг судалгаанд оролцогчид онцолж байна.
- Эрчим хүчний үйлдвэр аж ахуйн газруудын хувьд үнэ тарифыг өндөр байлгах, нэмэгдүүлэх сонирхолтой бөгөөд одоогийн үнийн түвшин нь зөвхөн зардлаа нөхөх хэмжээнд байгаа нь техник, технологийн шинэчлэл хийх, зардлын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн техник зохион байгуулалтын арга хэмжээг санаачилж, хэрэгжүүлэх сэдлийг дэмжих хөшүүрэг болж чаддаггүй.

- Хэрэглэгчид үнийн шийдвэрт нөлөөлж чаддаггүй боловч үнэ нэмэх шийдвэрийн талаар санаа бодол, эсэргүүцлээ цахим орчинд илэрхийлэх, нийтлэх боломжтой гэж дүгнэсэн. Харин орлогын ялгаанаас хамаарч өндөр орлоготой бол үнэ тарифын шийдвэрийг эсэргүүцэхдээ үзэл бодлоо улс төрч, Засгийн газар болон бусад бодлогын шийдвэр гаргагч талуудад хүргэж, нөлөөлөх боломжтой гэж хариулсан байна.
- ЭХЗХ болон зохицуулагчдын хувьд үнэ тарифын шийдвэрийг хараат бусаар гаргахыг зорьж ажилладаг, эцсийн шийдвэр гаргахаас өмнө нийтэд мэдээлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах нь эсэргүүцэлтэй тулгарна гэсэн байр суурьтай, эрчим хүч хэрэглэгч нь сонгогч гэдэг утгаараа шууд биш ч, дам нөлөөгөөр үнийн шийдвэрт хамгийн их нөлөөтэй гэж үздэг байна.

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийн нөлөө, хэрэглэгчийн хариу үйлдлийн талаар

- Цахилгаан эрчим хүчний үнэ нэмсэн шийдвэрт хэрэглэгчид богино хугацаанд хүчтэй эсэргүүцэл үзүүлдэг ба сошиал орчинд мэдээлэл түгэх хурднаас хамаарч хэрэглэгчдийн хариу үйлдлийг улс төрийн зорилгоор ашиглах, хямд үнийн бодлогыг сонгогчдод нөлөөлөх хэрэгсэл болгох хандлага байсаар иржээ.
- Хямд үнэд дассан хэрэглэгчид эрчим хүчний үнэ нэмсэн шийдвэрийг соргоогоор хүлээн авч, ихэвчлэн сошиал орчинд санал бодлоо илэрхийлдэг бол, аажимдаа үнийн өөрчлөлтөд дасан зохицдог, харин урт хугацаандаа үнийг тогтоох аргачлал нь тодорхой, нээлттэй байхыг илүүд үздэг байна. Аж ахуйн нэгж байгууллагууд үнийн өсөлтөөс гадна үнэ нэмэх зорилго, найдвартай, тасралтгүй хангамжийг чухалчилдаг байна.
- Эрчим хүчний үнэ нэмэх нь хэрэглэгчдийг эрчим хүчээ хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хайх, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгоход чиглүүлж, ухаалаг хэрэглээг дэмжих хөшүүрэг болсон байна.
- Өрхийн ба аж ахуйн нэгж байгууллагын орлогоос болон цахилгаан эрчим хүчээр халаалт дулаанаа шийдвэрлэсэн эсэхээс хамаарч үнийн өсөлтөд үзүүлэх хариу үйлдэл ялгаатай байна. Бага орлоготой иргэд болон өндөр орлоготой ч цахилгаанаар халаалтаа шийдвэрлэсэн айл өрхийн хувьд үнийн өсөлт хүчтэй нөлөө үзүүлж эсэргүүцэх, гомдол гаргах хандлага давамгайлж байна. Харин дундаж орлоготой айл өрхүүдэд эрчим хүчний үнийн өсөлтийг эсэргүүцэхээс илүүтэйгээр үнийн бодлогыг цаашид оновчтой болгох, найдвартай эх үүсвэрийг



нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг салбарын үр ашгийг дээшлүүлэхэд зөв зарцуулахыг сануулах хандлагатай.

- Эрчим хүчний үнэ тарифыг тогтоох субъект, түүний эрх мэдэл, нөлөөллийн талаар хэрэглэгчдийн мэдлэг, ойлголт хангалтгүй байна. ЭХЗХ нь зах зээлийг зохицуулж, үнэ тарифыг хараат бусаар гаргадаг талаарх мэдлэг хэрэглэгчдийн дунд муу, харин салбарын үйлдвэр аж ахуйн газруудын энэ талаарх мэдлэг харьцангуй сайн, харин мэргэжлийн холбоод, мэргэжилтнүүд энэ талаар мэддэг боловч Засгийн газар, улс төрчдийн нөлөө их, мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоодын санаа бодлыг тусгадаггүй гэсэн байр суурьтай байна.
- Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг өөрчлөх цаг хугацааг оновчтой сонгож, шийдвэр гаргах шаардлагатай. Хамгийн сүүлийн тохиолдолд цахилгаан эрчим хүчний хэрэглээний оргил ачааллын өмнө буюу өвлийн улиралд үнэ нэмэх шийдвэр гаргаснаар хэрэглээний өсөлтийн нөлөө нь хэрэглэгчдэд давхар ачаалал, зардлын дарамтыг өгсөн байна.

5.2. Судалгаанд үндэслэсэн бодлогын зөвлөмж

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын шийдвэрт оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэ тариф нэмсэн шийдвэр хэрэглэгчдэд хэрхэн нөлөөлсөн байдал, тэдний хариу үйлдлийг судалсан үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг судалгааны багаас боловсрууллаа.

Эрчим хүчний зохицуулах хороонд:

- Эрчим хүчний зах зээлийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг харгалзан үнэ тариф тогтоох аргачлалаа илүү боловсронгуй болгож, үйлдвэрлэл, нийлүүлэлтийн бүтцийн өөрчлөлт, түүний хандлага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын нөлөө, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсээс хамаарч жил бүр хувьсан өөрчлөгддөг байдлаар өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд шилжилтийн үед буюу эрчим хүчний салбарын эдийн засаг сайжрах хүртэл жил бүрийн үнийн өсөлтийг хуульчлан тогтоох талаар санал боловсруулж, бодлогын яам, УИХ, Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.
- Цаашид эрчим хүчний үнэ тарифын өсөлтийн хандлага, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх прогнозыг гаргаж, эдийн засгийн бусад салбар, зах зээлийн оролцогчдод нээлттэй мэдээлж хэвших. Ялангуяа өндөр өртөгтэй, урт хугацааны гэрээтэй, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгчдийн оролцоо нэмэгдсэнээр хэрэглэгчийн үнэ тариф хэрхэн өөрчлөгдөх, одоогийн үйлдвэрлэгчдийн оролцоо, тэдэнд хуваарилагдах мөнгөн урсгалын

өөрчлөлтийн тооцоолол, таамаглалыг хийж, оролцогч талуудыг мэдээллээр хангах.

- Эрчим хүчний салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардлын хяналтыг сайжруулж, тарифыг үндэслэлтэй тогтоох, нэгэнт тогтоосон тарифыг жил бүр биш 3 хүртэлх жилд тууштай мөрдөж, тарифыг тэдний зардлаа хэмнэх, алдагдлаа бууруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх хөшүүрэг болгож ашиглах.
- Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг хийж, эрчим хүчний үйлдвэрлэлийн шат дамжлага, өртөг зардал, эрчим хүчний үнэ цэн, хэмнэлтийн арга хэлбэрүүдийн талаар хялбаршуулсан мэдээллийг бэлтгэн, хэрэглэгчдийн насны бүлэгт нийцсэн сувгуудаар мэдээлэл өгч, ирээдүйн ухаалаг хэрэглэгчээ бэлтгэх.
- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд мөн эрчим хүчний салбар, зах зээлийн онцлог, үнэ тарифын өөрчлөлт, хандлагын талаар сургалт хийн мэдээлэл өгч, тэднээр дамжуулж бусад оролцогч талуудад нөлөөлөх.
- Үнэ тарифын болон бусад асуудлуудын талаар хэрэглэгч, үйлдвэрлэгч, хэвлэл мэдээллийн байгууллага, мэргэжлийн холбоод, судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг хийж, оролцогч талуудын саналыг бодлогын шийдвэрт тусгаж байх. Оролцогч талуудын саналыг үнэ тарифын бодлого, шийдвэрт тусгах албан ёсны оролцооны механизмыг (жишээ нь, зөвлөлдөх хороо байгуулж ажиллуулах, санал авах цахим платформ бүтээж ашиглах, цахим оролцооны арга хэрэгслийг хөгжүүлэх гэх мэт) бий болгож хэрэгжүүлэх, энэ талаарх зохицуулалтыг үнэ тарифын аргачлал, бусад эрх зүйн актад тодорхой тусгах.
- Эрчим хүчний салбарын хэрэглэгчдийн болон бусад талуудын санал, гомдлыг хүлээн авч, ангилж бүртгэн, мэдээллийн сан үүсгэх, түүнийг дараагийн үнэ тарифын шийдвэр гаргахад харгалзах мэдээлэл болгон ашиглаж хэвших.
- Үнэ нэмэх шийдвэрийн цаг хугацааг оновчтой сонгож, үнийн өсөлтийн дарамтаас гадна хэрэглээний өсөлтийн нөлөөг тооцоолж, үнэ нэмэх шийдвэрээ хавар, зуны улиралд гаргаж хэвших.

Улсын Их Хурал, Засгийн газарт:

- Эрчим хүчний үнэ тарифыг бага түвшинд барих бодлого баримталбал нөгөө талд нь салбарын эдийн засгийг дэмжих, хөрөнгө оруулалтад зарцуулах улсын төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарах.



- ЭХЗХ-ны хараат бусаар ажиллах нөхцөлийг баталгаажуулж, зохицуулагчдыг нээлттэй сонгон шалгаруулж, эхний удаад УИХ-аас томилдог, цаашид мэргэжлийн холбоод, хэрэглэгчдийн төлөөллөөс шууд сонгодог зарчмыг нэвтрүүлж, үнэ тарифын шийдвэрээ хараат бусаар гаргах нөхцөлийг хуульчлан баталгаажуулах.
- Эрчим хүчний зах зээлд оролцогчдын оролцооны хэлбэр, бүтэц өөрчлөгдөж, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаа нь цаашид эрчим хүчний үнэ тариф тасралтгүй өсөх нөхцөл болж байгааг анхаарч, хөрөнгө оруулагчидтай хийх хэлцэлд эрчим хүчний хараат бус, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгаж, тогтвортой үнийн гэрээг хуульчлан батлахгүйгээр үнэ тарифын зохицуулалт хийх эрхийг ЭХЗХ-нд үлдээхэд анхаарах.
- Эрчим хүчний салбарт хийх хөрөнгө оруулалтыг хөнгөлөлттэй зээлийн нөхцөл, татварын бодлогоор дэмжих замаар цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн үнэ тарифын өсөлтийн эрсдэлийг бууруулах бодлого баримтлах.
- Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит компаниудыг хэсэгчлэн, үе шаттайгаар хувьчлах, менежментийг нь сайжруулах, эрчим хүчний үнийг тогтвортой бага түвшинд барих нөхцөлд техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд төрөөс дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл тусламжийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

Дээр дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхээс гадна эрчим хүчний зах зээлийн хандлага, зохицуулалтын үр нөлөөг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Cambridge dictionary: <https://dictionary.cambridge.org/dictionary/english/-ээс>
Гаргасан
- [2017]. Үндэсний статистикийн хороо: https://www.nso.mn/en/data-base/meta-data/indicator/212?utm_source-ээс Гаргасан
- Acemoglu, D., & Robinson, J. A. (2013). *Why Nations Fail: The Origins of Power, Prosperity, and Poverty*. Crown Currency.
- Anatolii, M., Tetyana, M., & Yulia, D. (2024). Price Trends in the Global Electricity Market. *Scientia Fructuosa*, 4-28.
- Arthur, W. B. (1989). Competing technologies, increasing returns, and lock-in by historical events. *The economic journal*, 99(394), 116-131.
- Bryson, J. M. (2003). What To Do When Stake Holders Matter A Guide To Stakeholder Identification and Analysis. *School of Economics and Political Science*, 10.
- David, P. A. (1985). Clio and the Economics of QWERTY. *The American Economic Review*, 75(2), 332-337.
- Freeman, R. E. (1984). *Strategic Management: A Stakeholder Approach*.
- Fritz, V. (2014). *Dealing with a Resource Shock: Political Economy Analysis and Its Impacts in Mongolia. Problem-Driven Political Economy Analysis: The World Bank's Experience*, 31-66.
- Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.). (2014). *Fritz, V., Levy, B., & Ort, R. (Eds.). (2014). Problem-Driven Political Economy Analysis: The World Bank's Experience. Directions in Development*. Washington, DC: World Bank.
- Fronzel, M., & Kussel, G. (2019). Switching on Electricity Demand Response. *The Energy Journal*, September 2019 Vol.40, 1-16.
- Fung, A. (2006). Varieties of participation in complex governance. *Public administration review*, 66, 66-75.
- Fung, A. (2020). Four levels of power: a conception to enable liberation. *Journal of Political Philosophy*, 28(2), 131-157.
- Grindle, M. (2001). Despite the odds: The political economy of social sector reform in Latin America.
- Hofmann, M., & Lindberg, K. B. (2024). Evidence of households's demand flexibility in response to variable hourly electricity prices-Result from a comprehensive field experiment in Norway. *Energy Policy : journal homepage: www.elsevier.com*, 1-15.

- Inglehart, R. (1997). *Modernization and postmodernization: Cultural, economic, and political change in 43 societies*. Princeton university press.
- International Energy Agency. (2024). *World Energy Outlook 2024*. Paris: IEA Publications.
- Kaye, R. J., & Outhred, H. R. (1989). A theory of Electricity Tariff Design for Optimal Operation and Investment. *IEEE Transaction of Power Systems*. .
- Keefer, P. [. (2007). Clientelism, credibility, and the policy choices of young democracies. *American journal of political science*, 51(4).
- Liu, J., Hu, H., Yu, S. S., & Trinh, H. (2023). Electricity Pricing and Its Role in Modern Smart Energy System Design: A Review. *Designs*: <https://mdpi.com/journal/designs>, 2-29.
- M.Griffin, J. (1974). The Effects of Higher Prices on Electricity Consumption. *The Bell Journal of Economics and Management Science*, Vol. 5, No. 2, pp 515-539.
- Munasnighe, M., & Warford, J. J. (1982). *Electricity Pricing: Theory and Case Studies*. Baltimore and London: The John Hopkins University Press .
- N.Dorjdari, & Ts.Tumentsogt. (2023). *Mongolia Electricity and Heating Tariff Reform-Political Economy Analysis*. Ulaanbaatar: World Bank Country office in Mongolia.
- North, D. (1990). Institutions, institutional change and economic performance. *Cambridge university press*.
- North, D. C. (1990). *Institutions, Institutional Change, and Economic Performance*. Cambridge University Press.
- North, D. C. (1994). Economic performance through time. *he American Economic Review*, 6/1/1994, Vol. 84 *American Economic Association*, 361.
- North, D. C., Wallis, J. J., & Weingast, B. R. . (2009). *Violence and social orders: A conceptual framework for interpreting recorded human history*. Cambridge University Press.
- OECD. (2001). *Best Practices for Budget Transparency*. Paris: OECD Publishing.
- Reed et al. (2009).
- Reed, M. G. (2009). Who's in and why? A typology of stakeholder analysis methods for natural resource management. *Journal of environmental management*, 90(5), 1933-1949.
- Rodrik, D. (2008). *One economics, many recipes: Globalization, institutions, and economic growth*. Princeton university press.

- Ross, M. L. (2012). *The oil curse: How petroleum wealth shapes the development of nations*. Princeton University Press.
- Schledorn, A., Charousset-Brignol, S., Junker, R. G., Guericke, D., Madsen, H., & Dominkovic, D. F. (2024). Frigg 2.0: Integrating price-based demand response into large-scale energy system analysis. *Applied Energy*, 1-13.
- Silva, C. (2019). Energy Pricing and Political Stability in Latin America. *Journal of Energy Policy*, 45(3), 123-145.
- Stokes, L. C. (2020). *Short Circuiting Policy: Interest Groups and the Battle Over Clean Energy and Climate Policy in the American States*. Oxford University Press.
- UNISDR. (2015). *Terminology on Disaster Risk Reduction*. United Nations Office for Disaster Risk Reduction.
- Victor, D. G., & Heller, T. C. (Eds.). (2007). *The political economy of power sector reform: The experiences of five major developing countries*. Cambridge University Press.
- Weber, M. (1905). *The Protestant Ethic and the Spirit of Capitalism: The relationships between religion and the economic and social life in modern culture*. Charles Scribner's Sons.
- Wilkin. (2016).
- Williamson, O. E. (1993). Transaction cost economics and organization theory. *Industrial and corporate change*, 2(2).
- World Bank. (2022). *Energy Pricing Policy and Economic Implications in Developing Economies*. World Bank Group.
- Азийн хөгжлийн банк. (2020). *Energy Sector Master Plan Support*.
- Азийн хөгжлийн банк. (2021). *Upscaling Renewable Energy Sector*.
- Азийн хөгжлийн банк, *Energy Sector Master Plan Support*. (2020).
- АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газар. (2002). *Монгол улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратегид оруулах хувь нэмэр*. Улаанбаатар.
- Даваадулам, Ц. (2010). *Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*.
- Засгийн газар. (2016). *Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм*. Улаанбаатар.

- Монгол дахь Конрад Аденауэрын Сан. (2024). *Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь*. Амаржаргал, П. (Ред.).
- Мягмарсүрэн.Д. (2017). *Эрчим хүчний улс төр ба Монгол Улсын геополитик*. Улаанбаатар хот: Адмон принт.
- Н.Түвшинтөгс, & Б.Ариунжаргал. (2010). Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, хэтийн төлвийн талаарх судалгаа-мэдээлэл. *Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгааны төв Бодлогын судалгаа, шинжилгээ III боть*, хуудсд. 248-262.
- НҮБХХ: Европын холбооны санхүүжилттэй «Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь» төсөл . (2024). *Эрчим хүчний салбарын төсвийн зарлагын шинжилгээ*. Улаанбаатар.
- Орон сууцны тухай хууль. (1999). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/439>-ээс Гаргасан
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль. (2007). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/465>-ээс Гаргасан
- Удирдлагын академи. (2020). *Төрийн өмчит аж ахуйн нэгжийн эдийн засагт гүйцэтгэх үүргийн шинжилгээ*. Улаанбаатар хот: Мөнхийн үсэг ХХК.
- ҮСХ. (2025 оны 1 26). 1212.mn. [www.1212.mn](https://www.1212.mn/mn/statistic/statcate/573060/table-view/DT_NSO_1100_009V1): https://www.1212.mn/mn/statistic/statcate/573060/table-view/DT_NSO_1100_009V1-ээс Гаргасан
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*.
- Эрчим Хүчний Зохицуулах Хороо. (2024). *Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд - 2023*. Улаанбаатар.
- Эрчим хүчний зохицуулах хороо. (2024). *Эрчим хүчний үнийн өөрчлөлтийн талаарх танилцуулга*.
- Эрчим хүчний тухай хууль. (2011). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.-ээс Гаргасан
- Эрчим хүчний тухай хууль. (2011). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгч-айл өрхөөс авах судалгааны анкет

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид (айл өрх)-ээс авах судалгаа

Асуумжийн дугаар	
Дүүрэг	

Асуумжийн зорилго:

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн зан төлөв, үнийн талаарх санал бодлыг тодорхойлон, үнэ тарифын өөрчлөлт хэрэглэгчийн ялгаатай бүлгүүдэд хэрхэн нөлөөлснийг судалж, үнийн талаар баримтлах зохистой бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад чиглэсэн зөвлөмж боловсруулах зорилготой.

Мэдээллийн нууцлал болон сайн дурын оролцооны батламж:

- Таны хариултын нууцыг Монгол Улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай”- хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.
- Энэхүү асуулгад өгсөн хариултыг зөвхөн судалгааны зорилгоор ашиглах бөгөөд судалгааны үр дүнд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээллийг дурдахгүй болно.
- Хэрэглэгчдийн санаа бодол, судалгааны нэгдсэн үр дүн нь эрчим хүчний үнийн зохистой бодлого шийдвэрийг гаргахад дэмжлэг болно.
- Та энэхүү асуумжийг өөрөө, үнэн зөв, бүрэн гүйцэд хариулна гэж найдаж байна. Танд баярлалаа.

(Энэ асуулгыг өрхийн цахилгааны хэрэглээний талаар ойлголттой, төлбөрийн төлөлт хариуцсан гишүүнээс авна)

Нэг. Ерөнхий мэдээлэл

№	Асуулт	Хариулт
1.	Таны нас (тохирох насны бүлгийг дугуйлна уу)	1. 20-34 2. 35-49 3. 50-64 4. 65 ба түүнээс дээш
2.	Таны хүйс	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
3.	Ам бүлийн тоо (одоо хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийн тоо)	



4.	Өрхийн сарын орлого ойролцоогоор хэд вэ? (цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогуудыг тооцсоноор)	1. 1 сая төгрөгөөс доош 2. 1.1-2 сая 3. 2.1-3 сая 4. 3.1-5 сая 5. 5.1-7 сая 6. 7.1 саяас дээш	
5.	Танай өрхийн амьдарч буй сууцны төрөл	1. Гэр хороололд гэрт амьдардаг 2. Гэр хороололд байшинд амьдардаг 3. Нийтийн байранд амьдардаг 4. Орон сууцанд амьдардаг 5. Амины орон сууц (хаус)-д амьдардаг 6. Бусад.....	
6.	Танай өрх цахилгааны төлбөрт цахилгааны үнэ нэмэгдэхээс өмнө дунджаар хэдэн төгрөг төлдөг байсан вэ?	Улирал	Төлбөрийн хэмжээ
		Дулааны улиралд	
		Хүйтний улиралд	
7.	Цахилгааны үнэ нэмэгдсэнээс хойш сард дунджаар хэдэн төгрөг төлж байна вэ?	Хүйтний улиралд	

Хоёр. Цахилгаан эрчим хүчний салбарын нөхцөл байдал ба үнийн талаарх санал бодол

1. Та дараах хувилбарын алийг илүүд үзэх вэ? (Санал нийлэх нэг хариултын арын нүдэнд ✓ тэмдэглэнэ үү?)

Цахилгаан эрчим хүч өндөр үнэтэй харин тасралтгүй, найдвартай хангамжтай байх	
Цахилгаан эрчим хүчний үнэ бага, тодорхой хэмжээний хязгаарлалттай байх	
Цахилгаан эрчим хүчний үнэ болон хангамж ямар байх нь надад хамаагүй	

2. Таны хэрэглэсэн цахилгааны төлбөр үнэн зөв тооцогддог уу? (Санал нийлэх нэг хариултыг сонгож ✓ тэмдэглэнэ үү?)

Тийм - тоолуурын заалтын дагуу үнэн зөв тооцогддог	
Үгүй – тоолуур худлаа заадаг	
Үгүй – тоолуурын заалтыг авдаггүй, цахилгааны байцаагч заалтыг таамгаар бичдэг	
Мэдэхгүй – Төлбөрийн нэхэмжлэх ирдэггүй, ирсэн нь ойлгомжгүй байдаг	
Мэдэхгүй -Төлбөрийн нэхэмжлэхээ нягталж шалгадаггүй	

3. Та цахилгааны үнэ өссөн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? (Санал нийлэх хариултыг сонгож V тэмдэглэнэ үү?)

Цахилгаан түгээх компаниас	
Цахилгааны төлбөрийн нэхэмжлэхээс	
Нийгмийн цахим сүлжээнээс (фэйсбүүк, инстаграмм, жиргээ зэрэг)	
Хэвлэл мэдээллийн хэрэгслээс (телевизийн мэдээ, мэдээллийн сайт, сонин зэрэг)	
Эрчим хүчний зохицуулах хорооны цахим сайтаас	

Гурав. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх санал бодол

(1-Огт хүлээн зөвшөөрөхгүй, 2-Зөвшөөрөхгүй, 3-Дунд зэрэг, 4-Зөвшөөрнө, 5-Бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө)

№	Асуулт	1	2	3	4	5
1.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь зайлшгүй зүйл байсан					
2.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь улс орны эдийн засагт ач холбогдолтой					
3.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангах цор ганц арга мөн					
4.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хэрэглэгчид хэмнэлттэйгээр хэрэглэдэг болно					
5.	Цахилгаан эрчим хүчний үнэ өсөж эрчим хүчний салбар алдагдалгүй болсноор хөрөнгө оруулагчид нэмэгдэх боломжтой					
6.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах сонирхол нэмэгдэнэ					
7.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр айл өрхийн санхүүд хүндрэл учирч ядуурал нэмэгдэнэ.					
8.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж инфляц өснө.					
9.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хаягдал дугуй, хог түлэх гэх мэтээр агаарын бохирдол үүсгэх зохисгүй үйлдэл нэмэгдэнэ.					
10.	Бизнесийн байгууллагуудын орлого, ашиг буурна.					

Дөрөв. Цахилгаан эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах хэрэгтэй гэж бодож байна вэ?

(1-Огт хүлээн зөвшөөрөхгүй, 2-Зөвшөөрөхгүй, 3-Дунд зэрэг, 4-Зөвшөөрнө, 5-Бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө)

№	Асуулт	1	2	3	4	5
1.	Эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн зарчмаар, эрэлт нийлүүлэлттэй уялдуулж тогтоох					
2.	Инфляцтай уялдуулан тогтмол өөрчилж байх					
3.	Өртөг, зардлаа нөхөх хэмжээнд байх					
4.	Алдагдалтай ч төрөөс зохицуулан үнийг бага байлгах					



5.	Шөнийн цагийн хөнгөлөлтийг байнга хэрэгжүүлэх					
6.	Оргил ачааллын (17:00-21:00 цагт) үед хэрэглэсэн цахилгааны үнийг илүү өндөр тогтоох					
7.	Хэрэглээний хэмжээгээр ялгаатай үнэ тариф тогтоох					
8.	Сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн, эрчим хүчээ хэмнэсэн хэрэглэгчдийг урамшуулах					
9.	Хэрэглэгч цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж бусад хэрэглэгчдэд борлуулахыг дэмжих, худалдаж авах үнэ тарифыг нэмэх					
10.	Зуны цагт ажил, сургууль, цэцэрлэгийн эхлэх цагийг эрт болгож байгалийн гэрэлтүүлгийг илүү ашиглан цахилгааны хэрэглээг бууруулах					

Тав. Цахилгаан эрчим хүчний үнэ өссөн нь танай өрхийн хувьд хэр мэдрэгдэж байна вэ?

№	Асуулт	Хариулт
1.	Цахилгааны үнийн өсөлт танай өрхийн амьжиргаанд хэр нөлөө үзүүлж байна вэ?	1. Нөлөөлөл үзүүлээгүй 2. Бага хэмжээгээр 3. Маш их дарамт болж байгаа
2.	Үнэ өссөнөөс хойш танайх цахилгааны хэрэглээгээ өөрчилсөн үү?	1. Тийм, хэрэглээгээ хянаж багасгасан 2. Үгүй, хэвээр 3. Хэрэглээ нэмэгдсэн
3.	Цахилгаан эрчим хүчний үнэ өсөхөд танайх дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн үү? (олон хариулт сонгож болно)	1. Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж авч хэрэглэсэн 2. Хэрэглээгээ хянаж цахилгааны хэрэглээгээ бууруулсан 3. Гэр, орон байрныхаа дулаан алдагдлыг бууруулсан 4. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хайсан 4. Ямар нэгэн арга хэмжээ аваагүй 5. Бусад

Зургаа. Та эрчим хүчийг хэмнэх дараах аргуудын талаарх хэр зэрэг мэдэж хэрэгжүүлдэг вэ? (1-Маш муу, 2-Муу, 3-Дунд зэрэг, 4-Сайн, 5-Маш сайн)

№	Асуулт	1	2	3	4	5
1.	Оргил ачааллын (17:00-21:00 цагт) үед цахилгаан бага хэрэглэх					
2.	Гэр, байшингаа сайн дулаалах					
3.	Орон сууцны хаалга, цонхыг сайн хаах зэргээр дулаанаа хадгалах					
4.	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, төхөөрөмж ашиглах					
5.	Телевиз, компьютер гэх мэт цахилгаан хэрэгслээ хэрэглээгүй үедээ унтрааж байх					
6.	Хана, таазаа гэгээтэй өнгөөр будах, цонхоо томруулах гэх мэтээр байгалийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх					

7.	Мэдрэгчтэй гэрэл ашиглах					
8.	Бусад.....					

Долоо. Цаашдаа эрчим хүчний үнэ өсвөл цахилгаан хэмнэх дараах аргуудыг ашиглах бодолтой байна уу?

№	Асуулт	Үгүй	Магадгүй	Тийм
1.	Сэргээгдэх эрчим хүчний (нар, салхины) тоног төхөөрөмжийг ашиглах			
2.	Гэр, байшингаа сайн дулаалах			
3.	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах			
4.	Хана таазаа гэгээтэй өнгөөр будаж байгалийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх			
5.	Мэдрэгчтэй гэрэл ашиглах			
6.	Бусад.....			

Найм. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцох эрх мэдэл, нөлөөлөл, хариу үйлдэл

№	Асуулт	Хариулт
1.	Таны бодлоор Эрчим хүчний үнэ тарифыг хэн тогтоодог вэ? (олон сонголттой байж болно)	1. УИХ 2. Засгийн газар 3. Эрчим хүчний яам 4. Эрчим хүчний зохицуулах хороо 5. Цахилгаан түгээх компаниуд 6. Иргэдийн оролцоо, санал асуулгаар 7. Мэдэхгүй
2.	Эрчим хүчний үнийн бодлогод таны санал бодол тусдаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
3.	Та эрчим хүчний үнийг тогтооход нөлөөлж чадах уу? (олон сонголттой байж болно)	1. Эрчим хүчний үнэ тогтооход би ямар ч нөлөө үзүүлж чадахгүй 2. Би өөрийн хүрээлэлээрээ (эрчим хүчний салбарын танил тал, эрх баригч, улс төрчдөд ойр байдал) дамжуулан үнийн өсөлтөд нөлөөлж чадна 3. Өөрийн сонгосон УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчөөрөө дамжуулан нөлөөлж чадна 4. Нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлж нөлөөлнө 5. Би цахилгаан эрчим хүчний үнэ тогтооход өөрөө шууд оролцож бүрэн нөлөөлж чадна



4.	Та үнийн өөрчлөлтөд ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ? (олон сонголттой байж болно.)	1. Эрчим хүчний хэрэглээгээ багасгаж хэмнэхийг хичээдэг 2. Нийгмийн сүлжээ (сошиал)-нд санал бодлоо илэрхийлдэг 3. Холбогдох байгууллага (Засгийн газрын 1111 төв, Эрчим хүчний яам гэх мэт)-д санал гомдол гаргадаг 4. Цахилгаан түгээх компани (Хэрэглэгчдэд үйлчлэх төв, дуудлагын утас гэх мэт)-д гомдол гаргадаг 5. Хүлээн зөвшөөрч, дасан зохицдог 6. Ямар ч хариу үйлдэл үзүүлдэггүй
5.	Цаашид эрчим хүчний үнэ дахин өсвөл та ямар хариу үйлдэл үзүүлэх вэ? (олон сонголттой байж болно)	1. Хэрэглээгээ хязгаарлана 2. Шинэ технологи (сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр зэрэг) ашиглана 3. Эсэргүүцнэ 4. Нөхцөл байдалтай эвлэрч, хүлээн зөвшөөрнө
6.	Та эрчим хүчний үнэ тарифын талаарх мэдээллийг хэр их сонирхон хүлээн авдаг вэ?	1. Огт сонирхдоггүй 2. Хаяа сонирхдог 3. Байнга сонирхдог
7.	Эрчим хүчний үнэ тарифыг өөрчлөх үед таны оролцоог хэрхэн хангавал зохистой вэ? (олон сонголттой байж болно)	1. Цахимаар санал өгөх 2. Биечлэн уулзаж ярилцах 3. Сонголд оролцож санал бодлоо илэрхийлэх 4. Хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо илэрхийлэх 5. Өдөр тутмын хэвлэлд нийтлэгдсэн үнэ өөрчлөх шийдвэрийн төсөлд санал өгөх 6. Бусад.....

Ес. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, үнийн талаар Танд өөр хэлэх санал байвал доорх зайд бичиж тэмдэглэнэ үү.

.....

.....

.....

.....

.....

Судалгаанд оролцсон танд баярлалаа.

Хавсралт 2. Цахилгаан эрчим хүч хэрэглэгч-байгууллагаас авах судалгааны анкет

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгч-байгууллагаас авах судалгаа

Асуумжийн дугаар	
Дүүрэг	

Асуумжийн зорилго:

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн зан төлөв, үнийн талаарх санал бодлыг тодорхойлон, үнэ тарифын өөрчлөлт хэрэглэгчийн ялгаатай бүлгүүдэд хэрхэн нөлөөлснийг судалж, үнийн талаар баримтлах зохистой бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад чиглэсэн зөвлөмж боловсруулах зорилготой.

Мэдээллийн нууцлал болон сайн дурын оролцооны батламж:

- Таны хариултын нууцыг Монгол Улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай”- хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.
- Энэхүү асуулгад өгсөн хариултыг зөвхөн судалгааны зорилгоор ашиглах бөгөөд судалгааны үр дүнд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээллийг дурдахгүй болно.
- Хэрэглэгчдийн санаа бодол, судалгааны нэгдсэн үр дүн нь эрчим хүчний үнийн зохистой бодлого шийдвэрийг гаргахад дэмжлэг болно.
- Та энэхүү асуумжийг өөрөө, үнэн зөв, бүрэн гүйцэд хариулна гэж найдаж байна. Танд баярлалаа.

(Энэ асуулгыг байгууллагын цахилгааны хэрэглээний талаар ойлголттой, төлбөрийн төлөлт хариуцсан албан тушаалтнаас авна.)

Нэг. Ерөнхий мэдээлэл

№	Асуулт	Хариулт
1.	Танай байгууллагын үйл ажиллагааны чиглэл	1. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 2. Уул уурхай, олборлолт 3. Боловсруулах үйлдвэрлэл 4. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж 5. Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 6. Барилга 7. Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ 8. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 9. Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа 10. Мэдээлэл, холбоо 11. Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 12. Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 13. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 14. Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 15. Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 16. Боловсрол 17. Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа 18. Урлаг, үзвэр, тоглоом наадам 19. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 20. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа
2.	Танай байгууллагын өмчийн хэлбэр	1. Төрийн болон орон нутгийн өмчийн 2. Хувийн өмчийн 3. Төрийн бус байгууллага 4. Олон нийтийн өмчийн байгууллага 5. Гадаадын хөрөнгө оруулалттай
3.	Танай байгууллагын үйл ажиллагаа явуулсан жил	1. 1 жил хүртэл 2. 1-5 жил 3. 11-15 жил 4. 16-аас дээш жил

4.	Танай байгууллагын ажилтны тоо	1. 1-9 ажилтантай 2. 10-19 ажилтантай 3. 20-49 ажилтантай 4. 50-200 ажилтантай 5. 200-аас дээш тооны ажилтантай
5.	Танай байгууллагын жилийн орлого	1. 300 сая төгрөг хүртэл 2. 300 сая-1.0 тэрбум төгрөг 3. 1.0-2.5 тэрбум төгрөг 4. 2.5 тэрбумаас дээш төгрөг
6.	Таны хүйс	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
7.	Таны албан тушаал	1. Байгууллагын удирдах албан тушаалтан 2. Нягтлан бодогч, санхүүгийн мэргэжилтэн 3. Менежер 4. Бусад.....
8.	Танай байгууллагын сарын дундаж зардал	1. 25 хүртэлх сая төгрөг 2. 26-100 сая төгрөг 3. 101-200 сая төгрөг 4. 200 сая төгрөгөөс дээш
9.	Танай байгууллага ямар тоолууртай вэ?	1. Цахилгааны 1 фазын тоолууртай 2. Цахилгааны 3 фазын тоолууртай
10.	Танай байгууллага цахилгааны төлбөрөө ямар тарифаар тооцдог вэ?	1. Энгийн буюу нэг тарифаар 2. 3 тарифаар буюу өдөр, шөнө, оройн тарифаар
11.	Цахилгааны төлбөрт сард дунджаар хэдэн төгрөг төлж байна вэ?	1. Цахилгааны үнэ нэмэгдэхээс өмнө: төгрөг 2. Цахилгааны үнэ нэмэгдсэнээс хойш: төгрөг

Хоёр. Цахилгаан эрчим хүчний салбарын нөхцөл байдал ба үнийн талаарх санал бодол

1. Та дараах хувилбарын алийг илүүд үзэх вэ? (Санал нийлэх нэг хариултын арын нүдэнд ✓ тэмдэглэнэ үү?)

Цахилгаан эрчим хүч өндөр үнэтэй харин тасралтгүй, найдвартай хангамжтай байх.	
Цахилгаан эрчим хүчний үнэ бага, тодорхой хэмжээний хязгаарлалттай байх.	
Цахилгаан эрчим хүчний үнэ болон хангамж ямар байх нь надад болон манай байгууллагад хамааралгүй.	

2. Танай байгууллагын хэрэглэсэн цахилгааны төлбөр үнэн зөв тооцогддог уу? (Санал нийлэх нэг хариултыг сонгож ✓ тэмдэглэнэ үү?)

Тийм - тоолуурын заалтын дагуу үнэн зөв тооцогддог	
Үгүй – тоолуур худлаа заадаг	
Мэдэхгүй -Төлбөрийн нэхэмжлэхээ нягталж шалгадаггүй	

3. Та болон танай байгууллага цахилгааны үнэ өссөн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? (Санал нийлэх нэг хариултыг сонгож ✓ тэмдэглэнэ үү?)

Цахилгаан түгээх компаниас	
Цахилгааны төлбөрийн нэхэмжлэхээс	
Нийгмийн цахим сүлжээнээс (фэйсбүүк, инстаграмм, жиргээ зэрэг)	
Хэвлэл мэдээллийн хэрэгслээс (телевизийн мэдээ, мэдээллийн сайт, сонин зэрэг)	
Эрчим хүчний зохицуулах хорооны цахим сайтаас	

Гурав. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн талаарх санал бодол (1-Огт хүлээн зөвшөөрөхгүй, 2-Зөвшөөрөхгүй, 3-Дунд зэрэг, 4-Зөвшөөрнө, 5-Бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө)

№	Асуулт	1	2	3	4	5
1.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь зайлшгүй зүйл байсан.					
2.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь улс орны эдийн засагт ач холбогдолтой.					
3.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангах цор ганц арга зам мөн.					
4.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хэрэглэгчдийн хэрэглээнд өөрчлөлт гарч, хэмнэлттэйгээр хэрэглэдэг болно.					
5.	Цахилгаан эрчим хүчний үнэ өсөж эрчим хүчний салбар алдагдалгүй болсноор хөрөнгө оруулагчид нэмэгдэх боломжтой.					
6.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах сонирхол нэмэгдэнэ.					
7.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр аж ахуйн нэгж, байгууллагын санхүүд хүндрэл учирч алдагдал нэмэгдэнэ.					
8.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж инфляц өснө.					
9.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр түүхий эд материал, барааны үнэ өсөж, манай зардал нэмэгдэнэ.					
10.	Бизнесийн байгууллагуудын орлого, ашиг буурна.					

Дөрөв. Цахилгаан эрчим хүчний үнийг хэрхэн зохицуулах хэрэгтэй гэж бодож байна вэ? (1-Огт хүлээн зөвшөөрөхгүй, 2-Зөвшөөрөхгүй, 3-Дунд зэрэг, 4-Зөвшөөрнө, 5-Бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө)

№	Асуулт	1	2	3	4	5
1.	Эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн зарчмаар, эрэлт нийлүүлэлттэй уялдуулж тогтоох.					
2.	Инфляцтай уялдуулан тогтмол өөрчилж байх.					
3.	Өртөг зардлаа нөхөх хэмжээнд байх.					
4.	Алдагдалтай ч төрөөс зохицуулан үнийг бага байлгах.					
5.	Шөнийн цагийн хөнгөлөлтийг байнга хэрэгжүүлэх.					
6.	Оргил ачааллын (17:00-21:00 цагт) үед хэрэглэсэн цахилгааны үнийг илүү өндөр тогтоох.					
7.	Хэрэглээний хэмжээгээр ялгаатай үнэ тариф тогтоох.					
8.	Сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн, эрчим хүчээ хэмнэсэн хэрэглэгчдийг урамшуулах.					
9.	Хэрэглэгч цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж бусад хэрэглэгчдэд борлуулахыг дэмжих, худалдаж авах үнэ тарифыг нэмэх.					
10.	Зуны цагт ажил, сургууль, цэцэрлэгийн эхлэх цагийг эрт болгож байгалийн гэрэлтүүлгийг илүү ашиглан цахилгааны хэрэглээг бууруулах.					

Тав. Цахилгаан эрчим хүчний үнэ өссөн нь танай байгууллагын хувьд хэр мэдрэгдэж байна вэ?

№	Асуулт	Хариулт
1.	Цахилгааны үнийн өсөлт танай байгууллагын зардал, ашигт хэр нөлөө үзүүлж байна вэ?	1. Нөлөөлөл үзүүлээгүй. 2. Бага хэмжээгээр нөлөөлсөн. 3. Маш их дарамт болж байгаа.
2.	Үнэ өссөнөөс хойш танай байгууллага цахилгааны хэрэглээгээ өөрчилсөн үү?	1. Тийм, хэрэглээгээ хянаж багасгасан. 2. Үгүй, хэвээр. 3. Хэрэглээ нэмэгдсэн.
3.	Цахилгаан эрчим хүчний үнэ өсөхөд танай байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн үү? (олон хариулт сонгож болно)	1. Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж авч хэрэглэсэн. 2. Барилгын дулаан алдагдлыг бууруулж цахилгааны хэрэглээгээ багасгасан. 3. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хайсан. 4. Ажилтнууддаа цахилгаан эрчим хүч хэмнэх талаар анхааруулга, санамж өгсөн. 5. Ажлын хуваарьт өөрчлөлт оруулж оргил ачааллын үеийн хэрэглээг багасгах, шөнийн хөнгөлөлтөд хамрагдах зарчмаар ажилласан 6. Ямар нэгэн арга хэмжээ аваагүй. 7. Бусад.....

Зургаа. Та эрчим хүчийг хэмнэх дараах аргуудын талаарх хэр зэрэг мэдэж хэрэгжүүлдэг вэ? (1-Маш муу, 2-Муу, 3-Дунд зэрэг, 4-Сайн, 5-Маш сайн)

№	Асуулт	1	2	3	4	5
1.	Оргил ачааллын (17:00-21:00 цагт) үед цахилгаан бага хэрэглэх.					
2.	Барилгаа сайн дулаалах.					
3.	Барилгын хаалга, цонхыг сайн хаах зэргээр дулаанаа хадгалах.					
4.	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах.					
5.	Ажил тарсны дараа болон амралтын өдрүүдэд хүн ажиллахгүй үедээ гэрлээ унтраах.					
6.	Цахилгаан хэрэгсэл, залгуураа хэрэглэхгүй үедээ салгах.					
7.	Хана, таазаа гэгээтэй өнгөөр хийх, будах, цонхоо томруулах гэх мэтээр байгалийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.					
8.	Мэдрэгчтэй гэрэл ашиглах.					
9.	Сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдийг ашиглах.					
10.	Цахилгаан шатны хэрэглээг бууруулж, шатаар алхахыг ажилтнууддаа уриалах.					
11.	Агааржуулагч бага ажиллуулж, цонхоо онгойлгох, салхивчтай болох зэргээр цахилгаанаа хэмнэх.					
12.	Бусад					

Долоо. Цаашдаа эрчим хүчний үнэ өсвөл цахилгаан хэмнэх дараах аргуудыг ашиглах бодолтой байна уу?

№	Асуулт	Үгүй	Магадгүй	Тийм
1.	Сэргээгдэх эрчим хүчний (нар, салхины) тоног төхөөрөмжийг ашиглах.			
2.	Барилгаа сайн дулаалах.			
3.	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах.			
4.	Хана таазаа гэгээтэй өнгөөр будаж байгалийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.			
5.	Мэдрэгчтэй гэрэл ашиглах.			
6.	Онгойлгох боломжтой цонх, салхивчтай болох замаар байгалийн агааржуулалтыг ашиглах.			
7.	Цахилгаан шатны хэрэглээг бууруулах.			
8.	Бусад			

Найм. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэрт оролцох эрх мэдэл, нөлөөлөл, хариу үйлдэл

№	Асуулт	Хариулт
1.	Таны бодлоор Эрчим хүчний үнэ тарифыг хэн тогтоодог вэ? (олон сонголттой байж болно)	1. УИХ 2. Засгийн газар 3. Эрчим хүчний яам 4. Эрчим хүчний зохицуулах хороо 5. Цахилгаан түгээх компаниуд 6. Иргэдийн оролцоо, санал асуулгаар 7. Мэдэхгүй
2.	Эрчим хүчний үнийн бодлогод танай байгууллагын санал бодол тусдаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
3.	Танай байгууллага эрчим хүчний үнийг тогтооход нөлөөлж чадах уу? (олон сонголттой байж болно)	1. Эрчим хүчний үнэ тогтооход бид ямар ч нөлөө үзүүлж чадахгүй. 2. Бид өөрийн хүрээлэлээрээ (эрчим хүчний салбарын танил тал, эрх баригч, улс төрчдөд ойр байдал) дамжуулан үнийн өсөлтөд нөлөөлж чадна. 3. УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгчөөрөө дамжуулан нөлөөлж чадна. 4. Нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлж нөлөөлнө. 5. Бид цахилгаан эрчим хүчний үнэ тогтооход бүрэн нөлөөлж чадна.
4.	Танай байгууллага үнийн өөрчлөлтөд ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ? (олон сонголттой байж болно.)	1. Эрчим хүчний хэрэглээгээ багасгаж хэмнэхийг хичээдэг. 2. Нийгмийн сүлжээ (сошиал)-нд санал бодлоо илэрхийлдэг. 3. Холбогдох байгууллага (Засгийн газрын 1111 төв, Эрчим хүчний яам гэх мэт)-д санал гомдол гаргадаг. 4. Цахилгаан түгээх компани (Хэрэглэгчдэд үйлчлэх төв, дуудлагын утас гэх мэт)-д гомдол гаргадаг. 5. Мэргэжлийн холбоод, Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагад саналаа хэлж, тэд төрийн байгууллага, Засгийн газарт уламжилдаг. 6. Хүлээн зөвшөөрч, дасан зохицдог. 7. Ямар ч хариу үйлдэл үзүүлдэггүй.
5.	Цаашид эрчим хүчний үнэ дахин өсвөл танай байгууллага ямар хариу үйлдэл үзүүлэх вэ? (олон сонголттой байж болно)	1. Хэрэглээгээ хязгаарлана. 2. Шинэ технологи (сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр зэрэг) ашиглана. 3. Эсэргүүцнэ. 4. Нөхцөл байдалтай эвлэрч, хүлээн зөвшөөрнө.
6.	Та бүхэн эрчим хүчний үнэ тарифын талаарх мэдээллийг хэр авдаг вэ?	1. Огт сонирхдоггүй. 2. Заримдаа. 3. Үргэлж.



7.	Эрчим хүчний үнэ тарифыг өөрчлөх үед хэрэглэгчдийн оролцоог хэрхэн хангавал зохистой вэ? (олон сонголттой байж болно)	1. Цахимаар санал өгөх. 2. Биечлэн уулзаж ярилцах. 3. Сонсголд оролцож санал бодлоо илэрхийлэх. 4. Хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо илэрхийлэх. 5. Өдөр тутмын хэвлэлд нийтлэгдсэн үнэ өөрчлөх шийдвэрийн төсөлд санал өгөх. 6. Мэргэжлийн холбоодоор дамжуулан санал хэлэх, лоббидох, нөлөөлөх. 7. Бусад
----	---	--

Ес. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, үнийн талаар Танд өөр хэлэх санал байвал доорх зайд бичиж тэмдэглэнэ үү.

.....

.....

.....

Судалгаанд оролцсон танд баярлалаа.

Хавсралт 3. Экспертийн судалгааны хуудас

Экспертийн үнэлгээний хуудас

Үнэлгээний дугаар	
Огноо	

Үнэлгээний зорилго:

Цахилгаан эрчим хүчний салбарын эксперт (эрчим хүчний салбарын бодлого тодорхойлогч, зохицуулагч, шийдвэр гаргагч, судлаач, салбарын мэргэжилтний төлөөлөл)-ээр үнэ тарифын зохицуулалт, түүнд оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийн байдлыг үнэлүүлэн дүгнэх, судалгаанд үндэслэн зөвлөмж боловсруулах зорилготой.

Мэдээллийн нууцлал болон сайн дурын оролцооны батламж:

- Таны хариултын нууцыг Монгол Улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай”- хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.
- Энэхүү асуулгад өгсөн хариултыг зөвхөн судалгааны зорилгоор ашиглах бөгөөд судалгааны үр дүнд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээллийг дурдахгүй болно.
- Экспертүүдийн санаа бодол, судалгааны нэгдсэн үр дүн нь эрчим хүчний үнийн зохистой бодлого шийдвэрийг гаргахад дэмжлэг болно.

Та энэхүү асуумжийг өөрөө, үнэн зөв, бүрэн гүйцэд хариулна гэж найдаж байна. Танд баярлалаа.

Үнэлэх заавар:

Бүлэг тус бүр дэх үзүүлэлт, өгөгдсөн асуулт, хариулт бүрийн талаар Та өөрийн үнэлгээг 1-ээс 5 хүртэл оноогоор дүгнэн тохирох нүдэнд тэмдэглэж, шаардлагатай бол нэмэлт тайлбар оруулна уу. Сүүлийн хэсэгт нээлттэй асуултууд багтсан бөгөөд та өөрийн санал, зөвлөмжийг товч тодорхой бичнэ үү. (Тайлбар: Үнэлгээний асуулт тус бүр нь 1–5 гэсэн оноогоор дүгнэх багана, мөн нэмэлт тайлбарын талбарыг агуулсан болно.)

I. Ерөнхий мэдээлэл

№	Асуулт	Хариулт
1.	Таны нас (тохирох насны бүлгийг дугуйлна уу)	1. 20-34 2. 35-49 3. 50-64 4. 65 ба түүнээс дээш
2.	Таны хүйс	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
3.	Улсад ажилласан жил	
4.	Үүнээс цахилгаан эрчим хүчний салбарын мэргэжилтэн эсвэл судлаачаар ажилласан /улс төрч бол эрчим хүчний асуудлаар бодлого тодорхойлоход оролцож улс төрийн албан тушаал хашсан/ жил	
5.	Таны ажлын туршлага экспертийн бүлгийн аль ангилалд хамаарахыг тэмдэглэнэ үү.	1. Эрчим хүчний асуудлаар бодлого тодорхойлогч, / улс төрч, сайд 2. Эрчим хүчний зохицуулах хорооны дарга/ зохицуулагч 3. Эрчим хүчний асуудлаар судалдаг судлаач/ эрдэмтэн 4. Эрчим хүчний салбарын мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл

II. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлтийн шалтгааныг тодорхойлсон дараах өгүүлэмж тус бүртэй хэр зэрэг санал нийлж байна вэ? (1 –огт санал нийлэхгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – ихэнхдээ, 5 – бүрэн санал нийлж байна).

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Цахилгаан эрчим хүчний салбарын зардлын зохисгүй (бүтэц зохион байгуулалт буруу, худалдан авалтын ил тод байдал муу, технологийн хоцрогдол зэргээс шалтгаалсан) өсөлтийг нөхөх.						
2.	Техник технологийн хоцрогдлоос шалтгаалсан алдагдлыг нөхөх.						
3.	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, ашиглалтыг дэмжих зардлын өсөлтийг санхүүжүүлэх.						
4.	Тарифын зохицуулалт хангалтгүй байснаас үүдэлтэй салбарын хуримтлагдсан санхүүгийн алдагдлыг бууруулах.						
5.	Олон жил өртгөөс хэт доогуур хатуу үнэ баримталж ирсэн алдааг засах.						

III. Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт, түүний үр дагаврын талаарх таны санал бодол (1-Огт хүлээн зөвшөөрөхгүй, 2-Зөвшөөрөхгүй, 3-Дунд зэрэг, 4-Зөвшөөрнө, 5-Бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө)

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөснөөр салбарын санхүү, эдийн засгийн нөхцөл сайжирч хэвийн үйл ажиллагаа хангагдана.						
2.	Цахилгаан эрчим хүчний үнийг өсгөх нь эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдлыг хангах цор ганц арга зам мөн.						
3.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр хэрэглэгчид хэрэглээгээ хянах, хэмнэх дадал, үйлдэл нэмэгдэнэ.						
4.	Цахилгаан эрчим хүчний үнэ өсөж эрчим хүчний салбар алдагдалгүй болсноор хөрөнгө оруулагчид нэмэгдэнэ.						
5.	Эрчим хүчний салбар техник технологийн шинэчлэл, засвар үйлчилгээгээ төлөвлөсөн хэмжээнд хийж хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.						
6.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр аж ахуйн нэгж, байгууллагын зардлыг өсгөж, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.						
7.	Цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр инфляц өснө.						
8.	Цахилгаан эрчим хүчний үнийн өсөлт нь айл өрхийн амьжиргааг доройтуулна.						

IV. Цахилгаан эрчим хүчний үнийг тогтоож ирсэн аргын талаарх дараах өгүүлэмжтэй хэр зэрэг санал нийлж байна вэ (1 –огт санал нийлэхгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – ихэнхдээ, 5 – бүрэн санал нийлж байна)

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Захиргааны аргаар буюу эдийн засгийн хүчин зүйлсийг үл харгалзан тогтоодог.						
2.	Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан тогтоож ирсэн.						
3.	Улс төрчдийн саналыг тусган, тэдний өндөр оролцоо, нөлөөтэйгөөр шийдэж ирсэн.						



4.	Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөг зардалд тулгуурлан ашгийн зохих түвшнийг хангасан байхаар, салбарын мэргэжилтнүүдийн гаргасан бодит тооцоололд үндэслэн тогтоож ирсэн.						
5.	Хэрэглэгчийн санаа бодлыг үнэ тогтооход онцгойлон анхаарч зохицуулж ирсэн.						
6.	Үйлдвэрлэлийн өртөг, инфляц болон эрэлт, нийлүүлэлт зэрэг эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан эрчим хүчний үнийг зах зээлийн зарчмаар тогтоож ирсэн.						

V. Цахилгаан эрчим хүчний үнийн зохицуулалтыг хэрхэн хийж ирснийг тодорхойлсон дараах өгүүлэмжтэй та хэр зэрэг санал нийлж байна вэ?
(1 –огт санал нийлэхгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – ихэнхдээ, 5 – бүрэн санал нийлж байна)

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	УИХ-ын нөлөө бүхий гишүүдийн санал, нөлөөллөөр зохицуулдаг.						
2.	Үнэ тарифын зохицуулалтад Засгийн газрын тэргүүн болон гишүүдийн нөлөөлөл их байдаг.						
3.	Эрх барьж буй намын удирдлагын шийдвэрээр зохицуулдаг.						
4.	Эрчим хүчний зохицуулах хороо хуулиар хүлээсэн эрх, үүргийн хүрээнд хараат бусаар үнэ тарифыг зохицуулдаг.						
5.	Нийгмийн сүлжээн дэх иргэдийн санаа бодлыг харгалзан зохицуулдаг.						
6.	Хэрэглэгч, үйлдвэрлэгчийн харилцан зөвшилцлөөр зохицуулдаг.						
7.	Эрчим хүчний үйлдвэрлэгч, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хэрэглэгч зэрэг оролцогч талуудын саналыг тусган зохицуулдаг.						
8.	Зохицуулалт бага, зах зээлийн зарчим үйлчилдэг.						

VI. Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэр гаргалтад холбогдогч талуудын нөлөөллийн түвшнийг үнэлнэ үү (1 – маш сул, 2 – сул, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – хамгийн их)

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Улсын Их Хурал						
2.	Засгийн газар						
3.	Эрчим хүчний яам						
4.	Эрчим хүчний зохицуулах хороо						
5.	Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгчид						
6.	Цахилгаан түгээх компаниуд						
7.	Салбарын мэргэжлийн холбоод						
8.	Иргэд, хэрэглэгчид						
9.	Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээ						
10.	Лобби бүлэг, улс төрчид						

VII. Цахилгаан эрчим хүчний үнийг цаашид хэрхэн тогтоож зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна вэ? (1-Огт хүлээн зөвшөөрөхгүй, 2-Зөвшөөрөхгүй, 3-Дунд зэрэг, 4-Зөвшөөрнө, 5-Бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө)

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Цахилгаан эрчим хүчний үнийг бүрэн чөлөөлж үнэ тарифыг зах зээлийн зарчмаар тогтоох.						
2.	Үнэ тарифыг хэрэглэгчдийн бодит худалдан авах чадварт тулгуурлан өөрчлөх, зорилтот бүлэгт чиглэсэн үнэ тарифын ялгамжтай зохицуулалттай байх нь зүйтэй.						
3.	Цахилгаан эрчим хүчний үнэ тариф өртгөө нөхөхүйц байх ёстой.						
4.	Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг өртгөөс доогуур тогтоож иргэд аж ахуйн нэгжийг дэмжих ёстой.						
5.	Хэрэглээний хэмжээнээс хамааран шаталсан тарифын тогтолцоо нэвтрүүлэх.						
6.	Сэргээгдэх эрчим хүч ашигласан болон эрчим хүч хэмнэсэн хэрэглэгчдэд үнийн урамшуулал үзүүлэх.						
7.	Иргэн, байгууллагын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг төвлөрсөн сүлжээнд нийлүүлэхийг дэмжих, худалдан авах үнийг оновчтой тогтоох.						
8.	Эрчим хүчний үйлдвэрлэлийн өртөг, инфляц, эдийн засгийн бусад хүчин зүйлийг харгалзан хувьсдаг үнийн аргачлал нэвтрүүлэх шаардлагатай.						

VIII. Цахилгаан эрчим хүчний салбарын зохицуулалт, үнийн шийдвэрт оролцогч талуудтай харилцах үйл явцын талаарх дараах өгүүлэмжтэй хэр санал нийлэх вэ? (1 –огт санал нийлэхгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – ихэнхдээ, 5 – бүрэн санал нийлж байна)

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Цахилгаан эрчим хүчний үнийн шийдвэр гаргахад бүх талуудын саналыг урьдчилж авч судалгаанд суурилах зарчмаар тогтоох.						
2.	Хэрэглэгч, үйлдвэрлэгч, хангагч байгууллага, мэргэжлийн холбоод зэрэг бүх талуудыг оролцуулсан сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг авч үнийн шийдвэрт харгалзах.						
3.	Эрчим хүчний зохицуулах хорооны цахим хуудсаар мэдээлэх.						
4.	Цахилгаан эрчим хүчний үнийн өөрчлөлт, хэрэглээний дадал хэвшлийн талаар олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа байнга явуулах.						
5.	Цахилгаан эрчим хүчний үнийн бодлогын талаар мэдээлэх, сурталчлах шаардлагагүй.						

IX. Эрчим хүчний салбарын өөрчлөлт, үнэ тарифын зохицуулалтын цаашдын хандлагын талаарх дараах өгүүлэмжтэй хэр санал нийлэх вэ? (1 –огт санал нийлэхгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – ихэнхдээ, 5 – бүрэн санал нийлж байна).

№	Асуулт	1	2	3	4	5	Нэмэлт тайлбар
1.	Эрчим хүчний найдвартай, тасралтгүй хангамжийг хангахын тулд эх үүсвэрийг нэмж, өртгийг бууруулах нь чухал.						
2.	Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлтийг хийж зах зээлийн загварыг өөрчлөх шаардлагатай.						
3.	Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн өөрчлөлтийг хийх.						
4.	Эрчим хүчний салбарт технологийн шинэчлэл хийж сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.						
5.	Цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг хараат бусаар зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал.						

X. Цахилгаан эрчим хүчний салбарын ирээдүйн бодлого, үнэ тарифын шийдвэрийн талаар Танд өөр хэлэх санал байвал доорх зайд бичиж тэмдэглэнэ үү.

.....

.....

Судалгаанд оролцсон танд баярлалаа.

Хавсралт 4. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн судалгааг авах зааварчилгааны хуудас

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн судалгааг авах зааварчилгаа

Талархал

Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдээс судалгаа авахад дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа Танд судалгааны багийн өмнөөс талархал илэрхийлье.

Зааварчилгаа

Та бидэнд дэмжлэг үзүүлж ажиллахдаа дараах зарчмыг баримталж ажиллахыг зөвлөж байна. Энэ нь судалгааны үр дүн бодитой, үнэн гарахад шууд нөлөөлөхийг анхаарна уу.

1. Асуулга судалгааны хуудсыг зөвхөн тухайн айл өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ, төлбөр тооцооны талаар мэдлэгтэй насанд хүрсэн гишүүнээр бөглүүлэх.
2. Байгууллагын хэрэглэгчээс судалгааг авахдаа мөн тухайн байгууллагынхаа цахилгаан эрчим хүчний хэрэглээнд хяналт тавьж төлбөр тооцоог хариуцдаг эрх бүхий албан тушаалтнаар судалгааг бөглүүлэх.
3. Судалгаанд хамрагдах хэрэглэгчдийн бүлэг, түүнд хамаарах хэрэглэгчийг санамсаргүйгээр сонгож судалгааг бөглүүлэх. Жишээлбэл, Хан-Уул дүүргийн орон сууцны 20 хэрэглэгчээс судалгаа авах бол нэг хотхоны бус, өөр өөр байршилд амьдардаг орон сууцны хэрэглэгчдийг судалгаанд хамруулах.
4. Хэрэглэгч судалгааг бөглөх явцад судалгааны асуулт, хариултын утгыг ойлгуулах тайлбар хийхээс өөрөөр ямар нэгэн нөлөө үзүүлэх, хариултын сонголтыг зааж зөвлөхийг хатуу хориглоно.
5. Судалгааг бөглөх явцад санаа сэтгэлд нь нөлөөлөхүйц, асуултын хариултад хөтлөхүйц тайлбар өгөхгүй, яриа өрнүүлэхгүй байх.
6. Судалгааны хуудсыг бүрэн бөглөсөн эсэхэд хяналт тавьж хэрэв дутуу бөглөсөн байвал тухайн үед нь гүйцээж бөглүүлэх.
7. Судалгааны хуудсыг тарааж олшруулах, дамжуулахгүйгээр хэвлэж өгсөн хуудсыг бүрэн гүйцэт бөглүүлэх.
8. Судалгааны үр дүнгийн талаар таамаглаж ярилцах, буруу ташаа мэдээлэл өгөхгүй байх.
9. Судалгаанд оролцсон хүний харилцах утасны дугаарыг өгсөн хуудсанд тэмдэглэж авах. Утасны дугаараар эргэж холбогдон судалгааг үнэн



зөв бөглөсөн эсэхэд хяналт тавих зорилгоор уг мэдээллийг ашиглахыг тайлбарлаж хэлэх. Хэрэв тухайн утасны дугаарт байгаа хүн судалгааг бөглөөгүй, үнэн зөв хариулаагүй гэж хяналтын багт мэдэгдвэл түүврийн хэмжээг нөхөж хангахын тулд судалгааг дахиж авах шаардлага үүсэхийг анхаарна уу.

Танд баярлалаа, амжилт хүсье.

Хэрэглэгчийн (айл өрх) судалгаанд оролцогчийн утасны дугаарын мэдээллийг цуглуулах хуудас

Судалгаа авсан байршил:.....дүүрэг

№	Хэрэглэгчийн ангиллын аль бүлэгт хамаарахыг тэмдэглэнэ	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	
	☐ Орон сууцны ☐ Гэр хорооллын ☐ Хаус, амины орон сууц	

Хэрэглэгчийн (байгууллага, аж ахуйн нэгж) судалгаанд оролцогчийн утасны дугаарын мэдээллийг цуглуулах хуудас

Судалгаа авсан байршил:.....дүүрэг

[illegible]

Хавсралт 5. Ярилцлагын удирдамж

Ярилцлагын удирдамж

Фокус бүлгийн ярилцлагын удирдамж (аан хэрэглэгчид)

Бэлтгэл үе

Асуултаа хэвлэж гартаа барь: Хамгийн гол тулгуур бол асуултын жагсаалт.

Цагийн хуваарь тогтоо: Нийт 90 минут гэж үзвэл:

- Оршил 10 минут
- Гол сэдэв 65 минут
- Дүгнэлт 15 минут

Орчныг бэлд: Тайван, анхаарал сарниулахгүй, дулаахан өрөө.

Бичлэгийн зөвшөөрөл: Оролцогчдоос бичлэг хийх эсэх талаар асууж, зөвшөөрөл ав.

Эхлэл (Нүүр хагарах, 5–10 минут)

Модератор дараах байдлаар ярина:

“Сайн байна уу? Бүгдэд энэ уулзалтад оролцож байгаад баярлалаа. Би ____, өнөөдрийн ярилцлагыг удирдан явуулна. Ярилцлагын зорилго бол цахилгаан эрчим хүчний хэрэглээ, үнэ тарифын талаар таны бодол, туршлагыг сонсох. Зөв, буруу хариулт гэж байхгүй. Та бүхэн чөлөөтэй ярьж болно. Бид таны нэрийг дурдалгүйгээр зөвхөн дүгнэлтэд ашиглана.”

Дүрмээ хэлнэ:

- Хүн бүрийн саналыг сонсоно.
- Давхар ярьж таслахгүй.
- Хүсвэл асуултад хариулахгүй өнгөрч болно.

Оролцогчдыг өөрийгөө товч танилцуулахыг урих ба ярилцлагын үр дүн дүгнэлтэд нэрийг дурдахгүй гэдгийг хэлнэ.

Нүүр хагарах асуулт:

“Цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэн нь танай байгууллагад ямар нөлөөлөл үзүүлж байна гэж та үзэж байна вэ?”

Асуулт 1: Цахилгааны үнийг өсгөх шаардлага байна гэж та үздэг үү? Яагаад ингэж үзэж байна вэ?

Чиглүүлэх: Төрийн бодлого эсвэл техник хангамжийн асуудал нөлөөлж байна гэж бодож байна уу?

Асуулт 2: Цахилгааны үнийг хэрхэн тогтоох нь зөв гэж бодож байна вэ?

Чиглүүлэх: Зах зээлийн зарчимд тулгуурлах уу, эсвэл өртөг дээр суурилах уу? Өөр ямар зарчим баримтлах нь таны бодлоор зөв бэ? яагаад

Асуулт 3: Эрчим хүчний үнийн талаарх мэдээллийг та голчлон хаанаас авдаг вэ?

Чиглүүлэх: Мэдээлэл тодорхой, ойлгомжтой байдаг уу? Хаанаас авах нь илүү найдвартай вэ?

Асуулт 4: Танай байгууллага ханган нийлүүлэгч эсвэл зохицуулагч байгууллагатай үнэ тарифын талаар санал солилцож байсан уу?

Чиглүүлэх: Тэдний хандлага ямар байсан бэ? Таны саналд хариу өгсөн үү?

Асуулт 5: Эрчим хүчний үнэ тарифыг тогтооход хэн хамгийн хүчтэй нөлөөтэй гэж үзэж байна вэ?

Чиглүүлэх: УИХ, ЗГ, яам, зохицуулагч, компани, олон улсын байгууллага гэх мэт.

Асуулт 6: Үнийн өсөлтөөс танай байгууллагад тулгарсан хамгийн том сорилт юу байсан бэ?

Чиглүүлэх: Үйл ажиллагааны аль хэсэг хамгийн их өртсөн бэ?

Асуулт 7: Үнийн өөрчлөлтөд хариу болгон ямар арга хэмжээ авсан бэ?

Чиглүүлэх: Тоног төхөөрөмж шинэчилсэн үү? Хэрэглээгээ багасгасан уу? Ажлын цаг өөрчлөгдсөн үү?

Асуулт 8: Сэргээгдэх эрчим хүч эсвэл хэмнэлттэй технологи нэвтрүүлэх талаар ямар санаачилга гаргасан бэ?

Чиглүүлэх: Нарны панель, энерги хэмнэгч төхөөрөмж суурилуулсан уу?

Анхаарах зүйлс:

1. Уур амьсгал ба орчин

- Чөлөөтэй, аюулгүй орчин бүрдүүлэх – оролцогчид шүүмжлэлээс айлгүй бодлоо илэрхийлэх боломжтой байх.
- Анхаарал сарниулах хүчин зүйлсийг багасгах – утас дуугарах, гаднын хүн орж гарахаас сэргийлэх.
- Итгэлцлийг бий болгох – эхэнд нь уян хатан, урам өгсөн өнгө аяс ашиглах.

2. Асуулт тавих арга

- Энгийн, ойлгомжтой хэлээр асуух – техникийн үг хэллэгээс зайлсхий.
- Нэг асуулт нэг санаа – урт нийлмэл өгүүлбэрээс зайлсхий.
- Нээлттэй асуулт давамгайл – “тийм/үгүй” гэж хариулахгүйгээр өөрийн байр сууриа тайлбарлах боломж олго.
- Чиглүүлэх асуулт ашиглаж гүнзгийрүүлэх – “жишээ хэлж өгнө үү?”, “яагаад тэгж үзэж байна вэ?”.

3. Оролцогчдыг идэвхжүүлэх

- Дуугүй байгаа хүнийг татах – *“Таны бодлыг сонсмоор байна”*.
- Давамгай яригчийг зохицуулах – *“Энэ талаар өөр хүн юу гэж бодож байна?”*.
- Хүмүүсийн үгийг баталгаажуулах – *“Маш сонирхолтой санаа байна, өөр санал нэмэх хүн байна уу?”*.

4. Сэдвийн удирдлага

- Нэг сэдэвт автахаас сэргийлэх – “Энэ чухал санаа байна. Одоо холбоотой өөр нэг өнцгийг ярь” гэж дараагийн асуулт руу шилжүүлэх.
- Яриаг хэтурт сунжруулахгүй – гол санааг нь баталгаажуулаад дараагийн оролцогч руу шилжүүл.
- Шилжилтийг зөөлөн хийх – “Бид үнэ өсөлтийн талаар ярьсан, одоо хэрэглээний өөрчлөлтийн тухай ярь”.

5. Ёс зүй, мэдрэмж

- Хүндэтгэх хандлага – оролцогчийн үгийг таслахгүй, маргалдаан үүсвэл тэнцвэртэй зөөлөн удирдах.
- Эмзэг сэдэвт анхааралтай хандах – амьжиргаа, зардлын асуудалд инээх, шоолохоос сэргийлэх.
- Нууцлалыг дахин баталгаажуулах – хэн юу хэлснийг тайланд нэрээр дурдахгүй.

6. Тэмдэглэл ба бичлэг

- Бичлэг хийх бол зөвшөөрөл авах – эхэнд нь тодорхой хэлэх.
- Тэмдэглэл хөтлөх – гол ишлэл, байр суурийг тэмдэглэх.
- Оролцогчдыг тоолж, хэн ярьсныг тэмдэглэх – дүгнэлтэд жингүйдлийг арилгах.



7. Цагийн менежмент

- Хугацааг хянах – нэг асуултад дунджаар 5–7 минут зарцуулах.
- Оролцогч бүрийг яриулах – ярилцлагын төгсгөлд дуугүй үлдсэн хүнийг ярих боломж олго.
- Төгсгөлд дүгнэлт гаргуулах – “Өнөөдрийн хамгийн чухал санаа юу байв?” гэж асууж ярилцлагыг хаах.

Хавсралт 6. ААН хэрэглэгчдийн ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ

1. ААН хэрэглэгчдийн ярилцлагын шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Цахилгааны үнийн өсөлтийн нөлөөлөл	PE1	Санхүүгийн дарамт	Манай компанийн хувьд нэгж бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөх тусам өрсөлдөх чадвар буурч байгаа юм. 30 хувиар эрчим хүчний үнэ өсөж байгаа нь манай компанид төдий хэмжээний алдагдлыг үүрүүлж байна гэсэн үг юм... Үйл ажиллагааны зардал нэмэгдсэнээр хөрөнгө оруулалт танах, ялангуяа ногоон төслүүд хумигдсан.... Компанийн нийгмийн халамжийн үйл ажиллагаа (ажилчдын цалин, урамшуулал) буурсан.	Үнийн өсөлт нь үйл ажиллагааны зардлыг огцом нэмэгдүүлж, санхүүгийн тогтвортой байдалд шууд сөргөөр нөлөөлсөн.
1.2	Цахилгааны үнийн өсөлтийн нөлөөлөл	PE2	Хэрэглэгчдийн бухимдал	Нэг талдаа бүтээгдэхүүнээ нэмсэн нь хэрэглэгчдэд дургүйцэл бухимдлыг төрүүлсэн үйлдэл болсон.	Үнийн өсөлт нь зөвхөн байгууллагын дотоод зардалд бус, зах зээлийн хариу үйлдлээр дамжин давхар дарамт үүсгэсэн
1.3	Цахилгааны үнийн өсөлтийн нөлөөлөл	PE3	Эерэг нөлөөлөл	Цахилгааны үнэ нэмэгдсэн давуу тал нь гэвэл удирдлагууд анхаарлаа түлхүү хандуулж эхэлсэн. ROI (хөрөнгө оруулалтын өгөөж) тооцоо нэмэгдэж тооцоо нь харьцангуй гайгүй гарч ирж байгаа юм.	Үнийн өсөлт богино хугацаанд дарамт үзүүлдэг ч дунд хугацаанд шинэчлэл хийх шалтгаан болсон байна.
2.1	Хэрэглээний өөрчлөлт ба хэмнэлт	BE1	Хэрэглээний хэмнэлт	Өвлийн улиралд буюу оргил ачааллын үеүдэд унтрааж, цахилгаан эрчим хүчээ аль болох хэмнэлттэй ашиглахыг эрмэлздэг юм. Мөн дулаан үед бас тухайн хөдөлгүүрээ асаах цагийг нь багасгаж ажиллаж байгаа.	ААН-үүд хэрэглээгээ удирдаж, оргил үеийн зардлыг бууруулах, хэмнэх алхмууд хэрэгжүүлж байна.
2.2	Хэрэглээний өөрчлөлт ба хэмнэлт	BE2	Техникийн шийдэл	Хуучин эрчим хүч их зарцуулдаг муудсан тоног төхөөрөмжөө сольж эрчим хүчинд хэмнэлттэй сайн чанарын тоног төхөөрөмжүүдийг худалдан авч ашиглаж байна. Сэргээгдэх эрчим хүч рүүгээ аль болох түлхүү шилжье ээ гэсэн зүйлүүдийг ярьж байгаа.	Хуучин тоног төхөөрөмжөө шинэчлэн солих, эрчим хүчний хэмнэлттэй технологи авах нь хамгийн их давтагдсан хариу үйлдэл байна



№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
3.1	Үнийн бодлогын шүүмжлэл	CE1	Үнэ шууд нэмэх буруу	Үнийн нэг түвшинд бага багаар, түвшин түвшиндээ нэмээд жилд дунджаар 1,2,3 хувиар нэмэх гэж байна аа гэдгээ жилийн өмнөөс ч юм уу төлөвлөөд явах юм бол компани чинь өөрсдийнхөө бодлогодоо тулгуурлаад, за энэ жил эрчим хүчний үнэ 2 хувиар нэмэгдэнэ, бид бүхэн тэрэнд зориулж ийм төсөв батална гэх мэтээр бэлдэж явах юм. Гэтэл өнгөрсөн жилийнх шиг шууд огцом нэмчихээр бүх компаниуд, хэрэглэгчдэд үнийн том дарамт болоод ирж байгаа юм.	ААН-үүд огцом үнийн өсөлтийг “буруу бодлого”, бага багаар нэмэх нь зүйтэй гэж үнэлсэн.
3.2	Үнийн бодлогын шүүмжлэл	CE2	Шархаа нөхөх бодлого	Үнэ нэмснээр эрчим хүчний чанар, түгээлт, дамжуулалт нь сайжрах уу? эсвэл зөвхөн шархаа нөхөх төдий болчихов уу гэдэг дээр нэлээн эргэлзээ байгаад байна... Нодингийн үнийн өсөлт нь зөвхөн амиа бодож, шархаа нөхөх тийм түвшинд л хүрчихсэн байна.	Үнэ өсөлт салбарын чанарыг сайжруулахад бус, тогтвортой шинэчлэлд бус, салбарын алдагдал нөхөхөд чиглэсэн гэж үзсэн.
3.3	Үнийн бодлогын шүүмжлэл	CE3	Алдаатай бодлого	Утасны төлбөр ойролцоогоор 70 мянган төгрөг гарч байгаа шүү дээ. Гэтэл айл өрхийн цахилгааны хэрэглээ 70 мянга гарлаа гэхэд ямар өндөр зардал гараа вэ гээд байдаг. Яг үнэндээ үнийг жинлээд үзэх юм бол аль нь илүү үнэ цэнтэй вэ гэхлээр цахилгаан эрчим хүч илүү үнэ цэнтэй байгаад байгаа юм... Тиймээс анхнаасаа улс төрийн байдлаас ч юм уу болоод цахилгааны үнэ тарифыг удаан хугацаанд барьчихсан, Монгол Улсын хувьд инфляц их байгаад байгаатай холбоотой инфляц л яваад байдаг, үндсэн цахилгааны тариф зардлууд нь хэвэндээ байгаад байдаг. Эцсийн дүнд ямар ч нэмэргүй болсон хойно оо за одоо нэмэхээс өөр арга байхгүй гэсэн байр суурьтай болчихсон байдаг.	Үнийг удаан хугацаанд доогуур түвшинд барьсан нь инфляц хуримтлагдахад нөлөөлж, одоо огцом өсөхөөс өөр аргагүй нөхцөл үссэн бөгөөд тарифын бодлого удаан хугацаанд эдийн засгийн суурь үзүүлэлттэй нийцээгүй явсны үр дагавар гэж үзэж байна. Түүнчлэн цахилгаан эрчим хүчний үнэ цэний ойлголт бага.

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
4.1	ААН хэрэглэгчдийн оролцоо ба бодлогын суваг	PWE1	Шийдвэрт нөлөөлөх боломжгүй	...санал хэлээд ч шийдвэр гаргах түвшинд очоод гацдаг.	ААН-үүдийн оролцоо бодлогын түвшинд хүрдэггүй. Тарифын бодлого төвлөрсөн, оролцогч талуудын хэлэлцүүлэг сул байгааг илтгэнэ.
4.2	ААН хэрэглэгчдийн оролцоо ба бодлогын суваг	PWE2	Мэдээллийн суваг	Зохицуулах хорооны вебсайт, Улаанбаатар Цахилгаан түгээх сайтас, мөн албан бичгээр ирдэг.	ААН-үүдийн хувьд үнийн мэдээллийг өвхөн цахилгаан түгээх байгууллага, зохицуулах хорооноос албан бичгээр авах тул оролцоо бус, хүлээн авах төвлөрсөн горимд байна.
5.1	Шийдвэрлэх арга зам	SE1	Татвар, зээл, урамшуулал	Гадаадаас ч юм уу, Монголын банкаас бага хүүтэй зээл авах хэрэгтэй болж байна. Монголоос зээл авья гэхээр боломж байхгүй, гадаадаас гэхээр маш их өндөр шалгуур тавьдаг хэцүү байдалд байна. ЭХЗХ, ЗГ-аас сэргээгдэх эрчим хүч хариуцсан гадаадын тусламж, хөнгөлөлттэй зээлүүд их гаргаж баймаар байна. Татварын хөнгөлөлт (карбон кредит, нийгмийн хариуцлага) хэрхэн тооцогдох нь тодорхойгүй.	ААН-үүд сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэхэд бага хүүтэй зээл хомс, татварын хөнгөлөлт тодорхойгүй, карбон кредитийн систем өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрээгүй гэсэн хүндрэлтэй тулгарч байна.
5.1	Шийдвэрлэх арга зам	SE2	СЭХ-ийн илүүдэл эрчим хүч нийлүүлэх үйл явц тодорхойгүй	Бид сэргээгдэх эрчим хүчээр станц бариад хэрэглээгээ гаргаад илүүдлийг нь түгээхээр өгөх гээд байгаа. Тэгэхээр түгээхийн яамны процесс нь ойлгомжгүй техник нөхцөл аваад тэг ингэ гээд байдаг. Техникийн нөхцөлийг нь авангуут аймаар удаадаг, бүтэн 1-2 сар болдог. Үүний дараа техникийн нөхцөл дээрээ маш олон шаардлага тавьдаг. Улсаасаа сэргээгдэх эрчим хүчийг дэмжинэ гэсэн мөртөө бодит байдал дээрээ хийх гэхээр болж өгдөггүй.	СЭХ-ийн илүүдэл эрчим хүч нийлүүлэх процесс тодорхой бус, хүндрэлтэй байна

2. ААН хэрэглэгчдийн ярилцлагаас хэрэглэгчдийн хариу үйлдэл, сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаарх шинжилгээ

№	Гол сэдэв Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Хэрэглэгчийн хариу үйлдэл	HE1	Хэмнэлтийн зан үйл	Хуучин эрчим хүч их зарцуулдаг муудсан цахилгааныг аль болох хэмнэх, тоног төхөөрөмжүүдээ шинэчлэх, хэмнэх боломжтой цагууд дээрээ асаалттай байгаа гэрлүүдээ унтраагаас сэргээгдэх эрчим хүч рүүгээ аль болох түлхүү шилжье ээ гэсэн зүйлүүдийг ярьж байгаа	ААН-үүд цахилгаан эрчим хүчний хэмнэлт хийх, хэрэглээгээ удирдах, тоног төхөөрөмжөө шинэчлэх, турших зэргээр хариу үйлдэл үзүүлж байна. Түүнчлэн нэгж бүтээгдэхүүний үнэ нэмэгдүүлэх нөхцөл үүссэн.
1.2	Хэрэглэгчийн хариу үйлдэл	HE2	Бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өөрчлөлт	Нэгж бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх шаардлага үүссэн	
1.3	Хэрэглэгчийн хариу үйлдэл	HE3	Сэргээгдэх эрчим хүч эрэлхийлэл	Сэргээгдэх эрчим хүч, батерей хуримтлуурын систем судлах, турших.	
2.1	Хэрэглэгчийн сонирхол	IE1	Тогтвортой, тасралтгүй хангамж	Цахилгаан эрчим хүч огт тасрахгүй байх, хязгаарлалтгүй байх нь хамгийн чухал байна.	ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа тогтмол явуулахад тогтвортой, тасралтгүй хангамж чухал бөгөөд үнэ тарифыг огцом нэмэхгүй, компаниуд төсөв, бодлогодоо тусгах боломжтой байхыг чухалчилж байна.
2.2	Хэрэглэгчийн сонирхол	IE2	Огцом өөрчлөлт хийхгүй байх	Үнийг огцом нэмэхгүй, харин жилийн төлөвлөгөөтэй, баг багаар нэмэгдүүлж, компаниуд төсөв, бодлогодоо тусгах боломжтой байх хэрэгтэй байна	Түүнчлэн ААН-үүдэд илүүдэл эрчим хүчийг хэрхэн нийлүүлэх процесс, дүрэм журам, хөнгөлөлт урамшуулал тодорхой байх нь чухал байна.
2.3	Хэрэглэгчийн сонирхол	IE3	Илүүдэл эрчим хүчний нийлүүлэлт	Бид сэргээгдэх эрчим хүчээр бид станц бариад хэрэглээгээ гаргаад илүүдлийг нь түгээхээр өгөх гээд байгаа. Тэгэхээр түгээхийн яамны процесс нь ойлгомжгүй техник нөхцөл аваад тэг ингэ гээд байдаг. Техникийн нөхцөлийг нь авангуут аймаар удаадаг, бүтэн 1-2 сар болдог. Үүний дараа техникийн нөхцөл дээрээ маш олон шаардлага тавьдаг. Улсаасаа сэргээгдэх эрчим хүчийг дэмжинэ гэсэн мөртлөө бодит байдал дээрээ хийх гэхээр болж өгдөггүй	
2.4	Хэрэглэгчийн сонирхол	IE4	Татвар/карбон кредитийн урамшуулал	Бид нар үйлдвэрлэсэн эрчим хүчний хэмжээгээрээ карбон кредит тооцуулах ёстой... Тэгэхээр үүнтэй холбоотой процесс маань тодорхой юу? улс руу нийлүүлэх дээр дүрэм журам энэ тэр нь тодорхой болсон уу гэдэг байна. Карбон кредит системийг тодорхой болгох, нийгмийн хариуцлагын төсөл (хүлэмжийн хий багасгах) дээр татварын хөнгөлөлт хэрэгтэй	
3.1	Хэрэглэгчийн эрх мэдэл	PE1	Хэрэглэгчдийн эрх эдлэх боломж	Үнэ тарифын талаар саналаа нэг их хуваалцдаггүй. Манайх бол саналаа энэ жилийн орж ирсэн судалгаагаар л илэрхийлж байсан	ААН-үүдийн санал бодлоо илэрхийлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал байна.
3.2	Хэрэглэгчийн эрх мэдэл	PE2	Мэдээллийн хүртээмж	СЭХ-ний төслүүд, татварын хөнгөлөлт, улсын сүлжээнд нийлүүлэх дүрэм журам тодорхойгүй байгаа нь мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах эрх мэдлийг нь хязгаарлаж байна.	
4.1	Хэрэглэгчийн нөлөөлөл	INE1	Нөлөөлөх боломж	Үнэ тариф тогтооход Улсын Их Хурал, Засгийн газар гол нөлөөлөл үзүүлдэг тул шийдвэр гаргах түвшинд очоод гацдаг буюу ААН-үүд шууд нөлөөлөх боломжгүй	ААН-үүдийн бодлогын нөлөөлөл сул ч технологийн дам нөлөөлөл өндөр байна.

Хавсралт 7. Эрчим хүчний судалгааны компани, төрийн бус байгууллага, судлаачдын ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ

1. Судлаач, мэргэжилтэн, төрийн бус байгууллагын ЦЭХ-ний үнийн өсөлтийн шалтгаан, нөлөөллийн талаарх ярилцлагын шинжилгээ

№	Гол сэдэв Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Цахилгааны үнийн өсөлтийн шалтгаан	FS1	Бодит өртөгт дөхүүлэх	Эрчим хүчний салбар одоо алдагдалтай ажиллаад байгаа. Тэгэхээр ... үйлдвэрлэл маань алдагдлынхаа хэмжээгээр засвар шинэчлэлтээ хийж чаддаггүй, хөрөнгө оруулалтаа хийж чаддаггүй, ингээд доройтоод явж байгаа юм.... Ийм ч учраас бодит өртөгт нь хүргэсэн.	Үнийг нэмэх нь алдагдалтай ажиллаж буй салбарын амьсгалах (засвар, шинэчлэлт хийх) зай олгох, бодит өртөгт нь хүргэх эдийн засгийн шаардлага байсан
1.2	Цахилгааны үнийн өсөлтийн шалтгаан	FS2	Үнэ тарифыг буруу тогтоодог	Өнөөдөр 1 киловатт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд 160-180 төгрөгөөр, 300 МВт-ын чадалтай цахилгаан станц гарч ирэх гэж байна. Үнийг зарахдаа 8-9 центээр зарах, бараг одоо 2 дахин нугалж зарах гэж байна. Гэтэл өнөөдөр сайд ярьснаар, IV цахилгаан станцаас 115 төгрөгөөр эрчим хүчний сүлжээнд нийлүүлж байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ нь эрчим хүчний салбарын бодлого, үнэ тариф тогтоохдоо “буруу л” тогтоогдож байгаагийн жишээ юм.	Өнөөгийн үнэ тариф тогтоолт өртөг, чанар, үр ашигтай нийцэхгүй байна



1.3	Цахилгааны үнийн өсөлтийн шалтгаан	FS3	Улс төрийн нөлөөлөл	Үнийн шийдвэр хуулиараа ЭХЗХ-нд байх ёстой ч, улс төрөөс хэт их хамааралтай (ЗГ, УИХ-аар орсон) байдал нь өнөөгийн тогтворгүй байдлыг үүсгэсэн. Ерөнхийдөө энэ салбарыг улс төржилт л алсан юм шүү дээ. Өнөөдөр бид нар захирлуудыг сонгон шалгаруулалт хийхэд дандаа улс төрийн нөлөөний л хүмүүс ирдэг. Ажилдаа тэнцэхгүй гээд халагдсан хүн дарга болоод ирж байхад юу нэхэх гээд байгаа юм бэ. Үнэ нэмэлтийг тэр зардлын замбараагүй, үр ашиг нь үрэлгэн, менежмент дутуу байгаа	Үнэ тарифын шийдвэрт улс төрийн нөлөөлөл их, ЭХЗХ-ны хараат бус байдал сул байдал нь үнийн бодлогын тогтвортгүй байдлын гол шалтгаан.
2.1	Цахилгааны үнийн өсөлтийн эерэг нөлөөлөл	AS1	Ухаалаг хэмнэлттэй хэрэглээ	Ноднин жил, үнэ тарифыг өртөгт нь дөхүүлснээр, 6% өсдөг байсан оргил ачаалал ноднин жил 1,2% өссөн байх... Тэгэхээр энэ үнэ тариф одоо ингээд бодит өртөгтөө дөхсөнөөр хүмүүсийн хэрэглээг ухаалаг болгоход бас нөлөөлж байгаа юм.	Үнэ тарифын өсөлт нь хэрэглэгчийн хэрэглээнд зөв өөрчлөлт оруулж хэрэглээг оновчтой болгох шууд эерэг нөлөө үзүүлсэн.
2.2	Цахилгааны үнийн өсөлтийн эерэг нөлөөлөл	AS2	Салбарын “амьсгаа авах” боломж	Бид нар нэг удаа өртөгтөө хүргэнэ гэдэг чинь тэр жилдээ л бид нар жаахан амьсгаа аваад одоо нэг засвараа жаахан ахиу хийж чадахаар болчихож байна	Үнэ тарифын өсөлт нь бодит өртөгт ойртуулж салбарын засвар хийх бүтээмжийг нэмэгдүүлэх богино хугацааны боломжийг олгосон.
2.3	Цахилгааны үнийн өсөлтийн эерэг нөлөөлөл	AS3	Үйлдвэрлэгчийг дэмжих	Үйлдвэрлэгчдийн цалин, технологийн сайжруулалтад чухал	Үнэ тарифын өсөлт нь үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах хүчний нөхцөл сайжрах суурь нөхцөл болно
3.1	Цахилгааны үнийн өсөлтийн сөрөг нөлөөлөл	ANS1	Хэрэглэгчдийн буруу хүлээлт	Нэг сул тал нь юу вэ гэхээр, саяын тэр 40%-ийн өндөр нэмэлтийг 5-6 жил хүлээчихсэн байж байгаад хийгдсэн нэмэлт учраас ахиад үүнээс цааш нэмэлт хийхгүй юм байна гэдэг ойлголт, ахиад 2-3 жилдээ л нэмэхгүй юм байна гэдэг хүлээлтэд хэрэглэгч нарыг оруулчхаж байгаа	Огцом өсөлт нь хэрэглэгчийн хүлээлтийг гажуудуулж, дараагийн шаардлагатай өсөлтийн орон зайг хаадаг.

3.2	Цахилгааны үнийн өсөлтийн сөрөг нөлөөлөл	ANS 2	Улс төрийн буруу хандлага	Нөхцөл байдал нь улс төрөөс өндөр хамгааралтай гэдгээс хамаараад яах вэ гэхээр 2027 онд сонгуулийн ажил эхэлнэ, ахиад хэрэглэгч нарт дарамт учруулахгүй, улс төр өөрөө муу дүр байхгүйн тулд дахиад үнэ тарифыг барих хандлага руу орно.	Улс төрийн сонгуулийн мөчлөгтэй уялдан үнийн зохицуулалт бодлогын бус, популист шинжтэй болно.
3.3	Цахилгааны үнийн өсөлтийн сөрөг нөлөөлөл	ANS3	Үндэслэлгүй үнийн хөөрөгдөл	Цахилгааны үнэ нэмэгдэхэд нийгмийн суурь сэтгэл зүйг ашиглан (Жиш: өнөөдөр бензин нэмэгдсэн, одоо бусад бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ нэмэгдэнэ) бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдүүлдэг.	Үнэ өсөхөд эдийн засгийн бус шалтгаанаар өргөн хэрэглээний үнийн өсөлт, хөөрөгдөл бий болдог
3.4	Цахилгааны үнийн өсөлтийн сөрөг нөлөөлөл	ANS4	Орлогын хуваарилалт дахь гажуудал	Үнэ тариф нэмэх нь зайлшгүй байсан гэдгийг хүлээн зөвшөөрч байна, гэвч үр өгөөжийн хуваарилалт буруу... Үнэ нэмснээс олсон орлого ТӨК-уудад бага очиж, өндөр үнэтэй (9-10 цент) гадаадын хөрөнгө оруулалттай нар, салхины станцууд болон Бөөрөлжүүгийн станц руу илүү хуваарилагдаж байна.	Нэмэгдсэн орлого улсын ТӨК-уудад хүрэлцдэггүй; өндөр өртөгтэй хувийн станцууд болон гадаад гэрээнд заагдсан хэсэг рүү очдог гэж үзэж байна
4.1	Хэрэглэгчдийн ялгаатай хэрэглээний нөлөөлөл	JS1	Үнийн өсөлт хамгийн их мэдрэгдэж буй бүлэг	3,500-5,000 кВт/ц хэрэглээтэй, цахилгаан халаагуураар халаалтаа шийдсэн, дундаж орлоготой айл өрхүүд (сардаа 1.5-3 сая төгрөг төлж байсан нь 4-5 сая гарах эрсдэл).	Үнийн өсөлтөд хамгийн ихээр өртөж байгаа нь цахилгаан халаагуураар халаалтаа шийдсэн 3,500-5,000 кВт/ц хэрэглээтэй айл өрхүүд байна. Харин ААНБ-ууд, бага хэрэглээтэй болон өндөр
4.2	Хэрэглэгчдийн ялгаатай хэрэглээний нөлөөлөл	JS2	Үнийн өсөлт хамгийн бага мэдрэгдэж буй бүлэг	Ахуйн бага хэрэглээтэй (150 кВт хүртэлх), өндөр орлоготой (5,500-20,000 кВт хүртэлх, Зайсангийн хаус, байнга халаадаг хоосон байшин), ААНБ-ууд (цахилгааны үнэ нийт зардлынх нь 2-3% байдаг тул тоодоггүй).	орлоготой хэрэглэгчид (Зайсангийн хаус, 5,500-20,000 кВт/ц) мэдрэмж багатай байна. Оргил ачааллыг бодитоор үүсгэдэг уул уурхайн салбарыг үнийн бодлогод анхаарах шаардлагатай.
4.3	Хэрэглэгчдийн ялгаатай хэрэглээний нөлөөлөл	JS3	Уул уурхайг онцгой анхаарах	Оргил ачааллын 60-70%-ийг үүсгэдэг. Хуурмаг чадлын хэрэглээ (Cosq) дээр бага мөнгө авдаг тул үнэ тарифыг онцгойлон нэмэх шаардлагатай	

2. Судлаач, мэргэжилтэн, төрийн бус байгууллагын эрх мэдэл, сонирхол, нөлөөллийн талаарх шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Эрх мэдэл	PS1	Хуулийн эрх мэдэл, хараат бус байдал	Яг хуулийнхаа хүрээндээ үйл ажиллагааг явуулж чадахгүй улс төрөөс хэт их хамааралтай байдаг гэдгийг 11 сард харуулчхаж байгаа. ... үнэ тарифын нэмэлтийг ... зохицуулагч улс төрийн дэмжлэг их авч байж хийлээ. Уг нь Эрчим хүчний тухай хууль дээр бүрэн эрх нь Зохицуулах хороонд байдаг. Улс төрийн эрх мэдэл гар дүрэхгүй юм алга... мэргэжлийн салбар руу гар дүрж тоглоод удахгүй элгээрээ мөлхлөө.	Албан ёсны эрх мэдэл Зохицуулах хороонд байдаг ч бодит байдал дээр хараат бус байдал бүрдээгүй. Хуулийн зохицуулалт нь институцийн эрх мэдэл олгосон боловч улс төрийн оролцоо, улс төрчдийн дэмжлэггүйгээр тарифын шийдвэр хэрэгжих боломжгүй байна.
1.2	Эрх мэдэл	PS2	Улс төрийн эрх мэдэл	...Үнэ тарифт нь хүрээд эрчим хүчний салбарын алдагдал нь 0 болоод болж байсан. ...Тэгэхдээ одоо ерөнхий сайд дээр гүйж ороод үнэ тариф дээр улс төрийн шийдвэрийг гаргуулж чадах уу, үгүй юу? Ийм л түвшинд явж байна. Хамгийн их нөлөөлж байгаа юм бол ЗГ, сайд, ерөнхий сайд юм....	
2.1	Нөлөөлөл	INS1	Улс төрийн нөлөөлөл их	...хамгийн гол нь бид нар бодлогоо зөв тодорхойлох ёстой. Энэ бодлогод улс төрийн оролцоо оролцохгүй байх ёстой. Гэтэл одоо сонгуулийн цикл бодлого нь өөрчлөгддөг нэг ерөнхий сайд гарч ирэхэд бодлого нь өөрчлөгддөг Монголын улс төр яаж явдаг вэ гэхээр бидний (салбарын мэргэжилтнүүдийн) зургийг нь харуулаад хэлэлцүүлсэн гээд шийдвэр гаргаж байгаа.	Үнийн шийдвэрт нөлөөлөгч гол тал нь ЗГ, сайд, ерөнхий сайд байна.
2.2	Нөлөөлөл	INS2	Судлаач мэргэжилтнүүдийн нөлөөлөл сул	... мэргэжлийн сайдтай ч байж үзлээ, ахиц гараагүй, мэргэжлийн гишүүдтэй ч байж үзлээ, попроод алга болчих юм. Бид нарыг мангар тэнэг байсныг гайхаад байх юм. ... гишүүн дээр бол би аллерги хөдлөөд байгаа юм. Хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулаагүй байж хэлэлцүүлсэн гэж худлаа ярьж байна	Судлаачдын мэргэжлийн саналыг бодитой тусгадаггүй, эрх мэдлийн төвлөрөл нь тарифын үнэлгээг шинжлэх ухаанч бус, улс төрийн эрсдэлд автдаг болгож байна.

3.1	Сонирхол	IS1	Шинжлэх ухаанч удирдлагын сонирхол	Энэ салбарыг шинжлэх ухаанчаар удирдмаар байгаа юм. Бодит нөхцөл байдалд бүрэн үнэлгээ дүгнэлт өгөөд техникээ санхүү эдийн засгийн, боловсон хүчний, эрх зүй талаас нь бүгдийг нь шинжлээд шинжлэх ухаанчаар удирдмаар байгаа юм.	Салбарт шинжлэх ухаанчаар удирдах, судлаач мэргэжлийн талуудыг оролцуулах чухлыг онцолж байна
3.2	Сонирхол	IS2	Хараат бус байдлын сонирхол	ЭХЗХ хүчин төгөлдөр хуулиар бол үнэ тарифыг өөрсдөө тогтоох ёстой, улс төрийн нөлөөллөөс ангид байх ёстой. ... бие даасан хараат байдлыг, УИХ-ын гишүүд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээдэг байдлыг бий болгомоор байна.	Эрх мэдлийн төвлөрлийг задалж, институцийн бие даасан ажиллагааг хангах нь салбарын ирээдүйн тогтвортой байдалд чухал гэж үзэж байна.
3.3	Сонирхол	IS3	Хууль эрх зүйн хэрэгжүүлэлтийн сонирхол	Энэ салбарыг үр ашигтай ажиллуулна гээд бүгд л баримт бичиг байгаа. ... Гэргасан хууль дүрмээ мөрдөх ёстой. Бүх оролцогч талууд нь ороод 10-15 жил амьтай л хууль гаргах дээр төвлөрөөд ажиллачихвал магадгүй энэ яригдаад байгаа зүйл олон асуудлын ядаж зарим хэсгийг нь одоо шийдэх болов уу	Хуулийн бодит хэрэгжилт чухал байна

3. Судлаач, мэргэжилтэн, ТББ-ын төлөөллийн үнэ тариф тогтоох зарчим, зөвлөмжийн талаарх шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Үнэ тогтоох зарчмын асуудал	ZS1	Зарчим тодорхойгүй	Үнэ тогтоох зарчим тодорхойгүй, зардал дээр (сүүлийн 3 жилийн гүйцэтгэл) суурилж байна. Энэ нь үр дүнтэй, өгөөжтэй зардал мөн эсэх нь тодорхойгүй. Өртөг дээр суурилсан зарчим гэдэг үг хуульд байхгүй.	Тарифын аргачлал эдийн засгийн өртөг-үр ашгийн зарчимд биш, гүйцэтгэлийн зардалд суурилж байгаа нь үр ашиггүй зардлыг системд шингээж, буруу өртөг тооцох урамшуулал бий болгодог.
1.2	Үнэ тогтоох зарчмын асуудал	ZS2	Улс төрийн лоббигийн хэт нөлөөлөл	ЭХЗХ хараат бусаар тогтоох ёстой ч улс төрийн лоббид (Сонгуулийн цикл, ЗГ-ын мөрийн хөтөлбөр) бүрэн хамааралтай. Шийдвэр гаргах үйл явц нь ил тод бус/хаалттай.	Тарифын бодлого улс төрийн мөчлөгөөс хамаарч гардаг нь зохицуулагчийн бие даасан байдлыг алдагдуулж, бодит өртгийн дагуу тариф тогтоох боломжийг хаадаг.
1.3	Үнэ тогтоох зарчмын асуудал	ZS3	Үр өгөөжийн гажуудсан хуваарилалт	Үнэ нэмсний өгөөж суурь үйл ажиллагаа хийж буй ТӨК-уудад (ДЦС) хүртээлгүй байгаа. Харин гадаадын хөрөнгө оруулалттай, эзэл тусламжаар баригдсан (Салхит, Бөөрөлжүүт) болон сэргээгдэх эрчим хүчний өндөр үнэтэй (9-10 цент) үйлдвэрүүдэд ашигтай байна.	Тарифын өсөлтөөс үүссэн орлого үндсэн ТӨК рүү бус өндөр тарифтай сэргээгдэх эрчим хүч ба гэрээтэй станцууд руу чиглэж байгаа нь орлогын шударга бус хуваарилалтын илрэл
1.4	Үнэ тогтоох зарчмын асуудал	ZS4	Эдийн засгийн бус зарчим	Баригдах гэж буй станц 180т, 9-10 цент-ээр байхад, 4-р ДЦС 115т-өөр худалдаж авч буй нь үнэ тогтоох зарчмын алдааг илэрхийлж байна.	Тариф өртөг-үр ашгийн логиктой нийцэхгүй тогтоогдсон нь хөрөнгө оруулалтын дохиог гажуудуулж, салбарын өртгийн бүтцийг тэнцвэргүй болгодог.

2.1	Шинэчлэлт өөрчлөлт чухал	WS1	Инфляцаа дагаад индексжүүлэх ёстой	Үнэ тарифаа үе шаттайгаар инфляцаа дагаад өсөх ёстой.... инфляцаа дагаад индексжээд л явах ёстой, хэлбэлздэг байх ёстой... хэт хүний хамааралтай байгаа нь өөрөө үнийг тогтоох зарчим дээрээ нөлөөтэй.... автоматжуулалт хийвэл автомат систем нь худалдааны загвартайгаа холбогдон үнийг тогтоож байдаг юм ярих юм бол боломжтой гэж бодож байна.	Инфляцтай уялдсан индексжүүлэлт шаардлагатай Тарифын шийдвэрт хүний оролцоо өндөр байгаа нь улс төрийн нөлөөлөлд өртөмтгий. Автоматжуулсан тарифын загвар хэрэгтэй.
2.2	Шинэчлэлт өөрчлөлт чухал	WS2	Тааз үнэ тогтоох	Шинэ үнэ үсвэрүүдтэй холбоотойгоор хэрэглэгчийн дундаж тарифыг буулгах/өсгөх судалгаа хийж, тааз үнийн ойлголтыг тогтоох нь зүйтэй	Тааз үнэ тогтоох нь өндөр өртөгтэй шинэ төслүүдээс хэрэглэгчийг хамгаалах гол зохицуулалт.
3.1	Оролцоо ба нөлөөлөл	YS1	Шинжээчдийн оролцоо	Хангалттай оролцож чаддаггүй. Бид нарыг зүгээр л тоглоом болгож ашигладаг. Цахилгаан, дулааны эрчим хүчний үнийг суурилаад ингээд бүгдийг fixed болгоод бодчихсон байгаа. Тэгэхээр нэгэнт тогчихсон юм чинь тэнд оролцох ямар ч боломж байхгүй. Магадгүй эрх зүй талаасаа ч байхгүй, зохицуулалт талаасаа ч байхгүй, хэрэгжилт талаасаа ч байхгүй. Энд оролцох ёстой юу гэвэл ёстой.	Шинжээчдийн оролцоо хангалтгүй, хязгаарлагдмал
3.2	Оролцоо ба нөлөөлөл	YS2	Үүрэг хүлээсэн байгууллагын нөлөөлөл	Үнэ тариф нэмэхэд хүн болгон оролцох бол шаардлагагүй л дээ. Үүрэг хүлээсэн байгууллага нь, эрх бүхий байгууллага нь л юмаа хийгээд явчих хэрэгтэй. Гэхдээ өнөөдөр энэ байгууллага хараат бус ажиллаж чадаж байна уу гэдэг чинь өөрөө асуудал	Зохицуулагч байгууллага бие даасан бус, улс төрийн нөлөөнд автсан нь үнэ тарифыг бодитой тогтооход саармагжуулдаг.
3.3	Оролцоо ба нөлөөлөл	YS3	Гол нөлөөлөгч субъект	Үнэ тарифын шийдвэрт ЗГ/Сайд/Ерөнхий сайд хамгийн их нөлөөтэй. ЭХЗХ-ны дарга Ерөнхий сайдаар зөвшөөрүүлж чадах эсэхээс бүхэлдээ хамаардаг	Засгийн түвшний нөлөөлөл хэт өндөр, үнэ тарифын бодлого улс төржилтөд өртдөг.



4.1	Шийдвэрлэх арга зам, зөвлөмж	QS1	Шинжлэх ухаанч удирдлага	Салбарыг шинжлэх ухаанчаар (техник, санхүү, боловсон хүчин, эрх зүй) удирдах шаардлагатай. Онолын судалгаа, диссертаци хийгдээгүй, онолгүйгээр явж байна. Шийдлүүдийг мэргэжлийн хүмүүс хийх ёстой, улс төрчид биш. Салбарын 8 чиглэлээр мэргэшсэн хүмүүсийн хэлэлцүүлэг ба нэгдсэн дуу хоолой хэрэгтэй.	Салбарыг улс төрөөс холдуулан, шинжлэх ухаанч арга барилаар (техник, эдийн засаг, эрх зүй) удирдах явдал юм. Монголын нөхцөлд тохирсон онолын судалгаа болон шинэчлэлийн загварууд дутагдалтай байгаа бөгөөд гадны шийдлүүдийг сохроор дуурайхгүй, мэргэжлийн хүмүүсийн хамтын ажиллагаагаар Монгол хөрсөнд тохируулан буулгах нь чухал. Түүнчлэн салбарын хөгжилд улс төрийн оролцоог бууруулж хууль эрх зүйн орчныг тогтвортой болгох юм. Тухайлбал ЭХЗХ-г хуулийн дагуу хараат бус болгох, бүх талын оролцоог хангасан 10-15 жил амьтай нэгдмэл Эрчим хүчний хуулийг батлах, ТӨК-н засаглалыг сайжруулж, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох.
4.3	Шийдвэрлэх арга зам, зөвлөмж	QS2	Индексжүүлэх хэрэгтэй	Үнийг инфляцын түвшнээр (жилд 7-12%) тогтмол индексжүүлэх нь огцом нэмэгдэхээс сэргийлж, хүнээс хамааралгүй болгох ганцхан зоригтой алхам болно. Энэ индекс чөлөөлөх асуудал бол хуульдаа байж байгаа. Тэгээд энэ хуулиа ашиглаач ээ гэдэг асуудлыг байнга ЭХЗХ-ны даргаас өгсүүлээд л хуулиа ашиглах асуудлыг байнга ярьсан.	Мөн үнэ тарифын бодлогод үнийг индексжүүлэх, Цахилгааны үнийг тогтмол болон хувьсах гэж салгах. Тогтмол хэсгийг нь Засгийн газарт үлдээж, хувьсах хэсгийг нь салбар өөрөө зохицуулдаг амьд үнэ тогтоох механизм нэвтрүүлэх зэрэг чухал байна.
4.4	Шийдвэрлэх арга зам, зөвлөмж	QS3	Техникийн шийдэл	Тоолуур болон Сеттлерийн системийг бүгдийг нь цэгцлэх. СЭХ-ийн оролтыг зохицуулах зохицуулах эх үүсвэрүүд (шинээр) хэрэгтэй.	
4.5	Шийдвэрлэх арга зам, зөвлөмж	QS4	Үнийг салгах аргачлал	Үнэ тариф тарифыг 2 салгаад нэгийг нь тогтмол гээд ЗГ-т өгчих, хувьсахыг нь салбар нь өөрөө авч үлдээд зөв зохицуулалт хийсэн учраас үнэ өслөө, буурлаа гээд амьд үнэ тогтоож өгөх ёстой	
4.6	Шийдвэрлэх арга зам, зөвлөмж	QS5	Хууль эрх зүйн орчны тогтвортой байдал	Одоо мөрдөж байгаа хуулийг хэрэгжүүлэх ба ЭХЗХ-г хараат бус болгох. Эрчим хүчний тухай хуулийг бүх талын оролцоотой нэг хууль шиг (амьтай хууль) болгож, 10-15 жил амьтай байлгах.	
4.7	Шийдвэрлэх арга зам, зөвлөмж	QS6	Хариуцлагын тогтолцоо	ТУЗ алдагдалтай компания шүүхэд өгөхгүй байгаа, ТӨК-ийн засварын төлөвлөгөөг Сайд баталж байгаа нь засаглалгүй байгааг илтгэнэ. Хариуцлага тооцох тогтолцоо байхгүй байна	

Хавсралт 8. Эрчим хүчний судалгааны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн цэх-ний үнийн өсөлтийн шалтгаан, нөлөөллийн талаарх ярилцлагын шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Үнийн өсөлтийн шалтгаан	UK1	Үнийн өсөлт нь зайлшгүй шаардлагатай	Угаасаа нэн шаардлагатай, тулчихсан байгаа... 2019 оноос хойш ерөөсөө дорвитой нэмээгүй, 2019 онд нэг нэмэхдээ жоохон буюу хэдхэн төгрөг нэмсэн, тэр нь зардлаа ч нөхөж чадахгүй хэмжээнд байгаад, ашиггүй ажиллаад байгаа. Тариф нэмэх нь угаасаа яалт ч үгүй зөв л сонголт л доо... 2019 оноос хойш юмны үнэ бараг 40-50% нэмэгдчихээд байхад нөгөө их засварт зарцуулж байгаа өртөг нэмэгдэхгүй байна. ... тариф нэмж байж бид нар урсгал засвар, их засвараа бүрэн гүйцэт хийнэ..... Тоног төхөөрөмжийнхөө урсгал засварыг хийж чадахгүй байна... техник технологийг нэвтрүүлж чадахгүй байна.	Үнийн өсөлт зайлшгүй хийгдэх ёстой алхам, өртөг өссөн ч тариф удаан хугацаанд нэмэгдээгүй нь станцуудын засвар, урсгал зардлыг санхүүжүүлэх боломжийг хааж, системийн найдвартай ажиллагаанд эрсдэл дагуулж байна.
1.2	Үнэ тарифын тогтолцоо ба зохицуулалт	UK2	Үнэ тогтоох зарчмын асуудал	Аргачлалынхаа дагуу тарифаа гаргачхаж байгаа юм, харин зохицуулалт хийхдээ наадах чинь дотор нь энийг нь, эндээс нь, энийг нь, тэндээс нь, энийг нь хасна, энийг нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тийм зардлуудыг нь хасна гэдэг. Ингэсээр байгаад нөгөө нэг бодит өртгөөс багасгаж орж ирж, нөлөөгөө тогтоогоод, тэгээд зах зээл дээрх үнэ гаргачихдаг. Бусад орнуудыг харьцуулаад үзэхэд төвийн нэгдсэн сүлжээ, дулааны сүлжээ бол хот орон нутгуудад маш ихээр төвлөрсөн байдаг учраас дулаан хангамж бол нэлээн эрсдэлтэй байдаг. Ийм эрсдэлтэй байдаг учраас энэ дулааны үнийг бол хамгийн багаар тогтоож өгчхөөд, өөрийн өртгөөс нь бүүр арав-хорин хэд дахин бага тогтоож өгчхөөд цахилгааны өртөгт нь тодорхой хэмжээгээр шингээгээд өгчхөж байгаа юм. ... Энэ бол оновчгүй л байгаа юм.	Үнэ тогтооход бодит хэт өртгөөс доогуур тогтоож буй нь оновчгүй.



1.3	Үнэ тарифын тогтолцоо ба зохицуулалт	UK3	Тарифын ангилал хангалтгүй	Одоо хэрэглэж байгаа тарифын ангилал нь иргэн, ААН гээд хоёрхон тариф мөрдөөд байгаа. Тэгэхээр... тарифаа нэлээн нарийвчилж гаргаж өгөх ёстой юм болов уу.... Нийтийн байрыг ААН-ээр тооцдог... тэнд амьдарч байгаа хүмүүсээс бас гомдол ирнэ	Одоогийн тарифын ангилал (иргэн/ААН) хэт ерөнхий тул нийтийн байр зэрэг онцлогт тохирсон нарийвчилсан тариф шаардлагатай
1.4	Үнэ тарифын тогтолцоо ба зохицуулалт	UK4	Хувийн болон төрийн компаниудын ялгаа	Нарны эрчим хүч, салхины эрчим хүч ороод ирчихлээ. Тэд нар хатуу гэрээтэй, үнээ өндөр тогтоолгогчихсон учраас тэд нарт бол алдагдалтай биш... Төрийн өмчит компаниуд... хамгийн муу нөхцөл байдал төрийн өмчит компаниуд дээр бий.	Хувийн сэргээгдэх эх үүсвэрүүд өндөр үнэ, баталгаатай гэрээгээр ажилладаг тул алдагдлыг төрийн компаниуд үүрч байна
2.1	Улс төрийн хэт их нөлөөлөл	IK1	Үнийн шийдвэр дэх улс төрийн шууд оролцоо	...бага зэргийн нэмэлт дээр хүмүүс шуураад эхлэнгүүт 3Г-аас цахилгааны үнэ тариф нэмэх асуудлыг зогсоочихдог. улс төрөөс бол маш их хамааралтай. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд үг хэлээд, одоо энийг зогсоо гэх юм бол шууд зогсчихдог. Эрчим хүчний салбарын удирдлагуудыг мөн улс төрийн хамааралтай хүмүүс, ялсан намын хүмүүс удирддаг, өөрөөр хэлбэл мэргэжлийн бус хүмүүс ирдэг. Энэ хүмүүс маань ирээд тухайн улс төрийн намдаа үйлчилдэг, мэргэжлийн инженер, техникийн ажилчид бид нар ингэж хэчнээн хэлээд үг авдаггүй, болохгүй байна, хас гэдэг. ...данхар бүтэцтэй, төрийн өмчийн компаниуд илүү орон тоо ажиллуулж байна гэдэг. Илүү орон тоотой ажиллуулж байгаа шалтгаан гэвэл улс төрийн томилгоогоор л ирж байгаа хүмүүс байгаа шүү дээ. Энэ хүнийг ийм дарга болго, энэ хүнийг менежер болго гэсэн ийм л шахаанууд ирдэг. Ингээд орон тоог нь нэмээд байдаг, хамгийн сүүлийн жишээ гэхэд саяхан энэ өмнөх 3Г менежерүүд томиллоо шүү дээ... Одоо ТӨК-хэрэгцээгүй менежерүүд томилж байна шүү дээ... Одоо ТӨК-уд дээр өгсөн 2, 3, 4-өөр нь өгсөн энэ менежерүүдээ хурдан татаж авах хэрэгтэй. Тэгэхэд чинь орон тооноос бараг л 100 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргачих юм байна гээд байгаа.	Үнийн шийдвэрт улс төрийн, тэр дундаа ЕС-ын нөлөөлөл их байна. Түүнчлэн үр ашиггүй, мэргэжлийн бус томилгоо хийдэг нь салбарын асуудалд бодитоор нөлөөлж байна.
2.2	Улс төрийн хэт их нөлөөлөл	IK2	Улс төрийн нөлөөллийн сөрөг үр дагавар		

3.1	Эрчим хүчний хууль, эрх зүйн орчин	OK1	Хууль тогтоомжийн асуудал	2000-аад онд эрчим хүчний тухай хуулийг анх батлаад л компанийн систем рүү оруулж байхад энэ Монголын эрчим хүчний амьдрал бол яг социализмынхаа үеийн загвараар л орсон. Тэгээд байсан байснаараа салгаад л зүгээр нөгөөдүүлийг нь компани гэж нэртэй хийгээд л ингэж нөгөө одоо гэр барьж тоглох нь гэдэг шиг л орчихсон.	Эрчим хүчний хууль, эрх зүйн орчин нь суурь бүтцийн хувьд шинэчлэл шаардлагатай, технологийн шинэчлэлд дасан зохицоогүй байдалтай байна. Хууль эрх зүйн шинэчлэл нь эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, сэргээгдэх эрчим хүчний нэвтрэлт, хувийн хэвшлийн оролцоо болон салбарын санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх үндсэн нөхцөл болж байна.
3.2	Эрчим хүчний хууль, эрх зүйн орчин	OK2	Хууль тогтоомжийг шинэчлэх шаардлага	Би эрчим хүчний үйлдвэрлэгч гэж бодъё. 20 квт-ын 30 квт-ын нарны панель тавьчихсан айл гэхэд эрчим хүчний түгээхэд өгөөд би бас мөнгө авдаг байж болно шүү дээ... Гэтэл одоо энэ тогтолцоо болохоор юунд байхгүй байгаа юм. Хууль эрх зүйн тогтолцоо нь байхгүй байгаа юм, нэг дэх асуудал. 2 дахь асуудал болохоор эрчим хүчний хууль гээд 2001 онд батлагдсан. Ер нь бол бид нар бас хуультай байсан. ... Энэ хуулийг бол мөн нэн яаралтай шинэчлэх хэрэгтэй байгаа юм.	
3.3	Эрчим хүчний хууль, эрх зүйн орчин	OK3	Шилжилтийн шийдэл	Тархмал эх үүсвэрийг дэмжих ... Манайд хамгийн их баялаг бол одоо нар ч байна, салхи ч байна, нүүрс байна гэж байгаа юм. Алийг нь ч ашиглаад өөрөөр хэлэх юм бол ийм жижиг хэмжээний эх үүсвэр барихыг аль ч иргэн, ААН байж болно гээд... хууль эрх зүйн хувьд нь тогтолцоог нь бүрдүүлээд өгчихвөл цаашаага бол энэ эрчим хүчний асуудлууд зөв шийдэгдээд явах ийм боломжууд байж байгаа юм.	
4.1	Хэрэглэгчийн мэдлэг	KK1	Хэрэглэгчийн мэдлэг, хэрэглээний дадал	Биржийн систем гэдэг ийм системд шилжихивэл болно. Хувийнхан ч бай, хувьсгалынхан ч бай аль болох л эрчим хүчээ түгээе л гэсэн зарчимтай.	Хэрэглэгчдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх нь чухал
				Хэрэглэгчийн сэтгэл зүй бас бэлтгэгдээгүй, энэ бол нэн чухал шүү гэдгийг манай хэрэглэгч нар ангилж сураагүй байгаа учраас үнэ тариф нэмэхийг эсэргүүцээд байдаг.	
				1квт цаг хэд хэчнээн төгрөгөөр босож байна хэдэн төгрөгөөр худалдаж авч байна ч гэдэг юм уу тийм юм ерөөсөө нөгөө хэрэглэгчдэд мэдээлэл дутуу... бага багаар ухамсарт нь суулгаж, хэмнэлтийн хэрэглээнд сургах дадал олгох боловсролын нэг цагийн хичээл ордог ч юм уу тийм байдлаар сургахгүй бол эцэг эхчүүд өөрөө сургааа больчихоод байгаа байхгүй юу. Дээр үед бол тэгж сургадаг байсан.	



5.1	Оролцоо	PK1	Оролцоо	Жил болгон зардлын санал л өгч байгаа. Тэгээд бодохоор тэндээс ашиг алдагдлаа тооцоод, ер нь энэ жил тэдэн хувийн алдагдалтай ажиллах нь байна. Гэхдээ энэ ийм учраас ийм нөхцөл байдалд хүрээд байна энэ тэр гэдэг байдлаа зүгээр далд утгаараа эрчим хүчний тухай хуульд байгаа үүргээрээ явчхаж байгаа юм.	Үнийн шийдвэр дэх оролцоо нь далд утгаар буюу зардлын тооцоо саналаар илэрхийлдэг байна.
7.1	Салбарын удирдлага ба хөгжил	GK1	Улс төрийн хамаарлыг багасгах арга	 улс төрийн оролцоог хамгийн багасгах боломж яаж харагдаж байна вэ гэвэл олон нийтийн компани болгох нь хамгийн их боломжтой... Олон нийтийн компани болох юм бол энэ улс төрөөс багасна, улс төрийн хамаарал багасна аа гэдэг чинь асуудлаа зөв тавьж, ийм байна аа энэ одоо гарцаагүй гээд , тэр зохицуулах хороо бол тэр гаргаж ирсэн баримт бичгийг нь шалгаж үзээд үнэхээр буруу тооцоод худлаа ашиг хийх гээд ингэсэн байх юм бол тэрийг нь гаргаад ирнэ.	Улс төрийн нөлөөг системийн хувьд багасгахын тулд олон нийтийн компани, хариуцлагатай бие даасан зохицуулагч нарыг замаар шийдвэр гаргалтыг эдийн засгийн бодит байдалд ойртуулах явдал гэж үзэж байна
7.1	Салбарын удирдлага ба хөгжил	GK2	Салбарын чадамжийг дээшлүүлэх	Зохицуулагчдыг улс төрөөс хамааралгүйгээр сонгодог болох.... Тэгээд тэд нар бол гаргасан шийдвэрт өөрсдөө хариуцлагаа хүлээж чаддаг байх ёстой. Бид хэрэглэгчийг ийм түвшинд, үйлдвэрлэгчийг ийм түвшинд, дамжуулахыг ийм түвшинд үнийн зохицуулалтаа ингэж хийж чадсан, энэнийхээ хариуцлагыг би өөрөө хүлээнэ	Бие даасан институцийн чадавх сул байгааг оролцогчид олонтоо онцолсон.

2.Оролцогч талуудын сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаарх шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Эрх мэдэл	PK1	Улс төрийн үнэмлэхүй эрх мэдэл	Улс төрчид шдээ... Ерөнхий сайд үнэ нэмж болохгүй гэсэн гээд нэмдэггүй	Салбарын үнэ тарифын шийдвэр гаргах албан ёсны эрх мэдэл нь Зохицуулах хороонд байдаг ч, жинхэнэ эрх мэдэл Ерөнхий сайд болон улс төрчдийн гарт байна. Ялангуяа томилгооны болон чиглэл өгөх замаар төвлөрч байна Энэ нь салбарыг эдийн засгийн сонирхол бус улс төрийн сонирхлоор удирдах нөхцөлийг бүрдүүлдэг.
1.2	Эрх мэдэл	PK2	Томилгооны эрх мэдэл	Засгийн газар болон Ерөнхий сайд Эрчим Хүчний Зохицуулах Хорооны зохицуулагчдыг томилдог нь улс төрийн хамаарлыг үүсгэдэг. ...Зохицуулах хорооны тэргүүнийг, зохицуулагч нарыг чинь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нь томилж байгаа	
1.3	Эрх мэдэл	PK3	ЭХЗХ-ны хууль эрх зүйн эрх мэдэл	Эрчим хүчний зохицуулах хороо үнэ тарифт албан ёсоор алх цохидог ч улс төрийн нөлөөнд ордог.	
2.1	Нөлөөлөл	INK1	Компанийн зардлын нөлөөлөл	Салбарын компаниуд дараа жилийн үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөгөө өгөх замаар үнэ бүрдэлтэд далд утгаараа нөлөөлдөг...Бид нарын өгсөн санал үнэ өртөгт нөлөөлдөг.	Тарифын өөрчлөлт хэрэглэгчийн зан үйлд нийтлэг сөрөг хандлага үүсгэдэг ч бодит үр дүнд хэрэглээний хэмнэлт бий болгодог.
2.2	Нөлөөлөл	INK2	Хэрэглэгчийн зан үйлийн нөлөөлөл	Цахилгааны үнэ нэмэгдсэн нь оргил ачааллын үеийн хэрэглээг бууруулж, системийн найдвартай ажиллагаанд сайнаар нөлөөлсөн. Үнэ нэмэгдсэн нь оргил ачааллын график бууж харагдаж байгаа.	Улс төрийн шахалт, мэргэжлийн бус чиглэл өгөх байдал нь эрчим хүчний салбарын асуудлыг үүсгэж буй бөгөөд техникийн аюулгүй ажиллагаанд ноцтой эрсдэл дагуулдаг.
2.3	Нөлөөлөл	INK3	Улс төрийн буруу нөлөөлөл	Улс төрчдийн буруу үйл ажиллагааг аваар саатал үүсэхэд хүргэж, салбарын найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.....Сая одоо ТЭЦ-3 дээр гарч байгаа энэ аваар бол үндсэндээ улс төрчдийн буруу үйл ажиллагаанаас болж байна. Машин нь зуухаа, турбинээ зогсоочихсон байсан уу зогсоочихсон байсан. Энэ машиныг явуулж болохгүй гэхэд тэр машиныг явуул гээд шахаад, засвар үйлчилгээ хийгээд явж байна..	

3.1	Сонирхол	IK1	Ашиг алдагдлаа нөхөх сонирхол	Үйлдвэрлэгчид инфляц, валютын ханш өссөнөөс үүдэлтэй засвар, сэлбэгийн өндөр зардлыг нөхөх сонирхолтой байна. Тэр болгоны үнэ нэмэгдэхээр зардал өсөж байдаг... алдагдал руу л яваад байгаа.	Салбарын мэргэжилтнүүдийн үндсэн сонирхол нь салбарын тогтвортой байдал (инфляцад нийцсэн үнэ, алдагдлыг нөхөх, тархмал эх үүсвэр) байхад, улс төрчдийн сонирхол нь богино хугацааны нэр хүнд (үнэ нэмэхгүй байх) дээр тогтож байна
3.2	Сонирхол	IK2	Хөрөнгө оруулалтын сонирхол	Салбар ашигтай байвал хөрөнгө оруулалт орж ирэх сонирхол гадна, дотогш үүсдэг. ("Ашигтай салбар луу л хөрөнгө оруулалт орж ирэх гээд байгаа юм. ")	
3.3	Сонирхол	IK3	Системийн тогтвортой байдлын сонирхол	Тархмал эх үүсвэр хөгжүүлэх, биржийн системд шилжих, стандартыг мөрдөх зэрэг салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх сонирхол.	
3.4	Сонирхол	IK4	Ард түмэнд таалагдах сонирхол	Улс төрчид сонгууль болон нэр хүнд олохын тулд үнэ нэмүүлэхгүй байх шийдвэр гаргадаг. ("Дотоодын сонгуульд нэр хүнд олж авах гэж байна гэж харж байна. ")	

Хавсралт 9. Өрхийн хэрэглэгчдийн ярилцлагад хийсэн сэдэвчилсэн шинжилгээ

1. Өрхийн хэрэглэгчдийн ярилцлагын шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Цахилгааны үнийн өсөлтийн нөлөөлөл	АН1	Санхүүгийн дарамт	Маш их (нөлөөлсөн), төлбөр өндөр гарсан (500-700 мянга), сарын цалингийн эхний тал хэсэг, ААН-ийнх арай өндөр нэмэгдсэн, өрхийн санхүүд шууд нөлөө үзүүлж байна.	Үнийн өсөлт нь санхүүгийн шууд дарамт үүсгэж, өрхийн худалдан авах чадварыг бууруулсан.
1.2	Цахилгааны үнийн өсөлтийн нөлөөлөл	АН2	Дарамт үүсгээгүй	Байшинд амьдардаг хүмүүс, илүү их цахилгааны төлбөр төлдөг хүмүүст хэцүү байсан. Миний хувьд хоёулхнаа амьдардаг учраас цахилгааны төлбөр нэмэгдсэн ч надад нэг их өөрчлөлт байхгүй.	Тарифын өсөлт нь хэрэглээний бүтэц, амьдрах орчноос шууд хамааран ялгаатай нөлөөлөл үзүүлж байна.
2.1	Хэрэглээний өөрчлөлт ба хэмнэлт	ВН1	Хэрэглээний хэмнэлт	Хэмнэж эхэлсэн, гэрлээ унтраах, интернэтээ салгах, баллонтой усаа салгадаг болсон.	Өрхүүд богино хугацааны хэмнэлтийн зан үйлд идэвхтэй шилжсэн.
2.2	Хэрэглээний өөрчлөлт ба хэмнэлт	ВН2	Эрчим хүчний эх үүсвэрийн шилжилт	Шалны халаалт зогсоосон, яндан руугаа шилжиж байгаа.	Тарифын өсөлт нь сэргээгдэх бус уламжлалт эх үүсвэр рүү буцах шалтгаан болж байна.
2.3	Хэрэглээний өөрчлөлт ба хэмнэлт	ВН3	Сэргээгдэх эрчим хүчний талаарх сонирхол	Тог баригч нарны панел хайж байгаа.	Иргэдийн дунд сэргээгдэх эрчим хүчний эрэлт нэмэгдэж байна.
3.1	Үнийн бодлогын шүүмжлэл	СН1	Үнэ нэмсэн нь буруу	Шууд утгаар бол буруу, цаг үеэ олоогүй (улирлаа олоогүй), иргэдээ судлалгүй шууд нэмдэг ...буруу шийдвэр	Тарифын бодлого нь нийгмийн бодит нөхцөлтэй нийцээгүй гэж үнэлэгдэж байна. Үнэ тарифын загварт хэрэглээний онцлог тусгагдаагүй.



4.1	Иргэдийн оролцоо ба бодлогын суваг	DH1	Иргэдийн оролцооны саад	Санал гомдлыг хүлээж авдаггүй, гомдол нь дээшээ яваад л таг болдог, эрхээ бүрэн эдэлж чаддаггүй, санал асуулга явдаг л гэсэн ойлголттой, санал өгч үзээгүй, оролцож байгаа арга барил нь хүртээмж багатай	Хэрэглэгчдийн оролцоо болон төрийн үйлчилгээний хариуцлага сул. Оролцооны механизм бодитоор ажиллахгүй байна.
4.2	Иргэдийн оролцоо ба бодлогын суваг	DH2	Мэдээллийн суваг	Хэрэглэгчдэд Үйлчлэх төв гэдэг рүүгээ л очоод байдаг юм байна лээ. Одоо үүнээс хойш харин бусад сувгуудаар маш сайн дамжуулах ёстой юм байна гэж бодож байна.	Мэдээллийн суваг хязгаарлагдмал
5.1	Шийдвэрлэх арга зам	GH1	Шийдвэрлэх арга зам	Бие даасан эрчим хүчний станцтай болох, бүсчилсэн тусдаа бодлого явах, сум/орон нутаг руу чиглэсэн бүтээн байгуулалт хэрэгтэй	Иргэд эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, орон нутагт чиглэсэн бодлого хэрэгтэй гэж үзэж байна.
5.2	Шийдвэрлэх арга зам	GH2	Хөнгөлөлт урамшуулал	Хөнгөлөлт, урамшууллын бодлого хэрэгтэй	Хөнгөлөлт, урамшууллын бодлого хангалтгүй
5.3	Инновацийн хэрэгцээ	GH3	Инновацийн хэрэгцээ	Инновацийг сайн судлах (нарны панел)... сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, технологийн харьцуулалт хийх, мэргэжлийн зөвлөгөө, сервис үйлчилгээ байхгүй	Иргэд инновацыг нэмэгдүүлэх, технологи сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

2. Өрхийн хэрэглэгчдийн ярилцлагаас хэрэглэгчдийн хариу үйлдэл, сонирхол, эрх мэдэл, нөлөөллийн талаарх шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Хэрэглэгчийн хариу үйлдэл	НН1	Хэмнэлтийн зан үйл	Хэмнэж эхэлсэн. Гэрлээ унтраах, интернэтээ салгах, баллонтой усаа шөнө унтахдаа салгадаг болсон	Үнэ тарифийн өсөлт нь хэрэглэгчдийн хэмнэлтийн зан үйлд шууд, идэвхтэй өөрчлөлтийг авчирсан. Уг өөрчлөлт нь зөвхөн бага зэргийн хэмнэлтээр (гэрэл унтраах) зогсохгүй, том хэмжээний хөрөнгө оруулалтын шийдвэр (халаалтын эх үүсвэрийг солих, сэргээгдэх эрчим хүч хайх) гаргах түвшинд хүрсэн. Энэ нь хэрэглэгч үнийн өөрчлөлтөд маш мэдрэмтгий байгааг харуулж байна.
1.2	Хэрэглэгчийн хариу үйлдэл	НН2	Халаалтын эх үүсвэр солих шийдвэр	Шалны халаалт байсныг зогсоосон... яндан руугаа шилжиж байгаа.	
1.3	Хэрэглэгчийн хариу үйлдэл	НН3	Сэргээгдэх эрчим хүч эрэлхийлэл	Тог баригч нарны фанер... сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжийг хайж байна	
2.1	Хэрэглэгчийн сонирхол	ИН1	Урамшууллын бодлого	Бодит юм л хүснэ... урамшууллын бодлого хэрэгтэй	Хэрэглэгчдийн сонирхол нь зөвхөн тог хэрэглэх бус, сонголт хийх боломж, хэрэглээгээ өөрөө зохицуулах, мөн тогтвортой, хямд шийдэл (сэргээгдэх эрчим хүч) олох зэрэгт чиглэж байна. Тэдний хувьд иргэний оролцоо болон хэмнэлтэд суурилсан урамшуулал нь чухал үнэт зүйл болж байна
2.2	Хэрэглэгчийн сонирхол	ИН2	Сонголт	Би яагаад мөнгөөрөө худалдаж авч байж тэрийг авна авахгүй гэдгийг шийдэж болоогүй юм бэ? Сонголтууд байвал зүгээр юм аа	
2.3	Хэрэглэгчийн сонирхол	ИН3	Сэргээгдэх эрчим хүч ашиглах	Нарны панел... сэргээгдэх эрчим хүчний технологийг Монгол Улс төрөл бүрийн байдлаар гаргаж ирмээр байгаа юм	



3.1	Хэрэглэгчийн эрх мэдэл	РН1	Хэрэглэгчдийн эрх эдлэх боломж	Гомдол шийддэггүй... эрхээ бүрэн эдэлж чаддаггүй	Хэрэглэгчид гомдол гаргах, бодлогыг шүүмжлэх замаар эрх мэдлээ илэрхийлж байна. Гэвч тэд өөрсдийн оролцоо хязгаарлагдмал, хүнд сурталд дарагдсан гэж үзэж байгаа нь эрх мэдлийн зөрүүг харуулж байна.
3.2	Хэрэглэгчийн эрх мэдэл	РН2	Үнэлгээ	Шууд утгаар бол буруу... Цаг үеэ олоогүй (улирлаа олоогүй), иргэдээ судлалгүй шууд нэмдэг нь учир дутагдалтай	
3.3	Хэрэглэгчийн эрх мэдэл	РН3	Иргэдийн эрхийн хангалт	Бид нар эрхээ ч бүрэн эдэлж чаддаггүй... гомдол гаргаад хойноосоо явлаа гэхэд асуудлаа бүрэн шийдүүлж чаддаггүй	
4.1	Хэрэглэгчийн нөлөөлөл	ИНН1	Нөлөөллийн оролдлого	Сайд солигдох болгонд энэ асуудлуудаа очиж илэрхийлдэг... Их хурлын гишүүдээрээ дамжуулаад чуулган дээр хүртэл хэл өгч байсан	Хэрэглэгчид улс төрийн түвшинд асуудлыг шийдүүлэхээр идэвхтэй нөлөөлөх оролдлого хийж байгаа нь (сайд, УИХ-ын гишүүд рүү хандах) харагдаж байна. Мөн тэд бусдын туршлагыг (хөрш айлуудын бие даасан эрчим хүч хайх) судалж, өөр хоорондоо мэдээлэл солилцох замаар нөлөөлж байна. Гэсэн хэдий ч энэ нөлөөлөл нь үр дүнгүй байгааг тэд хүлээн зөвшөөрч байна
4.2	Хэрэглэгчийн нөлөөлөл	ИНН2	Бүлгийн нөлөөлөл	Яг манай тухайд Соёлын төвд... зарим хэсгийг хэсэгчилж унтрааж байж Соёлын төвд нэгдсэн арга хэмжээ явж байна	
4.3	Хэрэглэгчийн нөлөөлөл	ИНН3	Хөршүүдийн туршлага	Айл өрхүүд бүр байгууллагууд хүртэл эрчим хүчээ бие даасан болгох гээд үзэж байна	

Хавсралт 10. ЦЭХ-ний үнэ тарифын талаарх үнийн шийдвэр гаргагчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын сэдэвчилсэн шинжилгээ

№	Гол сэдэв / Ангилал	Код	Дэд код	Түлхүүр эшлэл (Ярилцлагаас)	Шинжилгээ / Тайлбар
1.1	Салбарын тулгамдсан асуудал	FD1	Эх үүсвэр, чадлын дутагдал	Эрчим хүчний салбар яг одоогийн байдлаар shaos байдалд ороход ойрхон байна. Шинэ хүчин чадал 40 гаруй жил баригдаагүй... Бөөрөлжүүгийн станц ортол нэмэлт чадалгүй явсан	Цахилгаан эрчим хүчний үнийг нэмсэн нь алдагдалтай ажиллаж буй салбарт "амьсгалах зай" олгож байгаа хэдий ч үнийг бодит өртөгт дөхүүлэх нь эдийн засгийн хувьд зайлшгүй шаардлагатай
1.2	Салбарын тулгамдсан асуудал	FD2	Техник шинэчлэл	Техникийн шинэчлэл хийх нормыг бид гаргасан, батлахгүй хойшлуулаад явсаар техник хоцрогдсон.	Үнэ тариф тодорхой хүчин зүйлсээс хамаарч хувьсаж өөрчлөгддөг байх зарчмыг илүүтэй дэмжиж байна.
2.1	Үнэ тариф тогтоох аргачлал	TD1	Үнэ тариф тогтоох зарчим	Тариф тогтоох аргачлалууд яваандаа улам нарийсна. Жишээлбэл: Улсын төсвийн төсөл дээр 2 дахь жилдээ, тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлнэ гээд ороод ирж байгаа биз, үүнийг бүх талууд хүлээн зөвшөөрч байна. Яг энэ шиг зарчим эрчим хүчинд нэвтэрч индексжүүлнэ гэдэг ойлголтыг хэрэглэгч, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгч аль аль тал нь анзаарч, төсөв төлөвлөгөөндөө тусгадаг болбол сайн. Хүмүүс анзаардаг болсон байна лээ. Одоо энэ чинь индексжүүлж байгаа хэлбэр. Эрчим хүчний салбарт дандаа урт хугацаатай төслүүд хэрэгждэг, минимум 5 жилээс дээш урт хугацааны төслүүд явдаг. Тэгэхээр мөнгөний урт хугацааны үнэ цэнэ, ирээдүйн орлогын өнөөгийн үнэ цэнийг ч харгалзаж тариф тогтоох хэрэгцээ гарна. Цаашид эх үүсвэрийн үйлдвэрлэгчдийн дунд хувийн хэвшлийн оролцоо улам нэмэгдэнэ, ойрын 10 жилд магадгүй 50:50 болох хандлагатай байна. Энэ урт хугацааны прогнозыг бид урьдчилж харж тарифын бодлогоо тогтоох ёстой. Дистерчерийн зохицуулалтыг ухаалаг оюунаар хийж, үйлчилгээнд хүний оролцоо буурна энэ нь зардлыг бууруулах үед тарифын бүтэц үндсэндээ өөрчлөгдөнө.	Эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд үнийг оновчтой тогтоохын чухлыг онцолж үнийг индексжүүлэхээс гадна эрчим хүчний салбарын бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг хянах, хөрөнгө оруулалтыг татах, шинэ бөгөөд үр ашигтай технологи нэвтрүүлэхийг үнийн бодлогоор дэмжихийг ч санал болгож байна.



2.2	Үнэ тариф тогтоох аргачлал	TD2	Үнэ тариф тогтоох зарчимд бусад хүчин зүйлсийг харгалзах нь чухал	...Манай эрчим хүчний зах зээлд одоо “зардал дээр нэмэх” зарчмыг хэрэглээд явж байгаа. Энэ бол олон улсад хэрэглэдэг л аргачлал. Эх үүсвэрийн дийлэнхийг хуучин станцууд үйлдвэрлэж байгаа буюу нэгэнт элэгдлийн зардлаараа өртгөө нөхсөн үйлдвэрүүд ажиллаж байгаа учир өртөг, зардал бага л гарна. Гэтэл цаашид шинээр өндөр өртөгтэй, зээлийн эх үүсвэрээр баригдах үйлдвэрүүд ашиглалтад орж тэдний үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг сүлжээнд нийлүүлэх тохиолдолд өртөг, зардал өсөх нь гарцаагүй. Үүнийг ч бид тарифын аргачлалд хэрхэн тусгахыг бодох л хэрэгтэй. Нэг худалдан авагчийн загвар нэвтрүүлэх эхэн үед гадаадын зөвлөхүүд өөр, өөр аргачлалыг зөвлөж л байсан. Түүнд бас шинэ үйлдвэрүүд ашиглалтад оруулбал яах вэ гэдгийг харгалздаг хувилбар байсан. ...Ер нь ЭХЗХ эдгээр хүчин зүйлсийг урьдчилж тооцоолоод үнийн прогнозоо зарладаг байж болох л байх.	Үнэ тарифын одоогийн аргачлалыг мөрдөхдөө эрчим хүч үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн зардлаас гадна эдийн засаг, нийгмийн бусад хүчин зүйлсийг харгалзан өөрчилж сайжруулах хэрэгцээ байна
-----	----------------------------------	-----	--	--	---

2.3	Үнэ тариф тогтоох аргачлал	TD3	Үнэ тарифын тооцоо судалгаа	... Миний хувьд 6-7 удаагийн үнэ тариф нэмэх үйл явцад оролцсон, тариф нэмэхэд яг юу болдог вэ гэхээр, "хэрэглэгчийн тариф нэмэх ёстой", "салбар алдагдалтай байна" гэдгийг бүгд л мэддэг. ЭХЗХ-оос бүх тооцоо, судалгаагаа хийгээд 20-30 хувиар нэмэгдүүлэх ёстой юм байна гээд гаргадаг, энэ судалгаагаа Хорооны дарга нар салбарын сайдтайгаа хоорондоо албан, албан бусаар ярилцана, тооцогоо бөөндөө очиж танилцуулна. Тэгээд сайд бол Ерөнхий сайдтай ярилцана л гэдэг юм. Тэгээд мөн л уулзана, ажлын албаны хүмүүсээ дагуулж орж танилцуулга хийнэ. Тэр үед тариф нэм ч гэхгүй, нэмэхгүй ч гэхгүй, энэ үед бид мэдээж хичээнэ, бүх нөхцөл байдлаа тайлбарлана, танилцуулна, тооцоо судалгаагаа үзүүлнэ. Харин салбарынхан бол ЭХЗХ нь тариф нэмэх оролдлого хийсэнгүй гээд л шүүмжилдэг, бид үүнтэй холбоотой баахан бичиг, тайлбар холбогдох газруудад явуулдаг, тухайлбал, ЗГХЭГ, УИХ-ын дарга, Ерөнхий сайд гээд хаяглаад илгээнэ. Ажилгаад байхад явж явж эцсийн шийдвэрийг Ерөнхий сайд л гаргаж байна. Гэтэл яг ийм процесс аль ч баримт бичиг, дүрэм журамд байхгүй шүү дээ. Тэр дүрэм журамд нь Зохицуулах хороо хараат бусаар тарифыг тогтооно, индексжүүлнэ, хэрэгжүүлнэ гээд тусгасан хуулийн сайхан заалттай. Гэтэл яг эцсийн шийдвэр бол тэнд очиж гарна. Яагаад Ерөнхий сайд, Засгийн газар тариф нэмж чадахгүй юм гэхээр аргагүй л юм байна лээ л дээ, цахилгаан, дулааны үнэ улсын бүх хүнд л хамааралтай учраас...	Салбарын тооцоо судалгаа хийгддэг болон талуудад танилцуулагддаг боловч бусад талууд хүлээж авах байдал хангагдахгүй байна
2.4	Үнэ тариф тогтоох аргачлал	TD4	Салбарын хөгжил, урт хугацааны тогтвортой төлөв байдал	Зарчмын хувьд одоогийн барьж байгаа зарчим бол зөв. Өөрөөр хэлбэл, тарифыг яаж тогтоодог вэ гэхээр бодит өртөг зардалд үндэслэдэг байхгүй юу. Ирээдүйд энэ аргачлал сул тал болж технологи хурдтай хөгжөөд ирэнгүүт түүний хурдыг гүйцэхгүй, нөлөөллийг тооцож чадахгүй байж магадгүй. Яагаад гэхээр үнэ тарифыг тооцох суурь мэдээлэл нь өнгөрсөн жилийн гүйцэтгэл байдаг учраас ирээдүйд гарах нөлөөллийг харж чадахгүй байх магадлалтай ба цаашид үүнийг урьдчилж харж бас тусгах гэж оролдох хэрэгтэй.	Үнэ нь эрчим хүчний салбарын зохицуулалтын гол хэрэгсэл учир зөвхөн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзахаас илүүтэй салбарын хөгжил, урт хугацааны тогтвортой төлөв байдлыг харгалзсан аргачлал нэвтрүүлэхийг талууд онцолсон



3.1	Хэрэглэгчдийн ойлголт, мэдээлэл	CD1	Хэрэглэгчид зөв ойлголттой байх нь чухал	Цахилгаан эрчим хүчний үнэ нэмэх шийдвэр нь хүн бүрт хамааралтай учир нийгэмд тодорхой давалгаа бий болгодог. Гэхдээ жирийн ард түмэн бол ойлгодог. ... намайг зохицуулагчаар ажиллаж байх үед гаргасан шийдвэрээс үүдээд нэг аймагт хүчтэй эсэргүүцэл гарч бид очиж уулзалт хийсэн, тухайн үед жоохон болгоомжтой л очсон тэгээд уулзалтын явцад сайхан яриад, харьцуулалт хийгээд, та нарын карманаас ийм юм гарч байгаа, гар утастай харьцуулах юм бол ийм гээд л хэлсэн бүгд л ойлгосон. Үнэ нэмэх шийдвэр гаргах нь хүнд боловч эрчим хүчний салбараа хүндрэлээс гаргахаас гадна хэрэглэгчдээ зөв хэрэглээнд сургах эерэг үр дагаврыг дандаа авчирдаг. Үнэ тарифын өөрчлөлтийг мэдээлэх олон нийтийн хэлэлцүүлгийг бид өнгөрсөн хугацаанд тун маруухан хийж ирсэн. Олон нийтийн хэлэлцүүлэг хийх нь битгий хэл, ер нь салбартаа ч бараг зарлаж болохгүй гэдэг ийм "командтай" шүү дээ. Хэрэв урьдчилж зарлавал наадах чинь улс төржих мэдээлэл болж "үнэ нэмэх гэж байна" гээд сөрөг хүчин, бусад талуудаас улс төржүүлэх магадлалтай гэсэн болгоомжлол байдаг. Яг сонгодог утгаараа зохицуулалт хэрэгжихгүй байгаа учраас олон нийтийн хэлэлцүүлэг хийх юм бол нээрээ л нэмэхээр төлөвлөсөн юмаа зогсоох эрсдэлтэй, тэгээд тэнд яг хэрэглэгчид нь оролцохгүй, асуудал үүснэ. Өнгөрсөн туршлагаас харахад дэмжиж байсан улсууд хүртэл буруу зохицуулалт хийчихэж гээд яриад байхаар ЭХЗХ-нд ч бас хэцүү байдаг. Яваандаа хэлэлцүүлгийг хийх ёстой юм байна, нөхцөл байдлаа ойлгуулж байх хэрэгтэй юм байна гэдэг бодолтой болоод байна. Судаалгааны үр дүнгээс ч, мөн үнэ нэмсэний дараа тал талаас ирдэг шалгалтуудаар ч та нар ерөөсөө олон нийтэд хэлээгүй байна, танилцуулаагүй байна гэдэг шүүмжлэл, дүгнэлтүүд ч гарсан. Тэгээд ямар ч байсан бодит үнэнээ ярих ёстой юм байна гэдэг ойлголттой болчихсон.	Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг хэрэглэгчид зөв ойлголттой бол хүчтэй эсэргүүцэхгүй. Хэрэглэгчдэд танилцуулах, хэлэлцүүлэх байдал сул байдгийг анхаарч, цаашид өөрчлөх шаардлагатай байна
3.2	Хэрэглэгчдийн мэдээлэл	CD2	Хэрэглэгчдэд танилцуулах/хэлэлцүүлэх шаардлага		

4.1	Үнийн шийдвэрт гол нөлөөлөгч субъект	ID1	Үнийн шийдвэр дэх эр зориг	...Би Зохицуулах хорооны дарга байхдаа үнийг өөрчлөх шийдвэрийг яг сонгуулийн дараа хийсэн, ямар Засгийн газар томилогдох, сонгуулийн дүн ямар болохыг мэдээгүй байхдаа л шууд хэлэлцээд шийдсэн. Үнэ нэмэх шийдвэрээ гаргасны дараа салбарын сайд дуудаад яагаад надад мэдэгдэхгүй үнэ нэмсэн бэ? гэхэд нь "хэрэв танд хэлбэл, Ерөнхий сайд руу ороод ЦЭХ-ний үнэ нэмэх шийдвэр зогсоно, хуулиараа бид хараат бусаар, тооцоо судалгаанд үндэслэж үнэ нэмэх шийдвэр гаргана шүү дээ" гэж хэлсэн. ... ЭХЗХ-ны гаргасан шийдвэр нь Зохицуулах газрын даргаас чөлөөлөх "албан бус" үндэслэл болсон тохиолдол ч байгаа. Ер нь олон хүчин зүйл нөлөөлдөг ч цахилгаан эрчим хүчний үнийг хөдөлгөх шийдвэр нь ЭХЗХ-ны дарга нарын тухайд "эр зориг" шаарддаг шийдвэр. ЭХЗХ хуулийн хувьд хараат бусаар шийдвэр гаргах зохицуулалттай боловч ялангуяа даргыг голчлон Эрчим хүчний сайд санал болгож Ерөнхий сайд томилдог учир томилооны хараат байх нөхцөл үүсдэг. Би ажиллаж байхдаа тооцоолол хийж бэлдэж байгаад яг сонгуулийн дараа үнэ нэмж байсан, энэ тохиолдолд хүртэл Ерөнхий сайд дуудаад яагаад үнэ нэмсэн билээ гэдэг асуудал тавьж л байсан. Зохицуулагч нар хараат бус байх гэж ихэд чармайдаг, үе үеийн сайд нартай үнэ, тарифын бодлого дээр зөрж явлаа. Би чиний цэрэг биш асуудлаа бичгээр ханд гээд хэлж л байсан. Улс төрийн нөлөө өндөр байж ирсэн нь үнэн. цаашид энэ байдал өөрчлөгдөнө. Зохицуулагч нарт нөлөөлөх хувийн хэвшлийн компаниуд, хөрөнгө оруулагчдын нөлөө асар өндөр болно.	Үнийн шийдвэр гаргах эрх мэдэл нь хууль эрх зүйн хувьд ЭХЗХ-нд хадгалагдаж байгаа боловч эцсийн шийдвэрт хамгийн хүчтэй нөлөөтэй, эрх мэдэлтэй субъект нь улс төр, тэр дундаа Засгийн газар түүний дотор Ерөнхий сайд байна
4.2	Үнийн шийдвэрт гол нөлөөлөгч субъект	ID2	ЭХЗХ-ын хараат бус байдлын асуудал		
4.3	Үнийн шийдвэрт гол нөлөөлөгч субъект	ID3	Улс төрийн нөлөөлөл өндөр		

